



*Монголын бэлчээрийн мал аж  
ахуйн эдийн засгийн холбогдолтой*

---

# **НОМ ЗҮЙ**

Улаанбаатар хот  
2004 он

## **НЭЭЛТЭЙ НИЙГЭМ ФОРУМ**

*Хаяг:* Жамьян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48, Монгол Улс

*Утас:* 976-11-313207

*Факс:* 976-11-324857

*Вэб хуудас:* <http://www.soros.org.mn>

<http://www.forum.mn>

© МННХ, 2004  
ISBN:99929-5-808-1

Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэхийг хүсвэл МННХ-ийн хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна.

“BCI” компанид хэвлэв.

Утас: 318632, 319032

## НОМЗҮЙГ ТОЛИЛУУЛАХ УЧИР

Манай Нээлттэй Нийгэм Форумас явуулж буй бодлогын судалгаа, шинжилгээний өргөн хүрээт ажлын нэг тэргүүлэх чиглэл нь бэлчээрийн мал аж ахуйтай холбоотой сэдэв болой. Энэ сэдэвт ажлын хүрээнд хийгдсэн “Монголын бэлчээрийн мал аж ахуйн холбогдолт ном зүйн судалгаа”-г Танд өргөн барьж байна.

Эл ном юуны түрүүн тухайн сэдвээр судалгаа хийдэг дотоод, гадаадын эрдэмтэн судлаач, оюутан сурагч, шийдвэр гаргах түвшин хийгээд Монголд хандивлагч байгууллагын хүмүүст зориулагдсан боловч тухайн сэдвийг сонирхсон хэн хүн ашиглаж болно. Номыг бид монгол хэлнээс гадна англи хэл дээр хэвлүүлж буйгаа сонордуулья. Номноос тухайн сэдвээр урьд өмнө хийгдэж байсан судалгаа шинжилгээний тойм, эх сурвалж, мэдээ мэдээлэл, номын тухай мэдээллийн тоймтой танилцах болно.

Нээлттэй Нийгэм Форумын захиалгыг амжилттай гүйцэтгэж энэ номыг Таны гарт хүргэх бололцоо олгосон Ц.Сүхбаатар ахлагчтай “Бүс нутгийн хөгжлийн судалгаа, сургалтын төв”-ийн хамт олонд талархлаа илэрхийлье.

Энэхүү номзүйн чанар, агуулгатай холбоотой санал хүсэлтийг [osf@soros.org.mn](mailto:osf@soros.org.mn) хаягаар бид дуртайяа хүлээн авах болно.



**Стефан Д. Ванс**

Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн  
Гүйцэтгэх захирал

Монголын нээлттэй нийгэм хүрээлэнгийн захиалгаар “Монголын бэлчээрийн мал аж ахуйн эдийн засгийн холбогдолтой ном зүй”-г бэлтгэсэн Бүс нутгийн хөгжлийн судалгаа, сургалтын төвийн судлаачдын баг:

Цэрэнсономын Сүхбаатар	(Доктор, профессор)
Лувсандоржийн Нямбат	(Доктор)
Доржийн Гансэлэм	(Магистр)
Дагьсийн Кадирбек	(Докторант)
Батсуурийн Алтанбаяр	(Магистр)

Хянан тохиолдуулсан: Ц. Гомбосүрэн  
Б. Мөнхсоёл



Монголын бэлчээрийн мал аж ахуйн эдийн засгийн холбогдолтой ном зүйн судалгааны энэхүү ажлыг Монголын нээлттэй нийгэм хүрээлэн (Соросын сан)-гээс санхүүжүүлэн хэрэгжүүлж байгаа юм.

Уг ном зүйд хамрагдсан Монголын бэлчээрийн мал аж ахуйн холбогдолтой бүтээлүүдийг сонгон эмхтгэхдээ Улсын төв номын сан, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн номын сан, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн номын сан, ХААИС-ийн номын сан, МУИС-ийн номын сан, Монголын Шинжлэх Ухааны Академийн Үндэсний хөгжлийн хүрээлэн, Түүхийн хүрээлэн, Олон улс судлалын хүрээлэн, Газар зүйн хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэн, Геоэкологийн хүрээлэнгүүдийн судалгааны фондууд, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын мэдээллийн сан, Улсын төв архивын шинэ фондууд, Шинжлэх ухаан, мэдээллийн паркын номын сан, Үндэсний статистикийн төв газрын номын сан, Олон улсын Монгол судлалын холбооны номын фонд, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн номын фонд, Монголын нээлттэй нийгэм хүрээлэн (Соросын сан)-гийн номын фонд, НҮБ болон олон улсын төслийн байгууллагуудын төсөл, судалгааны фондуудын каталогиудыг шүүн судалсан болно. Мөн Монгол улсын холбогдох хууль, тогтоомжууд, Засгийн газрын шийдвэр, яамдын бодлогын баримт бичиг, тайланг судалгаанд хамруулсан. Түүнчлэн Монголын бэлчээрийн мал аж ахуйн эдийн засгийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил явуулдаг гадаадын эрдэмтдийн бүтээлийг интернетээс олж, холбогдох мэдээллийг и-мэйлээр авч хамруулсан болно.

Ийнхүү Монголын бэлчээрийн мал аж ахуйн эдийн засгийн ном зүйн судалгааг анх удаа эмхтгэн гаргаж байна. Энэхүү ном зүйд 1995 оноос хойш бичигдсэн шинжилгээ судалгааны ном, товхимол, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, диссертаци, олон улсын байгууллагуудаас явуулсан төслийн тайлан, зөвлөмж зэргийг хамруулав.

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд бэлчээрийн мал аж ахуйг сонирхон судлах хүрээ мэдэгдэхүйц тэлж байна. Энэ нь, жишээлбэл 2002 онд болсон Монголч эрдэмтдийн VIII их хурлаар эдийн засгийн салбар хуралдааныг шинээр зохион байгуулж гадаад, дотоодын олон эрдэмтэн, судлаачид Монгол Улсын хөгжлийн асуудлаар сонирхолтой илтгэлүүд тавьж хэлэлцүүлснээс харагдаж байгаа юм.

Даяаршлын өнөөгийн шинэ зуунд дэлхийн улс орнуудын өмнө тогтвортой хөгжлийн замаар замнах зайлшгүй шаардлага тавигдаж байгаагийн дотор юуны өмнө байгаль орчноо хамгаалж, зүй зохистой ашиглах, хүн амыг эрүүл хүнс, усаар хангах асуудал эн тэргүүний нэг зорилт болоод байна. Энэхүү зорилтоос үүдэн бэлчээрийн мал аж ахуйн байгалийн цэвэр бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэхээр байна.

Монголын тогтвортой хөгжлийн ажлын албанаас эрдэмтэд, их дээд сургуулийн багш, эрдэм шинжилгээний ажилтнуудын дунд явуулсан санал асуулгаар бэлчээрийн мал аж ахуйн чиглэлээр ном зүйн судалгаа хийж энэ чиглэлийн эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлт, санал гарсныг энд бас дурьдаж болох юм.

Энэхүү ном зүйд 165 эрдэмтэн, судлаачийн 187 бүтээлийн бүтэц, агуулгын товч хураангуйг багтаасан болно. Түүнчлэн судалгааны багийнхан энэ эмхтгэлд орсон бүтээл тус бүрийн үр дүн, ач холбогдлын талаархи дүгнэлтийг анх удаа хийсэн болно.

Бэлчээрийн мал аж ахуйн эдийн засгийн холбогдолтой ном зүйн судалгаа явуулахад хэрэглэх сэдвийг (Thematic) судалж кодлон жагсаалт гаргав. Энд мал аж ахуйн эдийн засаг, үр ашиг, менежмент, маркетинг, тогтвортой хөгжлийн асуудлууд, санхүүгийн үйлчилгээ, бүртгэл тооцоо гэсэн 26 сэдвээр ном зүйг төрөлжүүлэн хийлээ.

Ном зүйд хамрагдсан бүтээл бүрт индексийн дугаар өгсөн бөгөөд энэ удаагийн эмхтгэл нийт 0187 гэсэн индекстэй, дараагийн ном зүйг гаргахдаа 0188 гэсэн дугаараас эхлэн бүтээлүүдийг үргэлжлүүлэн бүртгэнэ. Түүнчлэн зохиогчдыг үсгийн дарааллаар жагсааж, энэ бүтээлд хамрагдсан бүтээлийн индексүүдийг товчоолсон болно. Мөн зохиогчидтой харилцах хаягийн бүртгэлийг хавсаргасныг энэ төрлийн ном зүйд шинэлэг ажил гэж хэлж болно.

Энэхүү ном зүйд бэлчээрийн мал аж ахуйн эдийн засгийн судалгааны онцлогоос хамаарч ном зүйн ангиллын шаардлагыг харгалзан дараахь үзүүлэлтээр судалгаа тайлбар хийсэн болно. Үүнд:

- 1) Зохиогч, редакторын нэр, овог (хэрэв 3-аас дээш зохиогчтой бол эхний хоёр зохиогчийн нэрийг авч дараа нь бусад гэж бичсэн)
- 2) Бүтээлийн нэр (хэрэв уг бүтээл ном, сэтгүүлд хэвлэгдсэн бол тэр ном, сэтгүүлийн нэр, хэвлэгдсэн дугаар, оныг бичсэн)
- 3) Хэвлэсэн газар, эрхэлсэн байгууллагын нэр
- 4) Хэвлэсэн он
- 5) Хуудасны дугаар (хэрэв бие даасан бүтээл бол нийт хуудасны тоог, ном сэтгүүлд оруулж хэвлэсэн бол ...ээс...хүртэл /100-108/ гэж хуудасны дугаарыг бичсэн)
- 6) Ямар хэл дээр хэвлэгдсэн (англи, монгол гэх мэт)
- 7) Бүтээлийн чиглэл (онол, арга зүй, тайлан, диссертаци гэх мэт)
- 8) Товч хураангуй (бүтээлийн үндсэн агуулга, судалгааны онцлог, ач холбогдол)
- 9) Дүгнэлт (уг бүтээлийн судалгааны хэмжээ далайц, шинэлэг тал, асуудлыг хамарсан байдал, арга зүй, дутагдалтай тал)

Энэхүү ном зүйг санаачилж, санхүүжүүлж, хэвлэх боломж олгосон Монголын нээлттэй нийгэм хүрээлэнгийн Нээлттэй нийгэм форумд гүн талархал илэрхийлье.

# БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОГДОЛТОЙ НОМЫН АНГИЛАЛ

<b>Нэг.</b> Мал аж ахуйн эдийн засаг , үр ашиг	Код
1.1. Мал аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт	1010
1.2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг	1020
1.3. Монгол малын төрөл, түүний ашиг шим	1030
1.4. Малчдын амьжиргааны түвшин, нийгмийн асуудлууд	1040
1.5. Мал аж ахуй дахь эрсдэл, экологийн асуудал	1050
1.6. Мал аж ахуйн эрчимжүүлэлт	1060
1.7. Малчдын хоршоо, хамтын ажиллагаа	1070
1.8. Мал аж ахуй дахь хөдөлмөрийн нөөц	1080
1.9. Монгол улсын мал аж ахуйн дэлхийн зах зээлд эзлэх байр суурь	1090
<b>Хоёр.</b> Мал аж ахуйн менежмент	
2.1. Мал аж ахуйн зохион байгуулалт	1210
2.2. Бүсчилсэн хөгжлийн асуудлууд	1220
2.3. Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагаа	1230
<b>Гурав.</b> Мал аж ахуйн маркетинг	
3.1. Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл	1310
3.2. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ, чанар стандарт	1320
3.3. Мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалт	1330
<b>Дөрөв.</b> Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн тулгамдсан асуудлууд	
4.1. Мал аж ахуйн тогтвортой хөгжил	1410
4.2. Малын бэлчээр, бэлчээрийн менежмент, тэжээлийн хангамж	1420
4.3. Хашаа хороо, худаг ус	1430
4.4. Газар зохион байгуулалт, газрын харилцаа, газар зүй	1440
4.5. Мал аж ахуйн механикжилт, цахилгаанжилт	1450
4.6. Мал эмнэлгийн үйлчилгээ	1460
<b>Тав.</b> Мал аж ахуйн санхүүгийн үйлчилгээ	
5.1. Цалин хөлс, зээл, хадгаламж	1510
5.2. Татвар, даатгал	1520
5.3. Түрээсийн харилцаа	1530
<b>Зургаа.</b> Мал аж ахуйн бүртгэл тооцоо	
6.1. Мал аж ахуй дахь санхүү, бүртгэл	1610
6.2. Мал аж ахуйн мэдээ, мэдээлэл	1620

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
МАОЭШХ	Мал Аж Ахуйн Эрдэм Шинжилгээний Хүрээлэн
МСОУХ	Монгол Судлалын Олон Улсын Холбоо
МУИС	Монгол Улсын Их Сургууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НСИСОУХ	Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн
ОУСХ	Олон Улс Судлалын Хүрээлэн
СЭЗДС	Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль
УБИС	Улын Багшийн Их Сургууль
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
ХХААЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яам
ШУА	Шинжлэх Ухааны Академи





<b>НЭГ. МАЛ АЖ АХУЙН ЭДИЙН ЗАСАГ, ҮР АШИГ .....</b>	<b>17</b>
<b>1010 Мал аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт .....</b>	<b>17</b>
Малын гаралтай түүхий эдийн эрэлт хэрэгцээ ба нийлүүлэлт .....	17
<b>1020 Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг .....</b>	<b>17</b>
Малчин өрхийн аж ахуйн бүтээмжийн хүчин зүйлийн ашиглалтыг дээшлүүлэх асуудалд .....	17
Малчин өрхийн эдийн засаг, санхүүгийн асуудлууд .....	18
Хөдөө аж ахуйг хөгжүүлэх зарим асуудал .....	18
Монголын мал аж ахуйн үржил селекцийн өнгөрсөн ба өнөө үе: Үржил селекцийн уламжлалт болон орчин үеийн практик үйл ажиллагааны давуу ба сул талууд .....	19
Монголын бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийн үр дүн .....	19
Монголын нүүдлийн мал аж ахуй зах зээлд хүрэх зам дээр байна уу? .....	20
<b>1030 Монгол малын төрөл, түүний ашиг шим .....</b>	<b>20</b>
Тэмээ судлал .....	20
Монгол тэмээ .....	21
Хос зогдорт тэмээн сүргийн ноосон ашиг шим .....	21
Монгол адуу .....	22
Монгол сарлаг .....	22
Монгол үүлдрийн сарлаг .....	23
Үнээний сүүн ашиг шимийг нэмэгдүүлэх боломж .....	23
Сэлэнгэ үүлдрийн үнээний сүүний гарц .....	23
Монгол хонины ашиг шимийн удамшилт, селекцийн ялгавар, үр ашиг .....	24
Монгол хонь .....	24
<b>1040 Малчдын амьжиргааны түвшин, нийгмийн асуудлууд .....</b>	<b>25</b>
Жижиг үйлдвэр байгуулах замаар малчдын амьжиргааны түвшинг дээшлүүлэх .....	25
Малчин өрхийн аж ахуйн төрх, эрэлт хэрэгцээний өнөөгийн байдал .....	25
Малчны хүний эрхийн асуудал .....	25
Малчин өрхийн амьжиргааны түвшинг өөрсдийнх нь үнэлэмжээр судалсан дүн .....	26
Малчдын дунд явуулсан социологийн судалгаа .....	26
Монголын ядуурал ба зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт .....	27
Монгол орны хөдөөгийн аж амьдралыг дэмжих нь .....	27
Монголын нүүдэлчдийн орон сууцны түүхэн хөгжил .....	28

	Нүүдэлчдийн эрүүл мэндийн зарим асуудлууд .....	28
<b>1050</b>	<b>Мал аж ахуй дахь эрсдэл, экологийн асуудал .....</b>	<b>29</b>
	Төв Азийн бэлчээрийн малын экологийн зохистой нутаг .....	29
	Монгол дахь цөлжилт .....	29
	Хөдөө аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулах асуудалд .....	29
	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл, түүний сөрөг нөлөөллөөс сэргийлэх .....	30
	Малын зүй бус хорогдолд нарны идэвхжлийн нөлөөг судлах асуудалд .....	30
	Эдийн засгийн тогтвортой хөгжилд экологийн хямрал заналхийлж байна .....	31
	Бэлчээрийн мал аж ахуйн цаг уурын нөхцөл .....	31
	Монголын мал аж ахуйн үйлдвэрлэлд цаг уурын үзүүлэх нөлөө .....	31
	Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зарим асуудал .....	32
	Төв Ази дахь гамшгаас сэргийлэх, бэлэн байхад чиглэгдсэн бэлчээрийн эрсдлийн менежментийн үйл ажиллагаа Монголын жишээн дээр .....	32
<b>1060</b>	<b>Мал аж ахуйн эрчимжүүлэлт .....</b>	<b>33</b>
	Монголын мал аж ахуйн зохицуулалт .....	33
	Махны үхрийн аж ахуй, мах үйлдвэрлэлийн хөгжлийн хэв шинж .....	33
	Бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн хөдлөл зүй .....	34
	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн өнөөгийн байдалд өгсөн эдийн засгийн үнэлгээ .....	34
	Тэмээн сүргийн тогтвортой өсөлтийг хангах арга зам .....	35
	Монгол малчны амьдрахуйн ухаан .....	35
	Монголын хөдөө аж ахуйн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай .....	36
<b>1070</b>	<b>Малчдын хоршоо, хамтын ажиллагаа .....</b>	<b>36</b>
	Нүүдлийн мал аж ахуйд суурилсан хоршооллын ажиллагааг сайжруулах нь .....	36
	Говь нутгийн хот айл, түүний бүтэц ба онцлог .....	36
	Монголын бэлчээрийн мал аж ахуйн нөхцөлд хөдөө аж ахуйн хоршоог хөгжүүлэх үндсэн асуудлууд .....	37
	Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн баталгаа бол хоршоолол .....	38
	Монголын хөдөө аж ахуйн хоршоог шинэлэг байдлаар зохион байгуулж хөгжүүлэх асуудал .....	38
	Монголын нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэгчдийн бүлэглэл буюу нэгдэл .....	38
	Монголын нийгмийн шинэчлэлийн үйл явц дахь хоршооллын хөдөлгөөний шинэ хандлага .....	39
	Монголын хөдөөгийн хоршоо: түүх, ерөнхий дүр төрх, ирээдүй .....	39

	Монголын орон нутгийн байгууллага, газрын шинэчлэл, даяаршил .....	40
<b>1080</b>	<b>Мал аж ахуй дахь хөдөлмөрийн нөөц .....</b>	<b>40</b>
	Хөлсний малчин ажиллуулж байгаа зарим хэлбэрүүд .....	40
	Мал аж ахуй дахь хөдөлмөрийн нөөцийг зохистой ашиглах тухай .....	41
	Малчдын боловсролыг дээшлүүлэх зарим асуудал .....	41
	Хонины хишиг (малчны намтар) .....	41
	Малчин өрхийн эдийн засаг ба зохион байгуулалт .....	42
	Африкийн нүүдэлчдийн хувь заяа Монголд нүүрлэж байна .....	42
	Мал аж ахуй дахь хөдөлмөрийн нөөц ашиглалт .....	43
	Монголын менежментийн онол: хүний нөөцийн нүүдэлчин хандлага .....	43
	Монголын малчдын хөдөлмөрийн хуваарь ба ажлын нөхцөл .....	44
<b>1090</b>	<b>Монгол улсын мал аж ахуйн дэлхийн зах зээлд</b>	
	<b>эзлэх байр суурь .....</b>	<b>44</b>
	Үндэстнүүдийн нэгдлийн XXI зуунд Монголын нүүдлийн соёл	
	иргэншлийг хангах асуудлууд .....	44
	Төв Азийн нүүдэлчид .....	45
	Зүүн хойт Азийн хөдөө аж ахуйн хамтын ажиллагаанд Монголын	
	оролцоо .....	45
	Нүүдлийн мал аж ахуйн төгсгөл үү? .....	45
	Төв Азийн орнуудын нүүдлийн мал аж ахуйн харьцуулсан судалгаа .....	46
	Нүүдлийн мал аж ахуйн бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд .....	46
	Ямааны аж ахуйн эдийн засаг .....	47
	Нутгийн монгол мал Төв Азийн байгаль, цаг уур, экологийн	
	нөхцөлд дасан зохицсон байдал .....	47
	Монголын нүүдэлчин .....	48
	Бэлчээрийн эдийн засаг ба орчин .....	48
	Глобалчлалын үе дэх нүүдэл иргэншлийн уламжлал, шинэчлэлийн	
	асуудал .....	49
	<b>ХОЁР. МАЛ АЖ АХУЙН МЕНЕЖМЕНТ .....</b>	<b>50</b>
<b>1210</b>	<b>Мал аж ахуйн зохион байгуулалт .....</b>	<b>50</b>
	То вангийн сургаал ба Монголын нүүдлийн мал аж ахуй .....	50
	Хүрээ нэгдлээс фермерийн аж ахуй хүртэл .....	50
	Малчин өрхийн аж ахуйн бүтээмжийг дээшлүүлэх зарим боломж .....	51
	Монгол Улсын томоохон хот орчмын хөдөө аж ахуйн бүсийн	
	бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалт .....	51
	Монгол орны талархаг нутгийн мал аж ахуйн нутаг дэвсгэрийн	
	зохион байгуулалтын асуудалд .....	52
	Хот айл фермерийн аж ахуй .....	52

Одоо л чухам Монголын хөдөөгийн эдийн засгийн бааз суурийг бий болгох зохистой цаг .....	53
Хөгжиж буй дэлхий ертөнц дэх бэлчээрийн тогтвортой оршихуйн менежментийн стратеги .....	53
Малчин өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийн менежментийн асуудал .....	54
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нэгжийг фермерийн хэлбэрт шилжүүлэх онцлог, хэлбэр, арга зам .....	54
Нүүдэлчдийн бүс нутгийн нийгмийн өнөөгийн байдал, ирээдүй .....	55
Үнээний саалийн ферм – сүү үйлдвэрлэлийн гол газар .....	55
Өнөөдрийн Монголын хөдөө нутаг .....	56
<b>1220 Бүсчилсэн хөгжлийн асуудлууд.....</b>	<b>56</b>
Эдийн засгийн бүсүүдийн мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэлийн чадавхи (потенциал)-ийн үнэлгээ .....	56
Хөдөө аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх асуудал .....	57
Монгол Улсын Өрнөд бүс .....	57
Монгол, Японы хөдөө аж ахуйн салбарт явуулж байгаа хамтын ажиллагаа .....	58
<b>1230 Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагаа .....</b>	<b>58</b>
Буянт мал: малчдад зориулсан гарын авлага .....	58
Мал аж ахуй дээрээ яаж ажиллах тухай ардад өгөх сануулга, сургаал .....	59
Монголын нүүдэлчдийн үндэсний уламжлалт технологи .....	59
Бэлчээрийн мал аж ахуйг эрхэлж ирсэн монголчуудын уламжлалт арга .....	60
Монголын эдийн засгийн түүх .....	60
Мал маллах уламжлалт ухаан .....	61
Монголын аж ахуйн эдийн засаг түүхэн гурван үед .....	61
Монгол туургатны уламжлалт мал аж ахуйн хөгжлийн түүх - эдийн засгийн үндэс .....	61
Чингис хааны гүр улсын мал аж ахуй .....	62
Монголчуудын үйл урлахуйн эрдэм ухаан .....	62
Монголын нүүдлийн мал аж ахуйн гүн ухаан .....	63
Нүүдлийн соёл иргэншлийг судлах орчин цагийн ач холбогдол .....	63
Монголын нүүдэлчдийн байгальтай дасан зохицохуйн мэдлэг ухааны уламжлал .....	64
Монголын нүүдлийн мал аж ахуй .....	65
Монголын нүүдлийн сонгодог мал аж ахуй, иргэншлийн хөгжлийн хэтийн төлөв .....	65

**ГУРАВ. МАЛ АЖ АХУЙН МАРКЕТИНГ ..... 66**

**1310 Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл .....66**

Мал аж ахуйн маркетингийн системийг бүрдүүлэх талаар  
авч хэрэгжүүлэх арга хэмжээ, баримтлах бодлогын хувилбар ..... 66

Монгол Улсын махны маркетингийн иж бүрдэл ..... 66

Монголын мал аж ахуйн маркетингийн өнөөгийн тулгамдсан асуудлууд ..... 67

Монголын мал аж ахуйн үйлдвэрлэлийн зах зээлд саад болж буй  
зарим хүчин зүйлүүд ..... 67

Малчдын зах зээлийн эдийн засагт шилжих эдийн засгийн  
арга хэлбэрүүд ..... 68

Малчин өрхийн аж ахуйгаа эрхлэн хөтлөх төлөв байдал ..... 68

Монгол ноолуурын маркетингийн удирдлагын зарим асуудал ..... 69

**1320 Мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ, чанар стандарт ..... 69**

Өндөр уулын бүсэд үржүүлж буй нутгийн ямааны ноолуурын  
шинж чанарыг харьцуулан судалсан дүн ..... 69

Ойт хээрийн бүсэд үржүүлж буй нутгийн ямааны ноолуурын  
үндсэн шинж чанарыг судалсан дүн ..... 70

Цөцгийн тосны харьцуулсан судалгаа ба технологийг сайжруулах нь ..... 70

Монголын нүүдэлчдийн малын шир, нэхий боловсруулах  
уламжлалт технологи ..... 70

Шилжилтийн үе дэх арьс, ширэн түүхий эд, бүтээгдэхүүний  
маркетингийн үндсэн асуудал ..... 71

Монгол үүлдрийн хонины сүүний чанарын тухайд ..... 71

Монгол малын махны судлагдсан байдал ..... 72

**1330 Мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалт .....72**

Бизнесийн хэв шинж бүхий малчин өрхийн борлуулалтын  
үйл ажиллагаа ..... 72

Малчин өрхийн орлогод ноолуурын үзүүлэх нөлөөлөл ..... 72

Монгол ноолуур: эдийн засаг, стратегийн асуудлууд ..... 73

Ноолуурын бэлтгэл, борлуулалтын оновчтой суваг бүрдүүлэх арга зам ..... 73

**ДӨРӨВ. МАЛ АЖ АХУЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН  
ТУЛГАМДСАН АСУУДЛУУД ..... 74**

**1410 Мал аж ахуйн тогтвортой хөгжил .....74**

Тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүд (индикаторууд) ба мал аж ахуй ..... 74

Монголын хөдөө аж ахуйн хөгжлийн хандлага ..... 74

Мал аж ахуйг хөгжүүлэхэд төрөөс баримтлах бодлогын зарим асуудал ..... 75

Хөдөөгийн хөгжлийн стратеги ..... 75

Монголын хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хэтийн төлөв,  
тулгамдсан зорилтууд ..... 76

Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлын зарим асуудал .....	76
Монгол үндэстний нүүдлийн эдийн засаг болон уламжлалт экологийн үзэл .....	76
Бэлчээрт суурилсан мал аж ахуйн тогтворжилт .....	77
Малчин ба экологи .....	77
Монгол орны бэлчээрийн мал аж ахуйн өнөөгийн байдлын тойм .....	78
Ховд аймгийн нутагт мал аж ахуй эрхлэх байгалийн нөхцөл, нөөцийн онцлог .....	78
<b>1420 Малын бэлчээр, бэлчээрийн менежмент, тэжээлийн хангамж .....</b>	<b>79</b>
Бэлчээрийн менежмент ба тогтвортой хөгжил .....	79
Бэлчээрийн менежментэд малчдын оролцоо .....	79
Бэлчээрийн менежментийн хөгжлийн тулгамдсан асуудлууд .....	80
Монголын бэлчээрийн менежментийн асуудалд .....	80
Монголын нүүдэлчдийн үүрэг: Бэлчээрийн менежментийн экологийн талаар .....	80
Бэлчээр судлалын цогцолбор технологи .....	81
Төв Азийн бэлчээрийн доройтол ба төрийн бодлого .....	81
Хангайн уулархаг нутгийн бэлчээрийг зохистой ашиглах нь .....	81
Ойт хээрийн бүсийн зарим төрлийн бэлчээрийг ашиглах .....	82
Монгол орны цөлөрхөг хээрийн бүсэд мал бэлчээрлүүлэх экологийн нөхцөл .....	82
Монгол орны нөхцөлд хонин сүргийн бэлчээрийн маллагаа, тэжээлийн шинжлэх ухааны үндэслэл .....	83
Аюулаас хамгаалах тэжээлийн фондын талаарх зарим асуудалд .....	84
Монгол Улсын хадлан бэлтгэлийн чадавхи .....	84
Тэжээлийн зарим буурцагт ургамлын генийн сангийн судалгаа .....	84
Газар ашиглалт, бэлчээрийн менежмент .....	85
Хөдөөгийн ядуучуудыг малжуулах нь: Монголын бэлчээр ашиглалтыг оновчтой болгох, ядуурлыг бууруулах арга зам .....	86
Монгол орны малын тэжээлийн ургамал .....	86
Хотоос хөдөө рүү шилжих эрчимгүй хөдөлгөөн: Мал аж ахуйн салбарын эрчимгүй хөгжил .....	86
Монголын эдийн засгийн хөгжил ба бэлчээр .....	87
Монголын бэлчээр ашиглалтын газарзүйн түүх .....	87
Социалист гэгдэж байсан Монголын бэлчээр эзэмшилтийн өөрчлөлт .....	88
Бэлчээрийн ногооны ерөнхий шимт чанарыг солилцооны энергийг үйлчлэх боломж .....	88
Монголын нүүдлээр ашиглагдсан бэлчээрийн өөрчлөгдөх, сэргэх онцлог .....	88
Монголын бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн бодлогын зарим асуудлууд .....	89

	Монголын бэлчээр ашиглалтын өөрчлөлт ба тогтворжилт .....	89
	Бэлчээрийн маргаан зөрчил .....	90
<b>1430</b>	<b>Хашаа хороо, худаг ус .....</b>	<b>90</b>
	Зах зээлийн үеийн хөдөөгийн усан хангамж .....	90
<b>1440</b>	<b>Газар зохион байгуулалт, газрын харилцаа, газар зүй .....</b>	<b>91</b>
	Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй (Монголын нүүдэлчдийн жишээгээр) .....	91
	Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй .....	91
	Монголын нүүдлийн түүх ба газар эзэмших эрхийн талаар .....	92
	Монголын газар өмчлөлийн нөхцөл дэх мал хувьчлалын үр дүн .....	92
	Монголын хууль ба эмх цэгцгүй байдал: Монголын газрын хуулийн хэрэгжилт .....	92
	Монголын газар хувьчлал .....	93
	Малчин өрхийн газар эдэлбэр, эдийн засгийн асуудлууд .....	93
	Нүүдэлч малчдыг суурьшуулах газарзүйн зарим асуудал .....	94
<b>1450</b>	<b>Мал аж ахуйн механикжилт, цахилгаанжилт .....</b>	<b>94</b>
	Нарны болон салхины эрчим хүч нь нүүдлийн соёл иргэншлийг хөгжүүлэх үр дүнтэй арга мөн .....	94
	Сүү-таваарын жижиг фермийн механикжсан технологийн шинжлэх ухааны үндэслэл .....	95
<b>1460</b>	<b>Мал эмнэлгийн үйлчилгээ .....</b>	<b>95</b>
	Малын эрүүл мэндийг сайжруулах нь .....	95
	Мал эмнэлгийн үйлчилгээний эдийн засгийн үр ашиг .....	95
	Хувийн мал эмнэлгийн үйлчилгээний эдийн засаг .....	96
<b>ТАВ. МАЛ АЖ АХУЙН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ .....</b>		<b>97</b>
<b>1510</b>	<b>Цалин хөлс, зээл, хадгаламж .....</b>	<b>97</b>
	Хөдөө орон нутагт санхүүгийн үйлчилгээг хүргэх .....	97
<b>1520</b>	<b>Татвар, даатгал .....</b>	<b>97</b>
	Мал аж ахуйн албан татварын байдалд хийсэн шинжилгээ .....	97
	Монгол Улсын мал аж ахуйн албан татвар, түүний арга зүйг боловсронгүй болгоход шийдвэрлэх үндсэн асуудал .....	98
	Татварын онол, арга зүйн зарим асуудлууд .....	99
	Мал аж ахуйн орлогын татвар ногдуулалт, түүнийг төгөлдөржүүлэх зарим асуудал .....	99
	Мал аж ахуйн татвар, даатгалыг төгөлдөржүүлэх асуудал .....	99
	Мал аж ахуйн даатгалыг боловсронгүй болгох арга зам .....	100
	Монголд тохиромжтой малын даатгалын тогтолцооны судалгаа .....	100

<b>1530</b>	<b>Түрээсийн харилцаа .....</b>	<b>101</b>
	Малын түрээсийн төлбөр ба орлогын хуваарилалт .....	101
	Монгол Улс дахь түрээсийн харилцааг боловсронгуй болгох асуудал .....	101
<b>ЗУРГАА. МАЛ АЖ АХУЙН БҮРТГЭЛ ТООЦОО .....</b>		<b>102</b>
<b>1610</b>	<b>Мал аж ахуй дахь санхүү, бүртгэл .....</b>	<b>102</b>
	Малчин ерхийн аж ахуйн түвшинд хөтлөх төсөв, тайлангийн журам, аргачлал .....	102
	Малчин ерхийн үүргийн талаар: Монголын хувьд .....	102
<b>1620</b>	<b>Мал аж ахуйн мэдээ, мэдээлэл .....</b>	<b>103</b>
	Монголын хөдөө аж ахуй дахь мэдээллийн ач холбогдол .....	103
	Монголын нүүдэлчдийн сэтгэлгээ, мэдээлэл .....	103
<b>СУДЛААЧИЙН ҮГ .....</b>		<b>104</b>
<b>НОМ ЗҮЙД ХАМРАГДСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ .....</b>		<b>105</b>
<b>ЗОХИОГЧИЙН НЭРСИЙН ДАРААЛАЛ, БҮТЭЭЛИЙН ИНДЕКС .....</b>		<b>118</b>
<b>НОМ ЗҮЙД БҮТЭЭЛ НЬ ОРСОН ЗОХИОГЧДЫН ХАЯГ .....</b>		<b>120</b>



## НЭГ. МАЛ АЖ АХУЙН ЭДИЙН ЗАСАГ, ҮР АШИГ

### 1010 Мал аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт

#### 0001

Бадарч Д.

#### Малын гаралтай түүхий эдийн эрэлт хэрэгцээ ба нийлүүлэлт

*“Market-Economy Nomads-Technology” товхимол. УБ, 2002. НСНСОУХ. 168-171 хууд. Англи.*

Эдийн засагт хөнгөн ба хүнсний үйлдвэрлэл давамгайлдаг Монгол орны хувьд малын гаралтай түүхий эдийн эрэлт хэрэгцээ нэн чухал юм. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед мал аж ахуйн түүхий эдийг бэлтгэх, худалдаалах, түүний чанарт тавих шаардлага өндөр байв.

Хөдөө аж ахуйн нэгдэл задарч мал хувьчлагдсан болон түүхий эд бэлтгэх тогтолцоо задарсны улмаас түүхий эд, бүтээгдэхүүнээ малчид өөрсдөө зарж борлуулах, мөн улсын томоохон үйлдвэрүүд уналтад орж хүчин чадлынхаа 10-40 хувиас илүүг ашиглаж чадахгүйд хүрсэн юм. Иймээс Засгийн газраас бөөний худалдааг хөгжүүлэх зорилго тавьж малчдыг хэрэгцээт зүйлсээр хангах ажлыг хийж эхлэв.

Ноолуурын анхны дуудлага худалдаа Баянхонгор аймгийн Баацагаан суманд болсон. Энэ дуудлага худалдааны гол зорилго нь ноолуурын чанарыг дээшлүүлэх замаар малчдын орлогыг нэмэгдүүлэх явдал байв.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн түүхий эдийн зах зээлийн зохион байгуулалтыг сайжруулах, бөөний болон дуудлага худалдааг зохион байгуулах явдал чухал гэсэн санал дэвшүүлжээ.

### 1020 Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг

#### 0002

Адъяа Ю.

#### Малчин өрхийн аж ахуйн бүтээмжийн хүчин зүйлийн ашиглалтыг дээшлүүлэх асуудал

*Докторын (Sc.D) диссертаци. УБ, 1999. ШУА, 249 хууд. Монгол.*

Малчин өрхийн аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэхийн тулд зарим нөхцөлд бэлчээрийн маллагаанаас уламжлагдан ирсэн шалгарсан аргыг бэлчээр, байран маллагааны хэлбэрт аажмаар шилжүүлэх замаар малын тогтвортой өсөлтийг хангах нөхцлийг бүрдүүлж, мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах шинжлэх ухааны аргыг нэвтрүүлэх замаар тухайн өрх орлогоо нэмэгдүүлэх боломжтой гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Монголын малчин өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашиг хоёр хоорондоо төстэй боловч бүтээмж нь үйлдвэрлэлийн эдийн засгийн үр дүнгийн нэг үзүүлэлт, үр ашиг нь бизнес аж ахуйн үр дүнгийн шалгуур үзүүлэлт гэж үзжээ.

Энэхүү судалгаагаар малчин өрх бүтээмжээ нэмэгдүүлж, бизнес үйлчилгээ явуулах чадвартай аж ахуйн нэгжүүдийг байгуулах замаар буурай хөгжилтэй мал аж ахуйгаас хөгжингүй орны түвшинд ойртуулах чиг баримжааг онолын хувьд дэвшүүлсэн байна. Энэхүү үзэл баримтлал нь буурай хөгжилтэй орон, хөгжингүй орнуудад хэрэглэж буй бүтээмжийн удирдлагын бэлэн туршлагыг өрхийн аж ахуйд тохируулан хэрэглэх боломжтой гэж дүгнэжээ.

Малчин өрхийн аж ахуйн үйл ажиллагаанд нөлөөлөх олон хүчин зүйлийг тооцоноор зардлуудыг аль болох хэмнэлттэй зарцуулах оновчтой хязгаар тогтоож, түүнд тулгуурлан аж ахуй эрхлэх арга, өрхийн аж ахуйг

удирдах онолын шинэ санааг дэвшүүлсэн байна. Энэхүү онолын үндэслэлийг хэрэгжүүлэхэд бүс нутгийн онцлогоос хамаарч нэг өрх дунджаар 300-500 толгой (хонинд шилжүүлснээр 890) малтай байх нь хамгийн тохиромжтой бөгөөд аж ахуйн нэгжийн хэмжээнд ажиллах боломжтойг харуулжээ. Харин нэг өрхийн малын бүтцэд тэмээ 1,4%, адуу 13,1%, үхэр 6,8%, хонь 50,7%, ямаа 28% тус тус байх нь зохистой гэж үзжээ.

**Дүгнэлт:** Малчин өрхөд бөөний худалдаа, бирж зэрэг зохион байгуулалтын хэлбэр нэвтрүүлж, хөрөнгө, хөдөлмөр, үйлдвэрлэлийн технологио хорших, малчин өрхийн сайн дурын хоршоо, нөхөрлөлийг олшруулах, 1000-аас дээш малтай өрхүүд бие даан мал аж ахуйнхаа түүхий эдийг дахин боловсруулах үйлдвэрийг байгуулж бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх шинэ санааг дэвшүүлсэн байна.

### 0003

Бакей А.

#### Малчин өрхийн эдийн засаг, санхүүгийн асуудлууд

*"Nomadic Studies" сэтгүүл, 2002, №04. Өгүүлэл. УБ. НСНСОУХ. 118-120 хууд. Монгол.*

Бизнесийн хэв шинжтэй өрхийн аж ахуй нь өөрийн ашиглалт, эзэмшилдээ буй газар, үндсэн хөрөнгөндөө тулгуурлан хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг байнга эрхэлдэг, түүгээр өөрийн хэрэгцээгээ бүрэн хангаад зах зээлд таваарын бүтээгдэхүүн нийлүүлдэг, илүү их орлого олж, нэмэгдэл ажлын байр, хуримтлал бий болгож, хөлсний хөдөлмөр эрхэлдэг зэрэг шаардлага, шалгуурыг хангасан байх ёстой байна.

Судалсан өрхүүдийн 85.1% нь зөвхөн гэр бүлийн хөдөлмөрт түшиглэн үйлдвэрлэл эрхэлж байхад 14.9% нь хөлсний хөдөлмөр ашиглаж байна.

Чинээлэг болон бизнесийн хэв шинжтэй малчин өрхүүд нь мал, хөрөнгө, орлогын хувьд бусад аж ахуйн нэгжүүдээс дутахааргүй төлбөрийн чадвартай, санхүүгийн байгууллагатай тэдний нэгэн адил харилцах эдийн засгийн чадавхитай боловч хуулийн этгээдийн эрхгүй аж ахуй эрхлэгч байна.

Мал аж ахуйг эрсдлээс хамгаалах, өөрийн хуримтлал бий болгож, тогтвортой хөгжүүлэх үүднээс цаашид хөрөнгө оруулалт хийх, бие даасан аж ахуйн нэгжийн нэгэн адил банк, санхүүгийн байгууллагатай чөлөөтэй харьцах хэрэгцээ, шаардлага нэмэгдэж байгааг судалжээ.

**Дүгнэлт:** Бизнесийн хэв шинжтэй аж ахуйг хөгжүүлэх банк, санхүүгийн болон эрх зүйн таатай орчин бүрэлдэн хөгжөөгүй байгааг хэрхэн давж туулах талаар саналууд дэвшүүлжээ.

### 0004

Нямдаваа Г.

#### Хөдөө аж ахуйг хөгжүүлэх зарим асуудал

*"Market-Economy Nomads-Technology" товхимол. УБ, 2002. НСНСОУХ. 106-110 хууд. Англи.*

1960-аад оноос өмнө мал аж ахуй нь материаллаг баазын хувьд дутуу дулимаг байсан бөгөөд 1944-1945, 1954-1955 оны зуд энэ талаар анхаарлаа хандуулахад ихээхэн сургамж болсон. 1950-иад оны сүүлчээс нэгдэлжих хөдөлгөөн өрнөж, мал хоршооллын мэдэлд шилжснээр материаллаг баазаар хангагдаж, мал эмнэлгийн иж бүрэн хөтөлбөр, малчдын амьдрах нөхцөл, цалин хөлс зэрэг асуудлыг улсын зүгээс шийдвэрлэж өгсөн. 1990 оноос мал аж ахуйн талаар баримталж буй төрийн бодлогод зарчмын өөрчлөлт хийж, малчин бүрийг хувийн өмч буюу малтай болгох, улсаас хамаарахгүйгээр өөрийн аж амьдралаа хөтлөх боломжийг бүрдүүлсэн. Нэгдэл тарж, малыг хувьчилснаар малчин бүр өөрийн хөрөнгөтөй болж, зарим нь 1000 толгой хүртэл өсгөж байхад зарим нь бүрмөсөн малгүй болсон. Мөн нэлээд аймаг, сумдад малын тоо толгой буурч, бэлчээрийн даац хэтэрч, төв рүү шилжих шилжилт ихсэх зэрэг сөрөг үзэгдлүүд бий болсоор байна. Иймээс сүргийн бүтцийг оновчтой болгох, тэжээлийн аж ахуйнууд бий болгох зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байна. Туршилтын

журмаар цөөн малыг байран нөхцөлд тогтмол тэжээн маллаж үзсэн боловч хөдөлгөөнгүй байснаас болж малын бодисын солилцоо муудаж, өөрийгөө дулаацуулах чадваргүй болж хорогдол ихэссэн байна.

**Дүгнэлт:** Монгол орны хувьд хагас байран маллагаатай бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх нь тохиромжтойг судалгаа харуулж байна. Малын өсөлтөд бэлчээрийн даац, ган, зуд гол нөлөө үзүүлж байна гэж үзжээ.

## 0005

Теленгед Б.

### **Монголын мал аж ахуйн үржил селекцийн өнгөрсөн ба өнөө үе: Үржил селекцийн уламжлалт болон орчин үеийн практик үйл ажиллагааны давуу ба сул талууд**

*"Culture and Environment in Inner Asia: 1 - The Pastoral Economy and the Pastoral Environment"* товхимол. Их Британи, 1996. 161-188 хууд. Англи.

Энэ өгүүлэлд малын үржил селекцийн уламжлалт арга ажиллагаанд дүгнэлт өгч, үүнд сүүлийн 70 жилд тохиосон улс төр, эдийн засгийн үйл явдлууд хэрхэн нөлөөлснийг судалжээ. Тухайлбал, малын уугуул үүлдэр угсааг гадаадын үүлдэр угсаатай өргөн хэмжээгээр эмх замбараагүй эрлийзжүүлсэн, мөн нэгдэлжилтийн үеийн эдийн засгийн зарим үйл ажиллагаа нь үржил селекцийн уламжлалт арга ажиллагаанд ерөнхийдөө сөрөг нөлөөтэй байсан гэж үзжээ. Гэвч малын уугуул үүлдэр угсаа энэхүү эрлийзжүүлэлтийн улмаас устаж үгүй болсон гэх нотолгоо байхгүй аж. Харин малыг хувьчилснаар малын үржил селекцийн уламжлалт арга ажиллагаа сэргэх хандлагатай болж байна.

**Дүгнэлт:** Генетикийн шинжлэх ухааны өндөр хөгжил нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх бодитой, үр ашигтай арга боломжуудыг нээн өгч байна. Үүнийг бэлчээрийн мал аж ахуйд ч ашиглах өргөн боломжтой бөгөөд уламжлалт үржил селекцийн арга ажиллагаатай хослуулах замаар нутгийн үүлдэр угсааг сайжруулан өргөтгөх нь зүйтэй гэж судлаач үзжээ. Үүний зэрэгцээ хүн амын эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа учраас Монголд бэлчээрийн мал аж ахуйн ашиг шимийг дээшлүүлэх зайлшгүй шаардлага бий болж байна.

## 0006

Энх-Амгалан А.

### **Монголын бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийн үр дүн**

*Төслийн тайлангийн хураангуй. УБ, 2000. НҮБХХ. 10 хууд. Англи.*

Уг илтгэлд Монголын эдийн засагт мал аж ахуйн гүйцэтгэх үүргийг судлаад, мал аж ахуйн үйлдвэрлэлийн 1960, 1980, 1991 онуудын гол гол үзүүлэлтийг харьцуулж, 1969-1990 оны мал аж ахуйн гол үзүүлэлтүүдэд тулгуурласан үйлдвэрлэлийн функцийг ашиглан мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг тооцсон байна. Судалгааны үечлэлийг социализмын үе, мал аж ахуйн үйлдвэрлэлийн оргил үе, шилжилтийн үе гэсэн 3 үед хувааж, бүтээмжийн шинжилгээг хийсэн.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн функцийг  $[G=f(C, L, F, V, W, H, A, P, T)]$  ерөнхий хэлбэрийг тогтоож, үйлдвэрлэлийн мэдрэмжийг тодорхойлсон. Тухайлбал, мал аж ахуйн үйлдвэрлэл дэх хөдөлмөр, капитал, нэмэлт тэжээл, мал эмнэлгийн үйлчилгээ, хувийн малын хэмжээний 1%-ийн өсөлт нь үхрийн хувьд 0.019; 0.633; 0.543; 0.121; 0.726%-ийн цэвэр өсөлтийг, бог малын хувьд -0.015; 0.591; 0.335; -0.292; 0.044%-ийн цэвэр өсөлтийг тус тус бий болгоно гэж тодорхойлсон.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн үйлдвэрлэлийн 3 үеийн тоо баримтыг ашиглан мал аж ахуй дахь хөдөлмөр, капитал г.м. нөөцийн 1.0%-ийн өсөлт малын тооны өөрчлөлтөд хэрхэн нөлөөлөхийг үйлдвэрлэлийн функцийг ашиглан судалж, нөлөөллийг нөөц бүрээр тооцож гаргасан байна.

## 0007

Жеркер Эдстром, Ганзоригт Н.

### Монголын нүүдлийн мал аж ахуйг зах зээлд хүрэх зам дээр байна уу?

Судалгааны тайлан. *Policy Alternatives for Livestock Development (PALD)*. УБ, 1997. 89 хууд. Англи.

Өнөөдөр монголын мал аж ахуй бүхэлдээ хувийн хэвшлийн мэдэлд шилжээд байна. Бусад салбартай харьцуулахад хожуу ч гэсэн мал аж ахуйн үйлдвэрлэл чөлөөт үнийн харилцаанд бүрэн шилжсэн. Мах бэлтгэлийн алба 1993 оноос хүчингүй болсон. Гэхдээ махны худалдаа эрхэлдэг төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн хувьд махны хатуу тогтоосон дээд үнийг баримталсаар байгаа. 1991 оноос хойш нийт бараа борлуулалтын хэмжээ буурсаар ирсний дотор улсын төвлөрсөн системээр бэлтгэн борлуулсан махны хэмжээ эрс буурсан. Төрөөс явуулж байгаа маркетингийн шинэчлэлийн бодлогыг цаашид эрчимтэй үргэлжлүүлэх шаардлагатай.

Дотоод, гадаад худалдаа идэвхжсэнээр махны үйлдвэрлэл, борлуулалтыг харьцангуй нэмэгдүүлэх боломж бүрдэж байна. Энэ нь сүргийн бүтцийг сайжруулах, төллөх эм малын хувь хэмжээг нэмэгдүүлэх малчдын сонирхлыг нэмэгдүүлж байна. Ингэснээр мал аж ахуйн маркетингийн үйл ажиллагаа бүхэлдээ сайжрах хандлагатай болно гэж судлаач үзжээ.

Малчдад зах зээлийн таатай орчин бүрдүүлэх, ялангуяа татвар, зээл зэрэг бодлогын арга хэрэгслүүдийг ашиглан дундаж амьжиргаатай малчдыг олшруулахад чиглэсэн үйл ажиллагаа чухал. Зөв зохион байгуулж, тодорхой зорилгоор зээл олгох, онцгой тохиолдолд тэжээлийн туслалцаа үзүүлэх, малыг даатгалд хамруулах, дахин малжихад туслах, мал эмнэлгийн үйлчилгээг төлбөргүй болгох зэргээр орлого багатай ядуу малчдыг төрөөс дэмжиж болно. Гэвч урт хугацаанд зах зээлийн орчин нөхцлийг сайжруулах өргөн хүрээтэй хөтөлбөр хэрэгжүүлэхгүй бол дээрхи арга хэмжээ үр ашиг багатай болно.

**Дүгнэлт:** Малчдыг зах зээлтэй холбох, мэдээллээр хангах явдал бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн эхний гол алхам бөгөөд эргээд хүн амын хүнсний асуудлыг шийдвэрлэх, экспортын эх үүсвэрийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ болно. Мал аж ахуйг зах зээлд шилжүүлэх ажил эхний шатандаа явж байна гэж дүгнэсэн байна.

## 1030 Монгол малын төрөл, түүний ашиг шим

### 0008

Индра Р.

#### Тэмээ судлал

Нэг сэдэвт бүтээл. УБ, 1998. 304 хууд. Монгол.

Монгол Улсад дэлхийн тэмээний 2 хувь, хос бөхт тэмээний 30 хувь нь байдаг.

Манай улсын мал аж ахуйн өвөрмөц салбар болох тэмээ тооны хувьд бүх малын 1.2%, бодод шилжүүлснээр 3.5%-ийг эзлэх боловч гаргаж байгаа бүтээгдэхүүний ач холбогдол, улсын эдийн засагт үзүүлэх нөлөөллөөрөө хонь, үхрийн дараах байр эзэлж, жилд бэлтгэдэг мал аж ахуйн бүтээгдэхүүний 3.7, сүүний 0.4-0.5, ноосны 17, махны 2.8-3.0, экспортын бүтээгдэхүүний 5.6%-ийг тэмээний аж ахуйгаас нийлүүлдэг бөгөөд аж ахуйн дотоод ачаа тээврийн 25-30 хувь, говийн бүсийн аймгуудын мал аж ахуйн орлогын 35-40 хувийг тэмээний аж ахуй оруулдаг байна.

Тэмээ нь Монгол Улсын газар нутгийн 42 хувийг эзэлдэг говийн байгаль, цаг уур, бэлчээрийн нөхцөлд нэн зохицсон мал бөгөөд Монголын нүүдлийн мал аж ахуйн эртний салбаруудын нэг учир манай малчид тэмээг маллах, уналга, эдэлгээнд хэрэглэх, өсгөн бойжуулах, ашиг шимийг нь ашиглах арвин түршлагатай юм.

Тэмээг уналга эдэлгээнд өргөн ашиглагдаас гадна сүүгээр нь төрөл бүрийн цагаан идээ бэлтгэх, ноосоор нь үлэмж чанар сайтай, зөөлөн дулаан хувцас, хөнжил зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг тул тэмээний аж ахуйн эдийн засгийн ач холбогдол хэзээ ч буурахгүй. Тэрчлэн монгол үүлдрийн тэмээ нь дэлхийн хос бөхт тэмээний нэг үнэт генофонд юм.

**Дүгнэлт:** Судлаач тус номондоо бэлчээрийн мал аж ахуйг тус орны таван хошуу малын нэг болох тэмээний бие цогцос, галбир, бие махбодийн гадаад, дотоод тогтолцооны онцлог, цөл, говийн нөхцөлд зохицсон байдал, тэмээний мах, сүү, ноосон ашиг шим, тэмээг эдэлгээнд хэрэглэх, үржүүлэх, шилэн сонгох, ботго бойжуулах, маллах арга, тэмээнд мал эмнэлгийн үзлэг хийх, тэмээнд тохиолддог зонхилох өвчин, эмчлэх, анагаах арга ажиллагаа зэрэг нүүдэлчдийн эртнээс уламжлагдан ирсэн нарийн технологи, онцлогийг тусгажээ.

## 0009

Индра Р., Бийчээ Н., бусад

### Монгол тэмээ

*Төслийн тайлан. УБ, 2000. МААЭШХ. 36 хууд. Монгол.*

Монгол тэмээ XX зууны сүүлчийн хэдхэн жилийн дотор ихээхэн хорогдон цөөрчээ. 1997 онд Монголын тэмээний тоо 355.1 мянга болж, 1996 оныхоос 0.8 хувь буюу 2.8 мянгаар хорогдсон. 1997 оны тэмээний тоог 1987 оныхтой харьцуулбал 35.8% буюу 191.5 мянгаар цөөрсөн бөгөөд хамгийн эрчимтэй хорогдлын үе бол 1990-1993 он байжээ. Энэ нь тэр үед малыг хувьчлах явцад тэмээн сүргийн бүтцийг анхаарч үзээгүйн зэрэгцээ зах зээлийн бодлого хэрэгжиж эхлээгүй байсан тул хот, хөдөөд хүнсний тос, махны ховроос болж тэмээг олон тоогоор нядлах явдал гарч байсантай голчлон холбоотой гэж судлаачид үзжээ.

Монгол тэмээ хосломол ашиг шимтэй мал. Олон төрлийн ашиг шимээс одоогоор зөвхөн мах, ноосыг нь ашиглаж байна. Жилд 40.0 мянган ингэнээс ботго авч бойжуулдаг.

Тэмээний бусад төрлийн ашиг шим орлого багатай учраас тэмээн сүрэгтэй айл өрх зөвхөн махан ашиг шимээс нь орлого олох зорилгоор тэмээгээ нядалж махыг нь зарах сонирхолтой байна гэх үндэслэлтэй. Тэр тусмаа монголчууд олон мянган жил тэмээгээ өсгөх эрмэлзэл бодлогын үүднээс махыг нь хүнсэнд бага хэрэглэдэг байсан заншлаа зах зээлийн хэдхэн жилийн дотор үгүйсгэж махыг нь ямар ч хориг сэжиггүй хэрэглэдэг болсон нь энэхүү ашиг шимээр орлого олоход хүргэжээ.

**Дүгнэлт:** Тэмээ өсгөхөд энэ сүргээс олох орлогыг нэмэгдүүлэх явдал чухал юм. Жилд 0.8 мянган тонн ингэний сүү бэлтгэж байгаа баримтаас үзэхэд ингийг саалинд бараг ашиглахгүй байна. Ингийг саалинд сургах, саамшруулах журмаар саалийг нь нэмэгдүүлэх боломж бий. Гэвч нэг кг сүү саахын тулд нэг орчим тэжээлийн нэгж ордог. Ингэний сүүний биологийн онцгой чанар, хадгалалт, тээвэрлэлт даах байдал, эмчилгээ сувилгааны чанараас болж хот суурин газарт эрэлт хэрэгцээ их байдаг гэж судлаачид үзжээ.

Ингэний саалийн ферм, сүүнд анхан шатны боловсруулалт хийдэг, сүү хоормогийг ариутгаж савладаг жижиг оврын үйлдвэр байгуулж алс холоос сүү, хоормог тээвэрлэдэг асуудлыг шийдэж чадвал тэмээчдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой гэж үзсэн байна.

## 0010

Пүрэвragчаа Ш., Эрдэнэбаатар Б., Цэгмид М.

### Хос зогдорт тэмээн сүргийн ноосон ашиг шим

*"Мал аж ахуйн шинжлэл" товхимол. №5. УБ, 2003.23-32 хууд. Монгол.*

Тэмээн сүргийн ашиг шимийн үндсэн бүтээгдэхүүн нь ноос юм. Тэмээний ноосны гарц, нас, хүйс, арчилгаа маллагаа, тарга хүч, удамшлын онцлогоос хамаарч харилцан адилгүй байдаг. Хос зогдорт тэмээний бусад тэмээнээс ялгагдах гол онцлог нь ноосны гарц, хэмжээ, зогдорын ургасан байрлал, хэлбэр зэрэг юм.

Хос зогдорт тэмээний нэгжийн ноосны гарц нэг наст тэмээнийх дунджаар 3600-3700 гр, хоёр настных 4600-4700 гр, гурван настных 5200-5500 гр, дөрвөн настных 5600-5800 гр, атных 7700 гр, ингэнийх 5960 гр, буурных 12500 грамм байна. Энэ нь жирийн тэмээнийхээс 122-1953 грамм буюу 0.1-3.2 хувиар илүү гэсэн үг бөгөөд эр, эм ноосны аль алиных нь гарц илүү байгаа юм.

Хос зогдорт тэмээний ноос технологи чанараараа жирийн тэмээнийхтэй ойролцоо байна. Харин хоёр омгийн тэмээний ноосны уртаас 91.6-105.0 мм-ээр богино, нарийнаас нь 2.2-3.0 мкм-ээр бүдүүн байна. Зөвхөн хос зогдрын гарц 1137.0+0.43(170-2500) грамм байна.

**Дүгнэлт:** Хос зогдорт тэмээний ноосны гарц, чанар илүү байгаа учраас өсгөн үржүүлэхэд илүүтэй анхаарах нь эдийн засгийн хувьд үр ашигтай байна. Энэ талаар уг бүтээлд онолын судалгаа хийж, дүгнэлт өгсөн байна.

## 0011

Цэвэгмид Г.

### Монгол адуу

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2000. БСШУЯ, УБТДС. 405 хууд. Монгол.*

Уг бүтээл нь үндсэн 6 хэсэгтэй бөгөөд монгол адууны биологи, судалсан байдал, морины шинж, уяа сойлго хийх, монгол адууны омог, үүлдрийн тойм, адууг анагаах монгол аргууд, адуунд тохиолддог нийтлэг өвчнүүдийн талаар оруулсан байна.

**Дүгнэлт:** Нүүдэлчин монголчуудын эрхэлж ирсэн мал аж ахуйн нэг бүрэлдэхүүн хэсэг болох адууны аж ахуйн онцлог, үүсэл, омог үүлдэр, хурдан морины шинж зэргээс гадна янз бүрийн өвчнүүдийг анагаах аргуудыг тусгасан, монгол адууны талаар болон монголчуудын талаар цогц ойлголт өгөхөөр бүтээл болжээ.

## 0012

Дагвийхорол В. бусад.

### Монгол сарлаг

*Төслийн тайлан. УБ, 2000. МААЭШХ-ийн Өндөр уулын бүсийн салбар. 53 хууд. Монгол.*

Энэхүү төслийн судалгаанд монгол сарлагийн ашиг шимийг нэмэгдүүлэх арга, сарлагийн өсвөр бүх бойжуулах арга, сарлагийн үнээнд зохиомол хээлтүүлэг хийх аргачлал, Хангайн өндөр уулын бүсийн бэлчээрийг тордож сайжруулах арга, бэлчээр ашиглалт, түүний төлөв байдлын аргачлал зэргийг хамруулж судалжээ.

Хангай, Хөвсгөл, Алтайн уулархаг нутагт сарлагийн аж ахуй эрхлэлт, байгаль экологийн нөхцлөөс хамаарч харилцан адилгүй байна. Хангайн уулархаг нутагт сарлагийн аж ахуй нийгэм, эдийн засаг, байгалийн тэнцвэрийг хадгалсан, хувийн аж ахуйтнуудын амьжиргааны үндсэн мал болж байна.

Зах зээлийн өнөөгийн нөхцөлд нэг өрх аймаар сарлагийн аж ахуйн үйлдвэрлэл явуулах боломж хязгаарлагдмал, гагцхүү хот айлын хэлбэрт шилжсэн хандлага бий болсон. Нэг өрхөд дунджаар 76 толгой (40-100) үхэртэй буюу сүргийн дотор эр үхэр 15 (19.7%), үнээ 28 (38%), өсвөр үхэр 33 (43.3%) байх шинжтэй байна.

**Дүгнэлт:** Нэг хот айлд 3 өрх байх тохиромжтой. Хувийн аж ахуйтнууд сарлагаас өсвөр насны бүх сонгон бойжуулахдаа эцэг, эхийн гарваль, бие цогцос, амьдын жин, сүүний гарц, анги, зүсийг харгалзан үзэх шаардлагатай. Бухан бярууны эцгийн амьдын дундаж жин 405.1+-3.5 кг, эхийн амьдын дундаж жин 311+-2.9 кг, саалийн эрчимтэй үед хоногт 2.45+-0.8 литр саам өгч байна.

## 0013

Бат-Эрдэнэ Т.

### Монгол үүлдрийн сарлаг

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2002. ХААНС. 135 хууд. Монгол.*

Сарлаг нь Монголын уул, ойт хээрийн бүс зонхилсон 13 аймаг, 130 гаруй сумдад тархсан бөгөөд Архангай аймаг 100.6, Хөвсгөл аймаг 98.5, Баянхонгор 79.0, Завхан 74.9, Өвөрхангай 68.3 мянган сарлаг, хайнагтай байгаа нь бүх сарлаг, хайнагийн 71.3 хувийг эзэлж байна.

Сарлагийн аж ахуйгаас одоогийн байдлаар улсын хэмжээгээр 26.6 мянган тонн амьдын жинтэй тэнцэх мах үйлдвэрлэж байгаа нь жилд үйлдвэрлэж буй бүх махны 5.7%, үхрийн махны 18.1%-ийг эзэлж байна. Улсын хэмжээгээр 35 сая литр сүү сарлагаас сааж байгаа нь улсын хэмжээний бүх сүү үйлдвэрлэлийн 12.1%, үнээний сүүний 14% нь болно.

Монгол сарлагаас сүргийн дунджаар 400-450 грамм хөөвөр, 600 грамм (сүүл, саваг) хялгас авч байгаа нь жилд 354.5 тн хялгас, 250 тн хөөвөр ашиглах бололцоотой гэсэн үг юм. Мөн сарлагийг унах, 120-150 кг ачаа ачих, тэргэнд хөллөн 150-200 кг буюу амьдын жингийн 1/3-1/4-тэй тэнцэх ачаа тээх зэргээр ялангуяа бартаатай замд тээврийн хэрэгсэл болгон ашигладаг. Дээрхээс үзвэл монгол сарлаг нь хөдөө аж ахуйн төдийгүй улс ардын аж ахуйн чухал ач холбогдолтой бөгөөд нөхөн үйлдвэрлэл, ашиг шимийн чадавхиараа эдийн засгийн өндөр үр ашиг бүхий бие даасан үүлдэр мөн болох нь батлагдаж байна.

**Дүгнэлт:** Монгол Улсын эрс тэс уур амьсгалтай байгаль орчны нөхцөлд гойд зохицсон монгол сарлагийн талаар бичсэн түс судлаачийн нэг сэдэвт бүтээл нь монголын бэлчээрийн мал аж ахуйн талаархи бүтээлүүдийн дотор үнэтэй байр суурь эзэлнэ гэж бодож байна.

## 0014

Цэгмид М.

### Үнээний сүүн ашиг шимийг нэмэгдүүлэх боломж

*Эрдэм шинжилгээний бүтээл №28. Өгүүлэл. УБ, 1998. ХААНС. 15-17 хууд. Монгол.*

Монгол орны ойт хээрийн бүсийн байгаль, цаг уур, уур амьсгал, бэлчээрийн маллагааны нөхцөлд шинээр бий болсон хосолмол ашиг шимт эрлийз үхрийг арчлан маллах, ашиг шимийг нэмэгдүүлэх гол арга бол үнээг хайдагшуулан саах технологи юм. Эрлийз үнээг хайдагшуулан сааснаар нэг үнээнээс ашиглах таваарын сүүний хэмжээ 18.7-28.0 хувиар, мөн сүүний тослог, амьдын жин зэрэг бусад үзүүлэлтүүд нэмэгдэх байдал ажиглагдаж, саальчны хөдөлмөрлөх нөхцөл хөнгөвчлөгдөж байгаа нь үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд үр дүнгээ өгөх бололцоотой гэж үзсэн байна.

**Дүгнэлт:** Судлаач Монгол улсад үржүүлж буй алатау-монголын эрлийз үнээн дээр туршилт-судалгааны ажил явуулсны үндсэн дээр үнээний сүүг нэмэгдүүлэх технологийг санал болгосон байна. Энэ технологийг хэрэгжүүлснээр сүүний үхрийн аж ахуйн ашиг шим нэмэгдэх бололцоотойг тогтоосон байна.

## 0015

Энхболор Б., Цэгмид М.

### Сэлэнгэ үүлдрийн үнээний сүүний гарц

*"Мал аж ахуйн шинжлэл" товхимол. №5. УБ, 2003. 53-56 хууд. Монгол.*

Өрхийн аж ахуйд Сэлэнгэ үүлдрийн нэг үнээнээс жилд дунджаар 3.57%-ийн тослогтой 660-аад литр сүү буюу 20-иод кг цэцгийн тос, бусад цагаан идээ үйлдвэрлэх боломжтой байна.

Сэлэнгэ үүлдрийн үнээний сүүний гарц нутгийн шилмэл монгол үнээнийхтэй ойролцоо байна.

Хагас эхлээр аргаар бойжсон Сэлэнгэ үүлдрийн тугалын 6 сартай үеийн жин дунджаар 148 кг жинд хүрч, эхлээр бойжсон тугалаас 25-39 кг жингээр бага байна.

**Дүгнэлт:** Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн үхрийг цөөн тоогоор өсгөн үржүүлдэг өрхийн аж ахуйн нөхцөлд тугалын хэвийн өсөлтийг саатуулахгүйгээр үнээг саалинд ашиглах боломжтойг судалгаагаар тогтоожээ.

## 0016

Самбуу Г.

### Монгол хонины ашиг шимийн удамшилт, селекцийн ялгавар, үр ашиг

*“Мал аж ахуйн шинжлэл” товхимол. №5. УБ, 2003. 6-10 хууд. Монгол.*

Монгол хонины зарим ашиг шимийн удамшилтийг тодорхойлоход амьдын жингийн хувьд ( $h^2=0.4$ ) сул, ноосны уртаар ( $h^2=0.3$ ) дунд зэргийн илрэлтэй байна. Шилмэл хэсгийн ашиг шим сүргийн дунджаас амьдын жин 5 кг, ноосны гарцаар 80 грамм, ноосны урт 1.5 см илүү байсан ба энэ чанараар селекци явуулахад амьдын жингээр 2.5 үе, ноосны гарцаар 5 үе, ноосны уртаар 3.3 үе авсны дараа сүргийн дундаж үзүүлэлт шилмэл хэсгийн ашиг шимд хүрэх онолын тооцоог судлаач гаргажээ. Үг үр дүнд хүрэх селекцийн ажилд 10-20 жил шаардагдана.

Монгол улсад хонины 12 үүлдэр, үүлдрийн хэсэг, 3 үржлийн хэсэг, 4 омгийн хонь үржүүлдэг. Эдгээр хонийг дотор нь цэврээр үржүүлж ашиг шим удамшлын чанарыг батжуулахад тухайн хонины удамшлын коэффициент, селекцийн ялгавар, үр ашгийг тодорхойлох шаардлагатай бөгөөд Орхон хонинд дээрхи үзүүлэлтүүдийг тодорхойлсон байна.

**Дүгнэлт:** Монгол хонины ашиг шимийн удамшилт чанар, түүний үр ашгийг малын талаас нь дүгнэсэн бүтээл болжээ.

## 0017

Гончигжав З.

### Монгол хонь

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2000. 303 хууд. Монгол.*

Үг бүтээлд Монгол орны уур амьсгал бэлчээрийн мал маллагаанд хэрхэн нөлөөлдөг, цаг агаарыг урьдчилан шинжих уламжлалт арга, бэлчээр, түүний ургамал, монгол хонины гарал, биологи, физиологийн онцлог, өсөлт хөгжилт, ашиг шим, үүлдэр омог, хонин сүрэгт холбогдох зан үйл, ерөөл магтаал зэргийг багтаасан байна. Улирлын нөхцөлд тохирох хариулга маллагааны онцлог, технологи зэргийг нүүдэлчин ард түмний олон жилийн туршлагыг үндэслэн тусгажээ.

**Дүгнэлт:** Олон зуун жилийн турш нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн монголчуудын таван хошуу малын нэг хонин сүргийн маллагааны онцлог шинжүүдийг тодорхой тусгаснаараа ач холбогдолтой бүтээл юм. Хонины аж ахуйд холбогдох ахуй амьдралын бүхий л хүчин зүйлүүдийг нарийвчлан гаргасан нь бас чухал юм.



## 1040 Малчдын амьжиргааны түвшин, нийгмийн асуудлууд

0018

Авдай Ч.

### Жижиг үйлдвэр байгуулах замаар малчдын амьжиргааны түвшинг дээшлүүлэх

*"Nomadic Studies" сэтгүүл, №04. Өгүүлэл. УБ, 2002. НСИСОУХ. 131-134 хууд. Монгол.*

Малын ноос, арьс, нэхийний зонхилох хэсэг нь ямар ч боловсруулалтгүйгээр гадаадад гарч, зах зээлээс алслагдсан сумдын хөдөлмөрчид энэхүү үнэт түүхий эдийнхээ нэлээд хэсгийг ашиглахгүй хаяж, үрэгдүүлж байгаа болон мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах уламжлалт технологи, хөдөлмөр хөнгөвчлөх машин төхөөрөмж бий болж, малчдыг хамарсан эсгий эдлэл хийх, арьс шир боловсруулах, тариа ногоо тариалах, сүү, мах ашиглах жижиг үйлдвэрийн эх суурь хэд хэдэн аймаг, суманд эхлэн тавигдаж, үр дүнгээ өгч эхэлснийг дурьджээ.

**Дүгнэлт:** Нэгэнт өөрийн гарын дор түүхий эд боловсруулах үндэсний ба орчин үеийн технологийн сан бий болсон учраас малчдын хүчээр жижиг, дунд үйлдвэрүүд байгуулан ажиллуулбал тэдний амьдралын түвшин, нөхцөл дээшлэх боломж бүрдэнэ гэжээ.

0019

Адъяа Ю.

### Малчин өрхийн аж ахуйн төрх, эрэлт хэрэгцээний өнөөгийн байдал

*"Монголын эдийн засаг: өчигдөр, өнөөдөр, маргааш" сэтгүүл, №1. Өгүүлэл. УБ, 1997. СЭЗДС. 38-42 хууд. Монгол.*

Малчдын амьжиргааны түвшний талаархи энэ судалгаанд судлаач 4 бүсийн 9 аймгийн 11 сумын малчдыг хамруулжээ. Малчдыг зах зээлтэй холбох бүтээгдэхүүн борлуулалтын зохистой сүлжээг бүрдүүлэх шаардлагыг судалж, дунд зэргийн амьдралтай айл өрх малынхаа тоог өсгөхийг эрмэлзэж, баян чинээлэг айлын хэмжээнд хүрэхийн төлөө тэмүүлж байгааг тогтоосон байна. Үүнээс үндэслэн чинээлэг малчин өрхөд аж ахуйн нэгжийн эрх олгох, олон малтай малчдад хөлсний ажилчин авч ажиллуулах эрх зүйн тогтолцоог бий болгох шаардлага гарсныг судалжээ. Энэ шаардлагыг хэрэгжүүлбэл өрхийн аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөөд дэд бүтэц хөгжүүлэхэд ч хөшүүрэг болно гэж судлаач үзжээ.

Хөдөөгийн малчин өрхийн эрэлт, хэрэгцээнээс үзэхэд бэлчээрийн мал аж ахуйг одоогийн технологи, ажиллах хүч, капитал ашиглалтын нөхцлөөр цаашид хөгжүүлэх, хүн амын соёл иргэншлийн асуудлыг шийдвэрлэх бололцоогүй байна. Иймд өнөөгийн малчин өрхийг зөвхөн хэрэглээний шинжтэй хэвшлээс ангижруулах арга замыг олж, төвийн болон орон нутгийн бодлого, дэмжлэг, эдийн засгийн механизмыг боловсруулах явдал чухал гэж үзсэн байна.

**Дүгнэлт:** Судалгаанд хамрагдсан өрхүүдийн орлого, зарлагын бүтэц, бүтээмж зэргийг тодорхойлсны үндсэн дээр малчдын амьжиргааг дээшлүүлэх санал дэвшүүлснээрээ тус бүтээл онцлог болжээ.

0020

Амархүү О.

### Малчны хүний эрхийн асуудал

*"Nomadic Studies" сэтгүүл, №04. Өгүүлэл. УБ, 2002. НСИСОУХ. 106-110 хууд. Монгол.*

Малчдын хүний эрхийн, ялангуяа эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн төлөв байдалд өөрчлөлт хийж, байдлыг сайжруулах шаардлагатай гэж судлаач үзжээ. Үүнтэй холбогдуулан малчдын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн судалгааг Засгийн газрын ивээл дор зориуд тусгайлан хийх, улмаар НҮБ-ын болон хүний

эрхийн төрөлжсөн байгууллагад хандаж дэмжлэг туслалцаа авах, Монгол Улс “Нүүдэлч малчдын эрхийг хамгаалах тухай конвенц” санаачлан батлуулах зэрэг санал дэвшүүлсэн байна.

Засгийн газрын НҮБ-д тайлагнадаг “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын тухай” илтгэлд малчдын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаар тусгайлан тусган оруулж байх, НҮБ-ын Хүний эрхийн комиссоос 1995-2004 оныг Хүний эрхийн боловсролыг дэмжих 10 жил болгон зарласан ажлын хүрээнд малчдад хүний эрхийн боловсрол олгох сургалтыг тасралтгүй, шаталсан хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээ авах шаардлагатай гэж үзжээ.

**Дүгнэлт:** Малчдыг үйлдвэржсэн, эрчимжсэн, хамтын хөдөлмөрт тулгуурласан, фермерийн гэж томъёологддог хоршоололд хамруулах ажлыг сайн дурын үндсэн дээр төр, засгийн ивээл, нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулах, малчдын эрхийг хамгаалах төрийн бус байгууллага байгуулан ажиллуулах санал санаачлага гаргаж өрнүүлэх асуудал ч тулгамдсан хэрэгцээ болж байгааг анхааралдаа авах нь зүйтэй гэжээ.

## 0021

Баасандаш Д.

### Малчин өрхийн амьжиргааны түвшинг өөрсдийнх нь үнэлэмжээр судалсан дүн

Эрдмийн бичиг, №1. Өгүүлэл. УБ, 1998. ХААНС. 60-66 хууд. Монгол.

Харилцан адилгүй нөхцөлд аж ахуйгаа бие даан эрхэлсэн бүхий л хугацааны туршид янз бүрийн өрхийн амьжиргааны түвшин хэрхэн өөрчлөгдөж ирсэн чиг хандлагыг өөрсдөөр нь дүрслүүлэн зураглаж авсан ба тэдгээрийг нэгтгэн (1945 оныг суурь үзүүлэлт болгон) дундаж үзүүлэлт гаргаж, графикаар харуулсан байна. Тэгэхдээ 1945-1960, 1960-1980, 1980-1990, 1990 оноос хойшхи гэж 4 үед хувааж дүгнэлт хийжээ.

**Дүгнэлт:** 1990 оноос хойш малчид малаа өмчилсөн боловч тоо нь цөөн, зах зээлээс алслагдмал, хэрэглээний бүтээгдэхүүний үнэ өссөн, орлогоороо зарлагаа нөхөж чадахгүй байгаа учир амьжиргааны түвшин доошлох, ялгаа зааг нь ихсэх хандлагатай болсон байна гэж дүгнэжээ.

## 0022

Бат-Эрдэнэ Ц.

### Малчдын дунд явуулсан социологийн судалгаа

Эрдмийн бичиг, №1. Өгүүлэл. УБ, 1998. ХААНС, Эдийн засгийн факультет. 66-69 хууд. Монгол.

Хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс байгаль-эдийн засгийн янз бүрийн бүсэд багтах 13 аймаг, 23 сумын 86 малчин өрхийг хамруулан малчдын мал хөрөнгө, ахуй амьдрал, орлого, зарлага, хэрэглээ, зах зээлд хэрхэн шилжиж буй байдал зэрэгт 1996-1997 онд хийсэн судалгааны дүнг энэ өгүүлэлд тусгасан байна.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 18.6% нь 50 хүртэлх толгой малтай, 16.3% нь 51-100, 45.3% нь 101-300, 19.8% нь 301-ээс дээш толгой малтай байсан нь Монголын малчин өрхийн өнөөгийн дүр төрхийг харуулж байна.

Судалгааны дүнгээс үзэхэд малчдын сарын орлого нь хэрэглээнийхээ 60%-ийг хангадаг, орлого нэмэгдэхгүй байгаа нь зах зээлээс хол, түүхий эдийн үнэ хямд, бэлэн мөнгө дутагдалтай зэргээс шалтгаалдгийг дурьджээ.

Малчдын 10.7% нь радио, телевизээс, 75.0% нь явуулын хүмүүс, радиогоос, 14.3% нь зөвхөн явуулын хүмүүсээс тус тус мэдээллээ авдаг байна.

**Дүгнэлт:** Хэдэн малтай бол амьдралд тань хүрэлцэх вэ? гэдэг асуултад малчдын 41.9% нь 201-400, 45.3% нь 401-ээс дээш толгой гэсэн бол төрийн зүгээс арга хэмжээ авбал зохих зам харилцааг сайжруулах,

тээврийн зардлыг хямдруулах, цахилгаанжуулах, ажлын байр бий болгох, малжуулах, бүсчлэн хөгжүүлэх гэх мэт олон асуудлыг бүртгэж дүгнэлт хийсэн байна.

## 0023

Кит Гриффин

### Монголын ядуурал ба зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт

Судалгааны тайлан. УБ, 1995. НҮБХХ. Англи.

Хөдөөд ядуурал харьцангуй их, малчин өрхийн 59 хувь нь ядуу, 19 хувь нь нэн ядуу өрхийн тоонд орж байна. Малчдын байгууллага бий болгох, бэлчээр ашиглалт, маркетинг, зээл зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай бөгөөд энэ нь их хэмжээний хөрөнгө шаардана. Асуудлыг шийдвэрлэхийн тулд хөдөөг хөгжүүлэх, ялангуяа дэд бүтцийг хөгжүүлэх хэрэгтэй.

Жижиг үйлдвэрлэлийг урамшуулах, ялангуяа баг, сүм, аймгийн түвшинд мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр байгуулах нь чухал.

Төрийн бус байгууллагууд нь Ядуурлыг бууруулах үндэсний зөвлөлтэй хамтран гол үүрэг гүйцэтгэх болно. Аймаг бүрт ядуурлыг бууруулах орон нутгийн зөвлөлийг байгуулж, эрх баригчидтай хамтран орон нутагт төсөл хэрэгжүүлэх хэрэгтэй.

**Дүгнэлт:** Гадаадын хандивлагчид ядуурлыг бууруулах 5 жилийн хөтөлбөрт бодит хувь нэмрээ оруулсан. Тэд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах санд санхүүгийн дэмжлэг үзүүлж, 1-3 аймагт хөдөөгийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж санхүүжүүлсэн. Мөн боловсрол, эрүүлийг хамгаалах салбарт тусалж байна. Хандивлагчид үйл ажиллагаагаа үр дүнтэй, бодитой болгохын тулд эрчимтэй явуулах хэрэгтэй гэж судлаач үзжээ.

## 0024

Робин Мийрнс, Дуламдарь Э.

### Монгол орны хөдөөгийн аж амьдралыг дэмжих нь

Төслийн тайлан, УБ, 2000. Дэлхийн банк. 37 хууд. Англи.

1990-ээд он хүртэл оршин тогтнож байсан социализмын үед Монгол Улсын хүний хөгжлийн үзүүлэлтүүдэд илэрхий ахиц гарч амжилт олж байсан бөгөөд ядуурал гэдэг ойлголт байхгүй байв. Хөдөөгийн иргэд, малчдад төвөөс үзүүлэх үйлчилгээг оновчтой зөв зохион байгуулж байсны дүнд тэднийг эрүүл мэндийн анхдагч тусламж үйлчилгээнд бараг бүрэн хамруулж, насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын түвшинг 97%-д хүргэж чадсан байжээ.

1990-ээд онд эхэлсэн улс төрийн болоод эдийн засгийн өөрчлөлт, шилжилт нь хүмүүсийн дунд өмч хөрөнгө, орлогын ялгааг богино хугацаанд хурдан өсгөснөөр 1995 он гэхэд нийт хүн амын 1/3-нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур, ядуурлын байдалтай амьдарч байна гэж тодорхойлогджээ. Улсын мэдэлд байсан үйлдвэрлэлийн салбар уналтанд орсноор ажил орлогын эх үүсвэргүй болсон ажиллах хүчний нэг хэсэг нь хөдөө орон нутагт мал аж ахуйд шилжиж, нөгөө хэсэг нь том хотуудад өсөн нэмэгдэж буй далд эдийн засгийн секторт шилжив.

Ийнхүү хөдөөнөөс төв рүү урсдаг шилжилт хөдөлгөөн гэнэт эсрэг чиглэлтэй болсноор 1992-1997 онд нийт малчин өрхийн тоог 2 дахин өсгөсөн бөгөөд өнөөгийн байдлаар Монголын түүхэнд хамгийн их буюу нийт хүн амын бараг тал хувь нь хөдөө орон нутагт мал аж ахуй эрхлэн амьдарч байна гэсэн тооцоо хийжээ.

Ийм нөхцөл байдалд хөдөөгийн нийгмийн тогтвортой хөгжлийг хангах нь үндэсний эдийн засгийг хөгжүүлэх нэг гол түлхэц болох ёстой. Энэхүү чиглэлээр эдийн засгийн орчин хурдацтайгаар өөрчлөгдөж байгаа өнөөгийн

нөхцөлд хүмүүсийн аж амьдралын ялгаа, ядуурал ямар байгааг тогтоох зорилго бүхий нийт улс орны хэмжээнд хийсэн үнэлгээний ажлын үр дүнг урьдчилсан байдлаар уг бүтээлээр танилцуулжээ.

**Дүгнэлт:** “Тогтвортой амьжиргааг” хангахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлснээр, нэг талаар бага орлоготой бөгөөд ядуу иргэдэд өөрийн нөөц чадавхийг бий болгох, дээшлүүлэх, байгаль, нийгмийн баялагаас зохих ёсоор хүртэх гарц олгох, нөгөө талаар ядуу, бага орлоготой өрхүүдэд учирч буй эрсдэл, бэрхшээлийг бууруулах асуудлыг хяналтдаа авах стратегийн ач холбогдолд гол анхаарлаа хандуулах нь зүйтэй гэсэн санаа дэвшүүлжээ.

## 0025

Сонгино Ч.

### Монголын нүүдэлчдийн орон сууцны түүхэн хөгжил

“Nomadism-International Study” товхимол. Өгүүлэл. УБ, 2002. НСИСОУХ. 141-143 хууд. Англи, Монгол.

Бидний өлгий нутагт ухаант хүний өвөг дээдэс мэндэлж, амьдралын эх сурвалж болсон ан амьтанг гаршуулж, улмаар малынхаа аясаар нутаг бэлчээр сонгон нүүдэллэн аж төрдөг болохдоо ахуй амьдралын хэрэгцээт орон сууц, хувцас эдлэлийг нүүдэлчнийхээ онцлогт тохируулан урлан бүтээж иржээ. Энэ нь нийгэм дэвшин хөгжихөд шийдвэрлэх үүргийг гүйцэтгэж ирсэн билээ. Эдгээрийн дотроос нийтийн орон сууцны тухай нарийвчлан судалж үзвэл орон сууцны асуудал гэнэт гарч ирсэнгүй эгэл жирийн хэлбэрээс орчин үеийн соёлт ертөнцийн хүний ахуй амьдрал, гоо зүйн таашаалд нийцсэн сууц, уран барилга, хот суурин сүндэрлэн босох хүртэл хөгжүүлж ирсэн нь түүхийн урт удаан хугацааг хамарчээ. Судлаач Төв Ази болон нийт нүүдэлчдийн сэдэн бүтээж, боловсронгуй болгож ирсэн оромж сууцуудыг гарал үүсэл, түүхэн хөгжлөөр нь байгалийн жамаар бий болсон оромжид хоргодож байсан үе, хүний гараар бий болсон орон сууцны анхны хэлбэрүүд, орон сууц боловсронгуй болсон үе, бусад хүзүүт гэрийн үе, орчин үеийн гэр сууц гэж дэвшил хөгжлийн үе шатаар тус тус ангилжээ.

**Дүгнэлт:** Орчин үеийн гэр сууцны гарал үүсэл нь урц, овоохойноос улбаатай бөгөөд тэр цагаас тодорхой үеийг дамжин боловсронгуй болж хөгжиж иржээ. Түүнчлэн гэртэй салшгүй холбоо бүхий гал голомтын үүсэл, хөгжил, байршил, гэрийн дотор тавилгын түүхэн дэвшил, хөгжил нүүдэлчдийн онцлогт нийцсэн хэм хэмжээний талаар энэхүү бүтээлд өгүүлжээ.

## 0026

Мухар Ц.

### Нүүдэлчдийн эрүүл мэндийн зарим асуудлууд

“Dialogue among Civilizations: Interaction between Nomadic and Other Cultures of Central Asia” товхимол. Өгүүлэл. УБ, 2001. НСИСОУХ. 307 хууд. Англи.

Монгол Улс өнөө хүртэл нүүдлийн соёл иргэншлээ хадгалсаар ирсэн билээ. Хөгжил эрчимжихийн хэрээр нүүдэлчид суурин болон нүүдлийн амьдралын аль алинд нь таарч тохирох нийгэм-соёлын шинэ хэв маягийг эрэлхийлэх болсон. 2000 онд Монголын хүн амын 58.6 хувь нь хот суурин газарт, 41.4 хувь нь хөдөө амьдарч байжээ. Өнөөдөр 110 мянга орчим малчин өрхийн хагас сая орчим хүн хөдөө орон нутагт ажиллаж амьдарч байна. Тэд уламжлалт мал аж ахуйг эрхэлж байна. Гэвч сүүлийн жилүүдэд эрүүл бус амьдралын хэв маяг, мөн зан суртахууны доройтол, байгаль орчны бохирдол зэрэг сөрөг нөлөөлөл газар авч хүмүүсийн ёс суртахуун, эрүүл мэндэд нөлөөлөх болов.

Тамхины импорт 10-15 дахин өслөө. Судалгаанаас үзвэл 1987 оны байдлаар малчин эрэгтэйчүүдийн 76.9%, эмэгтэйчүүдийн 29.1 хувь нь тамхи татдаг, эрэгтэйчүүдийн 40-өөс дээш хувь нь архи хэрэглэж байжээ. Түүнчлэн 1999 оны байдлаар малчдын 12.1 хувь нь цусны даралт хэт ихэсдэг өвчтэй ба 7.5 хувь нь зүрхний шигдээсээр өвчилсөн байна.

**Дүгнэлт:** Сүүлийн арван жилд малчдын өвчлөл буурахгүй байгаа нь хөдөө орон нутагт хүн амын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, чанартай, хөнгөн шуурхай болгохын чухлыг харуулж байна. Ялангуяа, бруцеллёз, цагаан хорхой зэрэг малын гаралтай халдварт өвчнөөр өвчлөх явдал нүүдэлчдийн амьдралын нөхцөлтэй холбоотойгоор өсөх хандлагатай байна гэсэн дүгнэлт хийжээ.

## 1050 Мал аж ахуй дахь эрсдэл, экологийн асуудал

0027

Батбуян Б.

### Төв Азийн бэлчээрийн малын экологийн зохистой нутаг

*“Culture and Environment in Inner Asia:1-The Pastoral Economy and The Environment” товхимол. Их Британи, 1996. 198-207 хууд. Англи.*

Төв Азийн эрс тэс байгалийн нөхцөлд зохицсон бэлчээрийн мал аж ахуй нь тус бүс нутгийн малчдын эдийн засгийн үндэс юм.

Төв Азийн байгалийн нөхцөл, нөөц, түүнийг малчид уламжлалт нүүдлээр хэрхэн ашиглаж байсан түүхэн туршлага, малчдын нүүдлийн одоогийн байдал, чиглэл, зай, тоо зэргийг үндсэн үзүүлэлт болгон бусад туслах үзүүлэлттэй харьцуулан дүн шинжилгээ хийсэн байна.

**Дүгнэлт:** Энэ судалгаагаар бэлчээрийн мал аж ахуйн экологийн зохистой нутгийн гурван хэв шинж, зургаан дэд хэв шинжийг ялган тогтоосон байна.

0028

Батжаргал З.

### Монгол дахь цөлжилт

*“Rala report” товхимол. №200. Исланд, 1997. Хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний хурээлэн. 107-113 хууд. Англи.*

Говь, хээрийн бүсийн цөлжилтөд мал аж ахуйн үйл ажиллагаа нөлөөлөгч хүчин зүйлийн нэг болсоор байна. Түүний нэг үр дагавар бол хөрсний элэгдэл юм. Бэлчээрийн даац хэтэрснээс ургамлын төрөл зүйл доройтож, хөрс нүцгэрэхэд хүргэж байна.

Монголын газар нутгийн тал хувь нь элэгдлийн тодорхой зэрэглэлд орсон байна гэж судлаач үзжээ. Ургамал тариалах нь цөлжилт, хөрсний элэгдлийг зогсоох гол арга юм. Тариалах талбайн ихэнх нь мод эсвэл ойн зурвас байх нь зүйтэй гэж судлаач үзжээ.

**Дүгнэлт:** Монголын газар нутгийн зарим хэсгийг хамарч байгаа цөлжилт, түүнд хүргэж байгаа шалтгаануудын ихэнх нь мал аж ахуйн зохисгүй үйл ажиллагаанаас хамаарч байгааг цохон тэмдэглээд бэлчээрийн даацыг тохируулах нь цөлжилтийг багасгах, зогсооход тодорхой хэмжээгээр эерэг нөлөөлнө гэсэн дүгнэлт хийжээ.

0029

Баянмөнх П.

### Хөдөө аж ахуйн салбарын эрсдлийг бууруулах асуудалд

*“Мал аж ахуйн шинжлэл” товхимол, №5. УБ, 2003. ХААИС. 273-277 хууд. Монгол.*

Бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийг бууруулахад тэжээлийн аюулгүйн нөөц чухал ач холбогдолтой бөгөөд цаашид тэжээлийн аюулгүйн нөөцийн хэмжээ, байршлыг нэмэгдүүлэх, бүтцийг нь зохистой тогтоох нь чухал юм.

Улсын нөөцийн тэжээлийн бүтцийг өөрчилж, ойрын 3 жилд өвс, тэжээлийн бүтцийг 50:50 болгох, цаашид 30:70 хувь болгож үйлдвэрлэсэн тэжээлийн эзлэх хувийг өсгөх нь мал аж ахуйд учирч буй эрсдэлийг бууруулахад нааштайгаар нөлөөлнө гэж судлаач үзжээ.

**Дүгнэлт:** Улсын нөөцийн эрх зүйн орчинг боловсронгуй болгож, байршил, бүрдүүлэлтэд судалгаа, үндэслэлтэй хандах, улсын нөөцөд бүрдүүлэн хадгалж буй малын тэжээлийн бүтцийг өөрчлөх, удаан хадгалах технологи нэвтрүүлэх, тэжээлийн цэг салбаруудын менежментийг боловсронгуй болгох санал дэвшүүлсэн байна.

## 0030

Ганчимэг Г.

### Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл, түүний сөрөг нөлөөллөөс сэргийлэх

*Магистрын ажил. УБ, 2000. ХААНС, 99 хууд. Монгол.*

Гангийн давтагдалт хангайн сумуудаар 10 жилд 2-3 удаа тохиолддог байхад хээр, талын сумуудад 3 удаа тохиолдох магадлалтай байна. Улсын хэмжээнд бүхэлдээ зудархаг байсан жилүүдэд хээрийн бүсийн онцлогоос хамаарч зуд тохиолдох нь ховор байдаг ба 10-11 жилд их зудын давтагдалтай байна. Судалгаанаас үзэхэд 1980 оноос хойших жилүүдийн хавар бүр IV сарын 15-25-ны хооронд түр зуурын цаг агаарын хүндрэл бэрхшээл гардаг давтамжтай болжээ.

Иймд эрсдлийн сөрөг нөлөөллийг бууруулах сонгодог арга болох даатгал нэн чухал бөгөөд даатгалын хууль, эрх зүйн үндэс оновчтой бус, мал аж ахуйн онцлогоос шалтгаалж тухайн салбарт хэрэгжихгүй байна.

Зүй бус хорогдол, өвчнөөр хорогдсон малын тоо сүүлийн 10 жилд 80 хувиас буурахгүй байгаа нь өвчлөлтийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй байгааг харуулж байна гэж судлаач үзжээ.

**Дүгнэлт:** Даатгалын хууль гаргах, түүндээ малын даатгалыг заавал даатгах төрөлд хамруулах, даатгалын хураамжийг мал аж ахуйн гаралтай түүхий эдээр малчдад тохиромжтой үеэр нь авч байх санал дэвшүүлжээ.

## 0031

Индра Р., Энхбаатар Л.

### Малын зүй бус хорогдолд нарны идэвхжлийн нөлөөг судлах асуудалд

*Эрдэм шинжилгээний бүтээл, №28. ХААНС, УБ, 1998. 25-27 хууд. Монгол.*

Нийт том малын хорогдол дунджаар 3, 5, 10, 16 жил тутамд харьцангуй ихсэж байгааг ган, зуд, байгалийн гамшгийн давтамжтай холбоотой гэж үзжээ.

Ийм судалгааг аймаг тус бүрт гүнзгийрүүлэн хийх нь малын хорогдлыг тууштай бууруулах, гамшгийг прогнозчилох эдийн засгийн ач холбогдолтой гэсэн саналыг судлаачид дэвшүүлжээ.

**Дүгнэлт:** Монгол орны малын зүй бус хорогдлыг нарны идэвхжилийн нөлөө, экологийн байдал зэргээр аймаг тус бүрээр судалсан нь шинэлэг ажил болсон байна. Судлаачид уг бүтээлдээ малын хамгийн их зүй бусаар хорогдсон жилийн нарны идэвхжлийн нөлөөг судлаж, зүй бус хорогдолд нарны идэвхжил тодорхой нөлөө үзүүлдгийг тогтоожээ.

## 0032

Моёбуу Д.

### **Эдийн засгийн тогтвортой хөгжилд экологийн хямрал заналхийлж байна**

*Эрдэм шинжилгээний бүтээл, №31. Өгүүлэл. УБ, 2002. ХААИС. 121-125 хууд. Монгол.*

Дэлхийн олон оронд тохиож буй экологийн хямрал хөгжилд сөргөөр нөлөөлөх болжээ. Энэ үзэгдэл Монгол орныг тойрсонгүй. Монгол орны нийт нутгаар жилийн агаарын дундаж температур 0.7 хэмээр дулаарч, ган, зуд давтагдах нь ихэсч, хөрсний эвдрэл, бэлчээрийн талхагдал газар авах болжээ. Монгол орны ихэнхи нутгийн бэлчээрийн 15-20 хувь нь талхлагдсан байна. Ялангуяа хүн ам олноор төвлөрсөн хот, суурин орчмын бэлчээр хэт талхлагджээ.

**Дүгнэлт:** Монгол орны одоогийн хөгжилд экологи, эдийн засгийн асуудлыг дутуу анхаарч байгаагаас хойч үе маань асар их хохирол амсаж болзошгүй гэсэн дүгнэлт хийжээ.

Зохиогч байгалийн ба эдийн засгийн эрсдэл дааж чадах малчин өрхийн аж ахуйг төлөвшүүлэх зорилгоор малчны олон мянган жижиг аж ахуйг цөөрүүлж томруулах бүтцийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх санал дэвшүүлсэн байна.

## 0033

Туваансүрэн Г., Сангидансранжав С., Данзанням Б.

### **Бэлчээрийн мал аж ахуйн цаг уурын нөхцөл**

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 1996. Ус цаг уурын хүрээлэн. 121 хууд. Монгол.*

Монголын мал сүрэг жилийн дөрвөн улиралд байгаль цаг уурын байнгын нөлөөнд байдаг тул цаг агаарын огцом өөрчлөлт, эрс тэс уур амьсгал нь мал сүргийн тогтвортой өсөлтийг хангах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, түүний эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх явдалд багагүй бэрхшээл учруулдаг. Ус цаг уурын мэдээллийг мал аж ахуйн үйлдвэрлэлд улам ойртуулж, түүний үр ашгийг дээшлүүлэх, түүнчлэн мал маллагааны арга ажиллагааг шинжлэх ухааны зохих үндэслэл, аргатай хослуулан хөтлөх явдал чухал болж байна. Энэ зорилгын үүднээс сүүлийн жилүүдэд хийсэн мал аж ахуйн цаг уурын ашиглалт судалгааны мэдээ сэлтэд тулгуурлан таван хошуу малын хариулга маллагааг цаг агаарын байдалд зохицуулах шаардлагатайг энэхүү бүтээлд тусгажээ.

**Дүгнэлт:** Энэ бүтээлд мал аж ахуйд цаг агаарын нөлөөлөх асуудлыг судалж, мал аж ахуйн цаг уурын судалгааны эхний үе шатны үр дүнг толилуулсан байна.

## 0034

Туваансүрэн Г., Мижиддорж, Эрдэнэцогт Н.

### **Монголын мал аж ахуйн үйлдвэрлэлд цаг уурын үзүүлэх нөлөө**

*“Nomads and Use of Pastures Today” товхимол. Өгүүлэл. УБ, 2000. НСНСОУХ. 181-191 хууд. Англи.*

Бэлчээрийн мал аж ахуй нь цаг агаар, байгаль орчны хүчтэй нөлөөн дор байдаг. Сүүлийн жилүүдэд бэлчээрийн мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ихээхэн хэлбэлзэлтэй байна. Тухайлбал, газарзүйн байршлын онцлогоос хамаарч Монгол улсын хойд талаас өмнөд зүг рүү малын байршлыг судалж үзэхэд тоо толгой нь цөөрөх хандлага ажиглагдаж байна.

1998 онд 330.3 мянган тонн тэжээлийн нэгж малын тэжээл үйлдвэрлэсэн нь 1986-1990 онуудын дунджаас 3 дахин доогуур үзүүлэлт юм. Ийм хэмжээний тэжээл өвөл, хаврын цаг уурын тааламжгүй нөхцөлд хэрэгцээг бүрэн хангаж огт хүрэлцэхгүй байна.

**Дүгнэлт:** Бэлчээрийн мал аж ахуй нь зөвхөн бэлчээрийн өвс ургамлын гарцад түшиглэн үйлдвэрлэл явуулдаг онцлогтой, цаг уурын өөрчлөлт ихээхэн нөлөөлдөг учир таримал болон хадлан тэжээлийн нөөцийг бүрдүүлэх, хагас суурин мал маллагааны хэв загварт шилжих явдал чухал гэсэн санал дэвшүүлсэн байна.

## 0035

Тунгалаг Д.

### **Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зарим асуудал**

*Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ, 2001. МУИС, Эдийн засгийн сургууль. 178 хууд. Монгол.*

Судлаач Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах асуудлыг авч үзэхдээ мал аж ахуйн хөгжлийн байдалд шинжилгээ хийсэн байна.

Манай орны малчид байгалийн гамшгаас өөрийгөө бие даан хамгаалах чадваргүй, гэнэтийн аюул ослоос хамгаалах зах зээлийн нөхцөлд тохирсон тогтолцоо бүрэлдээгүйгээс өмнөх бэлэнчлэх сэтгэлгээнээсээ салж чадахгүй байна. Иймээс малчид байгаль, цаг уурын гэнэтийн гамшигт өртөж, ихээхэн хэмжээний гарз хохирол амсаж байна. Дэлхийн цаг уурын өөрчлөлтийн нөлөөгөөр манай оронд тохиолдох агаар мандлын гаралтай гамшигт үзэгдлүүдийн давтагдал ихэсч, эрч далайц нь нэмэгдэх боллоо. Сүүлийн 60 гаруй жилийн байдлаар манай оронд ган, зудтай жил 10-12 жилийн давтамжтайгаар байнга тохиолдож байжээ. 2000 оны зун манай орны ихэнхи нутагт хур бороо ороогүйн улмаас нийт нутгийн 60% гантай, 40% нь гандуу зуншсан ба ой хээрийн түймэр өмнөх оныхоос 3.2 дахин ихэсч, 5.1 сая га бэлчээр түймэрт шатаж, 6000 га талбай царцаанд идэгдэж, 20 сая га талбайд үлийн цагаан оготно тархснаас бэлчээрийн ургац муудан, мал сүрэг тарга тэвээрэг сайн авч чадалгүйгээр өвөлтэй золгосон юм.

Цас зуднаас шалтгаалан 1999 онд 2.1 сая, 2000 онд 3.5 сая толгой мал зүй бусаар хорогджээ.

**Дүгнэлт:** Монголд зудтай тэмцэх үндсэн хоёр арга зонхилж байна. Зудтай тэмцэж ирсэн уламжлалт аргын нэг нь зуд болсон нутгаас дайжин, нутаг сэлгэх явдал юм. Гэтэл малын тоо 30 саяас давж, бэлчээрийн хүрэлцээ хомсдох болсноор энэ арга нь төдий л үр дүнтэй болж чадахгүй байна. Харин зудын үед малыг тэжээх арга илүү үр нөлөөтэй учраас өвс тэжээлийн нөөцийг шаардлагын хэмжээнд хүртэл бэлтгэж байх нь чухал гэж судлаач дүгнэжээ.

## 0036

Эрдэнэбаатар Б., бусад

### **Төв Ази дахь гамшгаас сэргийлэх, бэлэн байхад чиглэгдсэн бэлчээрийн эрсдлийн менежментийн үйл ажиллагаа Монголын жишээн дээр**

*Хүнс, хөдөө аж ахуйн эрсдлээс сэргийлэх, хамгаалах, гамшигийн бэлэн байдлын чиглэлээр явагдсан Ази номхон далайн бүсийн бага хурал. Чиангмай, Тайланд, 2001. 06.12-15. Англи.*

Төв Азийн эдийн засагт бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл нь чухал үүрэгтэй. Гэвч энэ салбарын үйлдвэрлэл нь тогтворгүй, хэлбэлзэл ихтэй, хүрээлэн буй орчны болоод уламжлан тогтсон заншил, нийгэм-эдийн засгаас үүдэлтэй сөрөг нөлөөлөлд ихээр өртдөг. Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг малчдад учирдаг хамгийн тодорхой эрсдэл бол үе үе тохиолддог ган, зудын гамшиг юм. Үүний ойрын жишээ бол 1999-2001 оны өвөл Монголд тохиолдсон олон сая малын хорогдол хохирол учруулсан цас зудын их гамшиг. 1999-2000 оны өвөл 2370 гаруй малчин өрх огт малгүй болжээ. Арав хүрэхгүй толгой малтай айл өрхийн тоо даруй 10000 гаруйгаар нэмэгдсэн бөгөөд тэдний амьжиргаанд том аюул нүүрлэсэн юм. Хэдий тийм боловч Азийн нэлээд хэдэн орон гамшгаас сэргийлэх, эрсдлийг бууруулах, удирдах оновчтой бодлого, стратегийг боловсруулсан байна.



Энэхүү бүтээлд Дэлхийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагаас Монгол, БНХАУ, Киргиз улсуудад 1995 оноос эхлэн явуулж буй бэлчээрийн эрсдлийн менежментийн уламжлалт арга, хандлагын талаарх судалгааны дүнг нэгтгэн дүгнэсэн байна.

**Дүгнэлт:** Таван жилийн судалгааны үр дүн болон Монголын сүүлийн үеийн жишээн дээр тулгуурлан эрсдлийн менежментийн төлөвлөлтийг боловсронгуй болгох үзэл баримтлал, Төв Азийн бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийг үнэлэх зарчим, аргуудыг санал болгосон байна.

## 1060 Мал аж ахуйн эрчимжүүлэлт

0037

Дэвид Снийт

### Монголын мал аж ахуйн зохицуулалт

*“Зүүн Азийн хөгжлийн асуудлууд” олон улсын бага хуралд тавьсан илтгэл. Лондон, 1998. Англи.*

1990-ээд оны эхээр Монголын Засгийн газар хувийн өмчин дээр тулгуурласан зах зээлийн эдийн засагт шилжиж 5 жилийн дотор «Азийн бар» болно гэж байсан бөгөөд шинэчлэлийг өмч хувьчлалаар эхэлсэн. Гэвч бодит байдал дээр тэдний амьдралын түвшин доройтож, ажилгүйдэл нэмэгдсэн.

Нэгдлийн үед Монголын мах экспорт өндөр байсан бол энэ үед огцом буурсан, мөн «албаны мал» гэсэн ойлголт байсан бол өмч хувьчлалын дараа хүн бүр өөрийн гэсэн малтай болсон.

**Дүгнэлт:** Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнтэй холбогдуулан нэгдлийг тарааж, малыг хувьчилсан нь олон сөрөг үр дагаварыг бий болгосон.

Малчдын аж амьдралыг улам доройтуулсан. Өөрөөр хэлбэл барууны орнуудын эдийн засгийн шинэчлэлтэй харьцуулахад яг эсрэг байсныг дурьджээ.

0038

Айлтгүй Д.

### Махны үхрийн аж ахуй, мах үйлдвэрлэлийн хөгжлийн хэв шинж

*“Мал аж ахуйн шинжлэл” товхимол, №5. УБ, 2003. 47-52 хууд. Монгол.*

Дэлхийн хэмжээнд үхэр үржүүлдэг 200 гаруй улсын үхэр сүргийн тоо толгойн өсөлт, мах үйлдвэрлэл, экспорт, импортын хэмжээ, эрчимжилтийн төлөв байдлаас үзэхэд махны үхрийн аж ахуй, мах үйлдвэрлэлийн хөгжлийн түвшингээр нь эрчимтэй, эрчимт биш, тогтворгүй, зогсонги гэсэн 4 хэв шинжид хувааж болох юм.

Монгол улсын үхрийн аж ахуйн хөгжилт, мах үйлдвэрлэлийн сүүлийн 10 жилийн байдал, төлвөөс үзэхэд зарим үзүүлэлтээр эрчимтэй ба эрчимтэй биш хэв шинжийн үлсүүдтэй төстэйвтэр байгаа боловч ерөнхийд нь тогтворгүй хэв шинжид багтаж болох үндэслэлтэй байна.

**Дүгнэлт:** Махны үхрийн аж ахуйг эдийн засгийн үр ашигтай, эрчимжсэн чиглэлээр хөтлөн явуулах санал дэвшүүлжээ.

## 0039

Бизъяа Г.

### **Бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн хөдлөл зүй**

*Эрдэм шинжилгээний бичиг, №1. УБ, 1998. ХААНС. 29-38 хууд. Монгол.*

Монголын цөөнгүй малчид мал маллах арга мэддэг боловч зах зээлийн нөхцөлд зохицуулан бэлчээрийн мал аж ахуй эрхлэх арга ухааныг бүрэн эзэмшиж сураагүй, тэднийг зах зээлтэй холбоход нь түшиж тулах байгууллага байхгүй, удирдлага зохион байгуулалтын нэгдсэн үйл явц нь тодорхой тогтолцоонд ороогүй байна. Бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх системийг судалгаа шинжилгээ, туршилтын үндсэн дээр шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зах зээлийн нөхцөлд зохицуулан боловсруулах шаардлагатай гэж судлаач үзсэн байна.

**Дүгнэлт:** 1921 оноос хойших Монгол Улсын мал аж ахуйн хөгжил, мал аж ахуйгаас үйлдвэрлэж, экспортлож байсан бүтээгдэхүүний хэмжээ, нөлөөлж буй хүчин зүйлс, тохиолдож байсан зүд, хамарсан хүрээ зэргийг судалсны үндсэн дээр дүгнэлт хийсэн байна.

## 0040

Дашдондов Х.

### **Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн өнөөгийн байдалд өгсөн эдийн засгийн үнэлгээ**

*Зөвлөмж. УБ, 2002. ХААНС. 21 хууд. Монгол.*

Бэлчээрийн мал аж ахуйн фермерыг хөгжүүлэхэд тавих гол шаардлага бол хадлан, тэжээлийн найдвартай эх үүсвэртэй байх, зудын аюулд нэрвэгдэх магадлал бага байх явдал бөгөөд энэ шаардлагыг хангах бүс нутаг бол хангай, ойт хээр, хуурай хээрийн зарим хэсэг, дорнодын их талын хээр юм.

Фермерын аж ахуйн үндсэн шалгууруудыг хангаж байгаа малчин өрхийн тоо олноор нэмэгдэх төлөвтэй байна. Ийнхүү санхүүгийн чадавхи сайтай, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах, хуримтлал бий болгох чадвартай, мал аж ахуйгаа эрчимжүүлэх, түүний үүлдэр угсааг шилэн сонголтод анхаарал тавьдаг, малаа эрүүлжүүлэх чадвартай, хагас суурин хэлбэрийн фермер өрхийн тоо нэмэгдэх нь манай орны мал аж ахуйн ирээдүй гэж энэхүү зөвлөмжид үзжээ.

Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг фермер өрхүүд цаашид малын тооны хойноос хэт хөөцөлдөлтгүй, малын чанарт онцгой анхаарч, үүлдэр угсааг нь сайжруулах арга хэмжээ авах, цөөн малаас амьжиргаандаа хүрэлцэхүйц хэмжээний мөнгөн орлого олох явдлыг гол зорилт болгох ёстой. Үүний тулд нутгийн шилмэл үүлдэр, омгийн малаар одоо байгаа малынхаа чанарыг сайжруулж, нийт сүрэгт ашиг шим өндөртэй малын эзлэх хувийн жинг жил жилээр нэмэгдүүлснээр өндөр ашиг шимтэй малтай болох явдал чухал гэжээ.

**Дүгнэлт:** Малчид ган, зудын уршигт автахгүй байхын тулд аль болохоор хагас суурин байдлаар амьдрах арга барилд шилжиж, хоорондоо хөдөлмөрөө хоршин нэгдэж, отор-бэлчээрийн аргаар малаа маллах нь тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, үйлдвэрлэлээ эрчимжүүлж, хөдөлмөр хэмнэх замаар үйлдвэрлэлийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, ашиг орлогоо нэмэгдүүлэх, амьдрал ахуйн нөхцлөө сайжруулах боломж бүрдүүлнэ гэсэн зөвлөмж өгчээ.

## 0041

Логи Н.

### Тэмээн сүргийн тогтвортой өсөлтийг хангах арга зам

Эрдэм шинжилгээний бичиг, №30. Өгүүлэл. УБ, 2002. ХААНС. 108-112 хууд. Монгол.

Монголд дэлхийн хоёр бөхт нийт тэмээний 33.3 хувь нь байдаг. Харамсалтай нь тэмээний тоо сүүлийн жилүүдэд эрс буурч 1961 оны тооллогоор Монгол Улс 706.4 мянган тэмээтэй байсан бол 2001 оны эцсийн тооллогоор 322.9 мянга болсон буюу 2 гаруй дахин буурчээ.

Энэхүү судалгаагаар Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын 2001 оны эцэст тоологдсон 13446 тэмээний сүргийн бүтэц, нас, хүйсийн бүлэг тус бүрийн тооны хооронд байх зохистой харьцаа, нэг тэмээнээс ашиглах ноосны хэмжээг үндэслэн нийт тэмээнээс үйлдвэрлэх ноосны хэмжээг хамгийн их байлгах шалгуур бүхий сүргийн эргэлтийн эдийн засаг-математик загварыг боловсруулсан байна. Уг загвараар тэмээний тогтвортой өсөлтийг хангахын тулд сүргийн дотор өсвөр тэмээний эзлэх хувийн жин 34.5 хувь ба түүнээс дээш насны тэмээний эзлэх хувийн жин 47 хувь байвал зохистой гэсэн бүтцийг тогтоожээ.

**Дүгнэлт:** Судлаач тус улсын тэмээний аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд регресс, дисперсийн аргаар шинжилгээ хийжээ. Ингэхдээ сүүлийн 40 жилийн тоо мэдээнд тулгуурлан тэмээний зүй бус хорогдол, сүргийн бүтцэд ингэний эзлэх хувийн жин, 100 ингэ тутмаас бойжуулсан ботгоны тоо зэрэг хүчин зүйлс тэмээний тоо толгойн өсөлтөнд хэрхэн нөлөөлж байгаа зүй тогтлыг тогтооход анхаарлаа хандуулсан байна.

## 0042

Чагдаа Х.

### Монгол малчны амьдрахуйн ухаан

Нэг сэдэвт бүтээл. УБ, 2002. 343 хууд. Монгол.

Монгол нь нүүдлийн уламжлалт соёл иргэншилтэй орон бөгөөд одоогийн мал аж ахуй нь бэлчээрийн аж ахуй юм. Энэ нь жилийн дөрвөн улирлаар нутаг бэлчээрийг сэлгэн нутагладаг, бэлчээр нь аймаг, сум, багийн нутгийн тогтоосон хилээр хязгаарлагдаж байдаг.

Тодорхой нутаг усныхаа дотор улирлаар нутаг сонгон өвсний соргог, усны тунгалагт малаа хариулж, бэлчээрийн ургамлаар цатган, зун намарт нь тарга тэвээрэг авхуулж, тэр тарга хүчээр нь өвөл хаврын хатуу цагийг даван туулж онд оруулдаг мал маллагааны технологи юм.

Монгол орны нийт нутгийн 80 гаруй хувь нь малын бэлчээрт тохиромжтой бөгөөд олон арван төрлийн чанартай ургамалтай, мал аж ахуй эрхлэхэд нэн тохиромжтой. Мал аж ахуйг эрхлэн хөтлөх бэлчээрийн ба суурин хоёр хэлбэрийг манайд олон мянган жил эрхэлж ирсний дээр бэлчээрийн мал аж ахуй нь цаашдаа ч удаан хадгалагдах төлөвтэй.

**Дүгнэлт:** Сүүлийн жилүүдэд байгаль, цаг уурын байдал өөрчлөгдөж, ган, зудын давтамж ойртож, бэлчээрийн мал аж ахуйд бэрхшээл тулгарах нь их болов. Энэ үед мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэх, байгаль-экологийн орчныг хамгаалахад шинжлэх ухаанчаар хандаж, малчдын залуу үеийг сурган дадлагажуулж, тэдэнд уламжлалт арга ажиллагааг эзэмшүүлэн мэргэшүүлэх нь чухал гэсэн санаа дэвшүүлжээ.

Ган, зуд, байгалийн аюултай үзэгдлийн үед малчдын хүчийг нэгтгэн төвлөрүүлэх гол арга болсон хоршооллыг дэмжин дэлгэрүүлэх, малаа нийгмийн даатгалд хамруулах зэрэг ажлууд чухал болохыг мөн дурьдсан байна.

## 0043

Юкио Сузуки

### Монголын хөдөө аж ахуйн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай

“Зах зээлийн нөхцөл дэх хөдөө аж ахуйд тулгарч буй зарим асуудал” мини форум дээр тавьсан илтгэлүүдийн эмхтгэл. УБ, 2003. Монгол-Японы төв. 20-21 хууд. Монгол.

Судлаач Монголын мал аж ахуй нь байгалиас хараат, ихээхэн тогтворгүй, энэ байдал нь малчдын орлогод ихээхэн нөлөөлдөг тухай бичжээ.

Малчид мал аж ахуйн хоршоолол, малчны бүлгэм, өөрөө өөрсдийгөө дэмжих байгууллага байгуулж бэхжүүлэх, хамтын хүчээр түүхий эдээ борлуулах нь чухал юм. Түүнээс гадна малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бэлчээр болон худаг ашиглалтыг сайжруулах шаардлагатай гэж үзжээ.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд мал маллагааг сайжруулах, боловсруулсан түүхий эдийг экспортлох, хагас суурин технологид шилжих нь чухал гэсэн санал дэвшүүлжээ.

## 1070 Малчдын хоршоо, хамтын ажиллагаа

### 0044

Деннис Шихи

#### Нүүдлийн мал аж ахуйд суурилсан хоршооллын ажиллагааг сайжруулах нь

Хоршооллын өмч судлалын олон улсын холбооны VIII бага хуралд тавьсан илтгэл. Блумингтон, Индиана, АНУ. 2000. Англи.

Монголын нүүдэлч малчид байгаль, цаг агаарын бэрхшээлээс хамааралтай эрсдэлд байгаагаа багасгах, түүнээс бага боловч зайлсхийх шийдэл олохыг хүсч байдаг. Байгаль орчны эрсдлийг хамтран төлөвлөх, шийдвэр гаргах замаар багасгаж байна. Монголын хувьд үйлдвэрлэлийн нөөцийн зардал өндөр учраас малчид бас эдийн засгийн эрсдлийн нөлөөлөлд байдаг.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг зөв хөтлөн явуулахын тулд малын дасан зохицох чадварт тохирсон цаг хугацаа болон орон зайд тохируулан нөөцийг хуваарилах, мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдлийг бууруулж, амьдрах чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн уян хатан шийдвэр гаргах шаардлагатай. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээ шаардлагад тохирсон удирдлагын систем зайлшгүй шаардлагатай болж байна гэж үзжээ.

**Дүгнэлт:** Монголын мал аж ахуйн үйлдвэрлэл нь ихээхэн аз туршсан, эдийн засаг, байгалийн эрсдлийн нөлөөлөлд байдаг. Монголын мал аж ахуйн үйлдвэрлэлийг үр ашигтай хөтлөхийн тулд зөв бодлого, оновчтой удирдлага шаардлагатай гэсэн санал дэвшүүлжээ.

### 0045

Ито К.

#### Говь нутгийн хот айл, түүний бүтэц ба онцлог

“Mongolica” сэтгүүл, №9 (30). Өгүүлэл. УБ, 1999. МСОУХ. 219-220 хууд. Монгол.

1990 онд Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж, хувьчлал явагдснаар хувийн малд түшиглэсэн өрх гэрийн аж ахуй олноор бий болсон.

Малчдын нутаг орны зохион байгуулалт аажмаар өөрчлөгдөж, түүний дотор нэн анхаарал татаж байгаа нь 1990 он хүртэл хөдөө аж ахуйн нэгдлийн анхан шатны нэгж болж байсан суурийн оронд айл өрхүүд хамтарч, аяндаа бий болсон хот айл хэмээгдэх уламжлалт малчдын хамтлаг бий боллоо.

Хот айл нь 1950-иад оны сүүлчээр нэгдэлд хамрагдан орох хүртэл 700 жилийн турш өрх гэрийн аж ахуйн дутууг гүйцээж ирсэн нутгийн хамтлаг билээ.

Малчид дүр зоргоороо дэг журамгүй нүүдэлдэггүй, газар нутгийн онцлог, байгалийн эргэлтийг харгалзан жилийн дөрвөн улиралд харьцангуй тогтвортой нүүж сууна.

Хувийн мал бүхий өрх гэрийн аж ахуй дахин зонхилох болсноор сайн дурын хамтлаг нь ахуй амьдралаа төвхнүүлэхдээ хот айлаас эхлээд ямар нэгэн хамтын харилцааны хэлбэрийг бий болгодог. Тэр нь нүүдэлчин малчдын “нутаг усныхан” болно. Энэ ойлголтод хот айл, саахалт, хөрш, нэг баг, нэг сумынх, нэг голынх г.м. нэгжүүд багтана.

Урьд нэгдэл гэсэн том аж ахуйд таван хошуу малыг хүйс, нас, төрлөөр нь ангилж дагнан маллах болсноор мал сүргийн нөхөн үйлдвэрлэлийн эргэлтийн процесст малчид зөвхөн өөртөө ногдох хувиа үүрэх болсон байна. Гэтэл өрхийн аж ахуй өөрөө хариуцлагаа хүлээж, хөдөлмөрлөх хүчиндээ тохируулан таван хошуу малын бүх төрлийг чөлөөтэй зохицуулж, хэрэгцээтэй тохиолдолд хамтран ажиллаж, мал сүргийн нөхөн үйлдвэрлэлийн бүхий л процесст оролцдог. Тиймээс мал маллах, бэлчээр, ургамлаа таних, мал хөнгөлөх, имнэх, тамгалах, сааль сүү боловсруулах, арьс элдэх, сүр хийх, дээс томох, хужир бэлтгэх зэрэг үнэхээр олон янзын арга ажиллагаанаас суралцах хэрэгтэй болдог, үүнийг үр хүүхэд нь эцэг эхээсээ, залуучууд нь туршлагатай хөгшчүүдээсээ гэр бүл, хот айл, “нутаг орон”-ы дотор өвлөж авдаг.

**Дүгнэлт:** Монголын нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэл, ахуй амьдрал нь нарийн арга ажиллагаа, тогтолцоотой бөгөөд гэр бүл, хот айл, “нутаг усныхан”-ы гүйцэтгэх үүрэг үлэмж их байдаг, ялангуяа Монголын нүүдэлчдийн хувьд хот айл нь үнэхээр чухал асуудал болохыг дурьдсан байна.

## 0046

Логи Н.

### **Монголын бэлчээрийн мал аж ахуйн нөхцөлд хөдөө аж ахуйн хоршоог хөгжүүлэх үндсэн асуудлууд**

*Доктор (Sc.D)-ын диссертаци. УБ, 1999. Гэгээрлийн яам, ШУА. 224 хууд. Монгол.*

Энэхүү бүтээлд малчдын дунд хоршооллыг хөгжүүлэх хэлбэрийг дэлхийн практиктай уялдуулан хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хамтран эрхлэх (хэвтээ хоршилт) хэв маягаар, мөн манай орны бэлчээрийн мал аж ахуйн өвөрмөц онцлогийг харгалзан бэлчээртэй холбох маягаар хоршоог хөгжүүлэх нь зохистой гэж үзсэн байна.

Хоршооны хэлбэр, үйл ажиллагааны агуулгыг туршихын тулд 1996 онд Баянхонгор аймгийн Баацагаан суманд малчин 10 өрхийн бүрэлдэхүүнтэй, 1998 онд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл суманд малчин 22 хүний бүрэлдэхүүнтэй хоршоо байгуулж, үйлдвэрлэлийн бүхий л үйл ажиллагаанд нь аж ахуйн дотоод бүрэн тооцоог нэвтрүүлэхэд “Таван элс” хоршооны ашигт ажиллагааны түвшин 34,5%, “Тахилт” хоршооны 68% байжээ. Үүнээс үндэслэн малчдын нэмүү бүтээмж дээр суурилсан хоршооны эдийн засгийн үйл ажиллагаа явуулах үзэл баримтлал амьдралд нийцнэ гэж дүгнэжээ.

**Дүгнэлт:** Малчдын хоршоо цаг уурын аль ч нөхцөлд ашигтай ажиллаж мал аж ахуйн үйлдвэрлэлээ тогтвортой явуулах, үйлдвэрлэлийн салбаруудыг шаардлагатай хэмжээгээр хослон хөгжүүлэх боломжтойг судалгаагаар тогтоож, хоршоог шинээр зохион байгуулж хөгжүүлэх аргачлалыг боловсруулсан байна.

## 0047

Логи Н.

### **Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн баталгаа бол хоршоолол**

*Эрдэм шинжилгээний бичиг, №30. Өгүүлэл. УБ, 1999. ХААИС. 172-174 хууд. Монгол.*

Малын тогтвортой өсөлт бол эзэн хэн байна гэдгээс хамаарахгүй, харин уг малд өвс тэжээл, бэлчээр, усны хангамж хэр хүрэлцээтэй байгаа, түүний эрхэлж буй арга ажиллагаа ямар байна вэ гэдгээс үлэмж хамаарч байдаг. Хөдөө аж ахуйн хоршооллыг хөгжүүлэх үзэл баримтлалын загвар боловсруулж байгаль, цаг уурын өөр өөр нөхцөл бүхий Баянхонгор, Хөвсгөл аймгийн 2 суманд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хоёр хоршоог гишүүд-малчдын мал хөрөнгийг нийгэмчлэхгүй, тэдний хувийн өмч дээр тулгуурлан үйл ажиллагааг нь хорших замаар хамтын чармайлтаар үйлдвэрлэлийн үр дүнг дээшлүүлэхэд чиглүүлэн шинээр байгуулж туршсан байна. Тус хоёр хоршооны хувьд нэг жилд бий болгох орлогыг тодорхойлоход нийт малчдын дүнгээр ч, олонхи гишүүд-малчин өрх бүрийн дүнгээр ч орлогоороо зарлагаа нөхөөд 35-60%-ийн ашигтай ажиллах тооцоо гарчээ.

**Дүгнэлт:** Үйлдвэрлэлийн салбаруудыг оновчтой хосолсон байхаар бодож хоршооны эдийн засаг-математикийн статистик загварыг цаг агаарын тааламжтай болон тааламжгүй жил тохиох үеүдийн нөхцлүүдийг тусган боловсруулсан байна.

## 0048

Оюунбат Р.

### **Монголын хөдөө аж ахуйн хоршоог шинэлэг байдлаар зохион байгуулж хөгжүүлэх асуудал**

*Магистрын ажил. УБ, 1999. ХААИС. 109 хууд. Монгол.*

Сүүлийн жилүүдэд Монголд хөдөө аж ахуйн, түүний дотор бэлчээрийн мал аж ахуйн хоршмол ажиллагаа сонгодог хэлбэрээр хэрэгжих нь алдагдаж, хамтын хөдөлмөрийн үлэмж давуу талыг ашиглахаа үндсэндээ больсон байна.

Малчдын дунд явуулсан социологийн судалгааг ерөнхийд нь аваад үзвэл манай малчдад найдвартай үйлчлэх өөрийн байгууллага байхгүйн улмаас орлогынхоо ихэнх хэсгийг өөрсөддөө шингээж чадахгүй явуулын худалдаачдад алдаж байгаа, мөн нэлээд хэсэг нь бэлчээрийн мал маллагааны технологийн наад захын горимыг мөрдөхөө больсон нь нэг талаас харагдсан бол нөгөө талаас уг технологийг хэрэгжүүлэх боломжтой бөгөөд гарцаагүй хийх шаардлагатай нь бас харагджээ.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хоршоог өнөөгийн зах зээлийн харилцааны шинэ нөхцөлд нийцүүлэн шинэлэг арга барилаар зохистой зохион байгуулж хөгжүүлэх шаардлага тулгарсан байна гэсэн дүгнэлт хийжээ.

## 0049

Дэвид Снийт

### **Монголын нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэгчдийн бүлэглэл буюу нэгдэл**

*Товхимол. Лондон, 2002. Oxford University Press. 161-184 хууд. Англи.*

Эхний хэсэгт нүүдлийн мал аж ахуйн нэгдэл, түүний үр дүнгийн талаар өгүүлсэн бол 2 дахь хэсэгт хоршоо түүний онцлог, ач холбогдлын талаар дурьджээ. Үүнд Монголын малчин Хэнмэдэхийн мал маллаж, хоршоо байгуулж, үйл ажиллагаа явуулсан туршлагыг жишээ болгон авсан байна. Тэд анх 7 өрх 1000 толгой малтайгаар үйл ажиллагаагаа эхэлсэн ба 7 жилийн дараа буюу 1999 онд 2800 гаруй толгой малтай болсон. Гэрээт хувийн машинаараа түүхий эдээ Улаанбаатарт авчирч борлуулдаг.

Мөн Хөвсгөл аймгийн Ханх сумын малчин өрхийг амьжиргааны түвшингээр нь ангилсан. Тухайлбал, 20% нь нэн ядуу, 20% нь дунд зэрэг, 20% нь баян гэх мэт.

**Дүгнэлт:** Малчид амьжиргаагаа дээшлүүлэхийн тулд айл хотлоороо хоршоо байгуулан ажиллахын ач холбогдлыг онцлон судалж, Монголын малчин өрхийн жишээн дээр харуулсан байна.

## 0050

Цыбикжапов В.Б.

### Монголын нийгмийн шинэчлэлийн үйл явц дахь хоршооллын хөдөлгөөний шинэ хандлага

*"Market-Economy Nomads-Technology" товхимол. УБ, 2002. НСНСОУХ. 100-104 хууд. Орос.*

Монгол бол сонгодог бэлчээрийн мал аж ахуйн орон юм. Энэ нь олон зуун жилийн турш ард түмний амьдралаар уламжлагдан хөгжиж ирсэн бөгөөд байгаль, уур амьсгалын онцлогийн хувьд бусад нүүдэлчин ард түмнийхтэй ойролцоо юм. Судлаач Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт сумд болон Хөвсгөл, Сэлэнгэ, Булган аймгуудад социологийн судалгаа явуулж дүгнэлт хийсэн байна.

Сүүлийн жилүүдэд малчид хоршооны хүрээнд үйл ажиллагаа явуулах сонирхол өрнөж, эхний үе шатанд ихэвчлэн хамаатан садан, айл саахалтын 10-20 өрхийн хүмүүс хөдөлмөрөө нэгтгэн ажиллаж байна. Түүнчлэн малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг үйлдвэрлэл эрхлэх гарааны хөрөнгөө хуримтлуулж, тодорхой үр дүнд хүрч байна. Тухайлбал, Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл суманд туршилтын "Тахилт" хоршоолол байгуулагджээ. Энэ хоршоололд 3452 толгой мал бүхий 22 малчин өрх өөрсдийн хүсэлтээр нэгдэн орсон. Энэ хоршооллын мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлого нь эхний жилд дунджаар 19,3 сая төгрөг, түүнээс сүү 3,8 сая төгрөг, ноос 2,3 сая төгрөг, арьс шир 3,6 сая төгрөг тус тус болж, ашигтай ажилласан байна.

**Дүгнэлт:** Малчдын дунд хоршооллын хөдөлгөөнийг өрнүүлэх замаар байгаль цаг агаарын бэрхшээлийг хохирол багатай туулах төдийгүй ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтойг энэхүү судалгаагаар харуулжээ.

## 0051

Цыбикжапов В.Б.

### Монголын хөдөөгийн хоршоо: түүх, ерөнхий дүр төрх, ирээдүй

*"Nomadic Studies" сэтгүүл, №5. УБ, 2002. НСНСОУХ. 110-112 хууд. Англи.*

1998 оны тоо баримтаас үзэхэд Монголын малчин өрхийн 20 хувь нь ямар нэгэн хэлбэрийн хоршоонд нэгдэж, ажиллаж байлаа.

Судлаачийн тооцооноор эдгээр хоршоонууд нь дундаж ашгийнхаа 20 хувийг үйл ажиллагаагаа өргөжүүлэх, 30 хувийг нийгэм, соёлын хэрэгцээнд, 50 хувийг гишүүддээ хуваарилан зарцуулж байна. Гишүүд, хоршооны хооронд хоёр талын гэрээ байгуулж энэ гэрээнд үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээ, төлбөрийн нөхцөл, хугацаа, зардал, гүйцэтгэх ажлын төрөл зэргийг тусгаж байна.

**Дүгнэлт:** 1998 онд Монгол Улсад "Хоршооны тухай хууль" батлагдсанаар малчид хоршоонд нэгдэх сонирхолтой болсон. Энэ хууль нь хөдөө аж ахуйн хоршоог хөгжүүлэх, хөдөөгийн нийгэм, эдийн засгийн харилцааг зах зээлийн нөхцөлд шилжүүлэхэд чухал алхам болно гэж үзсэн байна.

## 0052

Юптон Кэролайн

### Монголын орон нутгийн байгууллага, газрын шинэчлэл, даяаршил

*Хоршооллын өмч судлалын олон улсын холбооны IX бага хуралд тавьсан илтгэл. Victoria Falls, Zimbabwe, 2002. Англи.*

Энэ илтгэлийг Монголын хөдөөгийн бодит байдал, өөрийн судалгаа, шинжилгээ, уншсан лекцэндээ тулгуурлан бичжээ. Судалгаа нь Монголын хөдөө аж ахуйн нэгдэл, түүний алдаа оноог шинжлэхэд чиглэгдсэн байна. Судалгаанд Монголын газрын талаарх баримтуудыг мөн ашигласан байна. Түүнчлэн орон нутгийн түвшинд малчид хоорондоо хорших, хамтран ажиллах үйл ажиллагаатай холбоотой урьдач нөхцлүүд, түүний хөгжилд гүйцэтгэх үүргийн талаар тусгасан байна.

**Дүгнэлт:** Судлаач Монголын хөдөө аж ахуйн нэгдэл болон хуучин ЗХУ-ын хамтралын үүрэг, сул талуудыг харьцуулан судалсны үндсэн дээр Монголын өнөөгийн бодит байдалд тулгуурлан малчид үйл ажиллагаагаа хорших, хамтран ажиллах талаар санал дэвшүүлжээ.

## 1080 Мал аж ахуй дахь хөдөлмөрийн нөөц

### 0053

Баасандаш Д.

### Хөлсний малчин ажиллуулж байгаа зарим хэлбэрүүд

*Эрдэм шинжилгээний бичиг, № 31. Өгүүллэл. УБ, 2002. ХААНС. 91-94 хууд. Монгол.*

Өнөөгийн байдлаар бэлчээрийн мал аж ахуйд хөлсний хөдөлмөр эрхлэх үйл явц малчин өрхийн хүрээнд дөнгөж эхлэлийн төдий байна. Монгол орны хувьд мал хувьчлагдаж зах зээлийн нөхцөлд аж ахуй эрхлэх болсон учир малчдын дотор хөрөнгө чинээний ялгарал огцом хүчтэй явагдаж, хөдөөд баян, хоосны ялгаа ихэслээ.

Олон малтай чинээлэг малчин өрх ажиллах хүчээр дутагдаж байхад мал цөөнтэй ядуу өрхүүдэд хагас ажилтай буюу ажилгүй хүмүүс олон байна. Ийм байдлаар нэг талд ажил олгогч чинээлэг малчин өрхүүд бий болохын зэрэгцээ нөгөө талд ажиллах хүчний сүл чөлөөтэй нөөц нэгэнт бий болжээ. Орон нутагт мал маллаж амьдрах сонирхолтой боловч амьжиргаанд нь хүрэлцэхгүй цөөн малтай өрхөд байгаа илүүдэл ажиллах хүч нь хөдөө дэх хөлсний малчны нөөцийг бүрдүүлж байна. Судалгаанд хамрагдсан чинээлэг өрхүүдийн 14.9% нь хөлсний хөдөлмөр ашиглаж байна.

Ямар нэгэн хэмжээгээр хөлсний малчин ажиллуулж байгаа ажил олгогчид цалин хөлсний 5 хэлбэр ашиглаж байгаа нь судалгаанаас харагджээ. Тэдгээрийг малжуулах гэрээтэй, түрээсийн гэрээтэй, цалингийн үнэлгээтэй, тусламжийн хэлбэртэй, бусад урамшуулалтай гэж ангилж болно.

**Дүгнэлт:** Судлаач 9 аймгийн 25 сумын малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж, хөлсний малчин ажиллуулж буй хэлбэр, онцлог, цалин хөлс олгож урамшуулж буй хэлбэр зэрэг хүчин зүйлсийг харгалзан дүгнэлт гаргасан нь шинэлэг ажил болсон байна.



## 0054

Бакей А., бусад

### **Мал аж ахуй дахь хөдөлмөрийн нөөцийг зохистой ашиглах тухай**

*Төслийн тайлан. УБ, 2000. ХААНС, ЭЗФ. 41 хууд. Монгол.*

Энэхүү төслийн судалгаагаар нийт малын тоог орон нутгийн бүсээр гарган, нэг малчны хариуцан маллаж чадах малын тоог тооцож, нийт шаардагдах малчны тоог одоо ажиллаж байгаагийн тоотой харьцуулж ажил эрхлэлтийг тодорхойлсон байна.

Мөн мал аж ахуй дахь хөдөлмөрийн нөөцийн ашиглалт, малчдын бүтэц (нас, хүйсний), хөдөлмөрийн бүтээмжийг судалжээ. Монгол Улсын нийт ажиллагчдын 52.6% нь, хөдөлмөрийн насны хүн амын 36.4% нь мал аж ахуйн салбарт ажилладаг, нийт малчдын 15.2%-ийг өндөр настангууд эзэлдэг байна. 1997 оны байдлаар 167.3 мянган малчин илүүдэлтэй байна.

**Дүгнэлт:** 1990-1997 онд малын тоо 21%-иар өссөн байхад малчин өрх 2.5 дахин, малчны тоо 2.8 дахин нэмэгджээ. Энэ нь бусад салбарт үүссэн ажилгүйдэлтэй холбоотой юм. Өнөөгийн мал аж ахуй дахь ажилгүйдэл нь эдийн засгийн хямралаас үүдэлтэй мөчлөгийн ажилгүйдэл юм.

## 0055

Жаргалсүрэн М.

### **Малчдын боловсролыг дээшлүүлэх зарим асуудал**

*"Nomadic Studies" сэтгүүл, №04. Өгүүлэл. УБ, 2002. НСИСОУХ. 168-171 хууд. Монгол.*

Малчдын боловсролыг дээшлүүлэхийн тулд гэрээсээ хол суралцаж байгаа малчдын хүүхдүүдийг ая тухтай суралцах боломжоор хангах, хүүхдээ сургуульд сургахыг малчдад дарамт болохгүй байхаар цогц шийдвэрлэх, малчдын хэрэгцээ шаардлагад тохирсон чиглэлээр зайн сургалт зохион байгуулах, үг сургалтад шаардлагатай сургалтын материал, гарын авлагаар малчдыг хангах ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр ажиллаж буй байгууллага, хүмүүсийг урамшуулан дэмжих ажлыг зохиож байх санал дэвшүүлжээ.

Ялангуяа, малчдын хүүхдийг малаас, өөрөөр хэлбэл үйлдвэрлэлээс нь хөндийрүүлэхгүйгээр суурь боловсрол олгох тогтолцоо бий болгох, тухайлбал, өмнө хэрэгжүүлж байсан "хот айл" зэрэг төслүүдийг улам боловсронгуй болгож, зуны улиралд багийн сургалт, фермийн сургалтыг зохион байгуулах, энэ чиглэлийн багш нарыг бэлтгэх, багш нарын амралтын үеэр тэдний орлого олох нэг эх үүсвэр болгон зохион байгуулах нь зүйтэй гэжээ.

**Дүгнэлт:** Өнөөдөр малчдын боловсролыг дээшлүүлэх, ялангуяа мал аж ахуйн үйлдвэрлэл, бэлчээр, цаг агаар, мэдээлэл, түүхий эдийг дахин боловсруулах чиглэлээр сургалт явуулах, үйлдвэрлэлээс хөндийрүүлэхгүй боловсрол олох боломж олгох асуудлыг шийдвэрлэх санал дэвшүүлсэн байна.

## 0056

Моррис Россаби

### **Хонины хишиг (малчны намтар)**

*Нэг сэдэвт бүтээл. Их Британи, 2000. 150 хууд. Англи.*

Монгол Улсын хөдөлмөрийн баатар, хоньчин Ц.Намхайнямбуугийн амьдрал, намтар түүхийг тусгажээ. Тэрээр 1948 онд Засагт хан аймгийн Цэцэн сартуул хошуу, одоогийн Завхан аймгийн Сонгино сумын нутагт төрсөн. 13 наснаасаа мал маллаж эхэлсэн түүний хөдөлмөрийг үнэлж, 29 насанд нь Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол олгосон юм. Малчин түмний дундаас анх удаа Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон ба Монгол, Оросын залуучуудын их наадамд төлөөлөгчөөр оролцож байсан. Мөн уг бүтээл нь "Малчдад зориулсан

гарын авлага” гэсэн хэсэгтэй бөгөөд энд жилийн 4 улирлын онцлогт тохируулан хонь хариулах, хурга бойжуулах, түүнчлэн хонь үржүүлэг, ашиг шим, малчны хөдөлмөрийн онцлог зэргийг тусгасан.

**Дүгнэлт:** Уг бүтээлд малчин хүний намтар, түүний мал маллаж байсан амьдралын баялаг туршлагын үр дүн болсон мал маллах арга ухааныг залуу малчдад тусламж болгох үүднээс тусгасан байна.

## 0057

Оле Бруун

### Малчин өрхийн эдийн засаг ба зохион байгуулалт

*“Mongolia in Transition: Old Patterns, New Challenges” товхимол. Их Британи, 1996. 65-89 хууд. Англи.*

Энэ судалгаагаар Монголын бэлчээрийн мал аж ахуй зах зээлийн харилцаанд шилжиж буй байдалд товч үнэлэлт өгөхийн зэрэгцээ малчин өрхийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, өрхийн төсөв, үйлдвэрлэлийн зардал, малчдын нийгэм-эдийн засгийн харилцааг авч үзсэн байна.

Хагас нүүдлийн хэлбэрийн эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зах зээлийн эрэлт шаардлага ч бий болж байна. Түүнчлэн Монголын Засгийн газрын өмнө тулгарч байгаа ойрын жилүүдэд шийдвэрлэвэл зохих асуудлуудын нэг бол хөдөөгийн хүн амын үйлчилгээг сайжруулах, мал аж ахуйн салбарын чадавхийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулах явдал юм. Нэгдлийг тарааж малыг малчдад өгч зах зээлийн гарааны харьцангуй ижил нөхцлийг олгосон ч олон арван жил хэвшсэн нэгдлийн үеийн эдийн засгийн сэтгэлгээ зонхилж байгаагаас хүмүүсийн идэвх санаачлага, ажил хэрэгч овсгоо харилцан адилгүй байна. Ялангуяа баян ядуугийн ялгаа улам бүр нэмэгдэж байгаа нь төв болон орон нутгийн удирдлагаас оновчтой зохицуулалт шаардсан нэг бэрхшээлтэй асуудал болж байна.

Монголын бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийг түргэсгэх томоохон боломж бол дутуу ашиглагдаж байгаа боловсон хүчний чамгүй нөөц юм. Өнөөгийн малчид дотор машин, трактор, хөдөө аж ахуйн техник хэрэгсэл эзэмшиж сурсан, үржил селекцийн болон мал эмнэлгийн мэдлэгтэй, хөдөө аж ахуйн төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс олон байна. Монголын малчдын ерөнхий боловсролын болон техникийн боловсролын түвшин харьцангуй өндөр юм. Монголын хөдөө аж ахуйд байгаа энэхүү хүн хүчний нөөцийг боловсруулах үйлдвэрийн хүчин чадалтай уялдуулан зохистой ашиглах боломжтой юм. Гэвч малчдын дийлэнх нь нүүдлийн хэв шинжийг хадгалсан мал аж ахуй эрхлэх сонирхолтой байгаа юм.

**Дүгнэлт:** Зах зээлийн нөхцөлд бэлчээрийн мал аж ахуй эрхлэхийн тулд дотоод нөөц боломжийг дайчлан ашиглах, ялангуяа хагас суурин хэлбэрийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд чиглүүлэн малчдын сэтгэлгээг өөрчлөх явдал нэн чухал гэсэн санал дэвшүүлжээ.

## 0058

Франц-Фолькер Мюллер

### Африкийн нүүдэлчдийн хувь заяа Монголд нүүрлэж байна

*Ардын эрх сонин. 1995.07.25. 144 (1103). УБ, Ардын эрх сонин. Монгол.*

Хувьчлалын улмаас хөдөө аж ахуй дахь хоршооллын болон улсын үйлдвэрлэлийн салбарт цалингаас хараат байсан малчид хараат бус малчид болох урьд өмнө үзэгдээгүй сүрхий шилжилтийг туулж байна. Үүний улмаас Монголын хөдөө нутагт байдал бүр дорджээ. Тэднийг чөлөөт үйлдвэрлэгчид буюу бие даасан үйлдвэрлэл эрхлэгчид гэхэд бэрх юм. Малчдын хараат бус энэ байдал бол Монгол орны эдийн засгийн өнөөгийн нөхцөл дэх хөдөөгийн нийгмийн бүтцийн үгүйрэлтэй холбоотой гэж зохиогч үзжээ.

Тухайлбал, сумын төвийн ач холбогдол буурснаар 1992-1993 онд оршин суугчдынх нь 30 хувь шилжиж явсан. Бригадын төвүүд ч ийм маягаар орхигдсон явдал бол хөдөөгийн суурьшилд том ухралт болсон юм.

Сумын төвд үлдэж хоцорсон иргэд нь гол төлөв хөдөө гарч мал маллах чадалгүй ядуучууд байна. Гэтэл мал дээр гарч ганц нэгэн жил болоод мал маллан аж төрж чадахгүйгээ ойлгосон мөнөөх "шинэ малчид" сумын төвд ирсэнгүй, азаа үзэхээр аймгийн төв, Улаанбаатар руу зүтгэж байна гэжээ.

**Дүгнэлт:** Энэхүү шилжилт хөдөлгөөн нь Ази, Африк, Латин Америкийн хөгжиж байгаа орнуудад тохиолдсончлон эдийн засгийн хувьд хөл дээрээ зогсох гэж хүмүүс нийслэлдээ чихсээр хотын хүн ам хэт бөөгнөрч, улмаар ахуй хангамж, ажил эрхлэлтийн байдалд нүсэр дарамт учруулж байгаатай адил үйл явц юм. Монголын нүүдэлч малчдын өнөөгийн байдал ихээхэн тогтворгүй байна гэсэн дүгнэлт хийжээ.

## 0059

Хандсүрэн С.

### Мал аж ахуй дахь хөдөлмөрийн нөөц ашиглалт

*Доктор(Ph.D)-ын диссертаци. УБ, 1998. ХААИС. 182 хууд. Монгол.*

Монгол Улсад 1997 оны байдлаар 410 мянган малчин байгаа нь 1990 оныхоос 2.7 дахин илүү байна. Малчдыг насны бүтцээр нь авч үзвэл 16-34 насныхан 54.7 хувь, 35-55 насныхан 30.1 хувь, 56-аас дээш насныхан 15.2 хувийг тус тус эзэлж байна.

Монгол Улсын нийт ажиллагчдын 36.4 хувь нь мал аж ахуй дээр ажиллаж байна.

Зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойших 7 жилийн хугацаанд Монголд малчдын тоо 2.3 дахин өссөн байхад тэдгээрийн бүтээмж нь 2 дахин буурчээ. Малын тоог малчдын бүтээмжтэй уялдуулан тооцож үзэхэд 1997 онд Монголын мал аж ахуйд 167 мянган малчин илүүдэж байна.

**Дүгнэлт:** Судлаач энэхүү бүтээлдээ Монголын бэлчээрийн мал аж ахуйн салбарын хөдөлмөрийн нөөц ашиглалтыг малын тоо, мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, малчдын нас, хүйсийн бүтэцтэй уялдуулан судалж, ойрын жилүүдэд хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг санал болгосон байна.

## 0060

Хулдорж Б.

### Монголын менежментийн онол: хүний нөөцийн нүүдэлчин хандлага

*"Mongolica" сэтгүүл., №9. Өгүүлэл. УБ, 1999. МСОВХ. 379-385 хууд. Монгол.*

Өргөн уудам орон зайд нүүдэллэн малаа малладаг нүүдэлчдийн соёл иргэншил монголчууд биднийг ерөнхийгөөс тодорхой руу ярьж, ерөнхийгөөс тодорхой сэтгэж, мэдэрдэг болгосон. Ийнхүү Монголын менежментийн онолын тулгын чулуу болох соёлын нөлөөг нүүдэлчин монголчуудын бодож сэтгэх, мэдрэх, үйл ажиллагаагаа явуулах түүхэн дэс дарааллаас эрж хайх нь арга зүйн хувьд зүйтэй гэж судлаач үзсэн байна.

Нүүдлийн мал аж ахуйн ажил эрхлэлтийн харилцааг авч үзвэл энэ харилцаа нь гол төлөв гэр бүлийн харилцаанд суурилсан байх бөгөөд тухайн хот айлд байгаа хүмүүс нь үйлдвэрлэлийн тодорхой нэг хэсгийг тухайлбал, залуучууд нь морь малаа сургах, бүсгүйчүүд нь сааль сүүгээ бэлтгэх, дээл хувцсаа оёх, дунд ахмад насны эрчүүд нь хашаа саравчаа барих, засах, худаг усаа гаргах, хадлан тэжээлээ бэлтгэх, арьс сураа элдэх, ногт чөдрөө зангидах зэргээр дагнан хуваарилах боловч эдгээр нь улирал, нутаг орны онцлогоос хамааран өөр өөр байж болохын зэрэгцээ эрхэлж байгаа ажлаа байнга сэлгэж байдаг онцлогтой. Монголчууд мал аж ахуйгаа эрхлэх асуудлаар хот айлынхантайгаа зөвлөлддөг, уг хот айлыг бүхэлд нь толгойлж байгаа ахмад хүн эцсийн шийдвэр гаргадаг. Энэ нь Монголын менежментийн бүтэц цомхон, удирдлагын үе шат цөөхөн байхын гол утгвар нөхцөл юм.

**Дүгнэлт:** Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг Монголчуудын нүүдлийн соёл дээр тулгуурласан менежментийн онол нь одоо байгаа менежментийн онолуудаас хүний нөөцийн менежментийн үндсэн хүчин зүйлсээр ялангуяа

Америкийн А онол, Японы Ј онолоос зарчмын хувьд ялгаатай байна. Менежментийн онолыг соёлын суурь өвд тулгуурлах замаар бий болгох нь хөгжиж буй орнуудад, ялангуяа хөгжлийн шилжилтийн шатанд байгаа орнуудад үлэмж ач холбогдолтой байж болох юм. Энэ утгаараа Монгол нь нүүдлийн соёл иргэншилтэй аль ч орны хувьд нийтлэг байж болох талтай гэсэн санал дэвшүүлжээ.

## 0061

Шомбодон Д.

### Монголын малчдын хөдөлмөрийн хуваарь ба ажлын нөхцөл

*“Culture and Environment in Inner Asia: 1 - The Pastoral Economy and the Environment” товхимол. Их Британи, 1996. 209-237 хууд. Англи.*

Үгээр малчны хөдөлмөрийг тусгайлан судалжээ. Малчны хөдөлмөр нь малчин, мал, байгалийн (бэлчээр) харилцан шүтэлцээнд суурилдаг. Ажиглалтаар малчин айлын өрхийн тэргүүн өдөрт дунджаар 623 минут, гэрийн эзэгтэй 231 минут тус тус гадаа ажиллаж байна. Мал нь хоногийн 24 цагийн турш байгалийн нөлөөн дор байх тул малчны хөдөлмөр нь байнгын үргэлжилсэн шинжтэй. Тийм учраас малчид байнга байгалийн нөлөөн дор байхын зэрэгцээ ажлынхаа онцлогоос болж өөрийн тав тухыг золиослох шаардлага ч гарч байдаг.

**Дүгнэлт:** Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлогоос болж малчид цаг наргүй байнга ажилладаг учир тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарах шаардлагатай болохыг тогтоосон байна.

## 1090 Монгол улсын мал аж ахуйн дэлхийн зах зээлд эзлэх байр суурь

### 0062

Алисиа Кампи

### Үндэстнүүдийн нэгдлийн XXI зуунд Монголын нүүдлийн соёл иргэншлийг хангах асуудлууд

*“Dialogue among Civilizations: Interaction between Nomadic and Other Cultures of Central Asia” товхимол. Өгүүлэл. УБ, 2001. НСНСОУХ. 41-48 хууд. Англи.*

Энэхүү өгүүлэлд Төв Азийн нүүдлийн соёл иргэншил болон суурин иргэншлийн хоорондын харилцаанд нөлөөлсөн Монголын түүхэн үүргийг тусгайлан авч үзсэн байна.

Нүүдлийн соёл иргэншлийн нийтлэг дүр төрхийг Монголчуудын нүүдлийн нийгэм, эдийн засаг, соёлын амьдралын түүхээс харж болох юм.

Монголын хөдөөгийн хөгжлийг дэмжиж туслахдаа нүүдэлчдийн асуудлыг анхааран авч үзэх ёстой гэж судлаач үзжээ.

Хөдөө аж ахуйн нэгдлийн үед мал аж ахуйг эрчимжүүлэх чиглэлээр хийгдэж байсан зарим ажлууд нь нүүдэлчдийн уламжлалт хэвшлийг тодорхой хэмжээгээр өөрчлөхөд хүргэсэн. Тухайлбал, хөдөө аж ахуйн нэгдэл байгуулагдахаас өмнө 1950-иад онд монголчуудын 95 хувь нь нүүдэлч малчид байсан. Гэтэл социализмын төгсгөл үе буюу 1989 онд энэ үзүүлэлт 28 хувь болж байжээ.

Хөдөө аж ахуйн нэгдэл тарж мал хувьчлагдсанаар эргээд малчдын тоо олширч 50 хувьд ойртож байна гэжээ.

**Дүгнэлт:** Монгол Улсад сүүлийн 10 жилд мал аж ахуйд гарч байгаа өөрчлөлтийг үнэн зөв дүгнэж, залах явдал нэн чухал юм.

Монголчуудын нүүдлийн иргэншлийн түүх нь засаг захиргаа, үлс төр, нутаг дэвсгэр, эдийн засаг, бүс нутаг болон нийгмийн өвөрмөц тогтолцоо юм гэсэн дүгнэлтийг судлаач хийжээ.

### 0063

Бураев А.И.

#### **Төв Азийн нүүдэлчид**

*“Dialogue among Civilizations: Interaction between Nomadic and Other Cultures of Central Asia” товхимол. Өгүүлэл. УБ, 2001. НСНСОУХ. 86-88 хууд. Англи.*

Төв Азийн нүүдэлчдийн түүх бол хүн төрөлхтний гарал үүслийн түүхтэй шууд холбоотой юм. Байгаль нуурын орчим болон Монголын нутгийг эртний нийгмийн соёлын төв гэж үздэг. Овог, аймгуудын эдийн засгийн үндэс нь мал аж ахуйн үйлдвэрлэл байжээ.

Дундад зууны үеийн монголчууд нь одоогийн Монгол Улс, Буриад, Халимаг болон бусад монгол ястны өвөг дээдэс бөгөөд бэлчээрийн мал аж ахуй эрхлэх арга ажиллагаа нь бараг хэвээр хадгалагдаж ирсэн байна.

**Дүгнэлт:** Төв Азийн хүн ам нь нүүдлийн соёл иргэншлийн бүхэл бүтэн түүхийг хадгалж ирсэн, одоо ч хадгалсаар байна гэж энэхүү өгүүлэлд дурьдсан байна.

### 0064

Дашдондов Х.

#### **Зүүн хойт Азийн хөдөө аж ахуйн хамтын ажиллагаанд Монголын оролцоо**

*“Олон улс судлал” сэтгүүл, №2. Өгүүлэл. УБ, 2003. ОУСХ. 72-86 хууд. Монгол.*

Зүүн хойт Ази нь хөдөө аж ахуйг хөгжүүлэх арвин их нөөц бүхий асар уудам газар нутагтай, байгаль, цаг уурын тааламжтай нөхцөл, хүн ардын эрт дээр үеэс эрхлэн дадаж заншсан уламжлалт технологи, орчин үеийн техниктэй. Зүүн хойт Азийн бүс нутгийн хойт хэсэгт орших Оросын Дорнод муж, Хятадын Зүүн хойт муж болон Монгол Улсад бүрэн ашиглагдахгүй байгаа өргөн уудам нутаг, мал аж ахуй эрхлэх өвөрмөц технологитой байхад зүүн талын хэсэгт орших Япон, Умард, Өмнөд Солонгост хөдөө аж ахуйн орчин үеийн өндөр бүтээмжтэй техник хөгжсөний дээр Орос, Япон, Хятадад хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийн орчин үеийн техник технологи өндөр хөгжсөн нь тус бүс нутгийн хамтын ажиллагааны зохион байгуулалтын загвар нэлээд өвөрмөц байхыг шаардаж байна. Хэрэв Зүүн хойт Азийн улс тус бүрийн үндэсний эдгээр давуу талуудыг хоршин ашиглаж чадвал ирээдүйд тус бүс нутаг нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр өөрийнхөө хэрэгцээг хангаад зогсохгүй, дэлхийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортод нэлээд чухал байр эзлэх ч боломж байна. Ялангуяа бэлчээрийн мал аж ахуйн салбаруудыг далайцтай хөгжүүлж, өөрийн бүс нутгийн хүнсний хэрэгцээг хямд өртөгтэй, химийн элдэв нөлөөлөлгүй, байгалийн цэвэр, чанарлаг бүтээгдэхүүнээр хангаад, бусад тив нутагт ч экспортлох асар их чадавхи тус бүс нутагт байгааг анхаарах нь зүйтэй гэсэн санал дэвшүүлсэн байна.

**Дүгнэлт:** Судлаач байгаль, цаг уурын онцлогоос болж тус бүс нутгийн улс орнуудын хүн амын зайлшгүй хэрэгцээт мал аж ахуйн бүтээгдэхүүнээр хангах үйлдвэрлэлийн төрөлжилт, хоршилт, хамтын ажиллагааны өндөр түвшинд хүрч чадаагүй байгааг жишээ баримтаар дурьджээ.

### 0065

Кэролайн Хамфри, Дэвид Снийт

#### **Нүүдлийн мал аж ахуйн төгсгөл үү?**

*Нэг сэдэвт бүтээл. Duke University Press, Durham NC 27708. 10 High Street, Knapwell, Cambridge CB3 8 NR, 1999. Англи.*

Судлаачид шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түргэн хурдацтай даяаршлын үед нүүдлийн мал аж ахуйн оршин тогтнох, хэтийн төлвийн талаар Өвөр Монгол, Буриад, Монгол зэрэг улсуудад харьцуулсан судалгаа хийсэн байна. Тэд нүүдлийн мал аж ахуй нь нийгэм, эдийн засгийн систем, шинжлэх ухааны ололт,

зах зээлийн нөхцөлд зохицох чадвартай салбар гэж үзсэн байна. Мөн эдийн засгийн газар зүйн нөхцлийг нь авч үзэхэд зарим бүс нутгуудад, ялангуяа Монголд хөдөлгөөнтэй нүүдлийн мал аж ахуй нь байгаль орчныг доройтуулахад нөлөөлсөн гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Нүүдлийн мал аж ахуйн талаарх шинжлэх ухаанаар батлагдаагүй төсөөллүүдийг няцаагаад, түүнийг үр дүнтэй судлах, тэгж судлахын ач холбогдлыг тодорхойлжээ.

**Дүгнэлт:** Нүүдлийн мал аж ахуй эрхэлж байгаа Монгол, Өвөр Монгол, Буриад зэрэг улсуудад нүүдлийн мал аж ахуйн хэтийн төлвийн талаар харьцуулсан судалгаа хийж, нүүдлийн мал аж ахуйн ирээдүйн талаар янз бүрийн төсөөллүүд дэвшүүлж, нүүдлийн мал аж ахуй нь мөхөлд хүрээгүй бөгөөд түүнийг цаашид судлан хөгжүүлэх нь чухал гэсэн санаа дэвшүүлжээ.

## 0066

Мягмаржав Б.

### Төв Азийн орнуудын нүүдлийн мал аж ахуйн харьцуулсан судалгаа

“Nomadism-International Study” товхимол. УБ, 2002. НСНСОУХ. 68-73 хууд. Монгол.

Төв Ази нь нүүдлийн мал аж ахуйн эртний өлгий нутаг билээ. Нүүдлийн мал аж ахуйн харьцуулсан судалгааг олон улсын экспедицийн хүрээнд Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-ын Буриадад зохион байгуулжээ. Уул судалгаанд энэ нутгийн төрөл бүрийн мал сүргийн байршил, бүтэц, тоо толгойн өсөлтийг сүүлийн 10 жилийн байдлаар харьцуулан судалж үзсэн юм. Сүүлийн 10 жилд Монгол Улсад адуу 118.0% өсөж, харин ӨМӨЗО, ОХУ-ын Буриадад 1990 оноос хойш 71-75% болж буурсан байна. Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-нд тэмээний тоо байнга хорогдсоор байна. Монгол Улс, ӨМӨЗО-д ямааны тоо өсч байгаа нь дэлхийн ноолуурын зах зээлийг эдгээр орнууд тодорхойлж байгаатай холбоотой.

Ийнхүү төрөл бүрийн мал өсөх буурах хандлага нь нэг талаас ноос, ноолуур, махны эрэлт хэрэгцээтэй уялдаж байгаа боловч нөгөө талаар тухайн төрлийн малын биологи, бүс нутгийн бэлчээр, усны хэрэгцээ, газарзүйн байрлалтай бас холбоотой учраас цаашид нарийвчлан судлах шаардлагатай гэж үзсэн байна.

Төв Азийн нүүдлийн мал аж ахуй эртний уламжлалтай бөгөөд Монгол Улсад нүүдлийн мал аж ахуйн хэлбэр өнөө хүртэл оршиж байгаа, харин ОХУ-ын Буриад болон ӨМӨЗО-д малчид суурьшмал, хагас суурьшмал байдалд шилжин орсон онцлог байдалтай байна.

Төв Азийн эдгээр оронд хийсэн судалгааны дүнгээс үзвэл орон бүр зах зээлийн харилцаанд шилжсэнтэй холбоотой нийтлэг зүйл ч бас байна. Энэ нь бэлчээрийг төлбөртэй ашиглах асуудал бөгөөд хэдийгээр Монгол Улс, ОХУ, БНХАУ-д бэлчээрийн төлбөрийн хэмжээ өөр өөр боловч бэлчээр нутгийг эдийн засгийн эргэлтэд нэгэнт оруулсныг энэхүү судалгаагаар харуулжээ.

**Дүгнэлт:** Төв Азийн нүүдлийн мал аж ахуйг харьцуулан судлах нь зөвхөн эдгээр орны хүрээгээр ач холбогдол нь хязгаарлагдахгүй юм. Байгаль, бэлчээртэй зохицсон, өртөг зардал хямдтай бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх нь нийгэм, эдийн засгийн ач холбогдолтойг энэ бүтээлд онцлон дурьдсан байна.

## 0067

Мягмаржав Б., Энхээ М.

### Нүүдлийн мал аж ахуйн бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд

“Nomadic Studies” сэтгүүл, №04. Өгүүлэл. УБ, 2002. НСНСОУХ. 160-163 хууд. Монгол.

Монгол малын махны талаар явуулсан шинжилгээ судалгааны дүнг нэгтгэн авч үзвэл бэлчээрийн маллагаатай монгол малын мах нь биохимийн найрлага, төгс чанараараа бусад оронд үржүүлдэг сайн үүлдрийн малын махтай адил бөгөөд биологийн үнэт чанарын зарим үзүүлэлт тухайлбал, үл орлогдох амин хүчил, усанд уусдаг

амин дэмүүд, бичил элемент, төмөр, манган, зэс зэргээр баялаг, эрүүл ахуйн аюулгүйн талаасаа экологийн цэвэр бүтээгдэхүүнд тооцогдох бүрэн үндэстэй, хүнсний үнэт бүтээгдэхүүн болох нь нэгэнт тогтоогджээ.

Зөвхөн Монгол Улс төдийгүй Ази, Африкийн нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг олон оронд экологийн цэвэр махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд энэ нь дэлхийн хэмжээнд хэдийгээр бага хувийн жин эзлэх боловч, тухайн орны экспортыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой бүтээгдэхүүн болохыг дурьджээ.

**Дүгнэлт:** Махан бүтээгдэхүүний тухайд Монгол Улс төдийгүй Ази болон Африкийн нүүдлийн мал аж ахуй бүхий олон арван орон хамтран энэ чиглэлээр шинжилгээний ажил явуулах, мэдээллээ харилцан солилцох явдал чухал гэж үзсэн байна.

## 0068

Нямаа Н.

### Ямааны аж ахуйн эдийн засаг

Нэг сэдэвт бүтээл. УБ, 2001. ХААНС. 46 хууд. Монгол.

Энэхүү бүтээлд дэлхийн ямааны аж ахуйг Монгол Улсын ямааны аж ахуйтай харьцуулах, ямааны аж ахуйн байршлыг тогтоох, ямааны аж ахуйг хөгжүүлэх, ямааг өсгөх экологийн тохиромжтой нутагт тоо толгойг нь өсгөх боломжийн талаар санал дүгнэлтээ дэвшүүлсэн байна.

Уг бүтээлийг туурвихад Монгол Улсын статистикийн ба бэлчээр, цаг уурын судалгааны материал, дотоод, гадаадын зарим эрдэмтдийн бүтээл, өөрийн судалгааны материалыг ашигласан байна.

**Дүгнэлт:** Монгол Улсад үржүүлж буй ямааны үүдрүүд, ашиглагдаж буй бүтээгдэхүүн, ямааны аж ахуйн байршил, ямааны өсөлтийн динамик судалгаа, ноолуур үйлдвэрлэлийн өнгөрсөн, өнөө үеийн байдал, цаашдын хандлага зэргийг дэлгэрэнгүй авч үзжээ. Цаашид ямааны аж ахуйг хөгжүүлэх асуудлыг бэлчээрийн даацаар тооцох, ямааны аж ахуйн сүргийн оновчтой бүтцийг бий болгоход анхаарах нь зүйтэй гэж үзсэн байна.

## 0069

Төмөржав М.

### Нутгийн монгол мал Төв Азийн байгаль, цаг уур, экологийн нөхцөлд дасан зохицсон байдал

"Mongolica" сэтгүүл, №9. Өгүүлэл. УБ, 1999. МСОУХ. 337-349 хууд. Монгол.

Монголын нүүдэлч малчид бүдүүлэг залхуудаа нүүдлийн мал аж ахуйг сонгон эрхэлж буй хэрэг биш, чухамдаа Монгол орны байгаль орчин, цаг уур, газарзүйн өвөрмөц онцлог, өргөн уудам нутаг бэлчээртэй холбоотойгоор нүүдлийн хэв маягийн амьдралтай болжээ.

Нутгийн монгол мал жилийн турш дан бэлчээрээр хооллодог, өвөл хаврын хахир тарчигт зогсонги байдалд ордог, биеийн өсөлтийн хөгжлөө зун, намарт нь сэргээн эрчимжүүлж, биеийнхээ массыг ихээхэн нэмэгдүүлдэг, илч, энергийн эх материал болох өөхийг биедээ хангалттай хуримтлуулж таргалдаг, үс ноос нь сайн ургадаг, биеийн дулааны физик-хими, экологийн зохицолдоо гойд хөгжсөн, орчны халуун хүйтний хэлбэлзлийг чадмаг давдаг, бие цогцос чийрэг, өвчин эмгэгт тэсвэртэй, сэргэлэн цовоо зан төрхтэй, сүрэнгэлэх, хоорондоо ижилсэх зөн билэг сайн хөгжсөн, ажил эдэлгээнд болон байгаль цаг уурын ширүүн нөхцөлд тэсвэр хатуужилтай, ашиг шим, үржил, төлөрхөг чанарын хувьд удамшлын ихээхэн чадавхитай зэрэг биологи, экологи, эталогийн олон онцлог шинжүүд цогцлон бүрджээ. Үүнээс гадна нутгийн монгол малын "хурга", "ишиг" эхээс төрөхдөө биендээ бор өөхтэй гардаг гэжээ.

Монгол мал ихэвчлэн бараан зүстэй, нутгийн хонь хар толгойтой, хар нүдтэй, шийр хар алаг байдгийг нарны хурц гэрлээс хамгаалсан болон дулааны зохицуулгын нэг илрэл гэж үзэх үндэстэй юм. Хүрэн, бор, хар

зүс бол нарны элчийг сайн шингээдэг тул өвөл, хавар мал бага даарах буюу элч энергиэ хэмнэлттэй зарцуулах экологийн зохилдлого болдог.

**Дүгнэлт:** Нутгийн монгол омгийн мал тухайн орон нутгийнхаа байгаль, экологийн нөхцөлд онцгой сайн зохицсон байдаг талаар онолын дүгнэлт өгчээ.

## 0070

Төмөржав М., Эрдэнэцогт Н.

### Монголын нүүдэлчин

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 1999. ХААИС. 292 хууд. Монгол.*

Монгол Улс бол эдийн засаг нь бэлчээрийн мал аж ахуй дээр тулгуурладаг цөөхөн орны нэг, хүн амын нэлээд хэсэг нь хөдөөд оршин сууж, нүүдлийн хэв маягийн амьдралаар аж төрж ирсэн билээ. Зах зээлийн харилцаанд шилжиж буй өнөөгийн шилжилтийн үед ч мал аж ахуй улс орны эдийн засгийн тулгуур салбар байсаар байгаагийн гадна хүн амын нэлээд хувь нь нүүдэллэн аж төрсөөр байна.

Монголын нүүдэлчид эрт дээр үеэс сүйрэл, дампуурал, үнэ ханшны дарамтад ордоггүй, гадаадын эдийн засгийн түрэмгийлэлд нэрвэгддэггүй, өвөрмөц хэв маягийн бэлчээрийн мал аж ахуйг бий болгон эдүгээ хүртэл эрхэлж, хөтөлж иржээ. Тэд амьдрах орон гэр, өмсөх хувцас хунар, идэх хоол, хүнсний хэрэгцээгээ малаа даган нүүдэллэн аж төрөх нөхцөлд өөрсдийн бүтээсэн хаягдалгүй технологийн ачаар гадны ямар ч оролцоо, тусламжгүйгээр хангаж байжээ.

Өөрөөр хэлбэл, монголын нүүдэлчид эрт дээр үеэс Төв Азийн цаг уур, газарзүйн хатуу ширүүн нөхцөлд жилийн эргэх дөрвөн улиралд тухайн бүс нутгийн бэлчээр, усны онцлогт зохицуулан таван хошуу малаа адуулан маллах, өсгөн үржүүлэх, сонгон шалгаруулах, өлчиржүүлэн чийрэгжүүлэх, уналга эдэлгээнд сурган номхруулах, ашиг шимийг нь авч боловсруулан хэрэглэх, өвчин согогий нь эмнэн анагаах талаархи ихээхэн мэдлэг туршлага хуримтлуулсны гадна орон байр, гэр ахуй, эд өлгийн зүйлс, тоног хэрэгсэл, хоол ундныхаа төрлийг хүртэл нүүдлийн амьдралд зохицуулж ирсэн байна.

Байгальд шүтсэн нүүдлийн амьдрал экологийн хувьд цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эрчим хүчийг дээд зэргээр хэмнэх хаягдалгүй технологийг боловсруулах, байгаль орчин, бэлчээр, ус, мал сүрэг, хүн гэсэн амьд байгалийн битүү хэлхээ үүсгэсэн нь чухал ач холбогдолтой гэж үзсэн байна.

**Дүгнэлт:** Судлаачид монгол малын биологи, эталоги, экологи, физиологи, морфологийн зэрэг асуудлаарх олон жилийн судалгаандаа түшиглэн бэлчээрийн мал аж ахуй, түүний бүтэц, бүрэлдэхүүн, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, эдийн засаг, хөгжлийн зүй тогтол, хөгжүүлэх үзэл баримтлалын талаар саналууд дэвшүүлжээ.

## 0071

Кэролайн Хамфри, Дэвид Снийт

### Бэлчээрийн эдийн засаг ба орчин

*"Culture and Environment in Inner Asia: I-The Pastoral Economy and The Environment" товхимол. Их Британи, 1996. Англи.*

Төв Азийн соёл ба хүрээлэн буй орчин нь ОХУ, Монгол Улс, БНХАУ гэсэн 3 улсад хуваагдана. Энэ бүс нутаг нь тал хээр хосолсон бөгөөд бэлчээрийн доройтол ихээхэн газар нутгийг хамарч байна.

Төв Азийн уламжлалт бэлчээрийн мал аж ахуй тал нутагт тохирсон нүүдэлчин маягийн амьдрал нь 2000 жилийн түүхтэй.

Энэ бүтээлд Орос, Монгол, Хятад улсуудын бэлчээрийн эдийн засаг, энэ талаар Засгийн газруудаас баримталж буй бодлого, бэлчээрийн цар хүрээ, байгаль орчинд үзүүлэх нөлөө зэрэг асуудлыг тусгайлж судалсан байна.



**Дүгнэлт:** Судлаачид Төв Азийн нүүдэлчдийн амьдралыг цогц байдлаар судалж дүгнэлт хийх оролдлого хийжээ.

**0072**

Чулуунбаатар Г.

**Глобалчлалын үе дэх нүүдэл иргэншлийн уламжлал, шинэчлэлийн асуудал**

*“Nomadism-International Study” товхимол. УБ, 2002. НСИСОВХ. 35-37 хууд. Англи, Монгол.*

Монголчууд өргөн уудам газар нутагт хүн ам таруу суурьшсан нүүдлийн ба суурин иргэншлийг төр улсынхаа түүхийн бараг бүхий л үед өвөрмөц байдлаар хослуулан хөгжүүлж ирсэн билээ.

Олон иргэншлийн идэвхтэй харилцан нөлөөллийн нөхцөлд нүүдлийн ба суурин иргэншлийг оновчтой хэлбэрээр үр өгөөжтэй хослуулах замаар эртний Монголын уугуул нутагт цоо шинэ иргэншлийн хэв маягийг цогцлоох тухай асуудал бол олон улсын иргэншил судлалын тулгамдсан чухал сэдвийн нэг мөн. XXI зуун нийгмийн амьдралын даяарчлал, олон иргэншлийн харилцан нөлөөллийн зуун болно гэж судлаач үзжээ.

**Дүгнэлт:** Нүүдлийн иргэншлийн бүтэц эдүгээ улам бүр баялаг агуулгатай, үлэмж нарийн нийлмэл шинжтэй болж байна. Үүнд нүүдэлчдийн технологи, нүүдэлчдийн хөдөлмөр, нүүдэлчдийн аж ахуйн арга ухаан, нүүдэлчдийн мэдлэг ухаан, соёл урлаг, нүүдэлчдийн эрчим хүч, экологийн мэдлэг, нүүдэлчдийн зан заншил, нийгмийн сэтгэл зүй зэргийг багтааж үзэх шаардлагатай гэжээ.

## ХОЁР. МАЛ АЖ АХУЙН МЕНЕЖМЕНТ

### 1210 Мал аж ахуйн зохион байгуулалт

#### 0073

Төмөржав М.

#### То вангийн сургаал ба Монголын нүүдлийн мал аж ахуй

*Эрдэм шинжилгээний бүтээл, № 29. УБ, 1998. ХААНС. 10-15 хууд. Монгол.*

То вангийн сургаалийн 10-р зүйлд бэлчээрийн мал аж ахуй, түүний гол асуудал болсон мал маллагаа, таргалуулалтын арга ухаан, мал өлчиржүүлэн чийрэгжүүлдэг уламжлал, байгаль орчин, цаг агаарын талаарх мэдлэг, малчин өрхийн аж төрөхийн ухааны талаар тодорхой дурьдсан байдаг.

Малчин өрх аж ахуйгаа жинхэнэ оюунаараа, уйгагүй хөдөлмөрөөрөө хөгжүүлэх, аж төрөх, арвилан хэмнэх арга ухааныг эзэмших нь зах зээлийн харилцааны нэг гол асуудал бөгөөд То Вангийн сургаал нь ийм харилцааны анхдагч монгол загвар гэж үзэх үндэслэлтэй гэж судлаач үзжээ.

**Дүгнэлт:** Судлаач энэхүү бүтээлдээ Монголын өнөөгийн нөхцөлд малчдын аж төрөх, мал аж ахуйг эрхлэн хөтлөх арга ухааныг халх даяар Хэцүү То ван гэж алдаршсан Тогтохтөрийн сургаалд тулгуурлан явуулах санал дэвшүүлжээ.

#### 0074

Чадраабал Г.

#### Хүрээ нэгдлээс фермерийн аж ахуй хүртэл

*Бүтээлийн эмхтгэл, УБ, 2003. 182 хууд. Монгол.*

1990-ээд он буюу чөлөөт эдийн засагт шилжих үе хүртэл мал аж ахуйг хөгжүүлэх асуудлыг зөвхөн төрийн бодлогоор зохицуулж байсан бол зах зээлийн өнөөгийн түвшинд мал аж ахуйн арга технологи, менежментийн хувьд өвөрмөц хувилбартай болсон байна.

Энэ байдлыг үндэс болгож мал аж ахуйг эрхлэх үндсэн объект, түүний хэлбэр, ахуй нөхцөл, менежментийн чадавхийг төрөөс хөдөөгийн талаар дэвшүүлж байгаа бодлоготой дүйцүүлж гол хандлага, үйл явцыг тодорхойлоход уул бүтээл чиглэгдсэн байна.

Судлаачийн бичсэн “Фермерийн аж ахуйн монгол загвар”, “Удам дамжсан өрхийн эзэн сургалт”, “Фермерийн аж ахуйн талаар явуулах эрдэм шинжилгээний ажлын тэргүүлэх чиглэл”, “Фермерийн аж ахуй – зах зээлд”, “Монголд фермерийн аж ахуй хэрэгтэй”, “Нарийн, нарийвтар ноостой хонины фермерийн аж ахуйн загвар” зэрэг нь бүхэлдээ аж төрөх арга ухааны орчин үеийн менежментийг мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбон тал бүрээс нь хөндөж, түүндээ эрдэмтэд судлаачдын бүтээл түүрвил болон гадаад орны туршлага, хөгжлийн чиг хандлагыг тусгасан нь танин мэдэхүйн өргөн хүрээг хамарчээ.

**Дүгнэлт:** Энэхүү номонд мал аж ахуйн урьд ба өнөөгийн байдал, түүх, ахуй, үржил технологи, өөрчлөлт, шинэчлэлт, уламжлал туршлага, чиг хандлагыг олон талаас нь сөхөн үзсэн нь малчдыг шинэ санаа, мөрөөдөл, тэмүүлээр сэдээж, нэгийг бодож, нөгөөг ухаарах, зам мөрөө сонгож олоход нь зүгчилэх ач холбогдолтой болно.

## 0075

Адъяа Ю., Пүрэв Б., Тулга Г.

### **Малчин өрхийн аж ахуйн бүтээмжийг дээшлүүлэх зарим боломж**

*Эрдмийн бичиг, №1. Өгүүлэл. УБ, 1998. ХААНС. 3-10 хууд. Монгол.*

Байгалийн 5 бүсэд бэлчээрийн маллагааны уламжлалт технологийн хүрээнд нэг малчин өрх дунджаар ямар бүтэцтэй, хичнээн малтай байх боломжийг тодорхойлсны үндсэн дээр нэг жилд мал аж ахуйн үйлдвэрлэл хичнээн зардал гаргаж, хичнээн хэмжээний орлого, ашиг олж болохыг тогтоох зорилгоор математик загвар боловсруулсан байна.

**Дүгнэлт:** Математик загварын шийдлээс харахад:

- Малчин өрхийн бүтээмжийг тооцоход нэг өрх байгалийн бүсийн ялгаанаас хамаарч дунджаар 300-500 толгой малтай байх боломжтой ба сүрэгт тэмээ 1.4%, адуу 13.1%, үхэр 6.8%, хонь 50.7%, ямаа 28.0%-ийг эзэлнэ.
- Малчид нь тохиолдож болох эрсдлээс хамгаалахын тулд хэвийн болон тааламжтай жилийн ашгаасаа 20-30%-иар нөөцийн сан байгуулж ажиллавал малын ашиг шим, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, малын тогтвортой өсөлтийг хангах боломжтой гэж үзсэн байна.

## 0076

Батдэлгэр Ч.

### **Монгол Улсын томоохон хот орчмын хөдөө аж ахуйн бүсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалт**

*Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ, 1995. ШУА, Газарзүйн хүрээлэн. 113 хууд. Монгол.*

Энэхүү бүтээлд Монгол Улсын нийслэл, томоохон хот орчмын бүс нутагт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, түүнийг боловсронгуй болгох асуудлыг дагнан судалсан байна.

Томоохон хотуудыг хамарсан сав нутагт байгалийн нөхцөл нөөцөд нь түшиглэсэн хот дундын болон хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн цогцолбор бүрдүүлэх асуудлыг мөн авч үзсэн байна.

Хот орчмын гинжин бүс нутаг үүсэн хөгжих нь бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг ардын аж ахуйтны хувьд нүүдэлчдийн сэтгэлзүй, нийгэм-эдийн засгийн олон асуудлыг өөрчлөхийг шаардана. Юуны өмнө бэлчээрийн мал аж ахуйд суурилан хот орчмын эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд нь ардын аж ахуйтанд төр засгаас туслах, байгалийн бүс бүрт ялгавартайгаар хандах шаардлагатай юм.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ нь хот орчмын хөдөө аж ахуйн бүсийн талбайг нэмэгдүүлэхэд хүргэж байна. Үүнтэй уялдан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг аж үйлдвэрийн аргад шилжүүлэх, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг боловсронгуй болгон дэвшлийн хэлбэрт шилжүүлэх, хот орчмын хөдөө аж ахуйн бүсийн зохистой хэмжээг тодорхойлох шаардлагатай гэж судлаач үзсэн байна.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нутаг дэвсгэрийн тогтолцоо, үйлдвэрлэл-нутаг дэвсгэрийн цогцолбор нь үйлдвэрлэлийн өөрийн үйл явцаар бий болсон нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын шинэ хэлбэр бөгөөд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ихээхэн нөөц бололцоог агуулдаг. Уг үйл явцын нөлөөгөөр хот орчмын эрчимжсэн буюу хагас эрчимжсэн мал аж ахуйн газарзүй шинээр бүрэлдэж байна гэж судлаач үзжээ.

0077

Батсуурь Х.

**Монгол орны талархаг нутгийн мал аж ахуйн нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын асуудалд**

*Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ, 1996. ШУА, Газарзүйн хүрээлэн. 151 хууд. Монгол.*

Монгол орны талархаг нутгийн малчдын нүүдэл, бэлчээр сэлгэлтийн онцлогийг нутаг эзэмшилтэй нь холбон энэхүү бүтээлд судалсан байна.

Мал аж ахуйг хөгжүүлэх байгаль, нийгэм, эдийн засгийн нөхцөл, нөөц нь нутаг дэвсгэр бүрт тодорхой ялгаатай байгаа бөгөөд эдгээр ялгааг тус салбарын үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж, малчдын нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэхэд харгалзан үзэх ёстой юм.

Талархаг нутгийн малчид нүүдэллэн нутаг эзэмшиж буй онцлог байдлыг судлан малын экологийн зохистой нутгийн 22 шинж 8 дэд муж, 2 муж байгааг тогтоосон байна.

Малын экологийн зохистой нутгийг судлан илрүүлсэн нь мал аж ахуйг шинжлэх ухааны үндэслэлтэй эрхлэн хөтлөх систем боловсруулах, аж ахуй хоорондын ба дотоод зохион байгуулалтын үндэслэлийг сайжруулах, хөдөөгийн нийгэм-эдийн засгийн нэгжийг зохион байгуулах зэрэг эрдэм шинжилгээ, төлөвлөлт, практикийн олон төрөл ажилд хэрэгцээтэй юм.

Судлаач бэлчээрийн малын экологийн зохистой нутаг нь тухайн бүс нутгийн нутаг дэвсгэрийг ялгавартайгаар хөгжүүлэх бодлого боловсруулахад тулгуур материал болно гэж үзсэн байна. Мөн Монголын нүүдэлч малчдын бэлчээрийн мал аж ахуйгаа эрхлэн байгалийн тодорхой системүүдтэй харилцан уялдаж ирсэн нийтийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын үндсэн нэгж нь “айл-хот”, “айл-нэг нутгийнхан” тогтолцоо юм.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг сайжруулах үндэслэл нь Монгол Улсын газрын тухай хуулиар баталгаажсан нутаг бэлчээрийг хуваарилан эзэмшүүлэх эрх бүхий орон нутгийн засаг дарга, иргэдийн хурлын үйл ажиллагаа, малчдын нутаг усаа зөв сонгон эдлэхэд байгалийн нөхцөл, нөөцийг харгалзан үзэх гол үзэл баримтлал байх ёстой. Иймээс мал аж ахуйг зах зээлийн харилцаанд шилжүүлэх, талархаг нутгийн хөгжлийн бодлого боловсруулах, Монгол Улсын газрын тухай хуулийг хэрэгжүүлэх зэрэг бодлогын болон практик шинжтэй олон ажилд судлаачийн илрүүлсэн зүй тогтлыг ашиглах боломжтой гэж үзнэ.

0078

Дорлигсүрэн Д.

**Хот айл фермерийн аж ахуй**

*Төслийн тайлан. УБ, 1995. ХААНС. 102 хууд. Монгол.*

Монголын нүүдлийн мал маллагааны түүхэн хөгжлийн явцад бүрэлдэн тогтсон аж ахуйг эрхлэх, хөдөлмөр хорших шалгарсан арга бол хот айл байсан. Иймээс цаашид ч хөдөлмөр зохион байгуулалтын үндсэн гол хэлбэр нь хот айл байсаар байна гэж хэлж болох юм.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгслийн бүтэц, түүний өвөрмөц онцлогоос шалтгаалан хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэр нь мөн өвөрмөц болдог байна.

Одоогийн хот айл болж буй шалтгаан нөхцөл нь улирал цаг уурын нөлөөлөл, малын тоо, хөдөлмөр зарцуулалт, бэлчээрийн даац, мал аж ахуйн технологи ажилтай уялдаж байна.

Судалгааны явцад хот айл нь хөрөнгөө бус, хүч хөдөлмөрөө түр зуур нэгтгэх хөдөлмөр зохион байгуулалтын нэг хэлбэр болохоос, аж ахуй эрхлэх тогтвортой хэлбэр биш, мал нь олшроод бэлчээр нь талхлагдахын цагт задрахаас өөр аргагүйд хүрдэг үйлдвэрлэлийн нэгж гэдэг нь харагдлаа. Харин аав-хүү, ах-дүү, төрөл садангийн холбоонд үйлдвэрлэлийн болон аж ахуйн нэгж ч болох тал байдгийг үгүйсгэж болохгүй. Аж ахуйн нэгж хөрөнгийн

зарим хэсгийг нэгтгэж бий болдог бол хөрөнгө тасалж, салгаагүй нэг хот айлын хэмжээнд тэр нь аж ахуйн болон үйлдвэрлэлийн нэгж гэсэн утгын аль алинд хамаарч байна.

Ерөнхийд нь хэлэхэд малчин-бэлчээр-мал гэсэн гурван тулгуурын шүтэлцээнд хот айл нь үйлдвэрлэлийн, нэг өрх айлтай хотын тухайд аж ахуйн ч нэгж байж болох юм гэсэн санаа дэвшүүлжээ.

**Дүгнэлт:** Хот айлд байх малын тоо, малын нас хүйс, төрлийн бүтцээс шалтгаалж хот айлын өрх, ажиллах хүчний тоо бүсүүдээр ялгаатай байна. Мал аж ахуйн хувийн өмч болон хамтын хөдөлмөрт тулгуурласан хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэр болох хот айлыг хөгжүүлэхдээ зах зээлийн нөхцөлд бие даасан өрхийн аж ахуйн хэмжээ, бүтэц, зохион байгуулалт, эдийн засаг, санхүүгийн чадавхийг тогтоох нь онол практикийн ач холбогдолтой гэж судлаач үзжээ.

## 0079

Ким Юхиөг

### **Одоо л чухам Монголын хөдөөгийн эдийн засгийн бааз суурийг бий болгох зохистой цаг**

*“Mongolica” сэтгүүл, №9. УБ, 1999. МСОВХ. 221-247 хууд. Монгол.*

Аль ч улсыг аваад үзсэн орон нутгийн өөртөө засах байгууллага нь санхүүгийн талаар биеэ даасан байж чадахгүй. Ялангуяа орон нутгийн засаг захиргааны үндсэн нэгж болох аймгууд Засгийн газрын гар харах байдал их байгаа нь хөдөө орон нутгийн хөгжил удаан байхаас өөр замгүй болгож байна. Эхлээд бэрхшээлийг даван туулах замыг бодож боловсруулахгүйгээр хөдөөгийн өрнөл хөгжлийн тухай санасны гарз. Хөдөө орон нутгийг хөгжүүлэх талаар НҮБ-аас гаргасан 10 зарчмын хоёрт нь анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Нэгдэх нь төв засгийн тусламжийн зарчим бөгөөд хоёрдахь нь олон зорилгот хөтөлбөрийг хэрэгжүүлэх явдал юм.

Одоо Монголын аймгууд тус тусын хөтөлбөртэй гэж бодож байна. Гэхдээ зөвхөн тухайн аймгийн чармайлтаар бүтэхгүй ажил зөндөө байна. Төв засгаас чухам тэрхүү асуудлыг л тайлж өгөх ёстой болно. Энэ нь саадыг даван туулах арга зам бөгөөд орон нутгийн эдийн засгийг өрнүүлэн хөгжүүлэх залуур, жанжин шугам (стратегийн) юм.

Монголын одоогийн байр суурь, мөн орон нутгийн өөртөө засах байгууллагын өнөөгийн байдлыг харгалзан үзэхэд бүх салбарыг нэгэн зэрэг хөгжүүлэх арга тохиромжгүй, амжилт олно гэх найдлага тун бага байна. Тиймээс цөөвтөр мөнгөөр ч амархан амжилтад хүрэх тийм үр дүнтэй салбарыг нэн тэргүүнд сонгон алгуур тэлж өргөжүүлбэл сайн.

Ийм салбар нь зардал багатай Монголын бэлчээрийн мал аж ахуй гэж үзэж судалсан байна.

**Дүгнэлт:** Орон нутгийн эдийн засгийн өрнөлт нь дан ганц аймгийн төлөвлөгөөгөөр үр дүнд хүрэхгүй бөгөөд Засгийн газрын цаг үеэ олсон стратеги бодлого хийгээд олон талын хөтөлбөрийг хамтад нь хэрэгжүүлснээр богино хугацаанд амжилтад хүрэх учиртайг цохон тэмдэглэжээ.

## 0080

Мария Фернандес-Гименес, Дэвид Свифт

### **Хөгжиж буй дэлхий ертөнц дэх бэлчээрийн тогтвортой оршихуйн менежментийн стратеги**

*“African Journal of Range and Forage Science” сэтгүүл, 2003. 2 (20). 131-146 хууд. Англи.*

Энэхүү бүтээлд зүүн Африкийн халуун орны бүс, Төв Ази, тэр дундаа Монголын сэрүүн бүс нутаг дахь нүүдэлчдийн бэлчээрийн менежментийн байдлыг харьцуулан шинжилж, түүнд нөлөөлөх сөрөг хүчин зүйлсийг судалсан байна. Мөн экологи болон нийгэм-эдийн засгийн хөгжлийн шаардлагын үүднээс эдгээр бүс нутагт АНУ-ын баруун бүсийн бэлчээрийн менежментийн бодлогыг хэрэглэх боломжийг авч үзжээ. Судалгааны дүнд

өөр өөр тив, нутагт амьдарч байгаа малчид өөр хоорондоо ижил төстэй олон арга ажиллагааг хэрэглэдэг болохыг тогтоосон байна. Ихэнх бүс нутагт бэлчээрийн мал аж ахуйд уламжлагдаж ирсэн бүтэц, тогтолцоо алдагдаж байгаа нь бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжилд нүүрлэж буй гол аюул болж байна гэж судлаачид үзсэн байна.

**Дүгнэлт:** Өндөр хөгжилтэй болоод хөгжиж буй орнуудад ялгаагүй бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангахын тулд шинжлэх ухааны үндэслэлтэй, далайцтай судалгаа явуулах шаардлагатай гэсэн санал дэвшүүлжээ.

## 0081

Нансалмаа Ц.

### **Малчин өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийн менежментийн асуудал**

*(Говийн бүсийн жишээн дээр). Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ, 1998. ХААНС. Монгол.*

Монгол улсад бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа малчдыг зах зээлийн эдийн засгийн харилцааны зүй тогтлын дагуу ажиллаж амьдрах арга ухаанд сургах явдал онцгой ач холбогдол бүхий асуудал болж байна. Иймээс малчин өрхийн аж ахуйн хүрээнд менежментийн онол, практикийн асуудлыг судалж микро түвшинд малчин өрхийн аж ахуйд зохицсон менежментийн бодлого, чиглэлийн үндэслэлийг боловсруулах зорилгоор говийн бүсийн малчин өрхийн үйлдвэрлэл, эдийн засгийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, аж ахуйгаа эрхлэх арга барил, цаашдын чиглэлийг энэхүү бүтээлд дагнан судалжээ.

Монгол малчид нь хөгжлийн олон зууны турш байгаль экологидоо зохицсон мал маллагаа, аж төрөх үндэсний өвөрмөц хэв шинж бүхий аж ахуй эрхлэх уламжлалт арга ухааныг бий болгожээ. Энэ нь малчин ардын аж ахуйн хэрэглээний шинжийн үйлдвэрлэл эрхлэхээс үйлдвэрлэгч, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий бизнесийн нэгж болон төлөвших явцад орчин үеийн менежментийн арга ухааныг оновчтой хослуулан ашиглах тохиромжтой нөхцөл болсон байна.

Өнөөгийн малчин өрхийн аж ахуй нь малын тоо, орлогын хэмжээ, хэрэгцээ хангамжийн талаар харилцан адилгүй. Үүнээс үндэслэн өрхийн аж ахуйг хэрэглээний шинжийн, бие даах чадвар бүхий завсрын шинжийн аж ахуй гэж ангилах боломжтойг судалгаагаар тогтоожээ.

**Дүгнэлт:** Малчин өрхийн аж ахуйн үйлдвэрлэл-эдийн засгийн үйл ажиллагаа, аж ахуй эрхлэх арга барилын талаар баримтлах малчин өрхийн аж ахуйн менежментийн бодлого, чиглэлийн зөвлөмжийг боловсруулжээ.

## 0082

Нямбат Л., Наранхүү Л., Пүрэв Б., бусад

### **Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нэгжийг фермерийн хэлбэрт шилжүүлэх онцлог, хэлбэр, арга зам**

*Төслийн тайлан. УБ, 2002. ХХААЯ. 84 хууд. Монгол.*

Фермерийн аж ахуйг жирийн өрхийн аж ахуйгаас ялгаж, салгаж ойлгоход дараах нөхцөл шалгууруудыг харгалзах нь аргазүйн хувьд зохимжтой гэж судлаачид үзжээ. Үүнд, эдийн засгийн тогтолцоо, газрын өмчлөл, байгаль орчны нөхцөл, аж ахуй эрхлэх зорилго, бүтээгдэхүүний тавааржилтын түвшин, эрхэлж байгаа аж ахуйн орлого, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах хуримтлал, хөрөнгө оруулалт хийх санхүүгийн найдвартай эх үүсвэртэй байх зэрэг юм.

Манай улсад мал бүхий 256.5 мянган өрх байгаагийн дотроос өнөөгийн байдлаар 4.0 мянган өрх 500-аас дээш толгой малтай байгаа бөгөөд тэдгээр нь өрхийн дотоод хэрэглээ, үйлдвэрлэлийн зардлаа өөрийн

орлогоор нөхөж, ашигтай ажиллах өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах боломжтой байгаа юм. Эдгээр өрхийг фермерийн аж ахуйн хэлбэрээр цаашид хөгжих шалгуурыг хангасан гэж судлаачид үзжээ.

**Дүгнэлт:** 500-1000 толгой малтай фермер өрх нь 10.0 сая төгрөгийн борлуулалт хийж 4.7 сая төгрөгийн ашигтай, 1000-1500 толгой малтай нь 17.5 сая төгрөгийн орлого, 9.8 сая төгрөгийн ашигтай, 1500-аас дээш толгой малтай нь 31.1 сая төгрөгийн орлого, 19.0 сая төгрөгийн ашигтай ажиллах боломжтой юм. Одоо шинээр байгуулагдаад байгаа фермерийн аж ахуйн эдийн засаг, санхүү, технологийн байдлаас үзэхэд сүү үйлдвэрлэдэг жижиг аж ахуй 15 үнээ, дунд хэмжээний аж ахуй 25 үнээтэй байх нь нэг өрх-фермерийн аж ахуйн хувьд тохиромжтой байна. Цаашид нийслэлийн сүү хангамжийн хувийг 2010, 2015, 2020 онуудад 60, 70, 80-д хүргэх зорилтыг биелүүлэхийн тулд 2020 он гэхэд жижиг фермерийн аж ахуйн тоог 1400-д, дунд хэмжээний фермерийн аж ахуйн тоог 2150-д хүргэх шаардлагатай гэжээ.

## 0083

Масао Онүки

### Нүүдэлчдийн бүс нутгийн нийгмийн өнөөгийн байдал, ирээдүй

*"Mongolica" сэтгүүл, №9. Өгүүлэл. УБ, 1999. МСОУХ. 321-327 хууд. Монгол.*

Энэхүү судалгаанд байгаль, малаас гадна малын ашиг шимийг хүртэж амьдарч байгаа хүмүүс, улмаар тэдний гэр бүл, хамтлагийг хамруулсан байна.

Ардын аж ахуйтан, хот айл, нөхөрлөл, хоршоо үүсэх явц, өөрөөр хэлбэл уламжлалт хамтлаг дахин сэргэж буй явцаас шинэ хэлбэрийн шат ахисан хамтын зохион байгуулалтад орох явц ягуухнаар доороос малчдын санаачлагаар аяндаа боловсронгуй болно гэж судлаач үзсэн байна.

Хоршооны бүтцийн анхдагч нэгж нь ардын аж ахуйтан юм. Хоршоо нь нөхөрлөлийн хүчин чадлаас давж гарсан зүйлийг нөхөх үүднээс 5-6 нөхөрлөлөөс бүрдэх зохион байгуулалтын дээд хэлбэр юм.

Хоршооны хувьд гэнэтийн цас зуд, ган зэрэг байгалийн гамшигийг тооцсон байх ёстой. Хоршоо байгуулах ач холбогдлын нэг нь энэхүү байгалийн бэрхшээлийг даван туулах явдал гэж үзсэн байна.

Хот айл гэдэг нь хэд хэдэн ардын аж ахуйтан нэгдэж байгаа бол хоршоолол нь бүтцийн хоёрдогч шатанд гарч ирдэг хамтын зохион байгуулалт болно. Улмаар хэд хэдэн хот айл нэгдэж хоршооны бүтцийн гуравдагч шатанд нөхөрлөл үүснэ.

Гэр бүлийн дотор үүсэх эцэг эх, үр хүүхэд, ах дүүгийн хайр халамжид түшиглэсэн хүмүүсийг хайрлах харилцаа, энэ нь хот айл, нөхөрлөл, улмаар хоршоо болон өргөжиж бүс нутгийн нийгэм дотор хүн боловсорч, хүнлэг чанараас үүдэлтэй хүний төлөө гэсэн сэтгэл, харилцан нэг нэгийгээ хүндэтгэх, харилцан туслах сэтгэл санаа багтдаг.

**Дүгнэлт:** Ардын аж ахуйтан, хот айл, нөхөрлөл, хоршоо үүсэх явц, түүний дотоод хүчин зүйлс, аажимдаа бүрэлдэж тогтох хандлага, ирээдүйн талаар дурьдсан байна.

## 0084

Төмөржав М., Мягмаржав Б.

### Үнээний саалийн ферм – сүү үйлдвэрлэлийн гол газар

*"Nomadic Studies" сэтгүүл, №6. Өгүүлэл. УБ, 2003. НСИСУХ. 30-39 хууд. Монгол.*

Батсүмбэр дэх энэхүү "Америк ферм" гэж нэрлэгддэг фермийн бүтэц, үйл ажиллагаа нь хамгийн энгийн, тун авсаархан, цахилгаан, механикжуулалт бага шаарддаг учир манай орны тодорхой бүс нутагт цөөн тооны үнээтэй айл өрхөд "загвар" ферм болгож, энэ фермийн зохион байгуулалт, арга ажиллагааны технологи,

эрхэлж хөтлөх менежментийн онцлогийг хоршин судалж, эдийн засгийн үр ашгийг нухацтай тооцон гаргасны үндсэн дээр энэ фермийн загвараар тодорхой бүс нутгийн тулгуур төвүүдэд сургалт явуулах нь зохистой.

Аль ч фермийг байгуулах, ажиллуулахдаа малын тэжээлийн асуудалд онц анхаарч, фермийн өмчийн болон эзэмшлийн нутаг бэлчээр, хадлан, таримал тэжээлийн талбайг шинэ тутам байгуулах фермүүдэд гарган өгөх бодлого барих, ер нь хадлан, таримал тэжээлийн талбай, тодорхой нутаг, бэлчээрийг өмчлүүлэх, эзэмшүүлэх замаар хот суурин, бүсийн тулгуур төвийн эргэн тойронд саалийн ферм байгуулах асуудлаар тендэр зарлах хүртэлх тодорхой арга хэмжээ авч эрчимжсэн мал аж ахуйн энэ хэлбэрийг дэмжин хөгжүүлэхийг санал болгожээ.

**Дүгнэлт:** “Америк ферм” бол манай орны саалийн фермүүдийн мөрдөх ганцхан загвар биш бөгөөд бүс нутгийн байгаль, экологийн онцлог, дэд бүтцийн хөгжлөөс хамааран үүнээс өөр, бүр ч боловсронгуй өндөр үр ашигтай загвар бас байхыг үгүйсгэхгүй гэж судлаачид үзжээ.

## 0085

Франц-Фолькер Мюллер, Иорг Янцен

### Өнөөдрийн Монголын хөдөө нутаг

“Geographische Rundschau” сэтгүүл, 1997. 05, НЗ211, 272-278 хууд. Герман.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үндэс болсон өмч хувьчлалын ажил маш эрчимтэй өрнөж байна. 1993 гэхэд хөдөө аж ахуйн нэгдлүүд тарж мал хувьчлагдсанаар бэлчээрийн мал аж ахуйн эдийн засаг, нийгмийн асуудал эрс өөрчлөгдөв. “Шинэ нүүдэлчид” төрөн гарч гол авто замын дагуу шинээр олон суурин газрууд үүсэж, хувийн хэвшлийн байгууллагууд бий болж байгаа нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн хамгийн сонирхолтой жишээ болж байна.

**Дүгнэлт:** Гэвч мал аж ахуйд оновчтой маркетингийн бүтэц бий болоогүй, малчдын нийгэм, эдийн засгийн хамтын ажиллагаа хоршилт дутагдаж байгаагаас хөдөөд зах зээлийн эдийн засгийн үндэс бүрдсэн гэж дүгнэх боломжгүй гэж судлаачид дүгнэжээ.

## 1220 Бүсчилсэн хөгжлийн асуудлууд

### 0086

Гансэлэм Д., Цэдэндамба Л.

### Эдийн засгийн бүсүүдийн мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэлийн чадавхи (потенциал)-ийн үнэлгээ

“Монгол Улсын хөгжлийн судалгаа” сэтгүүл, №1. Өгүүлэл. УБ, 2003. ШУА, Үндэсний хөгжлийн хүрээлэн. 159-166 хууд. Монгол.

Манай улс мал аж ахуйн гаралтай түүхий эд (ноос, ноолуур, арьс, шир г.м)-ийг ихэвчлэн ямар нэгэн боловсруулалтгүйгээр экспортлож байна. Үүнээс үүдэн ашиг орлогооо нэмэгдүүлэх ихээхэн нөөц боломжоо алдаж байна.

Малчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ ашигтай зах зээлд гаргах боломжоор хязгаарлагдмал байгаагаас гол төлөв бартерын хэлбэрээр борлуулж байна. Малчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн зөвхөн энгийн нөхөн үйлдвэрлэлээс хэтэрч чадахгүй байгаагаас аж ахуйгаа өргөтгөх, эрчимжүүлэх, хуримтлал бий болгох боломж багатай байгаа юм.

Энэ бүхнээс үзэхэд манай улсын мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрүүдийг шинэ техник, технологийн менежмент, төрийн зохицуулалт, чөлөөт өрсөлдөөний үндсэн дээр сэргээн хөгжүүлэх



бодит шаардлага тулгарч байна. Эл зорилтыг хэрэгжүүлэхдээ эдийн засгийн бүсүүдийн мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, бэлтгэх чадавхийг сайн тооцох шаардлагатай юм.

Бидний хийсэн тооцогоор манай улс экспортын зориулалтаар жилд (2001 оны байдлаар) 30-40 мянган тонн мах бэлтгэх боломжтой. Тухайлбал, үхрийн мах 10-13 мян.тн, адууны мах 10-11 мян.тн, хонины мах 7-9 мян.тн, ямааны мах 4-5 мян.тн-ыг тус тус бэлтгэж экспортлох боломжтой юм.

Судалгаанаас үзвэл Баруун бүс 7.7-9.1 мян.тн, Хангайн бүс 12.4-14.7 мян.тн, Төвийн бүс 7.3-8.5 мян.тн, Зүүн бүс 5.8-6.9 мян.тн мах экспортын зориулалтаар тус тус бэлтгэх боломжтой байна.

**Дүгнэлт:** Мах болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний дотоод, гадаад зах зээлийг улам өргөжүүлэх, хөрш болон бусад оронтой мал эмнэлэг, хорио цээрийн талаар хамтран ажиллах гэрээ хэлэлцээр байгуулах, ариун цэвэр, эрүүл ахуйн баталгаажуулалтын зарчмыг тохиролцох, харилцан итгэл хүлээлцэх чиглэлээр ажиллахыг санал болгожээ. Мөн эдийн засгийн бүсүүдээр мал аж ахуйн үйлдвэрлэлийн чадавхийг тооцож ажиллах санаа дэвшүүлсэн байна.

## 0087

Моёбуу Д., Бакей А.

### Хөдөө аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх асуудал

*Эрдэм шинжилгээний бичиг, №30. Өгүүлэл. УБ, 1999. ХААНС. 164-171 хууд. Монгол.*

Хөдөө аж ахуйг бүсчлэн хөгжүүлэхийн тулд бэлчээр, хадлан, тариалангийн талбайн тархалт бүс тус бүрт харилцан адилгүй байгааг харгалзаж хүн амын хүнсний хангамж, түүхий эдийн нөөц, хэтийн төлвийг тооцон гаргах шаардлагатайг судлан хөдөө аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх асуудалд олон цогц хүчин зүйлс хамрагдаж байгаагийн нэг гол асуудал нь малчин өрхийн аж ахуйг хөгжүүлэх асуудал гэж үзээд малчин өрхийн аж ахуйнуудын нийгэм, ахуйн нөхцлийг сайжруулах, өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгох, малчин өрхийн эдийн засаг, эрх зүйн асуудлыг боловсронгуй болгох гэсэн гурван асуудлыг онцгойлон авч судалжээ.

**Дүгнэлт:** Судлаачид хөдөө аж ахуйг бүсчилэн хөгжүүлэхийн тулд харгалзан үзэх гол асуудлуудад анхаарлаа хандуулжээ. Үүнд, одоо мөрдөж буй бүс тус бүрийн байгалийн нөхцөл, хүн амын тоо, хүн амын мал аж ахуй ба ургамлын гаралтай бүтээгдэхүүний хэрэгцээ, нөөц, хангамжийг 2000-2020 он хүртэлх хугацаанд урьдчилж тооцон гаргасан байна. Судалгаанаас үндэслэж хөдөө аж ахуйг бүсчилж хөгжүүлэхэд зайлшгүй харгалзан үзэх гол асуудлуудыг тоймлон гаргасан байна.

## 0088

Цэдэндамба Л. Батхишиг О. Маам Х.

### Монгол Улсын Өрнөд бүс

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 1999. 290 хууд. Монгол.*

“Монгол улсын Өрнөд бүс” хэмээх энэхүү нэгэн сэдэвт бүтээлд зах зээлийн тогтолцооны нөхцөлд улс орныг бүсчлэн хөгжүүлэх үндэслэл, зарим арга замыг сүүлийн арваад жилд явуулсан судалгаа, шинжилгээний ажлынхаа үр дүнд тулгуурлан онол, практикийн үүднээс цогцолбор байдлаар авч үзэж нэгтгэн дүгнэх оролдлого хийсэн болно.

“Өрнөд бүс”-эд багтах Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймагт явуулсан хээрийн судалгааныхаа үр дүнд тулгуурлан эдгээр аймаг тус бүрийн болон уул бүсийн байгалийн нөхцөл, нөөц, түүхэн газарзүйн тойм, засаг захиргааны хуваарь, нийгэм, эдийн засгийн салбаруудын тодорхойлолтыг өгсний дотор мал аж ахуйн байршил, сүргийн бүтэц, түүхий эд бэлтгэлийн нөөц зэргийн өнөөгийн байдлын дүн шинжилгээ хийжээ.

**Дүгнэлт:** Өрнөд бүсийг хөгжүүлэхийн тулд хүн амын дийлэнхи хэсгийн орлогыг нэмэгдүүлэх, мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг олноор байгуулах, түүнчлэн эрдэс түүхий эдийг ашиглах, замын сүлжээг хөгжүүлэх, эрчим хүчний хангамжийг сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна.

**0089**

Буянтөгс А.

**Монгол, Японы хөдөө аж ахуйн салбарт явуулж байгаа хамтын ажиллагаа**

*“Зүүн хойт Ази судлал” сэтгүүл, №2. Өгүүлэл. УБ, 1999. 20-22 хууд. Монгол.*

Хоёр Засгийн газрын хооронд 1994 оны 3-р сард “Мастер төлөвлөгөө” хийх судалгааны ажлын гэрээ байгуулсан. Энэ судалгаа нь Төв, Сэлэнгэ, Булган, Өвөрхангай, Дархан-Уул, Орхон гэсэн 6 аймгийн хөдөө аж ахуй болон хөдөөгийн тосгоныг иж бүрэн хөгжүүлэх, шинэ техник технологид шилжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хамарчээ.

Мал аж ахуйн салбартай хамт малын тэжээл нийлүүлэх тогтолцоог зохион байгуулах, тус бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Арвайхээр гэх мэтийн том хот болон аймгийн төв зэрэг газарт хуучин сангийн аж ахуйн өмч хөрөнгийг ашиглан сүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээ авах боломжийг судалсан байна.

**Дүгнэлт:** Япон улсын буцалтгүй тусламжаар хэрэгжих энэхүү төсөл нь өнөө үед манай улсын төр засгаас онцлон анхаарч буй хүнсний хангамж, нөөцийг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэхээс гадна цаашид хөрш хоёр орнууд руу хүнсний бүтээгдэхүүнийг экспортлох чадавхийг бий болгоход чухал ач холбогдолтой юм.

**1230 Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагаа**

**0090**

Минжигдорж Б., Найданхүү М., Наранцэцэг Г.

**Буянт мал: малчдад зориулсан гарын авлага**

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2001. Дэлхийн зөн Монгол. 173 хууд. Монгол.*

Манай орны эдийн засгийн үндсэн салбар болох бэлчээрийн мал аж ахуй нь байгалийн гамшигт өртөх магадлал өндөр байдаг онцлогтой. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр сүүлийн жилүүдэд манай оронд байгалийн гамшиг, түүний дотор ган, зудын давтамж ойртон эдийн засаг, нийгэмд ихээхэн хүндрэл учруулж байна.

Иймд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан “Мал сүргийг ган, зудаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн заалтуудад нийцүүлэн Монгол дахь “Дэлхийн зөн” олон улсын байгууллага нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах гол хүч болж байгаа малчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Буянт мал” хэмээх номыг тэдэнд зориулан гаргасан байна.

Энэ бүтээлд малын удмын санд багтдаг олон үүлдэр омгийн малын байршил, онцлог, үржил, ашиг шимийн үндсэн чанар, хэмжээ ялгааг тодорхойлон, малын чанарыг сайжруулахдаа ямар чиглэлийн үүлдэр, омгийг хаанаас авч, хэрхэн ашиглах; мал сүргийг үржүүлэх, түүний удмын санг хамгаалах, зохистой ашиглах, баяжуулан сайжруулах арга барил, анхаарах зүйлс; мал сүргийн үндсэн тэжээл болох байгалийн бэлчээр, түүнийг зөв эдлэх, хамгаалан сайжруулах, төрөл бүрийн тэжээл бэлтгэх, нөөц сан бий болгох, хадгалах, цаг үед нь тохируулан малыг тэжээх, арчилж тордох арга; байгалийн тааламжгүй үзэгдэл, гамшгаас сэргийлэх, хамгаалах, хохирол

багатай давах, мал өвөлжүүлэх, хаваржуулах бэлтгэл хангах; малын эрүүл мэндийг хамгаалах, өвчин эмгэг, түүнээс сэргийлэх, эмчлэх арга барил зэргийг тусгасан байна.

**Дүгнэлт:** Энэхүү бүтээлд мал аж ахуйн үйлдвэрлэлийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, мал аж ахуйн нөөцийг бүрэн ашиглах замаар өрхийн аж ахуйн орлого, ашгийг нэмэгдүүлэхэд хэрэглүүштэй олон чухал үнэ цэнэтэй санаа, мэдээ, мэдээлэл орсон байна.

## 0091

Самбуу Ж.

### Мал аж ахуй дээрээ яаж ажиллах тухай ардад өгөх сануулга, сургаал

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2000. ХХААЯ. 172 хууд. Монгол.*

Бэлчээрийн мал маллагааны талаар олон мянган жилийн туршид эцэг өвгөдөөс хуримтлуулсан туршлага, сургамж байдаг бөгөөд тэр болгоныг уламжлан авч эзэмшсэн нь цөөрсөөр байгааг харгалзан нүүдэлчдийн мал маллах арга ухааныг сурвалжлан хуримтлуулж, түүнээс 1200 орчим сануулга, сургаалийг сонгон авч 19 бүлэгт хураангуйлан ном болгожээ.

Энэхүү зохиолд Монгол орны байгаль газарзүйн онцлогийг хангай, тал хээр, цөл гэсэн 3 үндсэн бүсээр ялгаварлан тодорхойлж, таван хошуу малын бэлчээрийг жилийн дөрвөн улиралд сонгож тохируулах, малын үүлдэр угсааг сайжруулах, хээлтүүлэг, нийлүүлэг явуулах, төл бойжуулах, засаж хөнгөлөх зэрэг арга ажиллагааг зүйлчлэн тусгасан байна.

Мөн хашаа хороо, хадлан бордоо, худаг ус, хужир шүүг малын төрөл, нутгийн байдалд хэрхэн зохицуулах, ган зудын аюулаас мал сүргийг хамгаалах, сэргийлэх, аврах тухай аргачлан заажээ. Түүнчлэн төрөл бүрийн малын сүү шим, арьс шир, ноос ноолуурыг ашиглаж боловсруулах, бод малыг уналга эдэлгээнд сургаж хэрэглэх, мал аж ахуйн тоног хэрэгслийг бэлтгэх зэрэг арга ухааныг нэг бүрчлэн заасан нь нэн ач холбогдолтой юм.

**Дүгнэлт:** Энэхүү бүтээлд бэлчээрийн мал аж ахуйг нүүдлийн аргаар эрхлэн хөтлөх, түүний үр ашгийг нэмэгдүүлэх арга ухааныг цогц байдлаар тусган өгүүлжээ.

## 0092

Авдай Ч., Төмөржав М., Сонгино Ч.

### Монголын нүүдэлчдийн үндэсний уламжлалт технологи

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2003. НСИСОУХ. 384 хууд. Монгол.*

Энэхүү бүтээл нь нүүдэлчид судлал болон үндэсний уламжлалт технологийн судалгаагаар ажилладаг Монгол улсын нэртэй эрдэмтдийн туурвил юм. Нүүдлийн амьдралын хэрэгцээнээс үүдэн байгаль ертөнцийг таньж мэдэх, бэлчээр ашиглах, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах, нүүдлийн хийгээд суурьшмал амьдралын зохицлыг олох талаар монголчуудын хуримтлуулсан мэдлэг, арга туршлага нь шинжлэх ухаан, технологийн зохих өндөрлөгт хүргэсэн билээ. Монголчуудын уламжлалт мэдлэг ухааныг дотор нь одон зурхай, байгалийн ухааны мэдлэг, уламжлалт арга ухаан гэж хоёр томоохон бүлэгт ангилж болох бөгөөд монголчуудын уламжлалт арга туршлагыг энэхүү номонд үндэсний уламжлалт технологи нэрийн дор тоймлон оруулжээ.

НСИСОУ-ын хүрээлэн 2002 онд “Сүү, цагаан идээний технологи” гэсэн ном гаргасан бөгөөд энэ удаа судлаачид мал маллагаа, бэлчээр ашиглалт, мал аж ахуйн бүтээгдэхүүний уламжлалт технологи, мал аж ахуйн тоног хэрэгсэл, нүүдэлчдийн орон сууцны технологи, монголчуудын үйл урлалын уламжлалт ажиллагаа, газар тариаланг өөрийн оронд хөгжүүлсэн уламжлал, мод, металл боловсруулалт, эд зүйлс хийх уламжлалт технологийг цогцод нь уг номонд багтаажээ.

Монгол нутагт амьдарч ирсэн бидний өвөг дээдэс эрт дээр үеэс цаг агаарын эрс тэс уур амьсгалын өвөрмөц нөхцөлд нүүдлийн мал аж ахуй эрхлэн аж төрөхдөө өвөрмөц шинж чанартай үндэсний уламжлалт технологи хэмээн нэрлэгддэг мал маллах, мал аж ахуй, газар тариалан, байгалийн гаралтай түүхий эдээр элдэв төрлийн бүтээгдэхүүн, эд зүйлс хийх арга барилтай болж, түүнийгээ амьдралын явцад улам боловсронгуй болгон хөгжүүлсээр хойч үедээ өвлүүлэн үлдээж иржээ.

**Дүгнэлт:** Монголын уламжлалт технологийн талаар гадаад, дотоодын эрдэмтэд, судлаачид олон жилийн турш судалгаа явуулж, үр дүнгий нь хэсэгчилсэн байдлаар ном, хэвлэлээр нийтэлж байсан бөгөөд толилуулан буй энэхүү бүтээлд зохиогчид судалгааны материалуудаа бололцооны хэрээр нэгтгэн цогц байдлаар гаргах зорилго тавьсан байна.

## 0093

Батаа Д.

### **Бэлчээрийн мал аж ахуйг эрхэлж ирсэн монголчуудын уламжлалт арга**

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 1998. 152 хууд. Монгол.*

Нүүдлийн мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбогдсон олон талт асуудлыг авч үзэхдээ юуны өмнө орчин зүйн буюу экологийн нөхцөл болох нутаг бэлчээр, газрын хөрс, ус, ургамал, уур амьсгал зэрэг олон хүчин зүйлсийг авч үзэх хэрэгтэй. Судалгаанаас үзвэл манай орны хөрс, ургамал, бэлчээр, чийг, тунадас, салхи, температур зэрэг байгаль орчны хүчин зүйлүүд нь малын үржил, хувьсал, ашиг шимд нөлөөлөх байгалийн тэнцвэрт харилцааны гол үндэс болдог байна.

Нүүдэлчдийн ардын уламжлалт сүү цагаан идээ боловсруулах, мах, махан бүтээгдэхүүн бэлтгэж ашиглах, арьс шир боловсруулах, ноос, ноолууран бүтээгдэхүүн бэлтгэх арга ажиллагааг сэргээж, орчин үеийн нарийн технологитой хослуулж үйлдвэрлэл явуулбал илүү үр ашигтай гэдгийг санал болгожээ.

**Дүгнэлт:** Судлаач Монголын бэлчээрийн мал аж ахуйг эрхэлж, хөтөлж ирсэн ардын уламжлалыг, түүний дотор мал хариулж, тарга хүч авахуулах, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулан ашиглах, тэнгэрийн араншинг уншиж, таньж мэдэх арга ухааныг илүү гүнзгий тайлбарлажээ.

## 0094

Баянжаргал Ч.

### **Монголын эдийн засгийн түүх**

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2001. 275 хууд. Монгол.*

Монгол Улс эрт дээр үеэс мал маллаж, мал аж ахуй эрхэлж, түүгээрээ амьдарч ирсэн түүхтэй. Иймд мал аж ахуйн Монгол Улсын эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь одоо үед ч гэсэн их байгаа билээ. Тус бүтээл нь 2 үндсэн хэсэг, 9 бүлэг, 36 зүйлээс бүрдэж байна.

Нэгдүгээр хэсэгт, тулгар бүтээл, зохиолуудад тулгуурлан Монгол нутаг дээр нэн эртний хүмүүс мал аж ахуй эрхэлж ирсэн тэр цагаас ХХ зууны 90-ээд он хүртэлх үеийг үндсэнд нь хамарч, тоймлон бичжээ.

Хоёрдугаар хэсэгт, сүүлийн 10 жилийн байдлыг тусгажээ.

**Дүгнэлт:** Судлаач бүтээлдээ Монгол Улсын эдийн засгийн түүхийг бүр балар эртний үеэс одоог хүртэлх хугацааг хамруулан бичжээ гэж хэлж болно.

Эрт дээр үеэс мал сүргийг яаж өсгөж байсан, хаад ноёдууд мал аж ахуйн салбарт хэрхэн хандаж байсан, энэ салбарыг хөгжүүлэхийн тулд юун дээр анхаарах вэ, яаж шийдэж байсан гэх мэт түүхийн асуудлыг хөндсөн бүтээл болжээ. Энэхүү бүтээлд бэлчээрийн мал аж ахуйн талаар тоймлон түүхчилж авч үзсэн бөгөөд нарийвчилсан судалгаа хийгээгүй болно.

**0095**

Лхагважав С.

**Мал маллах уламжлалт ухаан**

*Эрдмийн бичиг, №1. Өгүүлэл. УБ, 1998. ХААИС, Эдийн засгийн факультет. 96-101 хууд. Монгол.*

Энэ өгүүлэлд өвөг дээдсийнхээ мал маллах уламжлалт арга ухааныг орчин үеийн шинжлэх ухааны аргатай хослуулж чадвал түүний үр өгөөж дээшлэх боломжтой гэсэн санаа дэвшүүлсэн судалгаа хийжээ.

**Дүгнэлт:** Бэлчээрийн мал аж ахуй эрхэлж буй хүн хамгийн гол нь нутаг усаа зөв сонгох, бэлчээрийг зохистой ашиглах, нүүдлийн нөхцөлд зохицсон аргаар малаа маллах, нүүдэл суудлаа оновчтой зохион байгуулах, бэлчээрт байх малын тоо, төрөл зэргийг харгалзан экологийн тэнцвэрийг алдагдуулахгүй байхад анхаарч, үйлдвэрлэлээ зохион байгуулж, үйл ажиллагаа явуулах талаар зөвлөмж өгсөн байна.

**0096**

Намжим Т.

**Монголын аж ахуйн эдийн засаг түүхэн гурван үед**

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2000. 1016 хууд. Монгол.*

Монголын нийгмийн байгуулал, хөгжил замналын түүхэн цаг хугацааны гурван хэлхээнд аж ахуй, эдийн засгийн олон зууны уламжлал, өсөлт дэвшил, хоцрогдол дутагдлыг хамруулан авч үзжээ. Үүнд:

- I хэсэгт феодалын нийгэм буюу Их Монгол улсаас эхлэн Богд хаант Монгол улсын үеийг хамарсан ба энэ үед бэлчээрийн мал аж ахуй нь бараг дангаараа улс орны эдийн засаг, ахуй амьдралын үндсийг бүрдүүлж байжээ.
- II хэсэгт Монголын шинэ эрин үе буюу 1921 оны хувьсгалаас 1990 он хүртэлх үе хамрагдсан. Энэ хэсэгт Монгол орны нийгэм, эдийн засгийн бодлого, уугуул салбар-мал аж ахуйн өсөлт өөрчлөлт, үйлдвэрлэл, үйлчилгээний бусад шинэ салбаруудын үүсэл хөгжил зэрэг асуудлууд тусгагдсан.
- III хэсэгт Монгол Улс нийгэм, улс төрийн шинэ тогтолцоог бүрдүүлж, зах зээлийн эдийн засгийн горимд шилжиж байгаа сүүлийн 10 жилийн эдийн засгийн тухай авч үзсэн. Тухайлбал: хувьчлалын үр дүнд хөдөө аж ахуйн нэгдэл тарж, мал хувийн өмчид шилжсэн тухай, сангийн аж ахуйнууд татан буугдаж, газар тариалангийн олон жижиг компаниуд үүссэн түүхэн үйл явцыг тусгасан байна.

**Дүгнэлт:** Судлаач бэлчээрийн мал аж ахуйн түүхэн хөгжлийг эрдэмтэд судлаачдын бүтээлээс түүвэрлэн нэгтгэж бүлэглэн дүгнэлт хийх оролдлого хийжээ.

**0097**

Потаев Виктор Сергеевич

**Монгол туургатны уламжлалт мал аж ахуйн хөгжлийн түүх - эдийн засгийн үндэс**

*Доктор (Sc.D)-ын диссертацийн хураангуй. УБ, 2003. ШУА. 33 хууд. Монгол.*

Монголын мал аж ахуй бүтцийн хувьд Буриадынхаас ялгагдах онцлог бол эрс өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзсэн байна. Харин Монголд шилэлт, сонголт хийх замаар малын төрөл, үүлдрийг боловсронгуй болгоход илүү анхаарал тавих хэрэгтэй.

Монголчуудын уламжлалт мал аж ахуйг хөгжүүлэх үндсэн арга зам нь Буриад ба Монголд малчин өрхийн аж ахуйн хэлбэр юм. Цаашид фермерийн аж ахуй болж хөгжих ёстой. Гэвч Буриад болон Монголд мал аж ахуйн эрчимжилтийн хэтийн төлөв хязгаарлагдмал байгаа юм. Эдгээр улсын байгаль-цаг уурын хүнд нөхцөл,

байршил нь газар тариаланг эрчимтэй хөгжүүлэхэд саад тотгор болж байгаа бөгөөд юуны өмнө мал аж ахуйг хөгжүүлэхэд үндсэн арга зам нь эрчимгүй хөгжил байхыг үгүйсгэх аргагүй гэж судлаач үзжээ.

Сүүлийн жилүүдэд дэлхийн хөдөө аж ахуйд альтернатив гэж нэрлэгддэг технологи өргөн хэрэглэгдэх болж байна. Түүний нэгд Монголчуудын уламжлалт мал аж ахуйг оруулж болох юм. Монголын мал аж ахуйд химийн хүчтэй хэрэгслүүдийг бараг ашигладаггүй. Уламжлалт мал аж ахуйн үндэс нь байгалийн бэлчээрийн өвс тэжээл, өтөг бууц ашиглах явдал юм.

Буриад, Халимаг улсад уламжлалт мал аж ахуйг сэргээн хөгжүүлэх төрийн бодлого чухал байна гэж судлаач үзжээ.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн бүтцийн өөрчлөлтөд санхүүгийн нөөцийг оновчтой зөв хуваарилахаас гадна, уламжлалт мал аж ахуйн бүтээгдэхүүнд дотаци өгөх, орлогын татварыг хөнгөлөх, зээл олгох явдал чухал юм.

Тухайлбал, бэлчээрийн мал аж ахуй нь улсын зүгээс туслалцаа, дэмжлэггүйгээр бие даан хөгжихөд бэрхшээлтэй гэдгийг бидний туулсан замаас харж болох юм гэж үзсэн байна.

## 0098

Содной Т.

### Чингис хааны гүр улсын мал аж ахуй

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2001. 78 хууд. Монгол.*

Монголын нүүдлийн мал аж ахуйн түүхэн хөгжлийг туулсан цаг хугацааны хувьд дараах 3 үед хувааж болно. Үүнд, 1) Монгол нутаг дээр оюун ухаант хүн аж төрж, зэрлэг амьтныг мал болгон хувиргах болсон цагаас нүүдлийн мал аж ахуйтай болох хүртэлх; 2) Сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй бий болсон үеэс XX зууны эхэн үе хүртэлх; 3) XX зууны эхнээс 1990-ээд он хүртэлх үе гэж ангилсан байна.

Энэ 3 үе шат нь өөр өөрийн хөгжлийн оргил үе шаттай байсан. Тухайлбал, нэгдүгээр үеийн оргил нь Хүннү гүрний үе буюу 2000 гаруй жилийн тэртээгээс сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй бий болсон үе юм.

Хоёрдугаар үеийн оргил нь Чингис хааны гүр улсын буюу XIII-XIV зуун юм. Энэ үед Монголын малын үүлдэр нь Хятад, Солонгос, Араб зэрэг орны малын үүлдрүүдтэй үржилд орох бололцоотой байсан нь Монгол орны малын удмын санг баяжуулж, малын үүлдэр бүрэлдэн тогтох нэгэн үе шат болсон. Энэ үед дээдсийн сүргийг бий болгож "Их засаг" хуулийн чанга заалтаар мал сүргийг хамгаалж, мал аж ахуйн үйлдвэрлэлд хөдөлмөрийн хуваарь бий болсон.

Гуравдугаар үед Монголын нүүдлийн мал аж ахуй нь шинжлэх ухаантай золгож, малын шинэ шинэ үүлдэр бий болсон, нэгдэл үүсэж, малчид хөдөлмөрөө хорших болсон зэрэг онцлогуудтай.

**Дүгнэлт:** Монгол судлаач Японы эрдэмтэн Онуки Масаогийн 1988 онд бичсэн "... Нүүдлийн мал аж ахуй нь Монголд уламжлалт мал аж ахуйн дэвшилтэй талаа батжуулан амьдарч байгаль, нийгэм, түүхийнхээ нөхцөлд зохицон үр дүнгээ өгөх өвөрмөц ажлыг туршиж байгаа мэт санагдана" гэсэн санааг нотлоход чиглэсэн арга зүйгээр бичжээ.

## 0099

Сонгино Ч.

### Монголчуудын үйл урлахуйн эрдэм ухаан

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 1999. 301 хууд. Монгол.*

Бидний өвөг дээдэс өлгий нутагтаа иргэншин сууж амьдралын эх сурвалж болсон ан амьтныг гаршуулан малжих суурийг тавьж, малынхаа аясаар өргөн уудам нутагтаа нүүдэллэн аж төрөхдөө малын гаралтай түүхий

эд боловсруулах, үйл урлах, дархан, мужаан гэх мэт амьжиргааны олон үйлдвэрлэлийг нүүдлийнхээ онцлогт тохируулан хөтлөн хөгжүүлж иржээ. Эдгээрийн дотроос үйл урлах ажил нь нүүдэлчний эн тэргүүнд бий болгосон ууган үйлдвэрлэл бөгөөд нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирснийг илтгэх асар том баталгаа юм.

**Дүгнэлт:** Нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн монголчуудын олон зуун жилийн амьдрал, туршлагын үр дүнд бий болсон соёл болон үйл урлалыг төрөлжүүлэн нарийвчлан судлах, тэрнээс үүдэлтэй үндэсний ёс заншил, дэг журмыг залуу үеийн төлөвшил хүмүүжлийн нэгэн эх сурвалж болгоход үйл урлалтай холбоо бүхий энэхүү бүтээл чухал ач холбогдолтой.

## 0100

Хавх Н.

### Монголын нүүдлийн мал аж ахуйн гүн ухаан

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2000. МУИС-ийн Буддын соёл судлалын төв. НСИСОУХ. 180 хууд. Монгол.*

Аль ч улсад стратегийн ач холбогдолтой буюу эдийн засгийн гол салбар гэж бий. Тэрхүү салбар нь нийгмийн амьдралын бусад салбарын оршин тогтнох үндэс, суурь нь болдог. Монголчуудын хувьд тийм салбар бол бэлчээрийн мал аж ахуй.

Монголчуудын соёл иргэншил, ер нь монголын нийгмийн оршин тогтнох үндсийн үндэс гэвэл бэлчээрийн мал сүрэг, түүнийг дагасан аж ахуй, дээр нь газрын баялаг. Монгол хүний зан заншил нь ч, урлаг соёл нь ч нүүдлийн мал аж ахуйгаасаа ямар нэгэн хэмжээгээр шалтгаалж, улс төрийн бодлого нь ч түүнийг тогтвортой, тэнцвэртэй байлгахад чиглэгдэнэ. Бэлчээрийн мал сүрэг нь эх газрын эрс тэс байгаль, цаг агаартай зохицсон, аж ахуй нь бэлчээрийн мал сүрэгтээ зохицсон, нийгмийн амьдралын бусад салбар нь тэрхүү мал аж ахуйтайгаа зохицон бий болсон нүүдлийн хэмээх соёл иргэншилтэй явж ирсэн улс үндэстний нэг бол монголчууд. Монголчуудыг нүүдлийн мал аж ахуйгаас нь салгаваас монголын гэж нэрлэгдэх соёл иргэншил тэр чигээрээ устаж үгүй болно.

Бэлчээрийн мал сүрэг нь эдийн засгийн хувьд хөрөнгө зардал нэн бага гарах хэрнээ орлогыг их оруулдаг, хөрөнгө, мөнгө, техникийн хүч чадлаар биш, байгаль, цаг агаартай зохицох хэр хэмжээгээр арвижин өсөж, хөгжиж байдаг, бараг цэвэр ашигтай аж ахуй. Танин мэдэхүйн талаасаа гэвэл, байгалийн шалгарлын хуулиар чанар чансаа нь сайдаж муудаж, ашиг шим нь ихсэж багасаж, тоо толгой нь өсч буурч байдаг мал сүрэг. Хүний идэвхтэй үйл ажиллагааны талаасаа гэвэл Монгол орны байгаль, цаг уурын тэнцвэрт тогтолцооны нарийн учир, түүнтэй бэлчээрийн мал сүргийн зохицон амьдрах хууль, тэрхүү хуулийн дагуу мал сүргийн дотор шалгарал явагдах зүй тогтлыг сайтар танин мэдэж, түүний дагуу төрөөс бодлогоо явуулах, малчин хүн мал маллах ухаанаа гаргах учиртай тийм өвөрмөц аж ахуй болохыг судалсан байна.

**Дүгнэлт:** Судлаач бүтээлдээ ертөнцийн хөгжил хөдөлгөөний уг сурвалж хэмээн тооцогддог зөрчлийн тухай дорно дахины, түүний дотроос буддын гүн ухааны арга билиг, таван махбодын онол сургаалын арга зүй, удирдлага болгон Монголын бэлчээрийн мал аж ахуйн орших, хөгжих зүй тогтлыг гүн ухааны түвшинд гарган тайлбарлажээ.

## 0101

Хавх Н.

### Нүүдлийн соёл иргэншлийг судлах орчин цагийн ач холбогдол

*“Nomadism-International Study” товхимол. Өгүүлэл. УБ, 2002. НСИСОУХ. 48-52 хууд. Монгол.*

Хүн төрөлхтний түүх нүүдэлчдээс эхэлсэн, эхэн үеийн түүхийг нүүдэлчид бүтээсэн гэдгийг хүн бүр хүлээн зөвшөөрөх байх. Германы сонгодог гүн ухааны нэрт төлөөлөгч Гегель “нүүдэлчин ард түмэн бол түүхээ үлдээж чадталаа хөгжиж чадсан улс ... түүхийг тэднээс эхэлсэн гэж үзвэл зохино” гэжээ (Гегель, Философия истории,

соч. Т. VIII. 96 дахь тал). Хожмоо дэлхийн нүүдэлчин олон улс үндэстнүүд суурьшлын соёл иргэншилд эргэлт буцалтгүй орж дэлхий дахин суурин иргэд төвтэй соёл иргэншилд орсоор олон зуун жилийн нүүр үзэж байна.

Суурин соёл иргэншлийн хөгжлийн өнөөгийн шатнаас нүүдэлчдийн соёл иргэншлийн нууцыг эрж хайх, танин мэдэх шаардлага гарч байна. Үүнийг гүн ухааны үүднээс тайлбарлавал: соёл иргэншил нь байгальтай зохицох, түүнийг өөрчлөх үйл ажиллагааны шүтэлцээгээр хөгжинө, нүүдлийн соёл иргэншилд байгальтай зохицох нь давамгайлж байхад суурин соёл иргэншилд өөрчлөх нь давамгайлна, зохицох нь хэт урт удаан хугацаагаар давамгайлваас хөгжил удааширч, царцанги байдалд орж хоцрогдоно, нүүдэлчид дэлхийн түүхэнд тэргүүлэх, дэвшилтэт үүргээ алдсаны цаад учир энэ гэж тайлбарлажээ.

Байгалийг экологийн аюулд оруулахгүйгээр эрхэлж болох аж ахуй гэвэл нүүдлийн мал аж ахуй. Нүүдлийн мал аж ахуй нь байгальтай хүйн холбоотой, тодотгож хэлбэл, байгалийн шалгарлын хуулиар тоо толгой нь өсч буурч, чанар чансаа нь сайжирч, муу нь үхэж үрэгдэж, сайн нь үлдэж хоцорч байдаг тийм мал аж ахуй юм. Зуднаар, мөн хавар, өвөл хоёр юм уу малчны сул дорой мал үхэж үрэгдэнэ, сайн малчны сайн чанартай мал шалгарч хоцордог болохоос биш өнөө үед зарим хүмүүсийн ярьдаг шиг нүүдлийн мал зуднаар үхэж үрэгдээд, нүүдлийн мал аж ахуйд найдахын аргагүй болчихоод байгаа юм биш гэж судлаач үзжээ.

**Дүгнэлт:** Монголчууд Монгол орны байгаль, газарзүйн орчны хуулийг сайтар танин мэдэж, тэгснээрээ байгалийн тэнцвэрийн хуулийг зөрчилгүйгээр аж ахуйгаа эрхэлж, түүнийг дагасан соёл иргэншлээ бий болгосоор ирсэн түүхтэй гэсэн дүгнэлт хийжээ.

Ирээдүйдээ хүн төрөлхтөн суурьшаар байх уу, аль эсвэл нүүдлийн амьдралд шилжих үү? Байгалиа экологийн аюулд оруулахгүйгээр соёл иргэншлийг хөгжүүлэх ухааны үндсийг нүүдэлчдийн сонгодог соёл иргэншлээс авч орчин цагийн техникийн соёл иргэншлийн өндөр түвшинд хүрэх явдал хүн төрөлхтний ирээдүй мөн байх. Энэ бол нүүдэл суурьшил хоёрын нэгдэл мөн гэж дүгнэжээ.

## 0102

Цэрэнханд Г.

### Монголын нүүдэлчдийн байгальтай дасан зохицохуйн мэдлэг ухааны уламжлал

“Mongolica” сэтгүүл, №13. Өгүүлэл. УБ, 2003. МСОВХ. 210-214 хууд. Монгол.

Малчдын нүүдэл бол байгаль-цаг уурын өөрчлөлт, мөчлөгтэй салшгүй холбоотойгоор амьдрал байдлаа зохицуулах үндсэн арга билээ. Иймээс нүүдэллэх ёс бол зүйл зүйлийн утга агуулга бүхий аж төрөх мэдлэг ухаан болно. Нүүдэл бол бэлчээр хамгаалах, малын тарга тэвээрэг авахад ашигтай. Талхлагдсан бэлчээр нь малын өвчний нян үүсгэх аюултай гэж үздэг.

Нүүдэл, нүүдэллэх ёс заншил тухайн бүс нутгийн онцлогтой шууд холбоотой. Тухайлбал, хангай нутгийн малчид зуны цагт гол усандаа ойртож нүүдэг бол Алтай нутгийн урианхай, торгууд, захчин, дөрвөд зэрэг монгол угсаатны бүлгүүд уулын нүүдлийн хэлбэрээр өндөрлөг нутагтаа зусч, өвлийн улиралд уулын бэл орчмоор нүүдэллэн өвөлждөг талаар угсаатан судлалын ном хэвлэлд тодорхой тусчээ. Байгаль орчны тухай манай нүүдэлчдийн мэдлэг нь бэлчээрийн мал аж ахуй эрхлэх амьдралын шаардлагаас үялдан гарчээ. Нүүдэлчид мал маллахдаа жилийн улирал солигдох, цаг уурын таатай, таагүй байдал зэргийг урьдчилан мэдэхийг чухалчилж байсны үр дүнд тэдэнд жил улирал солигдох, цаг агаарын өөрчлөлтийг мэдрэх тодорхой хэмжээний арга, зөн билэг хуримтлагддаг ч байж болно. Бэлчээрийн өвс ургамлыг таньж, шилэн сонгох арга ухаанд малчдыг нүүдлийн ахуй, байгаль орчин нь сургасан гэж судлаач үзжээ.

**Дүгнэлт:** Нүүдэлч малчид амьдрах орчныхоо талаар арвин түршлага, мэдлэгтэй байсан нь үеэс үед уламжлан хадгалагдаж оршин зохицохуйн ёс заншлаар аж төрж, нутагшил, нүүдлийн тогтсон дэг журам, соёлтой байсан тухай дэлгэрэнгүй тайлбарласан байна.



## 0103

Эрдэнэцогт Н.

### Монголын нүүдлийн мал аж ахуй

Нэг сэдэвт бүтээл. УБ, 1998. 302 хууд. Монгол.

Монгол улсын үүсэл хөгжил, доройтол сэргэлт зэрэг түүхийн урт бартаат замд манай нүүдэлчдийн дархлан бүтээж, дагнан эрхэлсээр ирсэн цорын ганц тулгуур аж ахуй бол бэлчээрийн сонгодог мал аж ахуй юм.

Монголчууд таван төрлийн мал аж ахуйг өөр хооронд нь харилцан шүтэлцээтэйгээр нүүдлийн аргаар хөтлөн эрхэлж эдийн засгийн харилцааны бүхэл бүтэн тогтолцоог буй болгосон байдаг.

Энэхүү бүтээлд нүүдлийн мал аж ахуй эрхлэх хэлбэрүүд, монгол малын биологи, экологи, дасан зохицох чадвар, монголчуудын малын ашиг шимийг боловсруулж ашиглах арга ажиллагаа, мал маллах ухаан, сонгодог мал аж ахуйг эрхлэн хөтлөх арга ажиллагааны зүй тогтол зэрэг чиглэлээр Монголын нүүдлийн мал аж ахуйн өнгөрсөн, өнөө, ирээдүйг хамруулан судалсан байна.

**Дүгнэлт:** Уг бүтээлд Монголын нүүдлийн мал аж ахуйн бүрэлдэхүүн, бүтэц, шинж чанаруудыг тодорхойлж, түүний арга ажиллагааг бие даасан 3 тогтолцоонд (малчид-нутаг бэлчээр-мал сүрэг) ангилан задалж, улмаар тэдгээрийн шинжлэх ухааны онол, аргазүйн үндэслэлийг нэгтгэн дүгнэж, эдгээр нь биологи, экологи, этологи, эдийн засгийн шинжлэх ухааны гүн үндэслэлтэй, онол практикийн их ач холбогдолтойг тогтоожээ. Үүнээс гадна мал аж ахуй хөтлөх арга ажиллагааны хөгжлийн зүй тогтол, хандлагыг тодорхойлсонд тус бүтээлийн ач холбогдол оршиж байна.

## 0104

Эрдэнэцогт Н.

### Монголын нүүдлийн сонгодог мал аж ахуй, иргэншлийн хөгжлийн хэтийн төлөв

"Mongolica" сэтгүүл, №9. УБ, 1999. МСОУХ. 445-455 хууд. Монгол.

Зохиогч сүүлийн 10 гаруй жил монголын нүүдлийн мал аж ахуйн агуулга, бүтэц, бүрэлдэхүүн, шинж чанар, түүний оршин байх онцлог, хөгжлийн зүй тогтол зэргийг биологи, экологи, эдийн засаг зэрэг шинжлэх ухааны олон салбарын хүрээнд авч үзэж нүүдлийн мал аж ахуйг иж бүрэн судлах чиглэлийг тогтоосны хамт цаашдын хөгжлийн зүй тогтол ямар байх, арга зам нь юу болох талаар бичжээ.

Монголын нүүдлийн мал аж ахуй нь нүүдлийн, эдийн засгийн, экологийн, улирлын, сонгодог таван үндсэн шинж чанартай, уламжлалт суурь ба дэд бүтэцтэй гэсэн санаа дэвшүүлсэн байна.

Монголын нүүдлийн мал аж ахуй нь хүн (малчин) – байгаль (бэлчээр нутаг) – мал сүрэг (5 хошуу мал) гэсэн 3 үндсэн харилцан шүтэлцсэн тулгууртай, мал сүргийг өсгөх маллах арга ухаан, малын ашиг шимийг ашиглах арга ухаан, малыг уналга эдэлгээнд сүрган ашиглах арга ухаан гэсэн 3 хэсэгтэй гэж үзжээ.

**Дүгнэлт:** Монголын нүүдлийн мал аж ахуйг цогцоор судлан түүний хөгжлийн зүй тогтлыг дараах байдлаар томъёолон гаргах санал дэвшүүлжээ. Үүнд:

- Нүүдлийн мал аж ахуйн суурь бүтцийн хөгжлийн зүй тогтол,
- Нүүдлийн мал аж ахуйн дэд бүтцийн хөгжлийн зүй тогтол,
- Монголын нүүдлийн мал аж ахуйд орчин үеийн зах зээлийн тогтолцоо үүсэн хөгжих зүй тогтол.

## ГУРАВ. МАЛ АЖ АХУЙН МАРКЕТИНГ

### 1310 Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл

#### 0105

Бадарч С.

#### **Мал аж ахуйн маркетингийн системийг бүрдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, баримтлах бодлогын хувилбар**

*Эрдэм шинжилгээний бичиг, №30. Өгүүлэл. УБ, 1999. ХААНС. 181-184 хууд. Монгол.*

Мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний дотоод зах зээл, маркетингийн системийг бүрдүүлэгч хамгийн гол нөхцөл болох дараах хэдэн асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзсэн байна. Үүнд:

- Мал аж ахуйн түүхий эдийн зах зээлийг бүрдүүлэгч үндсэн үйлдвэрлэгч болох малчин өрхийн аж ахуйг жинхэнэ үйлдвэрлэгчийн түвшинд хүргэх;
- Боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг мал аж ахуйн байршлыг харгалзан байгуулах;
- Үйлдвэрлэл эрхлэгчдийг сайн зохион байгуулагдсан борлуулалтын сувагтай болгох.

Судалгааны дүнгээс үзэхэд манай орны мал аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийг хэрэглэгчдэд хүргэх, эргээд малчдад шаардлагатай бараа, техник, технологийг бэлтгэж нийлүүлэх үүрэг бүхий зуучлагчдын дараах хэлбэрүүд байх нь зохимжтой гэж үзсэн байна. Үүнд:

- Малчин өрхүүдэд үйлчлэн зуучлах үүрэг бүхий хангамж, бэлтгэн нийлүүлэлтийн хоршоо байгуулах, үүнийг Засгийн газраас дэмжих;
- Мал аж ахуйн гол нэр төрлийн бүтээгдэхүүн, түүхий эдийн байршлын онцлогийг харгалзан төрийн болон хувийн томоохон үйлдвэр, компанийн төлөөлөгчдийн газруудыг орон нутагт олноор байгуулах;
- Дэд бүтцийн салбарын хөгжил, үйлдвэрлэгчид, хэрэглэгчид болон бүтээгдэхүүн, түүхий эдийн нөөцийн байршлыг харгалзан бөөний худалдааны сүлжээ байгуулан ажиллах.

**Дүгнэлт:** Судлаач Монгол Улсын мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэгцээ, хангамжийн одоогийн байдлыг авч үзсэний үндсэн дээр мал аж ахуйн бүтээгдэхүүний маркетингийн системийг бүрдүүлэх, энэ талаар төр засгаас авч хэрэгжүүлж болох бодлогын хувилбарыг дэвшүүлсэн байна.

#### 0106

Бадарч С.

#### **Монгол Улсын махны маркетингийн иж бүрдэл**

*Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ, 2002. ХААНС. 138 хууд. Монгол.*

Монгол орны мал аж ахуйн гол нэр төрлийн түүхий эд, бүтээгдэхүүнээс мах махан бүтээгдэхүүн нь дотоод, гадаад зах зээлд эрэлт хэрэгцээтэй, эдийн засагт эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргээрээ онцгой ач холбогдолтой юм. Монгол орны махны нөөц гол төлөв малчин өрхийн аж ахуйн анхдагч нэгж дээр үйлдвэрлэгдэх болсон тул түүнийг нэгдсэн журмаар цуглуулах, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, ашиглах талаар ихээхэн хүндрэлтэй байна.

Монгол орны нөхцөлд дунджаар 5 ам бүлтэй малчин өрхийн хувийн аж ахуй нутгийн монгол үүлдрийн мал сүргээр тооцвол 350-иас доошгүй зохих харьцааны 5 төрлийн малтай байвал сүргийн нөхөн үйлдвэрлэл хэвийн

явуулж, өөрсдийн өрхийн хэрэгцээг хангаад илүүдэл бүтээгдэхүүн, түүхий эдийг зах зээлд борлуулах боломжтой талаар эрдэмтэд тооцсоныг энэ судалгаагаар давхар нотолсон байна.

Монгол орны нөхцөлд мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн багтаамж бага, хэрэглэгчдийн байршил нь мал сүргийн байршилтай тохирдоггүй тул эдгээрийн хооронд цаг хугацааны болон орон зайн алслалт их байдаг онцлогтой байна.

Монгол Улсын махны маркетингийн иж бүрдлийг бүрдүүлэх арга хэмжээний талаархи бодлого нь бүс нутгаар ялгаатай, дэс дараатай хэрэгжүүлэх цогцолбор асуудал бөгөөд үүнд цаг хугацаа, хөрөнгө хүч нэлээд шаардагдах болно. Гэвч үүнийг төрийн бодлогын хэмжээнд авч хэрэгжүүлэхгүйгээр мал аж ахуйн үйлдвэрлэлийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх асуудлыг цэгцтэй, бага зардалтай, харьцангуй богино хугацаанд иж бүрэн шийдвэрлэх боломж хязгаарлагдмал гэж үзсэн байна.

**Дүгнэлт:** Судалгааны дүнгээс үзэхэд махны маркетингийн бүрдэлтэд малчин өрхүүдийн үүсгэл санаачлагаар тэдний хувь нийлүүлсэн хөрөнгөөр үйлчлэх, зуучлах үүрэг бүхий хоршоо байгуулан хамтран ажиллах явдал чухал гэж үзсэн байна.

Мөн мал аж ахуйн маркетингийн системийг бүрдүүлэх зуучлалын хэлбэрүүд нь гол төлөв хувийн хэвшилд үндэслэгдсэн байх боловч үйл ажиллагаа нь төрөөс хянах системтэй байх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлжээ.

## 0107

Бадарч С.

### **Монголын мал аж ахуйн маркетингийн өнөөгийн тулгамдсан асуудлууд**

*Эрдэм шинжилгээний бичиг, №31. Өгүүлэл. УБ, 2002. ХААИС. 145-149 хууд. Монгол.*

Монголын бэлчээрийн мал аж ахуй дахь малчин өрхийн дийлэнх нь цөөн тооны малтай тул өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах чадвар сул, таваарлаг шинж чанар алдагдахад хүрч байна.

Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах дэвшилттэй техник технологи нэвтрүүлэх, жижиг дунд үйлдвэрийг орон нутагт байгуулж ажиллуулах асуудал удаашралтай байна. Мөн малчин өрхийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах найдвартай, тогтмол ажиллагаатай зуучлагчид үгүйлэгддэг боллоо. Үүнээс гадна Монгол Улсын малчин өрхүүдийн тархай бутархай байршил, дэд бүтцийн сул хөгжил нь тэднийг зах зээлтэй зөв зохистой холбоход хүндрэл учруулж байна. Тухайлбал, бүтээгдэхүүн, түүхий эдийн зах зээлийн үнэ ханш болон бусад төрлийн шаардлагатай мэдээллээр цаг тухайд нь шуурхай хангах систем байхгүйгээс малчид зуучлагч, худалдаачдад бүтээгдэхүүн, түүхий эдээ борлуулахдаа болгоомжлох байдалтай байна.

**Дүгнэлт:** Энэхүү судалгаа малчин өрхийн түүхий эд, бүтээгдэхүүний борлуулалтад нөлөөлж буй хүчин зүйлсээс гадна цаашид авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, боломж зэргийг тодорхойлсноороо чухал ажил болжээ.

## 0108

Ралф Ван Гелдер

### **Монголын мал аж ахуйн үйлдвэрлэлийн зах зээлд саад болж буй зарим хүчин зүйлүүд**

*"Nomads and Use of Pastures Today" товхимол. Өгүүлэл. УБ, 2000. НСНСОУХ. Англи.*

Мал аж ахуйн бүтээгдэхүүний маркетингийн тогтолцоонд хамгийн анхаарал татсан асуудал бол хөдөөгийн хүн амын өмч, тэдгээрийн орлого, амьжиргааны түвшин юм.

Монголын хөдөөгийн хөгжлийн зах зээлийн үр ашигтай тогтолцоо нь хөрөнгө оруулалт болон дэд бүтцээс шалтгаалахын хамт мөн малчин өрхийн үйлдвэрлэл, бизнесийн үр ашиг, түүхий эдийн чанараас ихээхэн

хамааралтай юм. Малчид зөвхөн өнөөдрийн ашгаа бодож худалдаа арилжааг нэг удаагийн үйлдэл мэт сэтгэн ажиллаж байгаа нь түүхий эдийн чанарыг орхигдуулахад хүргэж байна.

Монголын мал аж ахуйн гаралтай түүхий эдийн чанар дэлхийн зах зээлийн шаардлагыг хангахгүй байгаа юм. Үүнийг давж гарахын тулд малчид зах зээл дээр шударга өрсөлдөөнөөр ажиллаж сурах хэрэгтэй байна.

Малчид түүхий эдийн чанар гэж юу болохыг ойлгохгүй бол, чанараа сайжруулахад зардал гаргахгүй бол зах зээлд чанартай түүхий эд нийлүүлж чадахгүй.

Малчид малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн шаардлагыг тэр бүр мэддэггүй, харин зөвхөн үнийн талаар ойлголттой байна.

**Дүгнэлт:** Малчдад зах зээлийн боловсрол олгох, тэднийг мэдээллээр хангах, өөр хоорондоо хоршиж ажиллах явдал нэн чухал гэж судлаач үзсэн байна.

## 0109

Лувсандорж С.

### Малчдын зах зээлийн эдийн засагт шилжих эдийн засгийн арга хэлбэрүүд

*"Market-Economy Nomads-Technology" товхимол. УБ, 2002. НСНСОВХ. 132-137 хууд. Англи.*

Монголчууд дэлхийн мал аж ахуйн түүхий эдийн зах зээлд нэвтрэх асуудлыг шийдвэрлэхдээ өөрсдөө дэлхийн зах зээлтэй харилцах, мөн Монголд худалдаа хийж байгаа гадаадын компаниудаар дамжин нэвтрэх 2 арга замыг ашигласан.

Өнөөдөр дэлхий дахинд даяаршлын үйл явц эрчимтэй өрнөж байна. Энэ нөхцөлд хөгжингүй техник, технологи нэвтрүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг зах зээлээр дамжуулан эрчимжүүлэх боломж бүрдэж байна гэж судлаач үзсэн байна.

**Дүгнэлт:** Орчин үеийн дэлхийн зах зээлийн хөгжлийн үр дүнд бий болсон ололт, дэвшлийг сайтар ашиглах, түүний эрэлт хэрэгцээнд тохируулан үйлдвэрлэл явуулах, малчдын үйл ажиллагааг зах зээлийн эдийн засгийн шаардлагад нийцүүлэн явуулж байхаар шинэчлэлт өөрчлөлт хийх шаардлагатайг тодорхойлсон байна.

## 0110

Нансалмаа Ц.

### Малчин өрхийн аж ахуйгаа эрхлэн хөтлөх төлөв байдал

*Эрдэм шинжилгээний бичиг, №31. Өгүүлэл. УБ, 2002. ХААИС. 129-131 хууд. Монгол.*

Малчин хүний өдөр тутмын хөдөлмөр нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа давамгайлсан, дахин давтан хийх 17-32 төрлийн ажлаас бүрдэж байна. Эдгээр үйл ажиллагааг гүйцэтгэж буй үүргээр нь мал аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эдийн ба туслах үйлдвэрлэл гэж ангилж болно.

Малчин өрх нь зах зээлийн байршлаас хамааран орлогын зонхилох хэсгийг бүрдүүлдэг ноос, ноолуурын 85-98%-ийг 4-8 дугаар сард аймаг, сумын наймаачид болон хот суурин газрын зах зээлд тухайн үеийн үнээр борлуулж байна.

Зах зээлийн нөхцөлд үйлдвэрлэгч өөрсдөө борлуулалтын оновчтой сүвгийг сонгох ёстой боловч байгаль, цаг уураас хараат, тархай байршилтай, жижиг аж ахуйд энэ бололцоо бага, малчин өрхийн дийлэнх нь 3-4 зуучлагчаар дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулж байна.

**Дүгнэлт:** Энд малчин өрхийн аж ахуйгаа эрхлэн хөтлөх төлөв байдлыг малчин өрхийн маркетингийн судалгаатай уялдуулан авч үзжээ. Үүнд, малчин өрхийн бүтээгдэхүүнээ борлуулахад учирч буй бэрхшээл, түүнийг даван туулах арга зам, авах арга хэмжээний саналыг дэвшүүлсэн байна.

## 0111

Нямаа Н.

### **Монгол ноолуурын маркетингийн удирдлагын зарим асуудал**

*Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ, 2000. ХААНС, ЭЗФ. 121 хууд. Монгол.*

Ноолуурын маркетингийн асуудал нь малчин үйлдвэрлэгч, боловсруулах үйлдвэр, наймаачид, гадаад дотоод зах зээлийг хамарсан өргөн хүрээтэй асуудал юм.

Ноолуурын гарц буюу тоо хэмжээний хойноос хөөцөлдөж, гарц ихтэй үүлдрийн ямааг өсгөж ирсэн хандлагыг гэтлэн давж ноолуурын чанарт анхаарах нь нэн тулгамдсан асуудал болоод байна.

Монгол Улсын ноолуур үйлдвэрлэлийн хэмжээ нь ямааны тоо толгойн өсөлттэй уялдаж сүүлийн жилүүдэд тасралтгүй нэмэгдэж ирсэн бөгөөд харьцангуй цөөн малтай өрхийн орлогын гол эх үүсвэрийн нэг болж, улсын экспортод тодорхой байр суурь эзлэх болжээ. Ноолуур бэлтгэл, борлуулалтын өнөөгийн тогтолцоо хэт олон шат дамжлагатай байгаа нь ноолуурын чанарт муугаар нөлөөлж байгаагийн зэрэгцээ боловсруулах үйлдвэрийнхний түүхий эдээ авч байгаа үнэ, малчдын ноолуураа борлуулах үнэ хоёрын хооронд үнийн зөрүү үүсгэж байна. Тухайлбал, малчид хотондоо хүрч ирсэн наймаачдад бараа солилцоогоор ноолуураа борлуулах нь нэг кг ноолуураас дунджаар 3200 төгрөг алддаг гэсэн тооцоо гарч байна. Малчдын 12.9% нь хүрч ирсэн ганзагын наймаачдад, 21.4% нь аймаг, сумын төв дэх компаниудад, 26.2% нь боловсруулах үйлдвэрийн төлөөлөгчийн газарт, 9.5% нь Улаанбаатар хотод өөрсдөө хүрч ирж ноолуураа борлуулдаг байна.

**Дүгнэлт:** Монгол Улсад ямаа өсгөх бэлчээрийн даац, байгалийн нөхцөл бүрдсэн хэдий ч тоо толгойн өсөлтийн хойноос хөөцөлдөх, эдийн засгийн эрчимт бус аргыг голлох биш харин эрчимтэй өсөлтийг хангах хэрэгтэй гэж үзээд дэлхийн ноолуурын зах зээлд Монгол Улсын эзлэх байр суурийг бэхжүүлэхийн тулд манай хүчтэй ба сул талыг тодорхойлж, стратегийн баримтлал боловсруулахад SWOT шинжилгээний матрицын аргыг хэрэглэн тооцоо хийжээ.

## 1320 Мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ, чанар стандарт

### 0112

Даваадорж Р., Бат-Эрдэнэ А.

### **Өндөр уулын бүсэд үржүүлж буй нутгийн ямааны ноолуурын шинж чанарыг харьцуулан судалсан дүн**

*"Мал аж ахуйн шинжлэл" товхимол, №5. УБ, 2003. 207-211хууд. Монгол.*

Судалгаанд хамрагдсан нутгийн ямааны ноолуурын дундаж урт эр ямаанд 38.7-47.85 мм, эм ямаанд 42.85-47.65 мм-ийн хооронд тус тус хэлбэлзэж нас ахих тусам нэмэгдэх нийтлэг зүй тогтол ажиглагдаж байна.

Цэнгэл сумын ямааны ноолуурын дундаж голч кашмир хэвшлийн ямааны ноолуурын чанарт хүрэхгүй болсон байна. Иймээс нутгийн ямааны ноолуурын голчийг нэмэгдүүлэхгүй барьж байх, үржлийн ажлыг нэгдсэн зохион байгуулалттай явуулахад энэ шинж тэмдгийг анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзсэн байна.

**Дүгнэлт:** Бэлчээрийн мал аж ахуйн орлогын нэг гол эх үүсвэр бол ноолуур бөгөөд нутгийн монгол ямааны ноолуурын урт, микроныг үйлдвэрийн чанарын стандартад нийцүүлэх талаар чиглэсэн судалгааг байнга хийж байх нь чухал гэсэн дүгнэлт өгчээ.

### 0113

Нансалмаа Ш., Бат-Эрдэнэ А.

#### **Ойт хээрийн бүсэд үржүүлж буй нутгийн ямааны ноолуурын үндсэн шинж чанарыг судалсан дүн**

*“Мал аж ахуйн шинжлэл” товхимол, №5. УБ, 2003. 212-217 хууд. Монгол.*

Ойт хээрийн бүсэд хамрагдах Хөвсгөлийн Төмөрбулаг сумын Эрчим омгийн ямааны ноолуурын голч нас дагаж бүдүүрэх хандлагатай бөгөөд эр ямаанд 15.29-16.82 мкм, эм ямаанд 15.82-16.85 мкм байна.

Нутгийн ямааны ноолуурын үрт нас хүйснээс хамаарч эр ямааных 37.2-46.3 мм, эм ямаанд 38.2-40.1 мм байсан бөгөөд нас ахих тусам уртасдаг.

**Дүгнэлт:** Нутгийн ямаанд үржлийн ажлыг нэгдсэн зохион байгуулалттай явуулж, өөр дотор нь шилж сонгохын зэрэгцээ ноолуурын чанар, гарцаар илүү сайн нутгийн шилмэл омгийг үр дүнтэй ашиглаж ноолуурын чанарыг бууруулахгүйгээр гарцыг нэмэгдүүлэх санал дэвшүүлсэн байна.

### 0114

Оргилсайхан А., Индра Р.

#### **Цөцгийн тосны харьцуулсан судалгаа ба технологийг сайжруулах нь**

*“Мал аж ахуйн шинжлэл” товхимол, №5. УБ, 2003. ХААНС. 234-240 хууд. Монгол.*

Монгол Улсад цөцгийн тос үйлдвэрлэн боловсруулах зах зээл хангалттай байгаа бөгөөд одоогийн байдлаар энэ зах зээлийн ихэнхийг амт чанар муутай, импортын цөцгийн тоснууд эзэлж байна.

Монгол орны сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрүүд, ялангуяа томоохон үйлдвэрүүд нь хэдийгээр зах зээлтэйгээ ойрхон байрладаг боловч түүхий эдээсээ алслагдмал байрлалтай учраас бүтээгдэхүүн нь өндөр үнэтэй гардаг.

Мөн монгол цөцгийн тос нь амт чанарын хувьд сайн боловч сайн чанарын сав баглаа, боодолгүйгээс хэрэглэгчид бүтээгдэхүүний чанарт эргэлзэх явдал байсаар байна. Иймд сав баглаа, боодлын асуудлыг эн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай гэж судлаачид үзжээ.

**Дүгнэлт:** Баяжуулсан (уургаар) цөцгийн тос үйлдвэрлэх нь Монгол орны хэрэглэгчдийн өнөөгийн шаардлагад нийцэж, улмаар цөцгийн тос үйлдвэрлэлийн өртгийг хямдруулж, технологийг сайжруулж, илчлэгийг багасгах боломжтойг тогтоосон байна.

### 0115

Төмөржав М.

#### **Монголын нүүдэлчдийн малын шир, нэхий боловсруулах уламжлалт технологи**

*Эрдэм шинжилгээний бүтээл, №30. Өгүүлэл. УБ, 1999. ХААНС. 20-25 хууд. Монгол.*

Монголын нүүдэлчид таван төрлийнхөө малын арьс, шир, нэхийг боловсруулан амьдрал ахуйдаа хэрэглэж ирсэн эртний уламжлалтай.

Монголчуудын сур хийх үндэсний технологи нь сур хийх шир, түүний байршил хэсгүүдийг тодорхой зориулалтаар сонгон авах, зүсэх, үсийг нь авах (зүйлэх), улаан шүүсгүй болгох, уринд идүүлэх, тослох, утах, элдэх (элдүүрдэх) гэсэн бие даасан шат дамжлагуудаас бүрдэнэ.

Монголын арьс шир боловсруулах уламжлалт энэ технологийг нарийн судалж, шинжлэх ухааны нарийн үндэслэлийг тогтоож, улам боловсронгуй болгох шаардлагатай гэж судлаач үзсэн байна.

**Дүгнэлт:** Судлаачийн энэхүү бүтээл малын арьс шир боловсруулах технологийг уламжлалтай холбон үзсэнээрээ онцлог юм. Технологийг нарийн задалж тайлбарласан, онолын шинжтэй өгүүлэл болсон байна.

## 0116

Хандсүрэн С.

### **Шилжилтийн үе дэх арьс, ширэн түүхий эд, бүтээгдэхүүний маркетингийн үндсэн асуудал**

*Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ, 2001. ХААНС. 147 хууд. Монгол.*

Арьс, ширний маркетингийн асуудал нь малчин үйлдвэрлэгч, боловсруулах үйлдвэр, наймаачид, гадаад дотоод зах зээлийг хамарсан өргөн хүрээтэй асуудал юм. Иймд арьс ширний маркетингийн үзэл баримтлал нь үйлдвэрлэгч, хэрэглэгч төдийгүй улс орны эрх ашгийг хамарсан нийгмийн чиглэлтэй үзэл баримтлал буюу маркетингийн баримтлалд суурилж байж тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх боломжтой болно гэж үзсэн байна.

Мал болон мал эмнэлгийн байгууллага хувийн өмчид шилжиж буй шилжилтийн үед малын өвчин эмгэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга ажиллагаа муудсан нь арьс, ширэн түүхий эдэд муугаар нөлөөлж, түүхий эдийн амьдын гэмтэл 1992 оныхоос 2 дахин, түүхий эд бэлтгэлийн үед гардаг гэмтэл 17,8%-иар тус тус өссөнөөр арьс ширний талбай ашиглалт 43,8%-иар буурчээ. Мал эмнэлэг, үржлийн ажил зохион байгуулалт муутай, хяналтгүй болсноос мал давжаарч, арьс ширний ашигтай талбай багасч буйг мөн тогтоосон байна.

Арьс шир үйлдвэрлэгчид болох малчин өрхийн аж ахуйнууд сэтгэл зүйн хувьд ч, аж ахуйгаа эрхлэх арга барилын хувьд ч төлөвшиж чадаагүй ба тэдний дотор өргөжсөн нөхөн үйлдвэрлэл явуулах бизнесийн хэв шинжтэй аж ахуйн эзлэх хувийн жин тун бага байна. Тухайлбал, 2000 оны эцсийн байдлаар нийт мал бүхий иргэдийн 85,7% нь 200 хүрэхгүй толгой малтай байна. Энэ нь арьс ширний маркетингийн микро орчин бүрдэхэд нэлээд бэрхшээл учруулж байна. Иймд малчин өрхийн аж ахуйг бизнесийн хэв шинж бүхий аж ахуйн хэлбэрээр хөгжүүлэх нь нэн чухал асуудал гэсэн санал дэвшүүлжээ.

**Дүгнэлт:** Малчин өрхүүд аж ахуйгаа маркетингийн удирдлагаар удирдахын тулд зах зээлийн мэдлэгээ дээшлүүлэх, түүхий эд, бүтээгдэхүүний үнэ ханш, чанарын талаар мэдээлэлтэй байх, арьс, ширний анхан шатны боловсруулалт хийх чадвартай байх, мал сүргээ эрүүл байлгахын тулд вакцинжуулалтад жил бүр хамруулах, мал маллагааны уламжлалт арга барилаас суралцах зайлшгүй шаардлагатай талаар судалгаа хийж дүгнэлт өгчээ.

## 0117

Цэндсүрэн С., Индра Р.

### **Монгол үүлдрийн хонины сүүний чанарын тухайд**

*"Мал аж ахуйн шинжлэл" товхимол, №5. УБ, 2003. ХААНС. 249-257 хууд. Монгол.*

Судалгаагаар хээрийн ба говийн бүсийн хонины сүүнд хуурай бодис, уургийн хэмжээ ойролцоо, харин хээрийн бүсийн хонины сүүнд тослог илүү, говийн хонины сүүнд чихэрлэг бодис ба үнс илүү байжээ. Энэ нь байгаль, газарзүйн онцлог болон тэжээлийн ургамлаас хамааралтай байж болох юм. Химийн найрлагын хувьд хонины сүүг үнээний сүүтэй харьцуулан үзэхэд хуурай бодис, уураг, тослог илүү байна. Үнээний сүүнд дунджаар хуурай бодисын хэмжээ 12.5% байдаг бол хонины сүүнд 14.6-24.0% байна. Монгол үүлдрийн хонины сүүнд хуурай бодис 15.80-17.70%, үүнээс уураг 5.26-5.83%, тослог 5.73-6.54% байгаа нь хуурай бодисын 70 орчим хувийг төгс чанартай уураг, тослог эзэлж байгаа хэрэг юм. Нийт уургийн хэмжээг 100% гэж үзвэл үүний 80% нь казеин, 20% нь альбумин, глобулин буюу шар сүүний уураг байна. Казеинаар баялаг учраас уурагт бүтээгдэхүүн боловсруулахад илүү тохирно.

**Дүгнэлт:** Монгол хонины сүүний чанар нь сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд илүү тохиромжтой болохыг энэхүү бүтээл харуулж байна.

## 0118

Цэрэнпунцаг Ш.

### Монгол малын махны судлагдсан байдал

Эрдэм шинжилгээний бүтээл. №30. Өгүүлэл. УБ, 1999. ХААНС. 17-19 хууд. Монгол.

Монголчууд өөрсдийн байгаль, ахуйн өвөрмөц нөхцлийн онцлогт тохирсон янз бүрийн махан бүтээгдэхүүнийг бэлтгэдэг.

Монгол малын мах амин дэм ихтэй, В-12 амин дэм, зэс, төмөр зэрэг бичил элемент их бий. Бэлчээрийн малын мах нь шингэц сайтай, экологийн цэвэр бүтээгдэхүүн болохыг судалсан байна.

**Дүгнэлт:** Судлаач монгол малын махны судлагдсан байдлыг авч үзжээ. Энэ чиглэлийн бүтээлүүдийг нэгтгэн дүгнэсэн нь уг судалгааны гол цөм болж байна. Харин бусад орны эрдэмтдийн судалгааг хамруулаагүй байна.

## 1330 Мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалт

### 0119

Бат-Эрдэнэ В.

### Бизнесийн хэв шинж бүхий малчин өрхийн борлуулалтын үйл ажиллагаа

Эрдэм шинжилгээний бүтээл, №31. Өгүүлэл. УБ, 2002. ХААНС. 87-91 хууд. Монгол.

Өнөөгийн малчин өрхийн орлого, зарлага нь тогтворгүй, хуримтлал багатай, өрхийн үйлдвэрлэл, хэрэглээ, борлуулалтыг тооцох мэргэжлийн үр чадвар дутмаг, өрхийн аж ахуйг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөгүй байна.

Малчин өрх зах зээлийн нөхцөлд үйлдвэрлэлээ өргөтгөх боломжтой байхын тулд 1) ашигтай ажиллах; 2) төлбөрийн чадвартай байх; 3) эрсдэл даах чадвартай байх шаардлагатай байна.

Өнөөгийн бизнесийн хэв шинжтэй малчин өрх аж ахуйн хувьд хувиараа эрхлэх аж ахуй, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйл ажиллагаа явуулах нь хамгийн тохиромжтой гэж үзсэн байна.

Малчин өрхийн үйлдвэрлэлийн өгөөжийг дээшлүүлэх, ажиллах хүч, техник, технологи, мөнгөн хөрөнгийн ашиглалтыг сайжруулахын тулд юуны өмнө мянгат малчдыг бизнесийн болон үйлдвэрлэлийн менежментийн сургалтад хамруулах санал дэвшүүлжээ.

**Дүгнэлт:** Судлаач малчин өрхийн борлуулалтын асуудлыг бүс тус бүрээр, малын гаралтай бүтээгдэхүүн тус бүрээр гаргасан байна. Борлуулалтын суваг болон малчин өрхийн орлогын гол эх үүсвэрийг тодорхойлох оролдлого хийжээ.

### 0120

Нямаа Н.

### Малчин өрхийн орлогод ноолуурын үзүүлэх нөлөөлөл

Эрдмийн бичиг, №1. Өгүүлэл. УБ, 1998. ХААНС. 51-56 хууд. Монгол.

Уг өгүүлэлд Монгол Улсын ямааны тоо болон ноолуур үйлдвэрлэлийг байгаль, эдийн засгийн 5 бүсээр 1996 оны байдлаар харуулсан.

Мөн нийт малын бүтцэд ямаан сүргийн эзлэх хувь, түүний өөрчлөлтийн судалгаа хийж, малчин өрхийн нийт орлогод ноолуурын орлогын хувь хэмжээг тодорхойлж, үнэлэлт өгсөн байна.

Ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээ эдийн засгийн дундад бүсэд 26.3%, говийн бүсэд 32% байна. Малыг бүтцэд ямааны эзлэх хувь эдийн засгийн өрнөд бүсэд 37%, говийн бүсэд 48% байна.



**Дүгнэлт:** Улсын хэмжээгээр малчин өрхийн орлогод ноолуураас олох орлого дунджаар 27.7%-ийг эзэлж байна. Малчид ноолуураа гол 5 сувгаар борлуулдаг ба ноолуурынхаа 25%-ийг ганзагын наймаачдад, 41.7%-ийг аймаг, сумын зах зээлд, 27.9%-ийг хоршоо компанид, 5.3%-ийг Уланбаатар хотод, 0.1%-ийг боловсруулах үйлдвэрлэлд тус тус борлуулж байна.

## 0121

Нямаа Н.

### **Монгол ноолуур: эдийн засаг, стратегийн асуудлууд**

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2002. ХААИС. 103 хууд. Монгол.*

Дэлхийн зах зээл дээр нэг кг самнасан ноолуур 80 орчим ам.доллар байхад манай боловсруулах үйлдвэрийнхэн 50 орчим ам.доллараар экспортлодог байна. Иймд ноолуурын талаар олон улсын маркетингийн цогц бодлого баримтлах нь зүйтэй гэж судлаач үзжээ. Юуны өмнө ноолуурын олон тооны хэрэглэгчидтэй орнуудад үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, дэлхийн ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг орнуудтай хамтран ажиллах, олон улсын интернетийн сүлжээнд манай ноолуур боловсруулах үйлдвэрүүд холбогдож, дэлхийн ноолуурын зах зээлийн тухай мэдээллийг цаг тухайд нь хүлээн авч үйл ажиллагаандаа тусгаж байх, техник, технологую шинэчлэх, бүтээгдэхүүний хийц, загвар, чанарыг цаг ямагт дээшлүүлж байх явдал чухал байна.

Түүхий ноолуурыг гаалийн татвартайгаар экспортлох бодлогыг Засгийн газрын зүгээс дэмжих нь зүйтэй гэсэн дүгнэлтэд судлаач хүрчээ. Энэ нь дэлхийн худалдааны байгууллагатай хийсэн гэрээг үл зөрчих, нөгөө талаар стратегийн чухал бүтээгдэхүүнээ хамгаалах, зах зээлийн үндсэн субъектүүдийн эрх ашгийг дээдлэхийн аль алинд нь нийцэж байна.

**Дүгнэлт:** Судлаач тус нэг сэдэвт бүтээлдээ дотоодын зах зээл дэх ноолуурын эрэлт, хэрэгцээ, ноолуур үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, чанар, ноолуурын үнэ бүрдэлт, ноолуурын экспорт, ноолуурын талаар төр засгийн баримтлах бодлогын хувилбарууд, ноолуурын маркетингийн стратегиуд зэрэг чиглэлээр тооцоо судалгаануудыг хийжээ.

## 0122

Нямаа Н.

### **Ноолуурын бэлтгэл, борлуулалтын оновчтой суваг бүрдүүлэх арга зам**

*Эрдэм шинжилгээний бичиг, №30. Өгүүлэл. УБ, 1999. ХААИС. 185-188 хууд. Монгол.*

Ноолуурын маркетингийн одоогийн урсгал нь малчдаас олон шат дамжлагыг дамжиж байж боловсруулах үйлдвэрийнхэнд очдог учир энэ замд ноолуурын үнэ өндөрсөж, чанар нь мууддаг байна. Иймээс малчид, боловсруулах үйлдвэрийнхнийг шууд холбож, завсрын зуучлагчгүй болгох шаардлагатай. Үүний тулд түүхий эд борлуулах төвлөрсөн системийг бий болгох саналыг судлаач дэвшүүлсэн байна. Тухайлбал, түүхий эд хүлээн авах төвүүд байгуулан, тэдгээр нь үйлдвэрүүдэд бүтээгдэхүүнийг төвлөрсөн журмаар нийлүүлж, тендэр, бирж, үнэ хаялцуулах худалдаагаар дамжуулан борлуулах юм. Энэ системийг байгуулснаар малчдад бодит ашгаа нэмэгдүүлэх бололцоо нээгдэж, бүтээгдэхүүнээ зах зээлийн жинхэнэ үнээр борлуулах, төлбөрийг шууд бэлнээр, хүсвэл бараагаар авах боломжтой болохын хамт улмаар малынхаа үүлдэр угсааг сайжруулж, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрмэлзэл нэмэгдэх зэрэг давуу талууд бий болно гэж үзсэн байна.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн түүхий эдийг борлуулах шинэ систем бүрдүүлж, борлуулалтыг оновчтой болгох асуудалд судлаач анхаарлаа хандуулж, түүхий эдийг борлуулах төвлөрсөн систем бий болгох санал дэвшүүлсэн байна. Энэхүү санал болгож буй ноолуур бэлтгэлийн шинэ тогтолцоо нь хуучин тогтолцоотой харьцуулахад 1 кг ноолуур тутамд малчдад 1300 төгрөг, улсын төсөвт 363 төгрөгийн илүү ашигтай байх боломж бүрдүүлнэ гэж тооцжээ.

## **ДӨРӨВ. МАЛ АЖ АХУЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД**

### **1410 Мал аж ахуйн тогтвортой хөгжил**

**0123**

Нямцэрэн Л., Энхсайхан Б.

#### **Тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүд (индикаторууд) ба мал аж ахуй**

*“Market-Economy Nomads-Technology” товхимол. УБ, 2002. НСИСОВХ. 199-202 хууд. Англи.*

Монголын хүн амын тавны хоёр нь хөдөөд оршин сууж мал аж ахуй эрхэлж байна. Тэдний аж амьдрал нь мал аж ахуй болоод бэлчээрээс маш их хамааралтай. Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг Монголд уул уурхайн үйл ажиллагаа, хөдөө аж ахуйн хортон мэрэгчид, шавьжны нөлөөллөөр бэлчээр устаж сүйтгэгдэж буй нь байгалийн гамшиг, сүйрэлд хүргэх шалтгаан болж байна.

Мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангахын тулд уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг бэлчээр болон тэжээлийн холсолсон хэлбэр рүү шилжүүлэх арга хэмжээг алхам алхмаар хэрэгжүүлэх замаар эрчимжсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх, баг, сум, аймгийн түвшинд эрсдлийн фонд байгуулах, мал аж ахуйн даатгалын үр нөлөөтэй эрх зүйн орчинг бүрдүүлэх зэргээр Монголд бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн гол асуудлуудыг онцгойлон авч үзэх шаардлагатай.

Мал аж ахуйн үндсэн ба эргэлтийн хөрөнгө, бэлчээр, түүний усжуулалт, орлого, зарлага зэрэг 39 үзүүлэлтийг сонгон бүртгэж байх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлсэн байна.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн байдал, тогтвортой хөгжлийг дүгнэх үзүүлэлтүүдийн системийн талаар тодорхой санал дэвшүүлсэн байна.

**0124**

Баатар И.

#### **Монголын хөдөө аж ахуйн хөгжлийн хандлага**

*“Олон улс судлал” сэтгүүл, №1. Өгүүлэл. УБ, 2003. 102-108 хууд. Монгол.*

Монгол Улс өнө эртний мал аж ахуйн түүхтэй тул хүмүүс “уламжлалт бэлчээрийн мал аж ахуй” гэж нэрлээд дадчихсан байдаг. Эртнээс таван хошуу мал сүрэг, тухайлбал үхэр, адуу, тэмээ, хонь, ямаа маллаж ирсэн. 1930-1997 оны хооронд Монголын малын тоо толгой өсөж, буурсаар 1997 он гэхэд 31 сая 260 мянгад хүрч 1996 оныхоос 6.7%-иар өсөв. Энэ бол түүхэнд мал хамгийн их өссөн жил байлаа. 1945 онд Монголын мал 20 сая 10 мянга хүртэл буурсан нь түүхэн дэх хамгийн цөөн малтай жил байжээ. Гэвч Монголын мал өсөх хандлагаар явж байсан гэж судлаач үзжээ.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн бүх төрлийн бүтээгдэхүүний өсөлт, бууралтын хэмжээг тооцож, түүний хандлагыг тогтоох оролдлого хийсэн байна.

## 0125

Гунгаадорж Ш.

### **Мал аж ахуйг хөгжүүлэхэд төрөөс баримтлах бодлогын зарим асуудал**

*“Market-Economy Nomads-Technology” төвхимол. УБ, 2002. НСНСОУХ. 111-116 хууд. Англи.*

Хөдөөгийн хөгжил ялангуяа мал аж ахуйн хөгжил нь улс орны одоо болон ирээдүйн хөгжилд асар их үүрэгтэй. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр мал бүхэлдээ хувьд шилжсэн. Энэ нь малчид өөрийн гэсэн малтай болсон, малын тоо өссөн зэрэг эерэг үр дүн өгснөөс гадна зах зээлийн харилцаанд суралцахын хажуугаар мал маллах уламжлалт арга ухаан мартагдаж, сүүлийн жилүүдэд байгалийн бэрхшээлийн өмнө өвдөг сөхрөхөд хүрч байна.

Мал аж ахуйн хөгжил нь Засгийн газрын анхаарлын төвд байгаа бөгөөд зөвхөн 2002 онд гэхэд мал аж ахуйг хөгжүүлэхэд 8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 2.6 тэрбум төгрөгийг зээл болон бүцэлтгүй тусламжийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна. Мал аж ахуйг хөгжүүлэх бодлогын хүрээнд эхний ээлжинд хөдөө дэх үйлдвэржилтийн асуудал хэлэлцэгдэж байна. Учир нь хөдөөгийн хөгжлийн хоцрогдол, малчдын “хөгжилтэй газар луу” буюу хот руу шилжих шилжилт эрс нэмэгдсэнээс бэлчээр эзэнгүйдсэн, хот суурин газарт хүн амын хэт төвлөрөл бий болсон зэрэг нь мал аж ахуйн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

**Дүгнэлт:** Эхний ээлжинд төрөөс энэ чиглэлээр зарим хууль гаргахын хамт мал аж ахуйг хөгжүүлэх эдийн засгийн орчинг бүрдүүлэхэд анхаарч, боловсруулсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд зориулж улсын төсөв болон гадаадын зээл тусламжаас тодорхой хэмжээний санхүүжилт хийхээр төлөвлөх нь чухал гэжээ.

## 0126

Насанжаргал Д.

### **Хөдөөгийн хөгжлийн стратеги**

*Монголд хандивлагчдын зөвлөлдөх уулзалтад хэлсэн үг. УБ, 2002. ХХААЯ. 1-14 хууд. Англи, Монгол.*

Мал сүргийг ган, зудаас сэргийлэн хамгаалах, ган, зуд тохиолдсон үед авах арга хэмжээ болон учирсан хохирлыг нөхөх тогтолцоог боловсронгуй болгож, тусламжийн сүлжээг бүрдүүлж, малчид, мал бүхий иргэд болон бүх шатны төрийн захиргааны байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн бодлого, зохицуулалт, дэмжлэг тусламжаа үзүүлэх зорилгоор “Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр”-ийг батлан гаргаж, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд өвс тэжээл бэлтгэх хэмжээг нэмэгдүүлж, мал сүргийг болзошгүй зудын гамшгаас хамгаалах өвс тэжээлийн нөөц бий болгох шаардлагатай гэж үзээд “Хадлан тэжээл 2001” төслийг батлан, түүнийг хэрэгжүүлэхэд 2001 онд 1.3 тэрбум төгрөгийг Засгийн газраас аймаг, сумын өвс тэжээлийн нөөцийг бий болгоход зориулан олгосон. Цаашид ийм арга хэмжээг улам идэвхижүүлж, өвс тэжээлийн нөөцийг тогтвортой нэмэгдүүлэх, нөөцөд зөвхөн байгалийн хадлангаас гадна багсармал, хорголжин тэжээлийг ахиу нөөцлөх, усалгаатай нөхцөлд малын тэжээл тариалах, хадлангийн талбайг хаших, бордох, услах зэргээр ургац нэмэгдүүлэх, аймаг дундын отрын нутгууд бий болгох, худаг усан хангамжийг нэмэгдүүлэх замаар алслагдсан бэлчээрийн ашиглалтыг сайжруулахад түлхүү анхаарахаар төлөвлөж байна. Үүнд гадны зээл тусламж ч хэрэгтэй тухай өгүүлжээ.

**Дүгнэлт:** Эрчимжсэн мал аж ахуйг далайцтай хөгжүүлэхгүйгээр цаашид нийгмийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангаж чадахгүй юм. Иймд юуны өмнө төвийн бүсэд сүүний үхрийн фермерийн аж ахуй, махны төрөлжсөн үхэр үржүүлдэг бордооны аж ахуйг хөгжүүлэх хэрэгтэй гэж үзэж байна. Үүний тулд гадаадын зээл тусламжийн тодорхой хэсгийг үүнд чиглүүлнэ. Түүнчлэн мал аж ахуйг хөгжүүлж, хөдөөгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд өнөөгийн тархай бутархай малчин өрхийн аж ахуйг хорших, хүчээ нэгтгэхэд ихээхэн анхаарал тавина. Малчдын төдийгүй, тариаланчдын төрөл бүрийн хоршоог дэмжих бодлогыг тууштай явуулна гэсэн зорилтууд тавьжээ.

## 0127

Сүхбаатар Ц.

### Монголын хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хэтийн төлөв, тулгамдсан зорилтууд

Монгол Улсын хөгжлийн судалгаа №1. УБ, 2002. ШУА-ийн Үндэсний хөгжлийн хүрээлэн. 113-126 хууд. Монгол.

Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа малчдын хувьд сүүлийн хэдэн жил дараалан зуд, гангийн гамшиг тохиолдсноос өрхийн орлого буурч, улмаар манай улсын нэг хүн амд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ буурахад нөлөөлөв. Гэхдээ байгалийн гамшгаас учирч байгаа хохирол нэг нутаг ус, ижил нөхцөлд байсан малчдын хувьд ялгаатай байсан нь малчдын арга ажиллагаатай шууд холбоотой байгаа юм. Энэ нөхцөлд хамгийн их хохирол үзсэн малчид нь зах зээлийн шилжилтийн үед төв суурин газраас хөдөө гарч малчин бологсод байв. Тэд мал маллагааны арга технологийг бүрэн эзэмшээгүй, мал маллагааны тоноглол хэрэгсэл дутуу, бэлтгэлээ бүрэн хангаагүй, өвс тэжээл бэлтгээгүй, малаа оторлон таргалуулаагүй, бэлчээрээ хуваарьтай ашиглаагүй, сүргийнхээ бүтцийг зөв зохистой бүрдүүлээгүй, ямаа голдуу бог малтай байсан, хашаа хороо, өтөг бууц, худаг усандаа анхаараагүй, бусад малчидтайгаа хоршин гар нийлж ажиллаагүй хүмүүс байсан гэсэн дүгнэлтийг судлаач хийжээ.

**Дүгнэлт:** Судлаач мал аж ахуйн үйлдвэрлэлд хөдөлмөрөө хорших үйл ажиллагааг дэмжих, түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх, зах зээлд хамтран борлуулалт хийх тогтолцоог бүрдүүлэх явдал чухал гэж үзсэн байна. Өнөөдөр дэлхийн улс орны мал аж ахуй эрхэлж байгаа фермерүүд үйлдвэрлэлийн бэлтгэл ажил, борлуулалтаа хоршин хийж байна. Энэ зохион байгуулалтад оруулахад туслах загвар аж ахуйг байгаль, цаг уурын бүс бүрт байгуулан ажиллуулах, турших шаардлагатай байна. Ялангуяа мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагаа алдагдснаас цаг агаарын бэрхшээлд амархан өртөмтгий болж, малгүй болсон малчид хот суурин бараадахад хүрч байна. Энэ байдал хөдөөгийн хөгжлийн дорвитой бодлого үгүйлэгдэж байгааг харуулж байна гэсэн дүгнэлт хийсэн байна.

## 0128

Тунгалаг Д., Цэрэнпил Д.

### Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлын зарим асуудал

Нэг сэдэвт бүтээл. УБ, 2002. Тагнуулын ерөнхий газрын дээд сургууль. 175 хууд. Монгол.

Эдийн засгийн аюулгүй байдал нь үндэсний эдийн засгийн өсөлт хөгжил, өрсөлдөх чадвараар тодорхойлогддог. Монголын эдийн засагт хөдөө аж ахуйн салбар гол үүрэг гүйцэтгэдэг. ДНБ-нд хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувийн жин нь 30-40% байна. Энэ нь монголчууд эрт дээр үеэс нүүдлийн мал аж ахуй эрхэлж, жилийн дөрвөн улиралд нутаг сэлгэн нүүдэллэж, дан ганц мал аж ахуйгаар амьдралаа залгуулж ирсэнтэй холбоотой. Сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйн салбар уналтад орж, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь буурсаар байна. Өөрөөр хэлбэл, ДНБ-нд хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь жилд 2.5-3.0%-иар буурч байна.

**Дүгнэлт:** Монголын эдийн засагт гол үүрэг гүйцэтгэдэг нүүдлийн мал аж ахуй уналтад орж байгаа нь үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй гэсэн дүгнэлт өгчээ.

## 0129

Баатар И.

### Монгол үндэстний нүүдлийн эдийн засаг болон уламжлалт экологийн үзэл

“Олон улс судлал” сэтгүүл, №1. Өгүүлэл. УБ, 2003. 66-69 хууд. Монгол.

Нүүдлийн эдийн засагт мал сүрэг нь шууд үйлдвэрлэлийн хэрэгсэл, хөдөлмөрийн хэрэгслийн хос үүргийг гүйцэтгэхээс гадна бас малчдын амьдралын болон солилцож болох таваарын хэрэгсэл болдог. Мал сүрэг нь

эзэмшигчийн олон янзын үйлдвэрлэл, амьдралын эрэлт хэрэгцээг хангадаг. Жишээлбэл, морь, тэмээ бол хээр талын хамгийн зохистой зам тээврийн хэрэгсэл (үйлдвэрлэлийн хэрэгсэл), үхэр, хонины мах бол монголчуудын гол идэш, сүү бол экологийн цэвэр ундаа. Арьс, ноолуурын хэрэгцээ нэн өргөн, түүгээр хувцас хунар, хөнжил дэвсгэрээс эхлэн олон төрлийн эдлэл хийж болно. Түүнийг солилцоонд хэрэглэвэл тавсаар болчихно.

Бэлчээр талхлагдах нь даруй үйлдвэрлэлийн хэрэгслээ эвдсэн явдал учир малчид тал нутаг, бэлчээрээ амьшигээ хайрлаж хамгаалдаг. Монголчууд тал нутгийг магтан дуулдгийн учир нь зөвхөн тал нутаг гоёдоо биш, харин нэн чухал нь тал нутаг тэд нарт амьдрал, үйлдвэрлэлийн нөхцөл, цаашлаад бүхий л амь биеийг нь олгосонд байгаа юм.

Иймээс нүүдлийн эдийн засгийг экологийн эдийн засаг гэж үзэж болно. Экологийн эдийн засгаас хүмүүсийн экологийн үзэл суртал үүссэн гэсэн санал дэвшүүлжээ.

**Дүгнэлт:** Мал сүрэг нь малчдын үйлдвэрлэл, амьдралын олон зүйлийн эрэлт хэрэгцээг хангадаг, гэхдээ зах зээлийн нөхцөл муугаас монголчууд тавсаарын эдийн засгийн үзлээр дутмаг байв. Харин байгалийг хамгаалах экологийн үзэл маш сайн. Одоогийн нөхцөлд малчид байгалиа хамгаалах, мал аж ахуйн эдийн засгийг хөгжүүлэхэд хамтад нь анхаарч, давуу болон дутагдалтай талаа харилцан нөхөх нь чухал болсон гэж дүгнэсэн байна.

## 0130

Дэннис Шихи

### Бэлчээрт суурилсан мал аж ахуйн тогтворжилт

*"Mongolia in Transition: Old Patterns, New Challenges" товхимол. Их Британи, 1996. 42-64 хууд. Англи.*

Монголын нөхцөлд мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх анхдагч алхам нь мал аж ахуйн үйлдвэрлэлд шууд болон шууд бусаар нөлөөлөгч байгаль, экологийн эрсдлүүдийг бодитой, нарийн тодорхойлох байгууллагыг хөгжүүлэх асуудал юм.

Хоёрдугаар ажил нь бэлчээрт суурилсан мал аж ахуйн үйлдвэрлэлийн зардал, үр ашгийг тооцоолох, ялангуяа мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотой экологи, эдийн засгийн зардлыг тодорхойлох асуудал болно.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг үйлдвэрлэл нь байгаль, эдийн засгийн болон мал амьтны зэрэг олон нөөц ашигладаг. Тэдгээрийг үр ашигтай ашиглах нь мал аж ахуйн тогтворжилтод нааштайгаар нөлөөлнө гэж судлаач үзжээ.

## 0131

Ыханбай А.

### Малчин ба экологи

*"Nomadic Studies" сэтгүүл, №04. Өгүүлэл. УБ, 2002. НСИСОВХ. 121-127 хууд. Монгол.*

Нутгийн иргэдийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах уламжлалт арга туршлага нь цаашдын тогтвортой менежментийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр болох юм.

Нутгийн иргэд, малчдад түшиглэсэн байгалийн нөөцийн оновчтой менежментийг бүрдүүлэхэд тэдний соёл, уламжлал, сэтгэл зүйн онцлогийг харгалзах шаардлагатай гэж судлаач үзжээ.

Орон нутагт байгалийн нөөцийн менежментийн асуудал зөвхөн тэр нутагт оршин сууж байгаа иргэд, малчдаас хамаарахгүй, бусад олон янзын оролцогч талууд байгаа бөгөөд малчид бол энэ системийн зөвхөн нэг хэсэг нь байна.

Бэлчээр болон байгалийн нөөцийн менежментэд иргэд, орон нутгийн төр захиргааны байгууллагууд, хувийн хэвшлийнхний үүрэг, хариуцлагыг тодорхойлсон хамтын менежментийн арга хэлбэр чухал байна.

Бэлчээрийн менежментийг байгалийн бусад нөөцийн хамт авч үзэх, нутгийн иргэдэд бэлчээр болон байгалийн нөөцийг эзэмшүүлэх, улмаар малчин өрхийг хөдөөгийн хөгжлийн тулгуур цэг нь гэж үзэх, бэлчээрийн мал аж ахуйг хагас суурин байдалд оруулах, гэхдээ бэлчээрийн мал аж ахуйг орхихгүй байх санал дэвшүүлжээ.

**Дүгнэлт:** Нутгийн иргэдийн холбоо, хамтлагийг зөвхөн эдийн засгийн ашиг сонирхолд хөтлөгдөх байдлаар нь биш, харин экологи-эдийн засгийн үр ашгийн үндсэн дээр бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, экосистемийг хамгаалах үзэлтэй малчин хүний сэтгэл зүйг бүрдүүлэх, малчдын нийгмийн асуудлыг зөв шийдэх нь чухал гэж үзсэн байна.

## 0132

Энх-Амгалан А.

### Монгол орны бэлчээрийн мал аж ахуйн өнөөгийн байдлын тойм

Эдийн засгийн клубт тавьсан илтгэл, УБ, 1999. 10 хууд. Монгол

Энэхүү илтгэл нь Монгол орны бэлчээрийн мал аж ахуйд тулгараад байгаа үндсэн бэрхшээлүүдийн тойм юм. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн олон улсын ангиллаар авч үзвэл Монгол орны мал аж ахуй нь бэлчээрийн буюу "пасторал" гэсэн ангилалд багтана. Бэлчээрийн мал аж ахуйн үндсэн шинж чанар нь байгалийн нөхцлөөсөө хамаараад маш доогуур ашиг шимтэй байгаа явдал юм. 1960-аад оноос бэлчээрийн мал аж ахуйг эрчимжүүлэх үүднээс мал эмнэлэг, үржил селекцийн ажлыг сайжруулах, нэмэгдэл тэжээл бэлтгэх, хашаажуулах зэргээр ихээхэн хэмжээний хөрөнгө зарсан ч нэг толгой биет малаас авч байгаа ашиг шим (биологийн ашиг шим) олигтой нэмэгддэггүйг тоо баримт харуулж байна. Мал аж ахуйн салбар зах зээлд шилжиж эхэлсэн сүүлийн хэдэн жилд гарсан өөрчлөлтийн улмаас малын тоо толгойг нэмэгдүүлэх нь өнөөгийн жижиг өрхийн аж ахуйнуудын үндсэн зорилго болжээ. Энэ нь нэг талаас бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн эдийн засгийн араншинтай, нөгөө талаас экологийн харьцангуй хатуу ширүүн нөхцлийн улмаас малчид малаа аль болохоор өсгөж хатуу жилд учирч болох байгалийн эрсдлийг зөөлрүүлэх бодлого баримталдагтай холбоотой юм. Малын тоог өсгөх малчдын хувийн сонирхол нь бэлчээрийн чадавхийг хадгалж, салбарын урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах үндэсний ашиг сонирхолтой улам бүр харшлах боллоо.

**Дүгнэлт:** Хуримтлагдсан асуудлуудыг шийдвэрлэх үүднээс газрын шинэтгэлийг манай малчдын дунд бэлчээрийг ашиглах талаар үе дамжин уламжлагдаж ирсэн нэг голийнхон, нэг усныхан зэрэг албан ёсны бус бүлгүүдэд түшиглэн хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлсэн байна. Энэ нь доорх үндэслэлтэй. Үүнд:

- Бэлчээр, малын чанарыг сайжруулахад хөрөнгө оруулах, малын толгойн тоог нэмэгдүүлэхээсээ үйлдвэрлэлийг эрчимтэй аргаар эрхлэх сонирхлыг идэвхжүүлэн улмаар малчдын амьдралын нийгмийн нөхцлийг өөрчилж чадах суурин хэвшилд шилжүүлэх үйл явцыг хурдасгах;
- Ядуу малчдыг баталгаатай бэлчээрээр хангаснаар ядуурлыг бууруулах;
- Мал хувьчлагдсанаас хойш малын тоо толгой харьцангуй хурдан өсч, улмаар мал, бэлчээрийн тэнцвэрт харьцаа алдагдаж эхлээд байна. Иймд бэлчээрийн хомсдол бий болоод байгааг оновчтой шийдэх шаардлага урган гарч байна.

## 0133

Нямдаваа Г.

### Ховд аймгийн нутагт мал аж ахуй эрхлэх байгалийн нөхцөл, нөөцийн онцлог

Нэг сэдэвт бүтээл. УБ, 2000. 137 хууд. Монгол.

Зах зээлийн хөгжлийн явцад мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх чиглэлийг баримтлах боловч манай орны өнөөгийн нөхцөлд бэлчээрийн мал маллагааны уламжлалт арга хадгалагдан шийдвэрлэх үүргийг гүйцэтгэсээр байх болно.

Ховд аймгийн байгалийн нөөцийн голлох үзүүлэлт бүрийн онцлог болон бэлчээрийн мал маллагааны биоэкологийн харилцан шүтэлцээг судлан таван хэв шинжийг тогтоосон байна.

Байгалийн нөхцөл нутаг дэвсгэрээр ялгавартай байдгийн гол хүчин зүйл болсон газрын гадаргын онцлог зүй тогтлыг малын өдөр тутмын ба улирлын хариулга маллагаанд чадварлаг ашиглах нь малын тарга тэвээрэг, ашиг шимийг нэмэгдүүлэх ихээхэн нөөц юм.

Ховд аймгийн уур амьсгалын орон нутгийн зүй тогтол, горим, түүнийг хэрхэн таньж мэдэх тухай зөвлөмжүүд залуу малчдад багагүй тус дэм болно.

Бэлчээрийн талбай, даац, тэжээлийн нөөцийн судалгаанаас харахад сүм бүрийн бэлчээр ашиглалтын зохион байгуулалтыг сайжруулах, усжуулах, ээлж дараатай ашиглан талхагдлыг багасгах, нөхөн сэргээх боломжтой нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлага байгаа нь нотлогдож байна.

**Дүгнэлт:** Энэхүү бүтээлд авч үзсэн мал аж ахуй эрхлэх байгалийн нөхцлийн талаархи хууль, зүй тогтол, шинж чанаруудыг өөрийн нутаг дэвсгэрт тохируулан мал аж ахуйг эрхлэх явцад ухаалгаар зохицуулан ашиглах нь эзэмшил нутгийнхаа нөхөн сэргээх нөхцлийг бүрдүүлж, цаашид мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангахад гол үндэслэл болно гэж үзэж байна.

Иймд нүүдэлч малчдыг зах зээлийн эдийн засагт шилжүүлэх, хөгжлийн стратегийг боловсруулахад Ховд аймгийн нутаг дахь мал аж ахуй эрхлэх байгалийн нөхцлийн хэв шинжүүдийг суурь болгон ашиглаж болно.

## 1420 Малын бэлчээр, бэлчээрийн менежмент, тэжээлийн хангамж

### 0134

Адъяасүрэн Ц.

#### Бэлчээрийн менежмент ба тогтвортой хөгжил

*“Market-Economy Nomads-Technology” товхимол. УБ, 2002. НСНСОВХ. 148-153 хууд. Англи.*

1990-ээд оны эхнээс зах зээлд шилжих үүднээс Монголд улс, хоршооллын өмчийг хувьчилж өмчийн бүх хэлбэрийг хөгжүүлэх бодлогыг баримталж ирсэн. Өмнө нь улсын хоршооллын мэдэлд байсан малыг хувьчилсан нь энэ үйл явцын хамгийн чухал ахиц дэвшил байв. Мал хэдийгээр бараг бүрэн хувьчлагдсан ч бэлчээрийн эзэмшил, зохицуулалтын асуудал шийдвэрлэгдээгүй үлдсэн. Мөн түүнчлэн малчдын амьжиргааны нөхцөл байдал сайжрахгүй байгаа нь тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хүндрэл бэрхшээл учруулж байна. Малчин-бэлчээр-мал аж ахуй гэсэн харилцан нягт уялдаа холбоо бүхий гурвалсан хэлхээ нь малчдын аж амьдралыг дээшлүүлэх, тэднийг зах зээлийн харилцаанд амжилттай оролцуулахад харгалзах гол үндэс суурь мөн.

**Дүгнэлт:** Судлаачийн үзэж байгаагаар малчдын нийгмийн асуудал нь малчин-бэлчээр-мал сүрэг хэмээх гурвалын харилцан хамаарлын системээр шийдвэрлэгдэх юм. Энэ өгүүлэлд мал аж ахуйн тогтвортой хөгжилд хамрах бэлчээрийн менежмент, хоршоолол болон мэдээлэл түгээлт зэрэг асуудлуудыг авч үзсэн болно.

### 0135

Алтанцэцэг Б.

#### Бэлчээрийн менежментэд малчдын оролцоо

*“Мал аж ахуйн шинжлэл” товхимол. №5. УБ, 2003. 195-200 хууд. Монгол.*

Бэлчээрийн менежментэд малчдын оролцох үүрэг, хариуцлага их нэмэгдэж байна. Малчид л бэлчээрийн жинхэнэ менежер байх ёстойг амьдрал харуулж байна.

Малчид бэлчээр ашиглалтын төлөвлөлтөд оролцоно гэдэг бол үйлдвэрлэлийнхээ асуудлыг шийдвэрлэхэд л оролцож байгаа хэрэг.

Малчид, ялангуяа залуу малчдын бэлчээрийн менежментийн мэдлэгийг сайжруулан төрөл бүрийн сургалтад хамруулах буюу танин мэдэхүйн болон уламжлалт арга ухааны чиглэлээр мэдээлэл солилцох шаардлагатай байна.

**Дүгнэлт:** Малчдын байгалийн нөөцөндөө хөрөнгө оруулах ажлыг дэмжиж татвараас чөлөөлөх зэргээр урамшуулах болон эрх зүйн асуудлыг оновчтой болгох шаардлагатайг судлаач санал болгожээ.

## 0136

Жигжидсүрэн С.

### Бэлчээрийн менежментийн хөгжлийн тулгамдсан асуудлууд

*Эрдмийн бүтээл №29. УБ, 1998. ХААНС. 44-52 хууд. Монгол.*

Зах зээлд татагдаж төвд тэмүүлсэн их нүүдэл үргэлжилж, бэлчээр нутгийн ачааллын тэнцвэр алдагдах, МАА-н үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө улам идэвхжиж эхэллээ. Олон арван сая га бэлчээр талхлагдаж гүйцэж байна.

Инженерийн хийцтэй уст цэгүүд үрэн таран болж бэлчээрийн усан хангамж эрс муудсанаас бэлчээрийн талбайн талаас дээш хувь нь ашиглагдахгүй байна.

Энэ бүхэн нь зах зээлийн харилцаанд шилжиж байгаа шинэ нөхцөлд нийцсэн бэлчээрийн менежментийг хөгжүүлэх зайлшгүй шаардлага бий болсныг харуулж байна. Судлаач бэлчээрийн өнөөгийн тулгамдсан асуудлыг бэлчээр ашиглаж ирсэн түүхэн туршлага, өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ гэсэн гурван бүлэгт хувааж судалжээ.

**Дүгнэлт:** Бэлчээр талхлагдсан байдлыг засах арга хэмжээний талаар санал дэвшүүлсэн байна.

## 0137

Мария Фернандес-Гименес

### Монголын бэлчээрийн менежментийн асуудалд

*Хоршооллын өмч судлалын олон улсын холбооны бага хуралд тавьсан илтгэл. Ванкувер, Канад. 1998. Англи.*

Энэхүү судалгаанд газар ашиглах, эзэмших асуудлыг шийдвэрлэхдээ нүүдлийн мал аж ахуйд аль болох тохирсон байх ёстой. Монголд тохиромжтой нэг арга нь улирлын чанартай нүүдлийн мал аж ахуйд тохирсон бэлчээр ашиглалтын орон нутгийн зохицуулалт байж болно гэжээ. Мөн нүүдлийн мал аж ахуйн онцлог тохирсон бэлчээр ашиглалт-эзэмшилтийн зохицуулалт шаардлагатай гэсэн дүгнэлт хийжээ.

**Дүгнэлт:** Монголын бэлчээр ашиглалтын байдлыг судлаад, бэлчээр ашиглалт хангалтгүй байна гэсэн дүгнэлт хийсэн байна.

## 0138

Мария Фернандес-Гименес

### Монголын нүүдэлчдийн үүрэг: Бэлчээрийн менежментийн экологийн талаар

*"Ecological Applications" сэтгүүл, 10(5). Америкийн экологийн нийгэмлэг. ANU, 2000. 1318-1326 хууд. Англи.*

Энэ судалгаанд нүүдэлч малчдын экологийн мэдлэгийн байдал, түүнийг дээшлүүлэх, нөөцийн менежментэд хэрхэн ашиглах талаар дурьдсан байна. Монголын нүүдлийн мал аж ахуйн экологи, бэлчээрийн менежмент дэх түүний үүрэг, бэлчээрийг хуваарьтай ашиглах, мөн бэлчээр хувьчлах талаар малчдын санаа бодлыг тусгасан.



Мөн нүүдэлчдийн экологийн талаарх мэдлэг, түүний зөрчлүүд, маргаантай асуудлууд, өнөөгийн бэлчээрийн менежментийн талаарх тэдний ойлголтыг хамруулсан байна.

**Дүгнэлт:** Монголын нүүдэлч малчдын бэлчээрийн менежмент, экологийн талаар ямар төсөөлөлтэй болохыг судалж, тэдний мэдлэгийг дээшлүүлэх талаар тодорхой санал дэвшүүлсэн байна.

## 0139

Денис Ожима, Хөдөлмөр С.

### **Бэлчээр судлалын цогцолбор технологи**

*“Fundamental Issues Affecting Sustainability of the Mongolian Steppe” товхимол. УБ, 2001. НСИСОУХ. 346-347 хууд. Англи.*

Орчин үед бэлчээрийн менежментийн шийдвэр гаргах, бэлчээрийн даацыг зөв үнэлэх, мал аж ахуйн эрсдлийг урьдчилан таамаглаж, зөв бодлого явуулах технологи ажиллагаа чухал юм.

Малчид хэрэв бага тэжээл бэлдсэн бол эрсдлийг бууруулах өөр арга замыг төлөвлөж, урьдаас бэлдсэн байх шаардлагатай. Ган болохыг урьдчилан таахад бэрх, хэрэв ган болвол түүнийг тохиолдсны дараа шийдвэр гаргах нь эдийн засгийн хохиролтой. Бэлчээрийн ургамлын үржил шимийг урьдчилан тооцоолсноор бэлчээрийн даацыг улирлаар тооцож малаа бэлчээх, зайлшгүй байх нэмэлт тэжээлийг тооцож бэлтгэсэн байх ёстой.

Үүний тулд бэлчээрийн ургацын урьдчилсан мэдээг цаг агаарын болон хөрсний чийгийн мэдээнд үндэслэн гаргаж ашиглаж сургах хэрэгтэй гэсэн санал дэвшүүлжээ.

**Дүгнэлт:** Бэлчээр ашиглалтын талаар иж бүрдэл мэдээлэлтэй болох, энэ ажилд орчин үеийн мэдээллийн технологийг өргөн ашиглах, эдгээр мэдээллийг түгээх сүлжээ бий болгох, малчдад хүргэж, ойлгуулж, эзэмшүүлж сургах явдал чухал гэж үзсэн байна.

## 0140

Дэвид Снийт

### **Төв Азийн бэлчээрийн доройтол ба төрийн бодлого**

*“Science” сэтгүүл. №281. АНУ, 1998. Америкийн шинлэх ухааныг дэмжих нийгэмлэг. 1147-1148 хууд. Англи.*

Төв Азид бэлчээр эзэмшигчдийн үйл ажиллагааг, жишээлбэл ОХУ, Монгол Улс, БНХАУ өөр өөрийн Засгийн газрын шийдвэрээр зохицуулдаг.

Кембриджийн Олон улсын судалгааны төслийн хүрээнд ОХУ, БНХАУ-ын бэлчээрийн доройтлыг тусгайлан судалжээ.

**Дүгнэлт:** Монгол зэрэг бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг улсад хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн техник, технологи өндөр хөгжсөн улс орнуудыг бодвол бэлчээрийн доройтол бага түвшинд байдгийг энэхүү судалгаагаар тогтоосон байна.

## 0141

Лхагважав Н.

### **Хангайн уулархаг нутгийн бэлчээрийг зохистой ашиглах нь**

*Эрдэм шинжилгээний бичиг. №30. Өгүүлэл. УБ, 1999. ХААИС. 53-59 хууд. Монгол.*

Судалгааны ажлыг 1998-1999 онуудад Архангай аймгийн Чулуут сумын нутагт гүйцэтгэсэн байна. Тус сумын бэлчээрийг далайн түвшнээс дээш 2000-2161 метрийн өндөрлөгт орших ойт хээр, 2000-2250 метрийн өндөрлөгт орших уулс хоорондын хөндий хотгор дахь нуга, 2500-2600 метрийн өндөрлөгт орших тайгын нуга,

1700-1800 метрийн өндөрлөгт орших бэсрэг уулын бэл хотгор дахь уулын нуга гэж 4 төрөлд хуваан авч үзсэн байна.

Уулын бүсийн бэлчээрийн ургацын хадгалалт сайн байна. Гэхдээ нийт хугацаанд элдэв өвсний эзлэх хэмжээ зуны үед нэмэгдэх бөгөөд намар, хаварт болон зуны эхэн үед үетэн, бушилз, улалжийн хувийн жин нэмэгдэж, элдэв өвсний оролцоо буурдаг байна.

**Дүгнэлт:** Энэ судалгааг хийхдээ экологийн хүчин зүйлсийн нөлөөллөөр бэлчээрийн ургамлын бүтэц, бүрэлдэхүүнд орж байгаа өөрчлөлт, ургац хуримтлагдах ба хадгалагдах байдал, хүний хүчин зүйлсийн нөлөөллөөр бэлчээрийн төлөв байдалд орж байгаа сөрөг өөрчлөлт, түүнийг байгалийн аясаар нөхөн сэргээх боломжийг нэг сумын жишээн дээр судалсан байна.

## 0142

Оюунцэцэг Ч.

### Ойт хээрийн бүсийн зарим төрлийн бэлчээрийг ашиглах

Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ, 2000. 150 хууд. Монгол.

Судалгаанд сонгож авсан хоёр хот айлын өвөл-хаврын бэлчээрийн 100 га талбай зун, намар 106 толгой хонь, өвөл, хавар 36 толгой хонь байх даацтай байжээ. Бэлчээрийн ашиглалт өвөл 34.4 хувь, бусад улиралд 41.4 хувь байв. Ойрын ба дундын бэлчээрийн ашиглалт зун хамгийн их 41.3 хувь, хавар ойрынх 53.9 хувь болж, ойрын бэлчээрийг эх мал, нялх төлийн бэлчээрт ашиглаж байгаа боловч даац нь сэрүүний улиралд 2-3 дахин хэтэрч талхлагдахад хүрч байна.

Бэлчээрийн мал аж ахуйд малчид бэлчээрийн талбайг зун, намрын, өвөл, хаврын гэсэн үндсэн хэсэгт хувааж газрын гадаргын өндрөөс нам руу босоо чиглэлийн замаар 3-5 удаа нутаг сэлгэн нүүж, улирлын бэлчээрийг алсын, ойрын, дундын, нөөцийн гэж хувааж байна.

**Дүгнэлт:** Судалгаанд хамрагдсан малчид бэлчээрийг нөөцөлж ашиглахаар эхний хоёр жилд зарцуулсан зардлаа бүрэн нөхөж, нэг үнээнээс 14.5 мянган төгрөгийн ашиг олж, зардлаа бүрэн нөхөж ажиллаж байжээ. Иймд бэлчээрийг зохистой ашиглах нь эдийн засгийн үр ашигтай болсныг судалгаагаар тогтоожээ.

## 0143

Энх-Амгалан С.

### Монгол орны цөлөрхөг хээрийн бүсэд мал бэлчээрлүүлэх экологийн нөхцөл

Докторын (Ph.D) диссертаци. УБ, 2000. УБИС, Газарзүйн тэнхим. 114 хууд. Монгол.

Энэхүү судалгаа нь байгалийн нөхцлийг мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбон дүгнэж, мал бэлчээрлэлтийн орчин үеийн экологийн нөхцлийн тэнцвэр алдагдаж, мал маллагааны үйл явцад сөрөг нөлөө үзүүлж буй асуудлуудыг сөхөж тавьсан байна.

Мөн цөлөрхөг хээрийн бүсэд мал бэлчээрлэх экологийн үндсэн нөхцлүүдийн орон зай, цаг хугацааны өөрчлөлт, түүний дотор газрын доройтол, бэлчээрийн хүрэлцээ, уур амьсгалын хүчин зүйлийн өөрчлөлтийн зүй тогтлыг тодорхойлсон байна.

Мал бэлчээрлэх экологийн нөхцөл улам доройтсоор байгаатай холбогдуулан мал бэлчээрлэлтийн арга технологийг хянан үзэх, мал сүргийн өсөлтийн дээд хязгаарыг тогтоон сүргийн бүтцийг сайжруулах, мал аж ахуйг эрчимжүүлэх, мал сүргийг байгалийн нөхцлийн хувьсал өөрчлөлтөд аажмаар дасган зохицуулах, байгалийн нөхцөл доройтох, газар нутаг элсжих, цөлжих явцыг сааруулах, зогсоох бодлого боловсруулан хэрэгжүүлэх зэрэг мал аж ахуйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэсэн санал дэвшүүлжээ.

**Дүгнэлт:** Байгалийн жам ёсны болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр малын бэлчээрийн экосистемийн нөхцөлд гарч буй өнөөгийн сөрөг өөрчлөлтийг тогтоох талаар боловсруулсан математик статистикийн аргачлал нь онол, практикийн ач холбогдолтой бөгөөд цаашид бусад бүс нутагт өргөнөөр хэрэглэгдэх бололцоотой гэж үзэж байна.

## 0144

Тогтох Ж.

### **Монгол орны нөхцөлд хонин сүргийн бэлчээрийн маллагаа, тэжээлийн шинжлэх ухааны үндэслэл**

*Доктор (Sc.D)-ын диссертаци. УБ, 1996. ХААНС, МААЭШХ. 286 хууд. Монгол.*

Монголын аль ч бүс нутгийн бэлчээрийн ургац 8 дугаар сарын дунд үед дээд хэмжээндээ хүрч мөн сарын сүүлээр ургамал хагдарч эхэлдэг бөгөөд намарт зуны ургацын 68,0-76,0, өвөл 53,0-54,4, хавар 35,0-43,0 хувь нь тус тус хадгалагдан үлдэнэ.

Бэлчээрийн ургамлын сэргэлт ойт хээр, хээрт 4 дүгээр сарын 15-наас 25-ны үед, чийгэрхэг нутгийнх 5 сарын эхний 15 хоногт эхлэх боловч мал ногоолуулах зохистой хугацаа ургамлын сэргэн ургалт эхэлснээс хойш 30-35 хоногийн дараа эхэлнэ.

Хонь бэлчээрээс 50 гаруй зүйл ургамлыг сонгон иддэг бөгөөд бэлчээрийн ургац бага, тачир байх тусам ургамлын харагдац сайжирч, амт үнэр нь илүү мэдрэгддэг учир малын сонгон идэх ургамлын нэр төрөл олширно.

Манай бэлчээрийн ногооны шимт бодисын шингэц өндөр, ойт хээрийн бэлчээрийн ногооны хуурай бодисын шингэц дунджаар 57,4, органик бодисынх 26,26, протеиных 62,51, тослогынх 47,68, ислэгийнх 58,76, азотгүй хандлаг бодисынх 63,80, үнснийх 47,83 хувь тус тус байна. Энэ байдал хээр, говийн бүс болон өндөр уулын бүсийнхэд нэгэн адил, дээрх үзүүлэлтээс ч их байна. Ургамал хагдрахад түүний шимт бодисын шингэц буурна.

Энерги болон шингэн протеиныг нормоос илүү идэж байгаа учраас хонь өвлийн улиралд алдсан тарга хүчээ зун, намрын улиралд бүрэн нөхдөг бөгөөд монгол хонины хаврын жин зун, намрын улиралд өндөр уулын бүслүүрт 58,4, ойт хээрт 33,8, хээрт 41,2, говьд 21,2 хувиар тус тус нэмэгдэнэ.

Намрын улиралд хонины бэлчээрээс идэх тэжээлийн хэмжээ хуурай бодисоор тооцоход ойт хээрийн бүсэд зуныхаас 6,18-7,25 хувиар нэмэгдсэн байхад, говийн бүсэд 20,35, өндөр уулын бүслүүрт 7,47 хувиар тус тус буурна. Өвөл, хаврын улиралд хонины бэлчээрээс идэж буй тэжээлийн шимт чанарыг нормтой харьцуулж үзэхэд эм хонь тэжээлийн нэгжийн 31,4%, шингэх протеины 66,7%, солилцлын энергийн 12,8%, өсвөр насны хонь тэжээлийн нэгжийн 44,0-49,1, шингэх протеины 79,7-80,0, солилцлын энергийн 16,5-27,8%-ийг тус тус дутуу иднэ. Энэ нь хонины турах гол шалтгаан болно.

**Дүгнэлт:** Хонины жин байгаль, газарзүйн байршил, экологийн нөхцлийг дагаж ялгаатай, өндөр уулын бүслүүрийн хонины намрын жин ойт хээрийн хонины жингээс 10,5, тал хээрийнхээс 16,3, говийнхоос (зүүн говь) 17,1%-иар тус тус бага байна.

Дөрөвдүгээр сарын дундаас 8 дугаар сарын эх хүртэл хээрийн бүсэд монгол хонины 10 хоногийн саам 42,5+-0,53, говийн бүсийнх 37,3+-0,39 л байгааг үндэслэн саалийн хугацаанд нэг хониноос 20-30 литр таваарын сүү ашиглах боломжтой гэж тооцжээ.

## 0145

Ринчиндорж Д.

### Аюулаас хамгаалах тэжээлийн фондын талаарх зарим асуудалд

“Мал аж ахуйн шинжлэл” товхимол. №5. УБ, 2003. 177-181 хууд. Монгол.

Монгол орны бэлчээрийн маллагаатай мал сүрэгт өвөл хаврын улиралд тохиолдож байгаа байгалийн гамшгийг хохирол багатай даван туулахад гол нөлөөлөх хүчин зүйлийн нэг бол аюулаас хамгаалах тэжээлийн нөөц юм.

Аймагт байгаа аюулаас хамгаалах тэжээлийн фондууд нь улсын нөөцийн газрын мэдэлд үйл ажиллагаа явуулж байгаа боловч тоо, чанарын хувьд шаардлага хангасан тэжээлээр нөөцийг бүрдүүлэх, хадгалах борлуулах талаар хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээ дутмаг байна.

Сумдын аюулаас хамгаалах тэжээлийн фондыг байгуулсан хэдий ч агуулах саравчгүй, бүрдүүлэх тэжээлийн бүтэц тогтоогүй, удирдлага санхүүгийн хувьд бэхжиж чадаагүй төдийгүй эргэн төлөгдөх нөхцлөөр улсын төсвөөр санхүүжүүлсэн учраас тэжээл борлогдохгүй нөхцөлд өрийн дарамтад орж байна.

Аймгийн түвшинд хүчит тэжээлийн фонд байгуулах нөөц боломж бүрдсэн хэдий ч санаачлага зохион байгуулалт дутмаг байна. Тэжээл бэлтгэхдээ тоон үзүүлэлтийг гол болгож чанарын шаардлагыг орхигдуулж хадгалалт хамгаалалтын горим алдагдаж байна.

**Дүгнэлт:** Аюулаас хамгаалах тэжээлийн фондыг шинэчлэн зохион байгуулах тодорхой саналууд дэвшүүлсэн байна.

## 0146

Хишигдаваа Б.

### Монгол Улсын хадлан бэлтгэлийн чадавхи

Магистрын ажил. УБ, 2003. ХААНС. 63 хууд. Монгол.

Энэ судалгаагаар улсын хэмжээний малын тоо толгойн өөрчлөлт болон бусад хүчин зүйлстэй уялдан тэжээл бэлтгэлийн зарим нэг асуудлыг хөндөж өнөөгийн нөхцөлд хэрхэн үр ашигтай хэрэгжүүлэх талаар дүгнэлт гаргажээ. Тухайлбал, тус орны одоогийн бэлтгэж буй хадлан нь нийт мал сүргийг жилдээ 30 хоног тэжээхэд хүрэлцэхгүй байна. Монголын мал аж ахуйн хөгжлийн үзэл баримтлал нь эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх явдал тул малын тоо харьцангуйгаар буурах хандлагатай байна. Гэхдээ бэлтгэх өвс, хадлангийн хэмжээг ойрын жилд одоогийнхоос эрс нэмэгдүүлэх шаардлагатай гэжээ.

**Дүгнэлт:** Хадлангийн талбайг цэвэрлэн хашиж, услах, бордох замаар га-ийн ургацыг нэмэгдүүлэх, эдийн засгийн бүсүүдэд мал сүргийг байгалийн эрсдлээс хамгаалах тэжээлийн сан байгуулж, техник, технологи, зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх, малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийг хадлан тэжээл бэлтгэх чиглэлээр хоршин ажиллах хэлбэрийг дэмжих, урамшуулах, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид, хөдөө аж ахуйн фермерүүдэд таримал бэлчээр, хадлангийн талбайг удаан хугацаагаар эзэмшүүлэн үр дүнтэй ашиглуулах санал дэвшүүлсэн байна.

## 0147

Цогоо Д., Төртогтох Б.

### Тэжээлийн зарим буурцагт ургамлын генийн сангийн судалгаа

“Мал аж ахуйн шинжлэл” товхимол. №5. УБ, 2003. 182-188 хууд. Монгол.

Хээрийн бүсийн усалгаатай нөхцөлд шар царгас (*Medicago falcata*) болон орос царгас (*M.ruthenica*), нумраа хунчир (*Astragalus adsurgens*), хоншоохой хунчир (*A.melilotoides*), говилт хунчир (*A.sulcatus*), сөөгөн

шимэрс (*Hedysarum fruticosum*), гэрийн хошоонгор (*Trifolium lupinaster*) зэрэг буурцагт ургамлууд тарималжих боломжтой. Харин нугын (*Lathyrus pratensis*) болон таван судалт төмөрдээ (*L. quinque nervis*), хошоонбут (*Lespedeza dahurica*), эвэрт хошоонцор (*Lotus corniculatus*) зэрэг буурцагт ургамлууд ургах боловч хөгжлийн үе шат гүйцэхгүй байна.

Шар бургасны нэг бүт ургамал 4.4-38.9 гр өвсний, 0.5-4.9 гр үрийн, нумраа хунчир дээрх дарааллаар 13.3-251.8 гр, 0.1-3.5, сөөгөн шимэрс 4.3-8.1 гр, 0.1-0.7 гр, гэрийн хошоонгор 3.4-8.0, 0.2-0.3 гр ургац өгч байна.

**Дүгнэлт:** Монгол орны бэлчээрийн мал аж ахуйн тэжээлийн нэр төрөлд буурцагт ургамлуудыг оруулж, нэмэлт тэжээл болгон ашиглах явдал чухал бөгөөд түүний эдийн засгийн үр ашгийг тооцоход суурь судалгаа болсон байна.

## 0148

Грегори Кеннетт

### Газар ашиглалт, бэлчээрийн менежмент

*Төслийн тайлан. УБ, 1999. Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлага. 50 хууд. Монгол.*

Энэхүү судалгаагаар бэлчээр бүхэлдээ талхлагдсан болохыг тогтоосон байна. Байгалийн өвс ургамлыг дэндүү их хэмжээгээр хэрэглэсэн, бүт ургамал нь цаашдаа нөхөн ургахгүй болтлоо талхлагдсан болон өвс ургамлын бүтцэд ихээхэн өөрчлөлт орж бэлчээрийн нөөц дуусч үгүй болох аюул тулгараад байна гэж үзжээ.

Бэлчээрийн даацыг энгийн аргаар тооцоолон гаргахад Говийн бүсийн бэлчээрийн даац бараг 200 хувиар хэтэрсэн байна. Нөөцийг ийнхүү хор хөнөөлтэй байдлаар хэтрүүлэн ашиглах нь эдийн засгийн болон экологийн хувьд муу үр дагавартай байдаг. Хөрсний элэгдэл, цөлжилт нэмэгдэх, хөрсний үс шингээх чадвар доройтож муудах, амьд байгалийн оршин тогтнох орчин алдагдах, байгалийн ховор зүйл устаж үгүй болох зэрэг нь малын бэлчээр ашиглалтын өнөөгийн түвшингээс үүдэн гарах байгаль орчны наад захын хор хохирлын жишээнүүд юм.

Малын тоо хэт өссөнөөр бэлчээр талхлагдан доройтдогийг малчид хэдийгээр мэддэг ч гэсэн малынхаа тоо толгойг нэмэх нь тэдний хувьд ашиг орлогоо нэмэгдүүлэх гол арга зам гэж үздэг. Учир нь малаа өсгөн түүнийгээ борлуулах замаар олох ашиг орлого нь зөвхөн тухайн малчинд ноогдох бөгөөд харин бэлчээрийг хэтрүүлэн ашигласны улмаас үүсэх сөрөг үр дагавар нийт малчдад дунд нь тусна. Малчид уламжлалт бэлчээрийн газартаа бусад малчдыг малаа бэлчээрлүүлэхийг зөвшөөрдөг нь Монголын нөхцөлд ихээхэн нийцэж байна гэж үзсэн байна.

**Дүгнэлт:** Мал бэлчээрлүүлэх зөвлөмж заавруудыг боловсруулах, малын тоо ба бэлчээрийн даацын хоорондын тэнцвэртэй байдлыг тогтоох, зах зээлтэйгээ сайн ойртохоос эхлүүлээд тээврийн үйлчилгээг сайжруулах, бүсийн усан хангамжийг дээшлүүлэх, онцгой нөхцөл байдлын үед малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх нь чухал юм.

Говийн бэлчээрийн өнөөгийн ашиглалт нь бэлчээрийн даацын үр өгөөжийг бууруулж, ингэснээрээ бүс нутгийн болон улсын хэмжээнд өгөх эдийн засгийн үр ашгийг багасгаж, бэлчээрийн нөөцөд муугаар нөлөөлж байна гэж судлаач дүгнэжээ.

## 0149

Жереми Свифт, Эрдэнэбаатар Б.

### **Хөдөөгийн ядуучуудыг малжуулах нь: Монголын бэлчээр ашиглалтыг оновчтой болгох, ядуурлыг бууруулах арга зам**

*Хоршооллын өмч судлалын олон улсын холбооны бага хуралд тавьсан илтгэл. Bloomington, Indiana, USA. 2000. Англи.*

Монголын бэлчээрийг эзэмших, хамтран ашиглахад тулгарч буй бэрхшээл бол малчид баян, ядуу гэсэн хоёр туйлд хуваагдаж хөдөөгийн ядуурал ихсэж байгаа явдал юм.

Ядуу малчид нь бэлчээр ашиглах зорилго, бодлогын хувьд баян малчидтай ижил байж чадахгүй бөгөөд энэ нь бэлчээрийг зүй зохистой ашиглахад сөргөөр нөлөөлнө. Ядуу малчдыг малжуулах нь бэлчээрийг зохистой ашиглах нэг чухал нөхцөл болно. 1995 оноос хойш мянган өрхийг малжуулсан бөгөөд малыг эхний жил даатгалд заавал хамруулж, хамтын хариуцлагыг сайжруулах замаар хэрэгжүүлсэн. Ингэснээр эргэн төлөлт 100% байсан.

**Дүгнэлт:** Уг илтгэлд бэлчээр ашиглалтыг сайжруулахын тулд малчдын баян хоосны ялгааг арилгах шаардлагатай бөгөөд ядуу малчдыг малжуулснаар ямар үр дүнд хүрсэн талаар дурьджээ. Малжуулах төслийн хүрээнд зарим өрхүүд зээлээр авсан малаа богино хугацаанд эргүүлэн төлж, өөрсдөө ч амьжиргаагаа дээшлүүлсэн байна.

## 0150

Жигжидсүрэн С., Дуглас Жонсон

### **Монгол орны малын тэжээлийн ургамал**

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2003. 564 хууд. Монгол.*

Бэлчээрийн мал аж ахуйг уламжлалт арга ажиллагаагаар хөгжүүлэхийн тулд малчдад эн тэргүүнд бэлчээр дэх тэжээлийн гол ургамлуудыг таньж мэдүүлэх шаардлага зайлшгүй тулгарч байна. Өөрөөр хэлбэл, улирлын бэлчээрийг малынхаа төрөл, тоо толгойд тохируулан сонгон нүүдэллэж чаддаг болоход ямар ургамлыг хэдийд идүүлэх нь ашигтай гэдгийг малчин хүн мэдэж байх учиртай. Энэ зорилгоор Монгол орны бэлчээрт голлон тархсан 38 овгийн 139 төрлийн 323 зүйл ургамлыг түүвэрлэн авч, ерөнхий шинжийг товч тодорхойлохын сацуу таньж мэдэхэд дөхмийг бодолцон фото зургийг нь хавсаргасан байна.

**Дүгнэлт:** Монгол орны өндөр уул, уулын тайга гэх мэт байгалийн бүсүүдийн ургамал нөмрөгийг бүрдүүлэгч тэжээлийн гол ургамлуудын идэмжийг 5 төрлийн мал тус бүрд улирлаар зааж өгөхийн сацуу ургамлын найрлага, шимт чанарын талаар дэлгэрэнгүй дурьдсан байна.

## 0151

Кейт Гриффин

### **Хотоос хөдөө рүү шилжих эрчимгүй хөдөлгөөн: Мал аж ахуйн салбарын эрчимгүй хөгжил**

*“Монгол дахь ядуурлыг бууруулах стратеги: Тэгш байдал, ядуурлыг бууруулах асуудлыг хөгжлийн стратегид тусгах” сэдвээр мэргэжлийн багийн боловсруулсан илтгэл. УБ, 2001. НҮБХХ-ийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар. 44-55 хууд. Англи, Монгол.*

Энэхүү судалгаанд зах зээлийн эдийн засагт шилжих үеийн эхэнд хүн ам хөдөө рүү шилжих хөдөлгөөн давамгайлж байсан бол 1999-2000 оны байгаль, цаг уурын бэрхшээлийн үр дагавраас болж шинэ, туршлагагүй малчид ихээхэн хохирол амсч эргээд хот суурин руу шилжих болсныг харуулжээ.

Бэлчээрийг нийтээр өмчилж байгаа нь талхагдал үүсэх үндэс болж байгаа учир түүнийг зохицуулдаг байгууллага шаардлагатай болж байна.

Иймд малчид хэсэг бүлгээрээ нэгдэж орон нутгийн захиргаатайгаа бэлчээр, усны нөөцийг ашиглах урт хугацааны түрээсийн гэрээ байгуулж ажиллах, түрээсээ жил бүр төлдөг байх нь чухал гэж судлаач үзжээ.

**Дүгнэлт:** Малчдыг бэлчээр, усны талаар олон жилийн түрээстэй ажиллуулах нь бэлчээр нутгаа оновчтой ашиглах сонирхлыг бий болгохоос гадна малчид нийтээрээ бэлчээр, усаар тэгш хангагдах боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, бэлчээрийг талхлахгүй болно гэсэн үг. Газар, усны нөөцийг ашиглах эрх эдэлж байгаагийн төлөө малчид түрээсийн төлбөр төлөх нь хөдөөгийн хөгжлийн санаачлагыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бий болгоно гэж судлаач үзсэн байна.

## 0152

Чарльз Крузкоф

### Монголын эдийн засгийн хөгжил ба бэлчээр

*“Change and Sustainability of Pastoral Land Use Systems in Temperature and Central Asia” товхимол. УБ, 2001. НСНСОУХ. 344-345 хууд. Англи.*

Монголын бэлчээр нь нүүдлийн мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой бөгөөд Засгийн газар ба малчид нь бэлчээр эзэмших, өмчлөх асуудлыг ихээхэн дэмжиж байна. Гэвч бэлчээр эзэмшигчдийн хооронд зөрчил гардаг, бэлчээрийн менежмент хөгжөөгүй, Засгийн газраас энэ асуудлыг зохицуулах байгууллага байхгүй байгаа зэрэг тодорхой бэрхшээлүүд цөөнгүй байна.

Судлаач Монголын бэлчээрийн менежменттэй холбоотой асуудлуудыг эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан шийдвэрлэх боломжтой гэсэн санаа дэвшүүлсэн байна.

**Дүгнэлт:** Монголын хөдөөгийн эдийн засгийн хөгжилд бэлчээрийн мал аж ахуй зонхилсон хэвээр байгаа өнөөгийн нөхцөлд газрын нөөцийг илүү үр дүнтэй ашиглах, ялангуяа бэлчээрийг өмчлүүлэх асуудлыг аажимдаа хэрэгжүүлж болох юм гэж үзсэн байна.

## 0153

Мария Фернандес-Гименес

### Монголын бэлчээр ашиглалтын газарзүйн түүх

*“Geographical review” сэтгүүл. 89(3). Нью-Йорк 1999. Америкийн газарзүйн нийгэмлэг. 315-342 хууд. Англи.*

Монголын улс төр, эдийн засагт гарсан сүүлийн үеийн өөрчлөлтүүд нь бэлчээр ашиглалтад нөлөөлсөн бөгөөд зах зээлийн эдийн засгийн нөхцөлд бэлчээрийг яаж хуваарилах, хэрхэн зохицуулах асуудал ихээхэн маргаантай байна. Монголд бэлчээрийг ашиглах, эзэмших талаар түүхээс харахад социализмын үе буюу малыг нийгэмчлэхээс өмнө бэлчээр ашиглах, эзэмших талаар нарийвчилсан ойлголт байгаагүй. Бэлчээрийг ашиглах, эзэмших талаар хийсэн судалгаагаар малчдын баян, ядуугийн ялгаа нь бэлчээрээ түргэн өөрчлөх чадвараар тодорхойлогдож байсан нь өнөөдөр батлагдсан байна.

**Дүгнэлт:** Монголын бэлчээр ашиглалтын түүхийг ардын хувьсгалаас өмнөх үеэс хойш дэлгэрэнгүй судалж, дүгнэлт өгсөн байна. Ихэвчлэн бэлчээр ашиглалтын газар зүйн асуудлыг хөнджээ.

## 0154

Петер Финке

### Социалист гэгдэж байсан Монголын бэлчээр эзэмшилтийн өөрчлөлт

*Хоршооллын өмч судлалын олон улсын холбооны VIII бага хуралд тавьсан илтгэл. Bloomington, Indiana, USA. 2000. Англи.*

Энэ илтгэлд Монголын баруун аймгуудын бэлчээр хуваарилалтын талаар өгүүлжээ. Судалгааны объект нь монгол, казах үндэстэн оршин суудаг, хуурай сэрүүн уур амьсгалтай бүс нутаг юм.

Монголын баруун бүсийн мал аж ахуй нь одоо хүртэл нүүдлийн шинжтэй, газар нь улсын өмч, социалист нийгмийн үед газар нутаг нь нэгдэлд хуваагддаг байсан. Түүнчлэн бэлчээр хуваарилалт нь улирлын шинжтэй байдаг.

Бэлчээр хуваарилалттай холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, ялангуяа нэгдлийн үеийн бэлчээр хуваарилалтыг өөрчлөх, эрх мэдлийн буруу зохицуулалт гаргахгүй байх явдал чухал гэж судлаач үзсэн байна.

**Дүгнэлт:** Баян-Өлгий аймгийн бэлчээр эзэмшилт, түүний одоо ба ирээдүй, казахчуудын цагаачлал бэлчээр эзэмшилтэд хэрхэн нөлөөлсөн талаар өгүүлж, бэлчээр хуваарилалттай холбоотой тус бүс нутгийн тулгамдсан асуудлыг дурьдсан байна.

## 0155

Тогтохбаяр Н., Гэндарам Х.

### Бэлчээрийн ногооны ерөнхий шимт чанарыг солилцооны энергиэр үйлчлэх боломж

*"Мал аж ахуйн шинжлэл" товхимол, №5. УБ, 2003. 107-114 хууд. Монгол.*

Дэлхий дахинд тэжээлийн шимт чанарыг солилцооны энергиэр үнэлж байгаа өнөө үед бэлчээрийн өвс, үйлдвэрийн аргаар бэлдсэн тэжээлийг энэхүү аргаар үнэлж хэмнэлттэй зарцуулах шаардлагатай юм.

Тэжээлийн шингэц, шимт чанарыг малд шууд туршиж тодорхойлохоос гадна тооцоолон гаргадаг олон арга байдаг. Энэхүү бүтээлд, Монгол орны бэлчээрийн өвс, хагдны химийн найрлага, шингэцийг судалсан эрдэмтэд, судлаачдын шинжилгээний дүнг Попов, Аксельсон, Калашников, Гэндарам, Морган нарын аргаар тус тус боловсруулан солилцооны энергийг тооцоолон гаргажээ. Эдгээр аргаар гарсан үзүүлэлтүүдийг хоёр түүврийн дисперсийн аргаар шинжилж үзэхэд Х.Гэндарамын арга илүү болох нь тогтоогдсон байна. Тооцоо хийсэн уулын нуга хээрийн бэлчээрийн 1 кг өвсний ерөнхий шимт чанар 10.9, хээрийнх 9.2, заримдаг цөлийнх 11.1 МДж байгаа нь доктор (Sc.D) Р.Цэрэндуламын тооцоолсон үзүүлэлттэй зүй тогтлын хувьд тохирч байна.

**Дүгнэлт:** Бэлчээрийн өвс ногооны шимт чанарыг зөв тооцоолж мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зардалд зөв тусгахад ач холбогдолтой онолын судалгаа болсон байна.

## 0156

Чогний О.

### Монголын нүүдлээр ашиглагдсан бэлчээрийн өөрчлөгдөх, сэргэх онцлог

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2001. 174 хууд. Монгол.*

Монгол орны бүх төрлийн бэлчээрийг бордох юм уу олон наст өвс тариалан сайжруулах боломжгүй. Ус дутагдалтай, хөрс муутай, хад чулуу ихтэй газрын бэлчээрийг байгалийн аясаар нь сэргээн сайжруулж, ургацыг нь ихэсгэх, чанарыг нь сайжруулах асуудал зүй ёсоор шаардагдаж байгаа юм. Энэхүү зорилгыг шийдвэрлэхийн тулд 1970-1990 онд Архангай, Өвөрхангай, Төв, Булган, Хөвсгөл, Завхан, Хэнтий, Сүхбаатар, Дорнод зэрэг ойт хээр, хээрийн бүсийн аймгуудын төв болон Улаанбаатар хот орчмын хүн амьтан, малын нөлөөгөөр ихээхэн өөрчлөгдөж талхлагдсан газрын ургамлын нөмрөгийн өөрчлөгдөх, сэргэх онцлогийг судалсан байна. Үүнээс





гадна дээрх нутгийн бэлчээрийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, зонхилох ургамлын бүлгэмдэл үүсгэх үүрэг, биоморфологи бүлгэмдлийн бүтэц, ургамлын хэмжээ, чанар, хүн, мал, амьтан, уур амьсгал зэрэг экологийн хүчин зүйлийн нөлөөгөөр болон тодорхой хугацаагаар амрах үед хэрхэн өөрчлөгдөж байгааг сорил судалгааны аргаар харьцуулан судалжээ.

**Дүгнэлт:** Монгол орны бэлчээрийн чанарыг үнэлэх, нөөцийг зохистой ашиглах, сэргээж сайжруулах, хамгаалах ажлын менежментийг сайжруулахын тулд юуны өмнө аймаг, сум, баг бүрийн бэлчээрийн талхагдлын (бага, дунд, их) зэргийг бэлчээрийн хэв шинж тус бүрээр тодорхойлж, тэдгээрийн талбайн хэмжээ, ургацын даацыг тооцоолж гаргах, талхлагдсан бэлчээрийг сэргээн сайжруулах сорил судалгаа явуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг өргөжүүлэх санал дэвшүүлсэн байна.

## 0157

Энх-Амгалан А.

### Монголын бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн бодлогын зарим асуудлууд

*Бодлогын зөвлөмж. УБ, 1998. "Сэтгэх хүч" MON/97/131 төсөл. НҮБХХ. 11 хууд. Монгол.*

Дэлхийн бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн хандлага, Монгол орны бэлчээрийн мал аж ахуйд хуримтлагдаад байгаа шийдвэрлэх асуудлуудыг харьцуулан дүгнэж, мөн өөрийн хийсэн судалгаа, ажиглалтын үндсэн дээр энэхүү чухал салбарын талаар төрөөс баримтлах бодлогын талаар зохиогч тодорхой санал дэвшүүлжээ. Санал нь Монгол орны бэлчээрийн мал аж ахуйн онцлогт тохирсон газрын шинэтгэлийг хэрэгжүүлэх замаар энэ салбарын удаан хугацааны тогтвортой хөгжлийг хангах үндсэн агуулгатай юм.

Газрын шинэтгэлийг оновчтой хэрэгжүүлсэн нөхцөлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зохион байгуулалтын асуудлыг давхар шийдэх бололцоотой гэж зохиогч үзжээ.

Газрын шинэтгэлийг Монголын малчдын дунд бэлчээрийг ашиглах талаар үе дамжин уламжлагдаж ирсэн нэг голынхон, нэг усныхан зэрэг албан бус бүлгүүдэд түшиглэн хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлжээ.

**Дүгнэлт:** Судлаач Монголын бэлчээрийн мал аж ахуйн үндэс болсон бэлчээр эзэмших эрхийг баталгаажуулснаар (газрын шинэтгэл хийснээр) мал аж ахуйн салбарын хөгжлийн зарим асуудлуудыг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулна гэж үзжээ.

## 0158

Энх-Амгалан А.

### Монголын бэлчээр ашиглалтын өөрчлөлт ба тогтворжилт

*"Change and Sustainability of Pastoral Land Use Systems in Temperate and Central Asia" төвхимол. УБ, 2001. НСНСОУХ. 228-231 хууд. Англи.*

Монголчууд олон зуун жилийн туршид нүүдэллэж ирсэн. Энэ нь уламжлалт бэлчээр ашиглах технологи буюу дөрвөн улирлаар бэлчээрийг хуваарилан ашигласнаар өмнө ашигласан бэлчээр нөхөгдөж, сэргэж байдаг онцлог, монголчуудын (байгальтай салшгүй холбоотой) амьдралынх нь хэв маяг зэрэгтэй холбоотой.

1990-ээд оны үеэс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр үйлдвэр аж ахуйн газар уналтанд орж, малчдын сонирхол үндсээрээ өөрчлөгдсөн. Харамсалтай нь, энэ өөрчлөлтийн эдийн засаг, нийгэм, экологийн үр дагаварыг урьдчилан харж, түүнд тохирсон бодлого явуулж чадаагүй.

Гол нь малыг хувьчлах, үнийг чөлөөлөх бодлого баримталсан. Малыг хувьчилснаар малын тоо нэмэгдэхэд түлэх болсон хэдий ч төрөөс тусламж (олгох) үзүүлэхээ больсноос малчид малын тоогоо өсгөх замаар эрсдлийг даван туулах хэрэгтэй болсон. Өөрөөр хэлбэл, малын тоо толгой өссөн нь эрсдлийн менежментийг бий болгоход хүргэсэн юм.

Малчдын 84% нь 200-аас бага толгой малтай ба тэдний хооронд малын тоог өсгөх, бэлчээр ашиглах зэрэг өрсөлдөөн нэмэгдсэн байна.

**Дүгнэлт:** Дээрх асуудлуудыг шийдвэрлэхийн тулд малчдын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн стратегийг хэрэгжүүлэх, малчид бизнес эрхлэх явдлыг дэмжиж, тийм чадвар эзэмшүүлэх, эрсдлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх санал судлаач дэвшүүлсэн байна.

## 0159

Эрдэнэбаатар Б., Батжаргал Н.

### Бэлчээрийн маргаан зөрчил

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 2001. Азийн сан. 107 хууд. Монгол.*

Мал сүргийн тоо зөвхөн сүүлийн 10 жилд 35.6 хувиар өссөн явдал бэлчээрийн хүрэлцээг улам муутгаснаас гадна бэлчээрийн 20 гаруй хувь нь нэн хүчтэй ба хүчтэй элэгдэлд орж мал бэлчээрлэх боломжгүй болсон нь байдлыг улам хүндрүүлж байна. Иймд Монгол Улсад бэлчээрийн менежментийг хөгжүүлэхийн тулд юуны өмнө бэлчээрийн даац, багтаамжид байнгын хяналт тавьж зохицуулах, бэлчээр нутгийг эзэмших, ашиглах эрх зүйн хамгийн оновчтой орчинг бүрдүүлэх, бэлчээрийн менежментийн талаар бүсчилсэн сургалт явуулах, бэлчээр нутгийн талаар төрөөс баримтлах хэтийн бодлого боловсруулах үүрэг бүхий бэлчээрийн алба байгуулан ажиллуулах санал дэвшүүлжээ.

**Дүгнэлт:** Бэлчээр бол нүүдлийн мал аж ахуйн хамгийн гол хүчин зүйл юм. Сүүлийн жилүүдэд газар, бэлчээрийн маргаан байнга гарах болсныг харгалзан бэлчээрийн маргаан зөрчлийг оролцогч талуудад харилцан ашигтай байдлаар шийдвэрлэх арга замыг тодорхойлох, бэлчээр ашиглалтыг сайжруулах арга замыг энэхүү бүтээлд судалсан байна.

## 1430 Хашаа хороо, худаг ус

### 0160

Балдандорж Ц.

### Зах зээлийн үеийн хөдөөгийн усан хангамж

*"Market-Economy Nomads-Technology" товхимол. УБ, 2002. НСИСОУХ. 164-167 хууд. Англи.*

Өргөн уудам газар нутагтай Монгол орны хувьд усны нөөцийн иж бүрэн судалгаа бараг хийгдэж байгаагүй. Сүүлийн дөрвөн жилд хөдөөгийн ус хангамжид зориулан 1.2 тэрбум төгрөг зарцуулсан ч энэ нь хэмжээний хувьд бага юм. Шинэчлэлтийн үед малчид хувь хувиа бодох болсноор худаг, уст цэг эзгүйрэхэд хүрсэн бөгөөд эвдэрсэн худгийг засаж янзлахад Засгийн газраас төсөв хөрөнгө зарцуулсан боловч олигтой үр дүнд хүрээгүй байна гэж судлаач үзжээ.

**Дүгнэлт:** Зах зээлийн нөхцөлд малчид тодорхой хэмжээний төлбөр төлж байж усаар хэрэгцээгээ хангах, эсвэл өөрсдийн өмчлөлийн уст цэгтэй байж хэрэгцээгээ хангах хоёр арга зам бий болоод байна. Мөн Засгийн газраас хөдөө аж ахуйн усан хангамжийг сайжруулахад чиглэсэн бодлого, хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн санал судлаач дэвшүүлжээ.

## 1440 Газар зохион байгуулалт, газрын харилцаа, газар зүй

### 0161

Базаргүр Д.

#### **Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй (Монголын нүүдэлчдийн жишээгээр)**

*Доктор (Sc.D)-ын диссертаци. УБ, 1996. ШУА, Газарзүйн хүрээлэн. 263 хууд. Монгол.*

Нүүдэлч малчдын уламжлалт “нэг нутаг усныхан” нэгжийг шинэчлэлтэй холбон зах зээлийн үеийн нэгж болгон, түүний нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг шинэчлэл хийж, улмаар төвийг байгуулан хөгжүүлэх замаар нүүдэлч малчдын нийгэм, эдийн засгийн асуудлыг малчдын төвлөрөл (хагас нүүдэл), хагас суурьшил, бүрэн суурьшлаар шийдвэрлэх онол, зүй тогтлыг судалсан байна. Тодруулбал, нүүдэлч малчдыг зах зээлийн эдийн засагт шилжүүлэхдээ хөдөөнөөсөө “тосгонжиж” хөгжих үзэл баримтлалыг энэ бүтээлд дэвшүүлсэн байна.

Одоогийн засаг захиргааны төвүүд болон шинээр үүсч байгаа жижиг суурингуудыг түшиглэн нүүдэлч малчдын нийгэм, эдийн засгийн нэгжүүд бий болгох, улмаар алс нутгийн нүүдэлч малчдыг хоршоололд хамруулан суурин төвийг үүсгэх замаар нийгэм, эдийн засгийн нэгжүүд болгох талаар судалсан байна.

Малчин өрхүүд бэлчээрийг экологийн зохистой нутгийн хуваарьгүй эзэмшиж байгаа өнөөгийн байдлаас энгийн хуваарьтай, нөөцөлсөн хуваарьтайгаар тус тус ашиглуулах, улмаар өнжүүлсэн бэлчээртэй, таримал бэлчээртэй болгох, ердийн хадлан бэлтгэлээс сайжруулсан хадлан, таримал тэжээл бэлтгэдэг болгох санал дэвшүүлжээ.

**Дүгнэлт:** Энэхүү бүтээлд бэлчээрийн мал аж ахуйг хагас суурин хэлбэрт шилжүүлэх, бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх үндсэн арга болох нүүдлийг нүүдэл-отор, отор-нүүдэл, отор, отор-фермийн, фермийн аргаар солих талаар дэлгэрэнгүй судалсан байна.

### 0162

Базаргүр Д.

#### **Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй**

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 1998. ШУА, Геоэкологийн хүрээлэн. 379 хууд. Монгол, Англи, Орос.*

Монгол оронд бэлчээрийн мал аж ахуй 2000 гаруй жил төлөвшин тогтож, хөгжиж ирсэн эртний уламжлалтай болохын нэг баталгаа нь Монголын нүүдэлчдийн мал маллагааны арга ажиллагаа, амьдралын хэв маяг, бусад аль ч орны нүүдэлчдийг дуурайгаагүй бие даасан онцлог шинжтэй байгаад оршино.

Байгальтай харьцах өдөр тутмын харилцаанаас олж авсан малчдын ажиглалт, мэдлэг туршлага маш өргөн хүрээтэй нь эргэлзээгүй. Энэхүү бүтээлд нүүдэлчин малчдын олон зуун жилийн амьдралаас урган гарч уламжлагдан ирсэн оюун ухааны их сан хөмрөгөөс зөвхөн газарзүйн холбогдолтойг түүвэрлэн эмхэтгэжээ.

**Дүгнэлт:** Тус бүтээлдээ судлаач монголын нүүдэлчдийн судлагдсан байдлыг гадаад, дотоод олон эрдэмтдийн бүтээлээр харьцуулж тодорхойлсон байна. Судалгаандаа газарзүйн хилийн арга, хөдөлгөөнт ареалын загварчлалын арга, бэлчээрийн малын экологийн зохистой нутаг, түүний хэвшинжийг илрүүлэх цогцолбор арга зэрэг олон аргыг ашигласан бөгөөд бэлчээрийн малын экологийн зохистой нутгийн хэвшинжийг тодорхойлж, улмаар “Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй” нь шинэ салбар гэдгийг батлах оролдлого хийжээ.

## 0163

Дэвид Снийт

### Монголын нүүдлийн түүх ба газар эзэмших эрхийн талаар

*Хоршооллын өмч судлалын олон улсын холбооны бага хуралд тавьсан илтгэл. Bloomington, Indiana, USA. 2000. Англи.*

1990-ээд оноос Монгол Улс хувийн өмчид тулгуурласан зах зээлийн эдийн засагт шилжих шинэчлэлтийн бодлого хэрэгжүүлж байна. Үүний дагуу улсын эзэмшилд байсан нэгдлүүдийг татан буулгаж, бэлчээрийн мал аж ахуйн эдийн засгийг их хэмжээгээр хувьчилжээ.

Энэ илтгэлд монголчуудын бэлчээр эзэмших талаар гарч байгаа зөрчлүүд болон түүнийг шийдвэрлэхэд саад болж байгаа нүүдэлч малчдын дунд хэвшиж тогтсон зөрчлүүдийг судалсан байна. Түүхийн үүднээс авч үзвэл Төв Азийн малчдын бэлчээр эзэмшилт нь ихээхэн хувьсамтгай, нүүдэлч малчид бэлчээрээ нийтээрээ ашиглаж байсан ба энэ нь тэднийг засаг захиргаа болгон хуваарилах зохицуулалт болж байсан.

**Дүгнэлт:** Эрт дээр үеэс өргөн уудам газар нутагт нүүдэлчин маягаар амьдарч ирсэн монголчууд зах зээлийн эдийн засгийн системд шилжсэнээр бэлчээрийг эзэмших, өмчлөх асуудалтай тулгарсан ба энэ үед гарч байгаа саад бэрхшээлүүдийг энд тоймлон өгүүлжээ.

## 0164

Мария Фернандес-Гименес

### Монголын газар өмчлөлийн нөхцөл дэх мал хувьчлалын үр дүн

*"Nomadic Peoples" сэтгүүл. №5. 2001. 49-66 хууд. Англи.*

Энэ өгүүлэлд Монголын малчид малаа хэрхэн хувьчилж авсан, түүний үр дүнгийн талаар дурьджээ. 1950-иад оноос үүссэн нэгдэлжих хөдөлгөөн, тэр үеийн малчдын үйл ажиллагаа, мал маллах арга туршлага, хувьчилсны дараах үр дүн ямар байсан зэргийг харьцуулан судалсан байна. Мал хувьчлагдсанаар маш ядуу болон чинээлэг малчдын ялгаа ихэсч, хотуудаас малтай шинэ өрхүүд хөдөөд шилжих нь нэмэгдсэн байна.

**Дүгнэлт:** Малчид нэгдэлд харьяалагддаг байсан үе болон малыг хувьчилсны дараах үеүдийн амьжиргааны түвшинг судалж харьцуулалт хийж, газар эзэмшилтэй холбон тайлбарласан байна.

## 0165

Мария Фернандес-Гименес, Батбуян Б.

### Монголын хууль ба эмх цэгцгүй байдал: Монголын газрын хуулийн хэрэгжилт

*Хоршооллын өмч судлалын олон улсын холбооны бага хуралд тавьсан илтгэл. Bloomington, Indiana, USA. 2000. Англи.*

Монголд 1992 онд хөдөө аж ахуйн нэгдлүүд тарснаар бэлчээрийн хуваарилалтыг зохицуулж байсан албан ёсны зохицуулалт алга болсон.

1994 онд Монголын парламент газрын тухай хууль баталсан ба түүнд газар эзэмших, тухайлбал бэлчээрийг түрээсээр эзэмших талаар заасан.

Энэхүү бүтээлд газрын хууль хэрхэн хэрэгжиж байгаа талаар судалгаа хийсэн байна.

**Дүгнэлт:** Хөдөө аж ахуйн нэгдэл задарсны дараахь бэлчээр ашиглалтын сөрөг үр дагаврыг дурьдаад, Газрын тухай хууль батлагдаж, газрыг түрээсээр эзэмших болсноос хойш малчдын амьдралд гарсан өөрчлөлт, ер нь газрыг түрээсээр ашиглахын үр нөлөөг авч үзсэн байна.

## 0166

Түмэнбаяр Н.

### Монголын газар хувьчлал

*Хоршооллын өмч судлалын олон улсын холбооны бага хуралд тавьсан илтгэл. Bloomington, Indiana, USA. 2000. Англи.*

Монголд газар нь хэзээ ч хувийн өмч байгаагүй. Харин зах зээлийн харилцаанд шилжиж, дэлхий дахинд өрнөж байгаа даяаршлыг хүлээн зөвшөөрснөөр Монголд газрын шинэчлэл хийх зайлшгүй шаардлага тулгарсан юм. Газар хувьчлаагүйгээс улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, газарт оруулах хөрөнгө оруулалтыг сааруулж байна.

Уг илтгэлд дээрх шинэчлэл нь зөвхөн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, улсын зардлыг бууруулах, улсын төсөвт дэмжлэг үзүүлэх, газар дахь хөрөнгө оруулалтыг хамгаалахад чиглээд зогсохгүй Монголын уламжлалт мал аж ахуйг дэмжсэн байх ёстой гэжээ. XXI зууны босгон дээр хийгдсэн эдийн засаг, нийгмийн шинэчлэлийн үр дүнд ихээхэн хохирсон нийгмийн бүлэг бол малчид байсан. Газрын хуулийн дагуу малчдын уламжлалт бэлчээр эзэмших эрх нь хадгалагдаж, газар нийтийн эзэмшлийнх хэвээр үлдсэн. Засгийн газраас малчдын бэлчээр эзэмших эрхийг дэмжсэн ч түүнийг өмчлөх эрхийг албан ёсоор зохицуулаагүй гэжээ.

**Дүгнэлт:** Монгол дахь газрын шинэчлэл нь бусад орнуудынхоос ихээхэн ялгаатай явагдаж байна.

Газрын шинэчлэлийн хэрэгжилтийн явцад янз бүрийн саад бэрхшээл, сөрөг үр дагавар гарч болох бөгөөд нийгмийн үр дүнг нь сайжруулахын тулд улс орны урт хугацааны хөгжлийг бодолцон сайтар боловсруулсан нийгмийн бодлого байх шаардлагатай гэж үзсэн байна.

## 0167

Цэвээн Ц.

### Малчин өрхийн газар эдэлбэр, эдийн засгийн асуудлууд

*Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ, 1999. МУИС. 167 хууд. Монгол.*

Газар (бэлчээр) нь хэний ч хөдөлмөрийн үр дүн биш бөгөөд бэлчээрийн мал аж ахуй эрхлэх үндсэн нөхцөл юм. Монголчууд мал аж ахуйдаа газрыг бэлчээр хэлбэрээр эдэлбэрлэн газрын гадарга, цаг уур, хур тунадас, ургамлын бүрхэвчтэй холбоотойгоор улирлаар ашиглаж иржээ. Газрын өгөөж нь мал аж ахуйг өсгөн үржүүлэх нөхцөл болж, малын ашиг шим нь монгол малчны аж амьдралын хэрэгцээг хангах үндэс болсон байна.

Монгол Улсын түүхэн хөгжлийн явцад бэлчээр-мал-малчны хөдөлмөрийн холбоо улам бэхжиж, тэдгээрийн дүнд малчин өрхийн аж ахуйн үндсэн хэлбэр тогтож, тэдний эдийн засгийн чадавхийг бүрдүүлж ирсэн гэсэн дүгнэлт хийсэн байна.

Малчин өрхийн ам бүлээс шалтгаалан орлого, зарлага, ашиг нь малын тоо, ашиг шимээс хамааралтай байна. Иймд судлаач 1-10 ам бүлтэй өрхийн орлого, зарлагатай холбогдсон тооцоонд үндэслэн малчин өрхөд байвал зохих малын тоог өрх нэг ам бүлээс бүрдэж буй үед 117, 10 ам бүлээс бүрдэж байвал 632 толгой малтай байвал зохимжтой гэж үзжээ.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн нэгжийг хөтлөн явуулж буй өрхийн тэргүүлэгч (менежер)-ийн болон өрхийн гишүүдийн боловсрол, мэдлэг, зах зээлийн туршлага өнөөгийн шаардлагаас хоцрогдсон байна. Энэхүү судалгаанд хамрагдсан 11 аймаг, 35 сумын 139 малчин өрх айлын 12-аас дээш насны 509 хүнээс 287 нь (56,4%) боловсролгүй буюу бага боловсролтой байна. Малчин өрхийн гишүүдийн боловсролын түвшин доогуур байгааг малчин өрх зорилго, стратеги чиглэлгүй зах зээлийн харилцаанд татагдан орсон болон ажил төрөл, амьдралаа дээшлүүлж чадахгүй байгаагийн нэг шалтгаан болж байна гэж үзжээ.

**Дүгнэлт:** Энэхүү бүтээлд Монголын бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэхэд бэлчээрийн ашиглалт, түүний төлөвлөлт, зохион байгуулалт, удирдлага, хяналтыг цогцолбороор нь авч үзэх онолын үзэл баримтлалыг дэвшүүлсэн байна.

0168

Шийрэв-Адъяа С.

**Нүүдэлч малчдыг суурьшуулах газарзүйн зарим асуудал**

*Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ, 1999. ШУА, Геоэкологийн хүрээлэн. 129 хууд. Монгол.*

Судлаач ардын аж ахуйтны үеийн малчдын мал аж ахуйн зохион байгуулалтын хэлбэр болох хот айл, саахалт, зөрүүлэх отор, отрын баг, нэг нутаг усныхан болон хөдөө аж ахуйн нэгдлийн үеийн хөдөлмөр зохион байгуулалт болох мал аж ахуйн хэсэг, мал төллүүлэх бааз, өсвөр үхэр эрчимтэй бордох бааз, малчин залуучуудын хоршоолол, отор саалийн өргөн айлсалт, мал аж ахуйн суурь зэргийг төрөлжүүлж авч үзсэн байна.

Нүүдэлч малчдын төвлөрөл суурьшил нь тэдний одоогийн механик төвлөрлөөс чанарын ялгаатай, хөдөөгийн хүн амын амьдрах жижиг тосгон үүсч, тэдгээрт үйлдвэрлэлийн ба нийгмийн дэд бүтцийн сүлжээг бий болгох замаар суурин амьдралын хэв маяг, соёл иргэншил давамгайлах зэргээр илэрхийлэгдэнэ.

Хөдөөгийн малчдын ая тухтай аж төрөх шаардлагыг бүрэн хангасан хөдөөгийн тосгон, суурин нь малчдын суурьшлын бас нэг нөхцөл болно гэдгийг туршилт судалгааны урьдчилсан дүн харуулсан байна.

Харин уламжлалт зохион байгуулалтын нэлээд төгөлдөржсөн бөгөөд одоо үед түүний дэвшилтэт талуудыг сэргээн хэрэглэж болох нэгж нь “нэг нутаг-усныхан” байсан гэжээ.

**Дүгнэлт:** Бэлчээрийн мал аж ахуйг нүүдлийн аргаар эрхэлдэг Монголын малчдыг суурьшуулахад нөлөөлөх байгалийн нөхцөл, нөөцийг үнэлэхэд харгалзах үндсэн үзүүлэлт нь газрын гадаргуугийн хажуунуудын ялгавартай чанар юм. Энэ чанар юуны өмнө нарны ээлт, салхины хүчнээс хамааран тухайн үеийн агаарын температурын болон тунадасны хуваарилалт, бэлчээрийн ургамлын төрөл зүйлийн хавсарсан нөлөөллөөр илэрхийлэгдэнэ.

Бэлчээрийн малын экологийн зохистой нутгийн доод шинж чанарыг газрын гадаргуугийн хажуунуудаар илэрхийлэх, экологи-технологи-эдийн засгийн үнэлгээ өгч, сэлгэн эдэлбэрлэж, цаашид түүний биологийн бүтээмжийн чанарыг дээшлүүлснээр малчдыг суурьшуулах нэг нөхцөл бүрдэнэ гэсэн санал дэвшүүлжээ.

**1450 Мал аж ахуйн механикжилт, цахилгаанжилт**

0169

Альберт Ю-Минг Чи, Ахти Лейнбуо

**Нарны болон салхины эрчим хүч нь нүүдлийн соёл иргэншлийг хөгжүүлэх үр дүнтэй арга мөн**

*“Nomads and Use of Pastures Today” товхимол. УБ, 2000. НСНСОУХ. 144-148 хууд. Англи.*

Энэхүү судалгааны дагуу таван жилийн төлөвлөгөө гарган мөрдөж байна.

Нүүдэлч малчдын эрчим хүчний хэрэгцээг хангах арга замыг судалж, Монголын нөхцөлд нар, салхины эрчим хүчийг өргөн ашиглах боломж нөхцлийг судалж, дүгнэлт өгсөн байна.

**Дүгнэлт:** Монголын нөхцөлд малчдын ахуйн хэрэглээг нар, салхины эрчим хүчийг ашиглах замаар хангах, энэ чиглэлээр үр дүнд хүрсэн гадаад орнуудын туршлагыг нэгтгэн дүгнэж, тулгамдсан асуудлуудыг дэвшүүлж тавьсан байна.

**0170**

Балдангомбо Б.

**Сүү-таваарын жижиг фермийн механикжсан технологийн шинжлэх ухааны үндэслэл**

*Доктор (Sc.D)-ын диссертаци. УБ, 1999. ХААИС. 283 хууд. Монгол.*

Судлаач энэхүү бүтээлдээ сүү-таваарын жижиг фермийн үйлдвэрлэлийн нэгжид судалгаа хийж, механикжсан технологийн аргачлалыг боловсруулж зоотехник, механик, эдийн засаг, зохион байгуулалтын асуудлыг оновчтой шийдвэрлэх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулсан байна. Сүү-таваарын жижиг фермийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг механикжуулах энгийн хийцтэй техник тоног төхөөрөмжөөр тоноглож гар ажиллагааг хөнгөвчлөх аргазүйн үндсийг боловсруулжээ.

**Дүгнэлт:** Монголд фермийн жижиг аж ахуй байгуулж бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, эрчим хүч, материалын зардлыг хэмнэж малчид саальчдийн хөдөлмөрийг механикжуулж бүтээмжийг дээшлүүлэх боломжийг судалсан байна.

**1460 Мал эмнэлгийн үйлчилгээ**

**0171**

Аманда Файн

**Малын эрүүл мэндийг сайжруулах нь**

*Төслийн тайлан. УБ, 2002. Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлага. 56 хууд. Англи.*

Уг төслийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлагаас хамтран хэрэгжүүлсэн ба говийн аймгуудын малчид, малын эмч нарт малын эрүүл мэндийг сайжруулах талаар сургалт явуулсан. Малд элбэг тохиолддог янз бүрийн өвчнүүд, тэдгээрийн гол шинжүүд, анагаах арга зам болон өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгч, сурталчлан таниулах үйл ажиллагаа явуулсан болно.

Төслийн тайланд малын өвчнүүдийг халдварт ба халдварт бус гэж ангилан малчид өөрсдөө малын өвчнөөр өвдөхгүйн тулд яаж урьдчилан сэргийлэх, улирлын онцлогт тохируулан малаа хэрхэн маллах, монголчуудын од гаригийн тоолол, цаг агаар шинжих уламжлал г.м. зүйлийг тусгасан.

**Дүгнэлт:** Уг төслийн тайланд малын өвчнүүд, тэдгээрийн гол шинжүүд, урьдчилан сэргийлэх, анагаах аргуудын талаар дэлгэрэнгүй оруулсан нь малчид болон малын эмч нарт нэн шаардлагатай гарын авлага болжээ. Мөн монголчуудын уламжлалт анагаах ухааны талаар тодорхой хэмжээний мэдээлэл оруулсан байна.

**0172**

Жандагсүрэн Б., Эрдэнэтуяа М.

**Мал эмнэлгийн үйлчилгээний эдийн засгийн үр ашиг**

*Төслийн тайлан. УБ, 1999. ХААИС, ЭЗФ. 100 хууд. Монгол.*

Судлаачид сүүлийн 15 жилийн дунжаар 15 төрлийн гол өвчний гарах магадлалыг судлаад халдварт өвчин, цусан халдвар, дуут, сохор, доголон, сахуу, хамуу, гуур, бөөрөнхий хорхой, түүзан хорхой зэрэг 11 төрлийн өвчин бүх төрлийн мал дээр 100%, ширх 67%, лейкоз 60%, бруцеллөз 40% гарах магадлалтай гэж тогтоожээ. Иймд өндөр магадлалтай, гол зонхилон гардаг өвчнүүдээс мал сүргийг урьдчилан сэргийлэх, эмчлэх, бруцеллөз өвчнөөс эрүүлжүүлэх, түүний эсрэг биотариа үйлдвэрлэх, орон нутагт хүргэх, хуваарилах явдлыг өргөтгөх хэрэгтэй гэсэн санал дэвшүүлжээ.

Гэтэл мал эмнэлгийн үйлчилгээ хүрэлцээ муутайгаас болж олон тооны мал хорогдож малчдад багагүй хохирол учирсаар байна. Зөвхөн 1997 оны байдлаар малын үхэл хорогдлоос болж нийгэмд 54 тэрбум төгрөгийн хохирол учирчээ.

Энэхүү судалгаанд малыг эмчилж, эдгэрүүлэн хохирлоос сэрэмжилснээр хэчнээн хэмжээний орлого олох боломжийг тодорхойлохын тулд 1 толгой малын үндсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс жилд олох дундаж орлогыг тооцож үзээд 87.7 мянган төгрөгийн орлого олох боломжтой гэж тогтоосон. Мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нөхөн төлөгдөх чадварын коэффициент 0.74 байгаа нь мал эмнэлгийн үйлчилгээ эдийн засгийн үр ашигтай болохыг харуулж байна.

Мал өвчлөлийн эдийн засгийн алдагдал дээрх үзүүлэлтээс гадна амьд малын арьсны өвчлөлт, гэмтлээс ихээхэн шалтгаалдаг. Энэхүү судалгаагаар зөвхөн амьд үхрийн ширний гэмтлээс болж жилд 730 сая төгрөгийн хохирол учирч болох урьдчилсан тооцоо гарсан байна.

Малын өвчний эдгэрэлтийн хувь улсын дунджаар 83.5% байгаа бөгөөд нэг малд жилд дунджаар 59.3 төгрөг зарцуулж байна.

**Дүгнэлт:** Гоц халдварт өвчний эмчилгээг төрөөс санхүүжүүлэх, малын өвчнөөс болж хориг саад тавьж буй бүтээгдэхүүнийг экспортод гаргахад хөнгөлөлт үзүүлэх, хувийн хэвшлийн болон аж ахуйн нэгжүүдийн аль ч байгууллагад ажиллаж буй малын эмч нарт халдварт, паразитгах, халдваргүй өвчний судалгаа гаргасны төлбөр төлдөг болох, малаас хүнд дамжин халдварладаг өвчинтэй тэмцэж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлого баримтлах нь зүйтэй гэсэн санал дэвшүүлжээ.

## 0173

Наранхүү Л., Жандагсүрэн Б., бусад

### Хувийн мал эмнэлгийн үйлчилгээний эдийн засаг

“Монголын мал эмнэлэг” сэтгүүл. УБ, 2000. Монголын мал эмнэлгийн холбоо. 9-22 хууд. Монгол.

Мал эмнэлгийн үйлчилгээ нь ХАА-н салбарын дэд бүтцийн бүрэлдэхүүнд хамаарагдах бөгөөд түүний гол зорилго нь аж ахуйн нэгжүүдийг туслах чанартай үйлчилгээнээс аажмаар чөлөөлж, тэдний хүч, хөрөнгийг үндсэн үйлдвэрлэлдээ төвлөрүүлэх боломж бүрдүүлэх явдал юм. Мал эмнэлгийг хувьчлахаас өмнө дэд бүтцийн гүйцэтгэх үүргийн ихэнхийг улсаас төвлөрсөн журмаар, зарим хэсгийг ХАА-н үйлдвэрийн газрууд бие даан гүйцэтгэж байв. Мал эмнэлгийн байгууллагыг хувьчилснаас хойш хөгжлийн цоо шинэ хандлага үүсч, мал эмнэлгийн үйлчилгээг хувийн мал эмнэлгийн хэлбэрээр явуулах болсон юм.

**Дүгнэлт:** Мал эмнэлгийг хувьчилсны дараа шийдвэрлэх эдийн засгийн асуудлууд, мал эмнэлгийн үйлчилгээний зардал, түүний ангилалт, мал эмнэлгийн үйлчилгээнээс олох орлого, баримжаа ашгийн тооцоо, мөн түүнчлэн малын эмчийн орлогын тооцоог хэрхэн хийх, төлөвлөх талаар энд харуулсан болно.



## ТАВ. МАЛ АЖ АХУЙН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

### 1510 Цалин хөлс, зээл, хадгаламж

0174

Ингрид Фишер, Ерөөлсүрэн Н.

#### Хөдөө орон нутагт санхүүгийн үйлчилгээг хүргэх

Төслийн тайлан (2001-2003). УБ, 2003. НҮБХХ. 73 хууд. Монгол.

Сүүлийн 2 жилд Монголын санхүүгийн салбар хурдацтай хөгжиж байгаа ч үйлчилгээг хүргэх зардал харьцангуй бага байдаг хот суурин газруудад хангалттай өндөр эрэлттэй байгаа учир санхүүгийн байгууллагууд зардал өндөр бөгөөд эрсдэл ихтэй гэж тооцогддог хөдөөгийн зах зээлд хүрэх сонирхолгүй байна. Хөдөө орон нутагт санхүүгийн үйлчилгээг хүргэх төсөл нь эрсдэлийг хянах боломжтой бөгөөд зээлийн хүүгийн одоогийн түвшин нь хөдөөгийн зээлийн үйл ажиллагааны ашигтай түвшинг хангана гэдгийг зөвлөж байна.

Арилжааны чиглэлийн санхүүгийн салбар нь Хөдөө аж ахуйн банк, Монгол шуудан банкаар дамжин бүх аймгийг хамарч байгаа боловч эдгээр банкны аль аль нь Хөдөө орон нутагт санхүүгийн үйлчилгээг хүргэх төслийн зорилтот зах зээлээс нэлээд ялгаатай, харьцангуй хязгаарлагдмал зах зээлийг хамарч байна. Канадын хоршооллын нийгэмлэг нь үндэсний хэмжээнд өргөжих боломжтой ч энэ нь маш жижиг хөтөлбөр бөгөөд зөвхөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн чиглэлийн хоршоодод зээл олгодог. Монголын хөдөөгийн ихэнхи хэсэгт санхүүгийн үйлчилгээ бага хүрч байгаа учраас Хөдөө орон нутагт санхүүгийн үйлчилгээг хүргэх төслийн туршлагыг дэлгэрүүлэх нь энэ тэргүүний зорилгын үндэс болсон юм.

**Дүгнэлт:** Монголын хөдөөд малчин өрхүүд тархай суурьшсан нь тэдний тогтмол цуглах боломжийг багасгаж, хүн ам цөөнөөс болоод садан төрлийн холбоогүй бүлэг байгуулахад төвөгтэй байна. Бүлгийн зээл ихэвчлэн санхүүгийн боломж муугаас гадна боловсрол, чадвараар хязгаарлагдмал хүмүүсийн сонирхлыг татах хандлагатай байдаг. Энэ нь бүлгийн зээлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд бүлгийг хөгжүүлэх, үр чадварыг нэмэгдүүлэхэд ихээхэн хөрөнгө оруулах нь чухал гэсэн үг. Иймд үндсэн бизнес нь санхүүгийн үйл ажиллагаа байдаг байгууллагууд бүлгийн зээлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд үр чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах түнш олох хэрэгтэй.

Харилцагч зээлийн өргөдөл гаргахад чирэгдэлтэй, цаг авдаг гэж шүүмжилж байгаа нь үнэндээ тэд мөнгөн урсгалын тооцоо болон бизнес төлөвлөгөө хийх дургүй байгааг илтгэнэ. Ихэнхи оронд ямар ч үед зээлдэгчид ийм хандлагатай байдаг боловч ийм шаардлага засвал байх ёстой нь туршлагаас харагдсан. Энэ нь эрсдэлийн удирдлагын салшгүй хүчин зүйл бөгөөд зээлийн илүү боловсронгуй арга хэрэгслийн үндэс тул хөдөөгийн санхүүгийн салбар, цаашилбал хөдөөгийн эдийн засгийн хөгжилд чухал нөлөөтэй гэж үзсэн байна.

### 1520 Татвар, даатгал

0175

Амгаа С.

#### Мал аж ахуйн албан татварын байдалд хийсэн шинжилгээ

Эрдэм шинжилгээний бичиг, №31. Өгүүлэл. УБ, 2002. ХААНС. 126-129 хууд. Монгол.

Мал аж ахуй манай орны эдийн засгийн үндсэн салбар боловч улсын төсвийг бүрдүүлэхэд тун ялихгүй хувь нэмэр оруулж байна.

2000 онд Монгол Улсын олон аймгийг хамарсан байгалийн бэрхшээл тохиолдож малын тоо хорогдсон, малчдын амьдралын түвшин доройтсон зэрэг шалтгаанаар мал бүхий иргэдээс хураах албан татварыг чөлөөлснөөр мал аж ахуйгаас татварын хэлбэрээр улсын төсөвт оруулах орлого өмнөх оныхоос 6 дахин буурсан байна.

Мал аж ахуйн албан татварыг судлах явцад эдийн засгийн бодлогын чанартай хэд хэдэн асуудал үүсч гардаг. Тухайлбал, бэлчээрийн аж ахуй нь эзэндээ орлого оруулдаг бизнесийн аж ахуй юу, өдөр тутмын хэрэгцээг хангадаг хэрэглээний шинжтэй аж ахуй юу гэдгийг ялгаж, мал аж ахуйн орлогод татвар ногдуулахдаа ямар үзүүлэлтийг ашиглах вэ гэдгийг шийдэх, мал аж ахуйн орлогын албан татвартай холбогдуулан малчин өрхийн аж ахуйн орлого, зарлагын бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн орлогын албан татвар ногдуулалтын өнөөгийн байдал, улсын төсөвт гүйцэтгэж буй үүрэг, оршиж буй доголдол, дутагдал зэргийг тусгайлан судалсан нь цаг үеэ олсон асуудал юм. Судалгаанаас үндэслэн мал аж ахуйн албан татвар ногдуулахад зайлшгүй харгалзан үзэх хэд хэдэн санал дэвшүүлсэн байна.

## 0176

Амгаа С.

### **Монгол Улсын мал аж ахуйн албан татвар, түүний арга зүйг боловсронгуй болгоход шийдвэрлэх үндсэн асуудал**

*Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ, 2001. ХААНС. 129 хууд. Монгол.*

Энэхүү бүтээлд Монгол Улсын төрийн татварын бодлогод орчин үеийн татварын онолын сэтгэлгээнүүдийг хослуулан хэрэглэх, төсвийн алдагдлыг багасгахад чиглүүлэн мал аж ахуйн татварын асуудлыг авч үзсэн байна.

Монгол Улсад мал аж ахуйн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний гуравны нэгийг үйлдвэрлэж байгаа боловч улсын төсвийн орлогын нэг хүрэхгүй хувийг бүрдүүлж байна. Иймд мал аж ахуйн албан татварын асуудлыг судалж, малчин өрхийг хамруулах асуудал тавигдаж байна.

Энэхүү судалгаагаар мал аж ахуйн орлого, зардал, малыг ашиглах зориулалт нь олон хувилбартай, малчин өрх аж ахуйн статусгүй учир төрийн өмнө ямар нэг хариуцлага хүлээдэггүй, бүртгэл тооцоо хөтөлдөггүй, хүн амын эмзэг бүлэгт багтах олон хүн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж амьдардаг зэрэг шалтгаан нь мал аж ахуйд албан татвар ногдуулж, хураах ажилд бэрхшээл учруулж байна.

Мал аж ахуйн албан татварыг тогтооходоо хүн амын амьжиргааны доод түвшинг хангах хэмжээний малыг татвараас чөлөөлөх, бүсийн ялгавартай тогтоосон татвар ногдуулах, орлогын нормыг баримтлан орлогын зарчмаар татвар ногдуулах, мал аж ахуйд ногдуулах үндэслэлтэй олон татвар хураамжийг нэгтгэн нэгдсэн татвар тогтоох, мал аж ахуйгаас бусад орлогыг хамарсан байх, татвар ногдуулах, хураах ажиллагаа нь хэмнэлттэй, энгийн хялбар байх гэсэн зарчмуудыг баримтлах нь зүйтэй гэж үзсэн байна.

Энэхүү судалгаагаар хүн амын амьжиргааны доод түвшинг хангахад шаардагдах малын тоо нь улсын дундаж 4.8 ам бүлтэй өрхөд бодоор 61, богд шилжүүлснээр 107 малтай байна. Энэ хэмжээний малыг татвараас чөлөөлөхдөө малын тоогоор бус, харин хүн амын амьжиргааны доод түвшинг хангах хэмжээний орлогыг мал аж ахуйн татвар ногдуулах орлогоос хасах замаар татвараас чөлөөлөхөөр тооцсон байна.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн албан татварын асуудлыг Хүн амын орлогын албан татварын тухай Монгол Улсын хуулийн хүрээнд шийдвэрлэж, орон нутгийн татвар болгох, мал аж ахуйн албан татварыг зохистой хэмжээгээр нэмэгдүүлэх нь малчдын хариуцлагыг дээшлүүлэх, бэлчээрийн мал аж ахуйг бизнесийн аж ахуй болгон хувиргах чухал хүчин зүйл болно гэсэн эдийн засгийн агуулгаар зарчмын чухал дүгнэлт хийсэн байна.

## 0177

Баатар С., Пүрвээ Д., Ганхүлэг Б.

### **Татварын онол, арга зүйн зарим асуудлууд**

*Нэг сэдэвт бүтээл. УБ, 1997. Үндэсний татварын газар. 202 хууд. Монгол.*

Манай орны хүн амаас авах татвар нь уламжлалт, бэлчээрийн мал аж ахуйтай холбоотой байсан бөгөөд 1921 оны хувьсгалаас хойш төрөөс төрийн санхүүг үүсгэж тогтоох явдал нэн шаардлагатай байгааг чухалчлан авч үзсэн. Ийнхүү шинэ төрийн анхны албан татварыг тогтоон явуулах бүрэн хэмжээг боловсруулах комиссыг дөрвөн аймаг болон Намын төв хорооны бүрэлдэхүүнтэйгээр дотоод яамны дэргэд байгуулж, уг комиссын боловсруулсан асуудлыг явц дунд хэлэлцэж байгаад Засгийн газрын гишүүдийн өргөтгөсөн хурлаар 1922 оны 3 дугаар сарын 17-ны өдөр "Мал аж ахуйгаас албан татвар хураах дүрэм"-ийг хэлэлцэн баталж байжээ.

Мал аж ахуйгаас хураах албан татварыг Ардын хувьсгалаас хойш зах зээлийн эдийн засгийн үе хүртэл хэд хэдэн удаа өөрчилж, дүрэм, хууль, тогтоол гаргаж байсан ба тэдгээрийн зорилго нь өөр өөр байжээ. Тухайлбал, 1950-иад оны үед гарсан татварын хуулиар хувийн хэвшлийн мал бүхий иргэдэд өндөр хэмжээний татвар ногдуулсан нь хувийн хэвшлийг устгаж, малчид, иргэдийг татварын дарамтаар нэгдэлжих хөдөлгөөнд ихээр хамруулах зорилготой байсан. Энэ мэтээр зарим хууль, дүрэм малын тоог нэмэгдүүлэхэд чиглэгдэж байхад, зарим нь баян хоосны ялгааг арилгах, зарим нь төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгджээ.

**Дүгнэлт:** Судлаачид татварын онол, аргазүйн асуудлыг хөндөж, судалгаагаа олон улсын хэмжээнд, мөн Монгол Улсын нутаг дэвсгэрт татвар ногдуулж буй арга хэлбэр, эерэг сөрөг талыг илрүүлэхэд чиглүүлжээ. Түүний дотор Монголын бэлчээрийн мал аж ахуйд Ардын хувьсгал ялнаас хойш татвар ногдуулж байсан арга хэлбэр, зорилгыг нь илүү сайн тодорхойлсон байна.

## 0178

Кадирбек Д.

### **Мал аж ахуйн орлогын татвар ногдуулалт, түүнийг төгөлдөржүүлэх зарим асуудал**

*Магистрын ажл. УБ, 2002. ХААНС. 100 хууд. Монгол.*

Монгол Улсад бэлчээрийн мал аж ахуйн орлогын албан татвар ногдуулж ирсэн түршлага, өнөөгийн байдал, улсын төсөвт энэ төрлийн татварын эзлэх байр суурийг судалж, цаашид мал аж ахуйн орлогын албан татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх бололцоотой гэж үзсэн байна.

Энэхүү бүтээлд мал аж ахуйн орлогын татварын бүс бий болгох, бүс тус бүрт ялгавартайгаар татвар ногдуулах, татвар ногдуулах орлогыг малын сүргийн эргэлтийн загварыг үндэслэн тодорхойлох шинэлэг санаа дэвшүүлсэн байна.

**Дүгнэлт:** Энэхүү судалгаанд мал аж ахуйн орлогын татвар ногдуулалтыг боловсронгуй болгох талаар нарийвчлан судалж, татвар ногдуулах орлогыг тодорхойлох, энэ талаар эрх зүйн шинэчлэлт хийх асуудлыг дэвшүүлсэн байна.

## 0179

Бакей А., Моёбуу Д.

### **Мал аж ахуйн татвар, даатгалыг төгөлдөржүүлэх асуудал**

*Төслийн тайлан. УБ, 2000. ХААНС, ЭЗФ. 24 хууд. Монгол.*

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 30%-ийг эзэлдэг мал аж ахуйн салбарын улсын төсөвт оруулдаг татварын хэмжээ 1.0%-д хүрэхгүй байгаа нь мал аж ахуйн орлогын албан татварын тогтолцоо буруу байгаагай

холбоотой гэж үзээд малчдад ногдуулах татварыг зах зээлээс алслагдсан байдал, байгалийн бүс, мал аж ахуйгаас орох орлогыг нь харгалзаж ялгавартай тогтоох санал дэвшүүлсэн байна.

Монгол Улсын аймаг, сумдыг зах зээлээс алслагдсан байдлаар нь 5 бүсэд хувааж, бүс бүр дэх малчдын малаас олох цэвэр орлогыг тодорхойлоод, татварын коэффициентийг ашиглаж төлөх татварыг тодорхойлох санал гаргасан байна.

**Дүгнэлт:** Энэ төслийн хүрээнд хувийн мал бүхий иргэдэд албан татвар ногдуулахад мал аж ахуйн орлогыг байгаль, газарзүйн бүсээс хамаарч ялгаатайгаар тодорхойлох зөвлөмжийг боловсруулжээ.

## 0180

Буяндэлгэр.М.

### Мал аж ахуйн даатгалыг боловсронгуй болгох арга зам

Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ, 2000. ХААНС, ЭЗФ. 171 хууд. Монгол.

Монгол орны уур амьсгалын онцлогоос хамаарч богино хугацаанд болж өнгөрдөг цаг уурын бэрхшээлүүд нь мал аж ахуйн үйлдвэрлэлд багагүй хохирол учруулдаг. Энэ нь манай орны газар газрын уур амьсгал тогтмол нэг хэвийн байдаггүйгээс шүүд хамааралтай бөгөөд байгалийн нөөц баялаг, бэлчээрийн ургац, хөрсний үржил шим байнга өөрчлөгддөг учир энэ байдлыг мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нарийвчлан харгалзах шаардлагатай.

Мал аж ахуйг даатгах шаардлагыг бий болгож буй байгаль, цаг агаарын 22 эрсдлийн хэлбэр байна гэж судлаач үзжээ. Судалгаанаас үзэхэд малын тоо сүүлийн жилүүдэд жил дараалан өссөн байхад даатгалд хамрагдсан малын тоо жил дараалан буурч, урвуу хамааралтай явж ирсэн байна. Иймд мал аж ахуйн даатгалын хуулийг яаравчлан гаргах, даатгалын үйл ажиллагааг бодитой ажил болгох шаардлагатай гэж үзсэн байна.

**Дүгнэлт:** Мал аж ахуйн даатгалыг бүсчлэн тогтоож, малчдад мал аж ахуйн даатгалын зорилго, ач холбогдлыг ойлгуулах, аймаг, сумдад орон тооны болон орон тооны бүс эрсдлийн менежер ажиллуулах, байгалийн эрсдлийг урьдчилан мэдээлэх системийг боловсронгуй болгох санал зөвлөмжийг боловсруулсан байна.

## 0181

Жерри Скийс, Энх-Амгалан А.

### Монголд тохиромжтой малын даатгалын тогтолцооны судалгаа

Дэлхийн банкны бодлогын судалгааны илтгэл № 2886, 2002 оны 9-р сар

Энэхүү судалгаа нь Монгол дахь малын даатгалын төвөгтэй асуудлыг судлах зорилго тавьсан бөгөөд малын даатгалын одоогийн буюу уламжлалт тогтолцоо болон цаг агаарын итгэлцүүр дээр суурилсан шинэ тогтолцооны тухай нэгдүгээр хэсэг, шинэ тогтолцоог нэвтрүүлэх зөвлөмж ба үндэслэл гэсэн хоёрдугаар хэсэг, санал болгож байгаа зөвлөмжүүдийн нарийвчилсан шинжилгээ гэсэн гуравдугаар хэсгээс бүрдэнэ. Малын даатгалын тогтолцоог 1) Өнөөгийн буюу хувь малчдын малыг даатгадаг; 2) Цаг агаарын гол сөрөг үзэгдлийн эсрэг даатгах цаг агаарын итгэлцүүрийн даатгал; 3) Сумын буюу багийн дүнгээр малын хорогдлын хувь хэмжээ дээр суурилсан итгэлцүүрийн даатгал гэсэн 3 хувилбараар авч үзсэн байна.

**Дүгнэлт:** Эдгээр 3 хувилбар нь аль аль нь сөрөг болон эерэг талуудтай боловч эхний 2 нь нэн чухал шалгууруудыг давж гарч чадахгүй байна гэж үзжээ. Харин 3-р хувилбар нь илүү тохиромжтой тул туршиж үзэх шаардлагатай гэсэн санал дэвшүүлсэн байна.

## 1530 Түрээсийн харилцаа

0182

Оросоо Р.

### Малын түрээсийн төлбөр ба орлогын хуваарилалт

Эрдэм шинжилгээний бичиг, №31. Өгүүлэл. УБ, 2002. ХААНС. 95-98 хууд. Монгол.

Сүүлийн жилүүдэд мянгаас дээш малтай малчин өрхүүд олноор төрөн гарч тэдэнд ажиллах хүч хүрэлцэхгүй болсноор малынхаа ашиг шимийг бүрэн ашиглаж чадахгүйд хүрч энэ нь эцсийн дүндээ мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашигт сөргөөр нөлөөлөх болов.

Иймд мал ихтэй, ажиллах хүчний хүрэлцээ муутай чинээлэг малчин өрхүүд малаа өсгөх, ашиг шимийг нь нэмэгдүүлэх үүднээс ажиллах хүчийг хөлсөөр ажиллуулах, бусдад малаа түрээсээр эзэмшүүлэх сонирхол байгаа боловч хууль эрх зүйн орчин сайн бүрдэж чадаагүй, хөдөөгийн хүн амын дунд хөлслөх, хөлслөгдөх гэсэн сэтгэлзүйн бэлтгэл хангалтгүй, түрээсийн харилцааны талаархи ойлголт дутмаг, малыг түрээслэхэд төлбөрийг хэрхэн тооцох аргачлал байхгүй зэрэг шалтгааны улмаас хөдөөд түрээс өргөн хүрээнд хэрэгжиж чадахгүй байна.

**Дүгнэлт:** Судлаач түрээсийн харилцааг Монголын бэлчээрийн мал аж ахуйн жишээн дээр авч үзэж мал аж ахуйн салбарын онцлогийг харгалзан түрээсийн харилцаанд оролцогч талуудын олж болох мөнгөн орлогыг тодорхой жишээгээр судалжээ. Судалгаандаа нэг малаас авах ашиг шим, 100 эхээс авах төл, 100 толгойд ногдох зүй бус хорогдол зэргийг сүүлийн 10 жилийн дунджаар авсан байна. Цаашид бэлчээрийн мал аж ахуйд түрээсийн төлбөрийг бүс нутгаар тооцож тогтоох талаар санал дэвшүүлжээ.

0183

Оросоо Р.

### Монгол Улс дахь түрээсийн харилцааг боловсронгуй болгох асуудал

Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ, 2002. ХААНС. 135 хууд. Монгол.

Мал аж ахуйн салбарын гэрээ түрээсийг эрчимтэй нэвтрүүлж эхэлсэн 1980-аад оны сүүлчээс хөдөөгийн хүн амын идэвх санаачлага, үйлдвэрлэлийн үр ашиг, амьжиргааны түвшин мэдэгдэхүйц дээшилж ирсэн боловч гэрээ түрээсээр бүрэн татгалзаж, мал, машин техникийг бүхэлд нь эрчимтэй хувьчлах болсон 1991 оноос эхлэн малын тоо толгойг эс тооцвол хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, үр ашиг бүх үзүүлэлтээрээ буурч иржээ. Иймд хөдөө аж ахуйн салбарт хийх шинэчлэл, зах зээлд шилжих шилжилтийг нөхцөл бололцоо бүрдээгүй байхад яаруу давчуу, хавтгайруулан хувьчлах замаар бус харин аж ахуйг эрхлэх дэвшилтэт хэлбэр болсон энгийн ба түрээсийн гэрээг цаашид улам эрчимтэй нэвтрүүлэх замаар шийдвэрлэсэн бол хөдөө аж ахуйн үйлдвэрлэл гүнзгий уналтад оролгүйгээр сэргэх боломжтой байжээ гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Одоо түрээсийн харилцааг өргөн хэрэглэх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Олон малтай, ажиллах хүчний хүрэлцээ муутай чинээлэг өрхүүд малаа өсгөх, ашиг шимийг нь бүрэн ашиглах үүднээс ажиллах хүчийг хөлсөөр ажиллуулах, бусдад малаа түрээсээр эзэмшүүлэх сонирхол байгаа хэдий ч хууль эрх зүйн орчин сайн бүрдэж чадаагүй, хөдөөгийн хүн амын дунд хөлслөх, хөлслөгдөх гэсэн сэтгэлзүйн бэлтгэл хангалтгүй, түрээсийн харилцааны талаархи ойлголт дутмаг, малыг түрээслэхэд төлбөрийг хэрхэн тооцох, тодорхойлох аргачлал байхгүй байгаа зэргээс шалтгаалан хөдөөд түрээс өргөн хэрэгжиж чадахгүй байна. Иймд малыг хэрхэн түрээслэх, түрээсийн төлбөрийг хэрхэн тодорхойлох талаар нэгдсэн аргагүй, зөвлөмж зэргийг боловсруулан гаргах санал дэвшүүлсэн байна.

**Дүгнэлт:** Түрээсийн харилцааг хөгжүүлж, цаашид улам боловсронгуй болгон төгөлдөржүүлэх үүднээс томоохон түрээслэгчид болон түрээсийн харилцаанд оролцогчид, ялангуяа чинээлэг малчдад зориулан сургалт, семинарыг зохион байгуулах нь зүйтэй гэжээ.

## ЗУРГАА МАЛ АЖ АХУЙН БҮРТГЭЛ ТООЦОО

### 1610 Мал аж ахуй дахь санхүү, бүртгэл

0184

Бакей А., Алтанцэцэг С.

#### Малчин өрхийн аж ахуйн түвшинд хөтлөх төсөв, тайлангийн журам, аргачлал

Зөвлөмж. УБ, 2002. ХААНС. 22 хууд. Монгол.

Судалгаагаар малчин өрхүүд албан ёсны төлөвлөгөө, төсөв, бүртгэл хөтөлдөггүй, зөвхөн гар тэмдэглэлтэй байна. Жилдээ ямар зардал гаргаж, хичнээн төгрөгийн орлого олж байгаагаа нарийн тооцсон юмгүй, энэ талын баримжаагаар тааварлан хариулж байна. Жилд олж байгаа 10 орчим сая төгрөгийг юунд яаж зарцуулснаа ч тодорхой мэдэхгүй өрх айл олон байна. Малчин өрхийн аж ахуй төлөвлөгөө, төсөвтэй байж бүртгэл хөтөлж, тайлан нэвтрүүлж байж бодит үр дүнд хүрэх нь ойлгомжтой юм.

Одоогоор малчин өрх бүрд мэргэжлийн нягтлан бодогч байхгүй ч гэсэн цаашдаа малчин өрхүүд ам бүлээсээ буюу гаднаас хүн сургаж, уг ажлыг хийлгэх боломж бий. Судалгаагаар чинээлэг өрхийн ам бүлд дээд боловсролтой хүн 4.8%, бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой хүн 57.4% байна.

Малчин өрхийн аж ахуйг зах зээлийн нөхцөлд үр ашигтай хөтлөхийн тулд төлөвлөгөө, төсөвтэй удирдаж, нягтлан бодох бүртгэл хөтөлж, тайлан тэнцэл гаргаж, түүндээ дүн шинжилгээ хийдэг арга барилд шилжүүлэх нь зайлшгүй чухал гэсэн санал дэвшүүлжээ.

**Дүгнэлт:** Малчин өрхийн аж ахуйг Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн аж ахуйн нэгжийн статустай болгох, бизнес төлөвлөгөө, төсөв зохиох, нягтлан бодох бүртгэл хөтөлж, тайлан гаргахад тус болохуйц журам, аргачлалыг боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж нэвтрүүлэх, банк, санхүү, даатгалын байгууллагуудтай харилцах, зээл олгох зэрэг үйл ажиллагаанд тайлан тэнцлийн зохих үзүүлэлтүүдийг үндэслэдэг байх, малчид өөрсдийгөө бизнес эрхлэгч гэсэн бодол, эдийн засгийн сэтгэлгээ, зах зээлийн сэтгэл зүй төлөвшүүлэхэд эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэлийн янз бүрийн хугацааны сургалтуудыг зохион явуулах зэрэг санал дэвшүүлсэн байна.

0185

Мария Фернандес-Гименес

#### Малчин өрхийн үүргийн талаар: Монголын хувьд

"Human Ecology" сэтгүүл. №27 (10), 1999. 1-27 хууд. Англи.

Монгол улсад 1992 онд нэгдэл тарж, мал хувьчилснаас хойш мал бүхий иргэдийн тоо огцом өссөн. Монголын малчин өрхийн хувьд Африк, Дундад Азийн мал бүхий өрхөөс ялгагдах онцлог гэвэл хөрөнгө оруулалт, хуримтлал бий болгоход ихээхэн эрсдэлтэй юм.

**Дүгнэлт:** Монголын хувьд малчин өрхийн үйл ажиллагааг үйлдвэрлэлийн хэлбэрээр зохион байгуулахад нь туслах, өрх, хот айлын гишүүдийн оролцоог албан ёсны болгож, малчид хоорондын төлбөр тооцоог гэрээ хэлцлийн хэлбэрээр зохицуулах нь зүйтэй гэсэн санаа дэвшүүлжээ.

## 1620 Мал аж ахуйн мэдээ, мэдээлэл

0186

Дорж Б.

### Монголын хөдөө аж ахуй дахь мэдээллийн ач холбогдол

*"Market-Economy Nomads-Technology" төвхимол. УБ, 2002. НСНСОУХ. 19-24 хууд. Англи.*

Мал аж ахуй нь олон зууны туршид монголчуудын гол үйлдвэрлэл байсаар ирсэн. Гэхдээ монголчууд дан ганц мал аж ахуйг бус мөн газар тариаланг эрт үеэс эрхэлж байсныг Монгол нутгаас олдсон МЭӨ 3000 жилийн тэртээд хамаарах хүрлийн үеийн хадны сүг зурагт дүрслэгдсэн үр тариа хальсалж, цайруулж буй малчдын дүрсүүд гэрчлэнэ. Энэ бол монголчууд мал аж ахуй болоод газар тариалан хоёрыг хослон эрхэлж байсны баталгаа юм.

Бэлчээрийн мал аж ахуй болон газар тариаланг хослуулан хөгжүүлж байсан уламжлалт арга ухааныг өнөөдөр шинжлэх ухааны үндэстэйгээр сайжруулан хөгжүүлэх хэрэгтэй байгаа бөгөөд уур амьсгалын ижил төстэй бусад орны арга туршлагаас суралцах замаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн энэхүү хоёр салбарын үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Их хэмжээний хуурайшилт явагдаж байгаа өнөө үед шинжлэх ухааны мэдээлэл нь экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, хөрсний эвдрэлээс сэргийлэх, бэлчээрийн даац болоод малын тоо толгойн зохистой харьцааг бий болгох гол хүчин зүйл болж байна.

Үүнээс үндэслэн үйлдвэрлэлийг цаг уурын өндөр эрсдэлтэй нөхцөлд явуулж буй малчид, тариаланчдад тэдний мэдлэг чадавхийг дээшлүүлэх зорилготой мэдээлэл түгээлтийн тусгай сүвгийг зохион байгуулах шаардлагатай гэж үзсэн байна.

**Дүгнэлт:** Хөдөө аж ахуйн салбарт, ялангуяа мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэхэд мэдээллийн ач холбогдлыг онцгойлон авч үзэж тайлбарласан байна.

0187

Төмөржав М., Эрдэнэцогт Н.

### Монголын нүүдэлчдийн сэтгэлгээ, мэдээлэл

*Эрдэм шинжилгээний бүтээл, №31. Өгүүлэл. УБ, 2002. ХААНС. 23-26 хууд. Монгол.*

Монголын нүүдэлчид олон зуун жил амьдарч ирэхдээ монголын гэх өвөрмөц мэдлэг ухаан, уламжлалт сэтгэлгээг бий болгожээ. Үүнийг зарим судлаачид эс зөвшөөрч, зарим нь "ардын ухаан", "уламжлалт сэтгэлгээ", "уламжлалт эрдэм мэдлэг" гэх мэтээр нэрлэж ирсэн.

Монгол малчны сэтгэлзүй, сэтгэлгээний онцлог, өөрчлөлт шинэчлэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан дүгнэх, түүнийг мал аж ахуйн үйлдвэрлэлийн менежмент, холбогдох хуулиудад тусган хэрэгжүүлэх нь чухал. Үүнээс гадна монгол малчны сэтгэхүй, сэтгэлзүй, сэтгэлгээнд тулгуурлан бий болсон уламжлалт мэдлэг ухааныг шинжлэх ухааны онол, практикийн үүднээс нэгтгэн дүгнэх шаардлагатай гэсэн санал дэвшүүлжээ.

**Дүгнэлт:** Судлаачид монгол малчны сэтгэлгээ, арга ухааныг бусад эрдэмтдийн бүтээл судалгааг нэгтгэн дүгнэх хэлбэрээр тогтоох оролдлого хийжээ. Мөн нүүдэлчдийн мэдээлэл авах, өгөх байдлыг бие биедээ мэдээлэл өгөх, байгаль орчноос мэдээлэл авах, мал сүргээс мэдээлэл авах гэж ангилж, тус бүрийг нь тайлбарласан нь сонирхолтой болжээ.

## СУДЛААЧИЙН ҮГ

Монголын бэлчээрийн мал аж ахуй нь өвөрмөц онцлог бүхий нүүдэлчдийн соёл иргэншлийн урт удаан хугацааны түүхийн нэг хэсэг юм.

Орчин үед хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах үүднээс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлснээр экологийн хувьд цэвэр бүс бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсч, эргээд хүн төрөлхтөнд өөрт нь зохисгүй нөлөө, үр дагавар авчрах болов.

Бэлчээрийн мал аж ахуй нь байгалийн цэвэр бэлчээрт түшиглэн үйлдвэрлэл явуулдаг учир хүний эрүүл мэндэд таатай нөлөө бүхий экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах эх үүсвэр болдог. Гэвч унаган төрхөөрөө үлдсэн байгаль, түүнд тохирсон үйлдвэрлэлийн арга хэлбэр дэлхийд төдийлөн элбэг биш болжээ.

Монголын бэлчээрийн мал аж ахуй бол Төв Азийн байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлд зохицож түүхийн урт хугацааны шалгарлыг даван туулсан, өөрийн өвөрмөц технологи бүхий, зардал хямдтай, экологийн туйлын цэвэр бүтээгдэхүүн нийлүүлэх чадвартай, дэлхийд цөөхөн үлдсэн уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийн нэг хэлбэр юм.

Монгол орон зах зээлийн эдийн засагт шилжсэн нь мал аж ахуйн уламжлалт үйлдвэрлэлд ямар нөлөө үзүүлэхийг сонирхон судлах судлаачдын тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдлээ. Тэд зах зээлийн шинэ харилцаа, бэлчээрийн уламжлалт аж ахуйн хөгжлийн холбоо үялдааг олон талаас нь судалж байна.

Соросын сангаас санаачилж, санхүүжүүлсэн Монголын мал аж ахуйн эдийн засгийн ном зүйн энэхүү тоймыг анх удаа нэгтгэн гаргаж байгаа нь энэ чиглэлээр ажилладаг эрдэмтэн судлаачид, оюутан сурагчдад чухал гарын авлага болохын хамт чадварлаг судлаачдыг төрүүлэх, цаашид бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийг боловсронгуй болгоход их хувь нэмэр болох нь дамжиггүй.

Эдийн засгийн ухааны доктор (Ph.D)

**Сономын Амгаа**



## НОМ ЗҮЙД ХАМРАГДСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

(ангилал (код), индекс, зохиогчийн нэр, бүтээлийн нэр)

Код	Индекс	Зохиогчийн нэр, овог	Бүтээлийн нэр	Хаана, хэдэн онд, (ямар бүтээлд), ямар хэл дээр хэвлэгдсэн
<b>НЭГ. МАЛ АЖ АХУЙН ЭДИЙН ЗАСАГ, ҮР АШИГ</b>				
1010 Мал аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт	0001	Бадарч Д.	Малын гаралтай түүхий эдийн эрэлт хэрэгцээ ба нийлүүлэлт	<i>"Market-Economy Nomads-Technology"</i> товхимол. УБ, 2002. НСИСОУХ. 168-171 хууд. Англи.
	1020 Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг	0002	Адьяа Ю.	Малчин өрхийн аж ахуйн бүтээмжийн хүчин зүйлийн ашиглалтыг дээшлүүлэх асуудалд
0003		Бакей А.	Малчин өрхийн эдийн засаг, санхүүгийн асуудлууд	<i>"Nomadic Studies" сэтгүүл, 2002, №04. Өгүүлэл. УБ. НСИСОУХ. 118-120 хууд. Монгол.</i>
0004		Нямдаваа Г.	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх зарим асуудал	<i>"Market-Economy Nomads-Technology" товхимол. УБ, 2002. НСИСОУХ. 106-110 хууд. Англи.</i>
0005		Теленгед Б.	Монголын мал аж ахуйн үржил селекцийн өнгөрсөн ба өнөө үе: Үржил селекцийн уламжлалт болон орчин үеийн практик үйл ажиллагааны давуу ба сул талууд	<i>"Culture and Environment in Inner Asia: 1 - The Pastoral Economy and the Pastoral Environment" товхимол. Их Британи, 1996. 161-188 хууд. Англи.</i>
0006		Энх-Амгалан А.	Монголын бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийн үр дүн	<i>Төслийн тайлангийн хураангуй. УБ, 2000. НҮБХХ. 10 хууд. Англи.</i>
0007		Жеркер Эдстром, Ганзоригт Н.	Монголын нүүдлийн мал аж ахуй зах зээлд хүрэх зам дээр байна уу?	<i>Судалгааны тайлан. Policy Alternatives for Livestock Development (PALD). УБ, 1997. 89 хууд. Англи.</i>

1030 Монгол малын төрөл, түүний ашиг шим	0008	Индра Р.	Тэмээ судлал	Нэг сэдэвт бүтээл. УБ, 1998. 304 хууд. Монгол.
	0009	Индра Р., Бийчээ Н., бусад	Монгол тэмээ	Төслийн тайлан. УБ, 2000. МААЭШХ. 36 хууд. Монгол.
	0010	Пүрэвragчаа Ш., Эрдэнэбаатар Б., Цэгмид М.	Хос зогдорт тэмээн сүргийн ноосон ашиг шим	"Мал аж ахуйн шинжлэл" товхимол. №5. УБ, 2003.23-32 хууд. Монгол.
	0011	Цэвэгмид Г.	Монгол адуу	Нэг сэдэвт бүтээл. УБ, 2000. БСШУЯ, УБТДС. 405 хууд. Монгол.
	0012	Дагвийхорол В, бусад.	Монгол сарлаг	Төслийн тайлан. УБ, 2000. МААЭШХ-ийн Өндөр уулын бүсийн салбар. 53 хууд. Монгол.
	0013	Бат-Эрдэнэ Т.	Монгол үүлдрийн сарлаг	Нэг сэдэвт бүтээл. УБ, 2002. ХААИС. 135 хууд. Монгол.
	0014	Цэгмид М.	Үнээний сүүн ашиг шимийг нэмэгдүүлэх боломж	Эрдэм шинжилгээний бүтээл №28. Өгүүлэл. УБ, 1998. ХААИС. 15-17 хууд. Монгол.
	0015	Энхболор Б., Цэгмид М.	Сэлэнгэ үүлдрийн үнээний сүүний гарц	"Мал аж ахуйн шинжлэл" товхимол. №5. УБ, 2003. 53-56 хууд. Монгол.
	0016	Самбуу Г.	Монгол хонины ашиг шимийн удамшилт, селекцийн ялгавар, үр ашиг	"Мал аж ахуйн шинжлэл" товхимол. №5. УБ, 2003. 6-10 хууд. Монгол.
	0017	Гончигжав З.	Монгол хонь	Нэг сэдэвт бүтээл. УБ, 2000. 303 хууд. Монгол.
1040 Малчдын амьжиргааны түвшин, нийгмийн асуудлууд	0018	Авдай Ч.	Жижиг үйлдвэр байгуулах замаар малчдын амьжиргааны түвшинг дээшлүүлэх	"Nomadic Studies" сэтгүүл, №04. Өгүүлэл. УБ, 2002. НСИСОУХ. 131-134 хууд. Монгол.
	0019	Адьяа Ю.	Малчин өрхийн аж ахуйн төрх, эрэлт хэрэгцээний өнөөгийн байдал	"Монголын эдийн засаг: өчигдөр, өнөөдөр, маргааш" сэтгүүл, №1. Өгүүлэл. УБ, 1997. СЭЗДС. 38-42 хууд. Монгол.
	0020	Амархүү О.	Малчны хүний эрхийн асуудал	"Nomadic Studies" сэтгүүл, №04. Өгүүлэл. УБ, 2002. НСИСОУХ. 106-110 хууд. Монгол.
	0021	Баасандаш Д.	Малчин өрхийн амьжиргааны түвшинг өөрсдийнх нь үнэлэмжээр судалсан дүн	Эрдмийн бичиг, №1. Өгүүлэл. УБ, 1998. ХААИС. 60-66 хууд. Монгол.
	0022	Бат-Эрдэнэ Ц.	Малчдын дунд явуулсан социологийн судалгаа	Эрдмийн бичиг, №1. Өгүүлэл. УБ, 1998. ХААИС, Эдийн засгийн факультет. 66-69 хууд. Монгол.
	0023	Кит Гриффин	Монголын ядуурал ба зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт	Судалгааны тайлан. УБ, 1995. НУБХХ. Англи.
	0024	Робин Мийрнс, Дуламдарь Э.	Монгол орны хөдөөгийн аж амьдралыг дэмжих нь	Төслийн тайлан, УБ, 2000. Дэлхийн банк. 37 хууд. Англи.
	0025	Сонгино Ч.	Монголын нүүдэлчдийн орон сууцны түүхэн хөгжил	"Nomadism-International Study" товхимол. Өгүүлэл. УБ, 2002. НСИСОУХ. 141-143 хууд. Англи, Монгол.
	0026	Мухар Ц.	Нүүдэлчдийн эрүүл мэндийн зарим асуудлууд	"Dialogue among Civilizations: Interaction between Nomadic and Other Cultures of Central Asia" товхимол. Өгүүлэл. УБ, 2001. НСИСОУХ. 307 хууд. Англи.

1050 Мал аж ахуй дахь эрсдэл, экологийн асуудал	0027	Батбуян Б.	Төв Азийн бэлчээрийн малын экологийн зохистой нутаг	"Culture and Environment in Inner Asia: I-The Pastoral Economy and The Environment" товхимол. Их Британи, 1996. 198-207 хууд. Англи.
	0028	Батжаргал З.	Монгол дахь цөлжилт	"Rala report" товхимол. №200. Исланд, 1997. Хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн. 107-113 хууд. Англи.
	0029	Баянмөнх П.	Хөдөө аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулах асуудалд	"Мал аж ахуйн шинжлэл" товхимол, №5. УБ, 2003. ХААИС. 273-277 хууд. Монгол.
	0030	Ганчимэг Г.	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл, түүний сөрөг нөлөөллөөс сэргийлэх	Магистрын ажил. УБ, 2000. ХААИС, 99 хууд. Монгол.
	0031	Индра Р., Энхбаатар Л.	Малын зүй бус хорогдолд нарны идэвхлийн нөлөөг судлах асуудалд	Эрдэм шинжилгээний бүтээл, №28. ХААИС, УБ, 1998. 25-27 хууд. Монгол.
	0032	Моёбуу Д.	Эдийн засгийн тогтвортой хөгжилд экологийн хямрал заналхийлж байна	Эрдэм шинжилгээний бүтээл, №31. Өгүүлэл. УБ, 2002. ХААИС. 121-125 хууд. Монгол.
	0033	Туваансүрэн Г., Сангидансранжав С., Данзанням Б.	Бэлчээрийн мал аж ахуйн цаг уурын нөхцөл	Нэг сэдэвт бүтээл. УБ, 1996. Ус цаг уурын хүрээлэн. 121 хууд. Монгол.
